

# БИБЛИЙН ДАГУУХ САЙНМЭДЭЭ ТАРААЛТ БА ДАГАЛДУУЛАЛТ



Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй христитгэлт удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Др. Стефен К. Гибсон

Зохиогчийн эрх © 2023 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх 3 дахь хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Ариунаа

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2013 хувилбараас ашиглав.

**Зөвшөөрөлтэй холбоотой заавар:**

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

# Гарчиг

Курсын тойм.....	5
(1) Агуу захирамжийг хүлээн авах нь .....	7
(2) Итгэлд ирэх талаарх Теологи .....	13
(3) Сайнмэдээ тараах яаралтай хэрэгцээ.....	21
(4) Сайнмэдээний үндсэн ойлголтууд.....	27
(5) Эвангелизм ба Сайнмэдээний тэргүүлэх чиглэл .....	31
(6) Ариун Сүнсний ажил .....	37
(7) Залбирал ба мацаг барих нь .....	43
(8) Есүсийн арга барил.....	51
(9) Сайнмэдээг танилцуулах “Гүүр” аргачлал .....	61
(10) Ромын зам .....	67
(11) Сайнмэдээний номлол .....	73
(12) Сайнмэдээнд чиглүүлэх нь.....	81
(13) Сайнмэдээ тараах аргуудыг өөриймсүүлэх нь.....	89
(14) Хүүхдүүдэд үйлчлэх нь.....	97
(15) Чуулганы төсөл/загвар.....	107
(16) Жинхэнэ дагалдагч .....	113
(17) Сүнслэг төлөвшлийн зүг.....	121
(18) Жижиг бүлгийн гарын авлага.....	129
(19) Дагалдагчдын төлөө залбирах нь .....	141
Санал болгох эх сурвалжууд.....	145
Даалгаврын тэмдэглэл.....	147



# Курсын тойм

## Курсын агуулга

Энэхүү курс нь чуулган үүрэг даалгавраа биелүүлэхэд туслах хэрэгсэл юм. Тус хичээл нь нутгийн чуулганд төвлөрч, сайнмэдээ нь чуулганы илгээлт гэдгийг, түүнчлэн сайнмэдээний мөн чанар нь чуулганыг хэлбэржүүлэх ёстой гэдгийг харуулах зорилготой. Сайнмэдээний үндсүүдийг тайлбарлах энэ курсээр хүнийг жинхэнэ итгэлд болон Христийг дагах амьдралд авчирдаггүй орчин үеийн алдаатай арга барилуудыг засах болно. Ингэснээр суралцагч нь өөрийн үйлчлэлээ хөгжүүлэхэд бэлтгэгдэнэ.

Курсын ихэнх хичээлүүд нь олон төрлийн бүлэгт зориулан заах бүрэн хэмжээний сэдвүүдийг багтаасан. Жишээлбэл, нэг хичээл нь сайнмэдээг танилцуулах арга барилыг заахад ашиглагдаж болох юм.

Тус курсээр суралцагч нь хэрхэн дагалдагч бэлтгэхийг сурна. Shepherds Global Classroom нь шинэ итгэгчдэд зориулан **дагалдуулах материалыг** боловсруулсан. Энэхүү дагалдуулах хичээлийн *Cultivate Discipleship Lessons (Дагалдуулах хичээлүүдийг хөгжүүлэх нь)* номыг [shepherdsglobal.org](http://shepherdsglobal.org) вэб хуудсаас татаж авах боломжтой. *Cultivate Discipleship Lessons* нь 26 хичээлээс бүрдэх бөгөөд суралцагчийн хуудас болон багшийн гарын авлага тус тус багтсан байгаа.

## Курсын зорилго

- (1) Чуулганы мөн чанар болон загварт зохицох сайнмэдээний хэрэгжүүлэлтийг тайлбарлах
- (2) Сайнмэдээний үндсэн онол сургаалыг нягталж үзэх
- (3) Итгэгчдийг сайнмэдээний практик арга барилд сургах
- (4) Дагалдуулах чуулганы үүрэг хариуцлагын талаар ойлгож мэдэх
- (5) Дагалдуулалтыг тодорхойлж, тайлбарлах
- (6) Дагалдуулахын тулд жижиг бүлгийг хэрхэн удирдах практик арга барилд суралцах
- (7) Шинэ итгэгчдийг дагалдуулахад ашиглах цуврал хичээлүүдээр хангах

## Ангийн удирдагчдад зориулсан зөвлөмж

Ангийн удирдагчдад зориулсан тэмдэглэлүүд хичээл бүрийн тодорхой хэсэгт байгаа бөгөөд *тэдгээрийг ташуу байдлаар тэмдэглэсэн*.

**Хэлэлцүүлгийн асуултууд** болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултуудын хувьд, ангийн удирдагч асуултыг асууж, суралцагчид хариулах боломжийг олгоно. Хэлэлцүүлгийн үед асуулт болгонд бүрэн хариулах

шаардлагагүй. Харин хичээлийн материал нь асуултад хариулах боломжтой. Хэрэв нэг суралцагч л голдуу анхны хариултыг өгч, бусад нь ярьдаггүй бол удирдагч асуултыг өөр хүнээс асууж чиглүүлнэ. Жишээ нь: "Исаиа, чи энэ асуултад юу гэж хариулмаар байна?" гэж хэлж болно.

Хичээл бүрийн төгсгөлд **даалгавруудыг** танилцуулна. Даалгавруудыг дараагийн хичээлээс өмнө биелүүлж, тайлагнах ёстой. Хэрэв суралцагч даалгавраа биелүүлээгүй бол дараа нь хийх боломжтой. Гэсэн хэдий ч, удирдагч суралцагчдыг хуваарийн дагуу хийхэд урамшуулснаар тэд ангид суралцах хичээлээсээ ихийг сурах боломжтой болно.

Суралцагчид хэд хэдэн төрлийн **бичгийн даалгавруудыг** хийж гүйцээнэ. Ихэвчлэн ангийн удирдагч бичгийн даалгавруудыг хичээл эхлэхэд цуглуулна. Даалгаврын хоёрыг нь (6-р хичээлийн даалгавар 1 болон 14-р хичээлийн даалгавар 1) буцааж өгөх шаардлагагүй, зөвхөн тайлагнахад хангалттай.

Суралцагчид ангид заалгасан арга барилуудаа ашиглан олон хүнд **сайнмэдээг танилцуулна**. Танилцуулга бүрийн дараа тэд туршлагаа бичиж, энэ нь хэрхэн явагдсан талаар ангид хуваалцана. Тэд насанд хүрэгчдэд зориулсан сайнмэдээний номлол болон хүүхдүүдэд зориулсан хичээлийг бэлтгэнэ. Энэ курсын 5 болон 10-р хичээл дээр сорил авна. Суралцагчид сорилын хариултыг материал харахгүй, хоорондоо ярилцахгүйгээр, өөрийн санаж байгаагаар бичих ёстой. Ангийн удирдагчид зориулсан сорилын хариулт өгөгдөхгүй. Учир нь бүх хариултыг хичээлийн материалаас амархан олох боломжтой юм.

13-р хичээлд сайнмэдээг бусдад хуваалцах зааврыг танилцуулсан байгаа. Суралцагчид үүнийг хаанаас харж болохоо мэдэх хэрэгтэй. Хэрэв боломжтой бол үүнийг тухайн хичээлээ бататгахын тулд авчирна уу.

Хэрэв суралцагч нь **Shepherds Global Classroom** байгууллагаас **гэрчилгээ авахыг** хүсвэл тухайн хичээлүүдэд хамрагдаж, даалгавруудаа бүрэн хийсэн байх шаардлагатай. Курсын төгсгөлд даалгавруудаа бүрэн хийснийг тэмдэглэх маягт хавсаргасан байгаа.

# 1-р хичээл

## Агуу захирамжийг хүлээн авах нь

### Танилцуулга

► Нэг суралцагч Матай 28:18-20-ийг ангид уншина.

Зарим хүмүүс энэхүү тушаалыг зөвхөн элч нарт өгөгдсөн гэж итгэдэг.

► Энэ тушаал зөвхөн тухайн өдөр үүнийг сонссон хүмүүст хамаатай юу? Хариултаа тайлбарлана уу.

Виллиам Кери нь Англид төрж өссөн, 1761-1834 оны хооронд амьдарч байсан нэгэн юм. Тэрээр гуталчин байсан бөгөөд сайнмэдээг түгээх өрнүүн их хүсэлтэй хүн байв. Түүний хамрагддаг чуулган гадаад улс оронд хандсан илгээлтийн ажилд тийм ч их санаа тавьдаггүй байжээ. Тэдний хувьд Бурхан аль хэдийн аврах хүнээ аврахыг шийдсэн бөгөөд Түүнд хүний тусламж хэрэггүй гэж үздэг байв.

Нэгэн пасторуудын чуулган дээр Кери “Хэрэв Агуу захирамж нь энэ дэлхийн төгсгөл хүртэл хийх чуулганы ажил байгаад, мөн энэ дэлхийн төгсгөл хүртэл хамт байх амлалтыг Есүс Агуу захирамжийн хамтаар өгсөн юм бол бид энэ сэдвээр ярилцах ёстой биш үү” хэмээн асуусан байдаг. Харин тус чуулганыг удирдаж байсан хүн Керид хандан “Залуу минь сууж үз, чи их дэврүүн [хөөрүү] байна. Бурхан харь хүмүүсийг итгэлд авчрахыг таалбал Тэр үүнийгээ чиний бас миний ямар ч тусламжгүйгээр хийх болно” гэжээ.

Чуулганд өгөгдсөн энэхүү тушаал нь бүх цаг үед хамаатай гэдгийг бид мэднэ. Есүс сайнмэдээг түгээдэг хүмүүстэй үеийн төгсгөл хүртэл хамт байна гэдгээ амласан юм. Энэ нь чуулганд хамаарах үүрэг даалгавар нь бүх үеийнхний хариуцлага болохыг харуулж байна. Элч нар өөрсдийнхөө цаг үед энэхүү үүрэг даалгаврыг дуусгаж амжаагүй бөгөөд Есүс “энэхүү сайнмэдээ бүх үндэстэнд тунхаглагдана” (Матай 24:14) хэмээжээ.

Иймээс сайнмэдээг түгээх нь бүх цаг үеийн чуулганы үүрэг хариуцлага билээ.

► Матай 28:18-20-д өгүүлсэн нарийн ширийн зүйлсийг анзаарч хараарай. Аль нь тодорхой тушаал вэ?

Есүсийн айлдсан тодорхой тушаал нь чуулган хаа сайгүй явж, Түүний дагалдагчдыг бэлтгэх юм.

Энэхүү тушаалд сайнмэдээг тараах нь багтсан бөгөөд учир нь хүн итгэлд ирэх хүртлээ дагалдагч байх боломжгүй билээ.

Энэ тушаал нь чуулган сайнмэдээ тараах болон дагалдуулалтыг эхэнд тавьж, зорьж үйлдэхийг хэлж байна. Эс бөгөөс чуулган оршин буй утга учраа гээх болно.

“Бүх үндэстнийг” (бүх үндэстэн ястан) гэсэн хэллэгээр гадаад илгээлтийн ажлыг хийхийг тушаасан бөгөөд үндэстэн ястнуудад хүрэхээс нааш сайнмэдээ тэднийх болохгүй. Ямар ч бүлэг хүмүүс үүнээс орхигдох ёсгүй юм.

Энэхүү тушаал нь зөвхөн сайнмэдээг тунхаглах явдал биш. Заах үйл явц үүнд шаардлагатай бөгөөд учир нь бид итгэлд ирсэн хүмүүст Есүсийн тушаасан бүхнийг зааж өгөх ёстой юм.

Багш хүн өөрөө Христийн тушаалуудыг дагах бүрэн шийдвэртэй нэгэн байх ёстой. Учир нь тэрээр итгэлд ирсэн нэгэнд сайн үлгэр дуурайл болж, Христийг дуулгавартай дагах амьдралыг харуулах учиртай.

Итгэлд ирсэн нэгэн мөн Христийг дуулгавартай дагахад өөрийгөө зориулах ёстой. Учир нь сурсан зүйлээ дагаж мөрдөхгүй бол Христийн тушаалуудад суралцах нь хангалтгүй юм. Хэрэв тэрээр суралцсан зүйлээ дагахгүй бол дагалдуулах ажлыг эсэргүүцэж байна гэсэн үг. Дагалдуулах нь зөвхөн боловсролын үйл явц биш, харин зан чанарыг төлөвшүүлдэг.

“Хэрэв бид Эзэнийхээ зааврыг дагаж, анхны дагалдагчдад Түүний өгсөн баталгааг бүрэн дүүрэн удирдамжаа болгох аваас тэдгээр нь анхны дагалдагч нарын цаг үеийнхтэй адил өнөө бидний цаг үед ч хамаатай болохыг би улам бүр баттай мэдэх болно.”

Ж. Хадсон Тэйлор,  
“Үйлчлэлийн дуудлага”

### **Сайнмэдээ тараахыг Бичвэрт чухалчилдаг**

Сайнмэдээ тараах нь чуулганд өгөгдсөн Бурханы үндсэн зорилго болохыг Агуу захирамжаас гадна олон Библийн эшлэлд өгүүлсэн байдаг.

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Суралцагчид дараах эшлэлүүдийг уншаад, сайнмэдээ тараахыг Бичвэрт хэрхэн онцолсон талаар ярилцана. Сэтгэгдлээ хуваалцахад нь тэдэнд туслаарай.*

**Матай 9:36-38.** Есүс дагалдагч нараасаа алдагдсан хүмүүсийн төлөө өр нимгэн сэтгэлтэй байж, сүнслэг ургацын талбарт Бурхан ажилчдыг илгээхийн төлөө залбир хэмээн хүсжээ.

**Үйлс 4:29.** Чуулган анх хавчлагатай нүүр тулах үед тэдний гол асуудал нь бие махбодод учруулах аюул занал гэхээс илүүтэй, сайнмэдээнд саад учирч болзошгүй гэж болгоомжилж байсан. Хавчлага дунд ч Бурханы Үг түгэн тархах болтугай хэмээн тэд залбирчээ.

**Үйлс 11:18.** Харь үндэстнүүдэд өгөгдсөн авралын төлөө иудейчүүдийн чуулган Бурханыг алдаршуулж байна.

**Филиппой 1:18.** Түүнийг зовж, гэрийн хорионд байх үед ч Христ тунхаглагдсаар байсанд Паул баяртай байлаа.

**Ефес 6:19.** Паул үр нөлөөтэй сайнмэдээ тараалтын төлөө залбирахыг хүсжээ.



**Ром 10:13-15.** Сайнмэдээний элч болох хүмүүс яаралтай хэрэгтэй байгаа талаар Паул онцолж байсан. Учир нь аврал нь сонсож итгэх хүмүүст л боломжтой юм.

► Итгэгч хүн хүмүүсийг итгэлд ирээсэй гэж хүсэх зарим шалтгаанууд?

### **Итгэгч хүн яагаад алдагдсан нэгэн итгэлд ирэхийг хүсдэг вэ?**

- Тэр Есүсийн үлгэр дуурайлыг дагах хүсэлтэй. Учир нь Есүс алдагдсан нэгнийг аврахын тулд тэнгэрийн улсыг орхиж, энэ дэлхийд амьдарч, өөрийн амийг зориулжээ.
- Бурханыг эсэргүүцэгч нэгэн Түүнийг мөргөн хүндлэгч болсноор Бурхан алдаршихыг тэр хүсдэг.
- Христийн эвлэрүүлэл ба ялалт болох сайнмэдээ түгэн тархахыг тэр хүсдэг.
- Бурханы чухалд тооцдог ажил үйлсэд тэр оролцохыг хүсдэг.
- Нүглийнхээ улмаас мөнхийн шийтгэлийг хүртэх алдагдсан хүмүүсийг тэр өрөвдөн энэрдэг.

► Хүн буруу сэдэл шалтгаанаар сайнмэдээ тараахыг хүсэх боломжтой юу? Буруу шалтгаан нь юу байж болох вэ?

Нутгийн чуулганыг өсгөх болон үйлчлэлдээ амжилт хүсэх нь буруу зүйл биш юм.

Харин амжилтандаа эрдэж бардамнан, бусад чуулгануудтай өрсөлдөж, маргаан мэтгэлцээнд дурлах нь буруу.

Бурхан зарим итгэгчдэд сайнмэдээг тунхаглах онцгой дуудлага, билиг авьяасыг өгдөг (Ефес 4:11). Бүх итгэгчид ийм адил байдлаар сайнмэдээ тараах чадваргүй гэдгийг удирдагчид мэдэх ёстой. Гэсэн хэдий ч, итгэгч хүн бүр сайнмэдээг хуваалцахад бэлэн байж, сайнмэдээг түгээх чуулганы үүрэг даалгаварт өөрийгөө зориулж туслах хэрэгтэй.

### **Зарим итгэгчид сайнмэдээ тараадаггүй шалтгаанууд**

► Яагаад бүх итгэгчид сайнмэдээг тараадаггүй вэ?

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Суралцагчид дараах жагсаалтыг харахаас өмнө өөрсдөөр нь бодуулж, шалтгаануудыг жагсаана уу.*

- Ерөнхий сүнслэг зорилгоо гэсэн
- Сайнмэдээ тараах хариуцлагыг хувьчлан хүлээж аваагүй
- Сүнслэг яриаг хэрхэн эхлүүлэхээ мэддэггүй
- Сайнмэдээг хэрхэн танилцуулахаа мэддэггүй
- Эсэргүүцэлд хариулж чадахгүй хэмээн айх
- Дэлхийнхээс өөр ялгаатай байгаадаа ичих
- Оролдлого чармайлт нь бүтэлгүйтэх вий гэсэн эргэлзээ
- Хавчлага

► Эдгээр нь хангалттай шалтгаан мөн үү?

### **Гараагаа эхлүүлцгээ**

► Алдагдсан нэгний авралын төлөө юу ч хийхгүй байгаа хүний хувьд хаанаас эхлэх хэрэгтэй вэ?

Хэрэв тэр сүнслэг зогсонги байдалд орсон бол түүнд хувийн сүнслэг сэргэлт хэрэгтэй.

Хэрэв хүн сүнсний хувьд сэргэг, халуун сэтгэлтэй бөгөөд Агуу захирамжийг биелүүлэх хувийн хариуцлагаа ухамсарлаж байгаа бол тухайн хүний хувьд дараах хоёр хүчин зүйл хэрэгтэй байж болох юм.

**1. Итгэл** – Бурхан сайнмэдээг хүчирхэг болгодог гэдгийг тэр ойлгох ёстой.

**2. Бэлтгэл** – Сайнмэдээг бусдад дамжуулахад сургагдах хэрэгтэй.

► Нэг суралцагч Иохан 4:28-30, 39-р эшлэлийг ангид уншина. Самарийн эмэгтэй хүмүүсийг Есүс рүү авчрахад ямар шалгуур хангасан бэ?

“Аврагчийг сайн таньж мэдсэн хүмүүсийн зориулалт бүхий амьдралаар дамжуулан чуулган ялан дийлэх нь Түүний арга зам байв. Түүний Сүнс болон арга нь тэднийг бусдад хэлэхийг албадаж байсан юм.”

- Роберт Коулмэн,  
*Мастерын төлөвлөгөө*

Түүнд сургалт байсангүй. Харин түүнд нигүүлслийг хүлээн авсан туршлага, бусдад Есүсийн тухай ярих чин хүсэл байв.

Хэрэв хүнд нигүүлслийг хүлээн авсан туршлага, бусдад үүнийгээ хэлэх хүсэл хоёр л байхад тэр хүн сайнмэдээг тунхаглагчийн хамгийн чухал шалгуурыг хангаж байна гэсэн үг. Сургалт мэдээж чухал ч, хэрэв тухайн хүнд энэ хоёр шалгуур байхгүй бол ямар ч сургалт түүнийг сайн сайнмэдээг тунхаглагч болгохгүй.

### **Гараагаа эхлүүлэхэд танд хэрэгтэй чухал зүйл юу вэ?**

► Сайнмэдээг түгээхэд та хэрхэн тусалж байсан бэ? Та үүний төлөө хийж буй зүйлдээ сэтгэл хангалуун байдаг уу?

► Сайнмэдээг илүү идэвхитэй үр нөлөөтэй хуваалцахад танд ямар тусламж хэрэгтэй вэ?

### **Сайнмэдээг тунхаглагчийн зан чанар**

Агуу захирамжийг хүлээн авах боломжтой хүний талаар ярилцъя.

Шинэхэн итгэгч ч өөрийн гэрчлэл болон итгэлд авчирсан үнэнийхээ талаар хуваалцаж чадна.

Гэсэн хэдий ч, урт удаан хугацааны туршид Бурханаар ашиглагдах, үр нөлөөтэй сайнмэдээг тунхаглагч байхад тодорхой шинж чанарууд хэрэгтэй.

### **(1) Итгэгч болсон байх**

Сайнмэдээг тунхаглагч нь итгэлд ирсэн хүн байх ёстой. Учир нь:

1. Тэр хуваалцах гэрчлэлтэй байх хэрэгтэй.
2. Тэр итгэлд ирсэн туршлагагүйгээр үүний талаар ойлгох боломжгүй.
3. Итгэгч болох үед тохиодог зан чанарын өөрчлөлт түүнд байх ёстой.

Хэрэв хүн итгэгч бололгүйгээр шашны ажил хийж байгаа бол тэр хүн юу хийж байгаагаа ойлгохгүй бөгөөд буруу сэдэл шалтгаанаар хийж байна гэсэн үг.

“Христэд итгэгчдийн итгэж найдахуйц харилцааны гол түлхүүр нь харилцаа холбоог дамжуулагчид өөрсдөө бөгөөд тэд ямар хүмүүс байгаагаас хамаардаг гэж бид үздэг. Тэд христитгэлийн хайр, итгэл, ариун байдлын хүмүүс байх ёстойг энд хэлэх шаардлагагүй юм. Өөрөөр хэлбэл, тэд Ариун Сүнсний хувьсган өөрчлөх хүчийг амсаж мэдсэн, үүн дотор өсөж яваа хүмүүс юм. Ингэснээр тэдний зан чанар хандлага дотор Христийн дүр төрх улам бүр тод томруун харагддаг.”  
- Дэлхийн Сайнмэдээ түгээлтийн төлөөх  
Лузанны зөвлөл,  
*Виллиовбанк тайлан*

### **(2) Христитгэлийн амьдрал нь тогтвортой байх**

Хэдийгээр бид сайнмэдээг хуваалцах боломжийг хэзээ ч алдах ёсгүй ч сайнмэдээг хүн итгэж найддаг хүнээсээ сонсох нь хамгийн үр дүнтэй байдаг. Танд хамгийн их итгэдэг хүмүүс таныг хамгийн сайн мэддэг хүмүүс юм. Сайнмэдээг тунхаглагч хүний Бурханд бүрэн зориулсан амьдрал нь түүний Бурханыг дуулгавартай дагасаар байгаа амьдралаас харагддаг.

### **(3) Чуулгантай холбоотой байх**

Сайнмэдээг тунхаглагч нь чуулганд өөрийгөө зориулдаг гишүүн байх хэрэгтэй. Учир нь:

1. Тэр итгэлийн гэр бүлд хүмүүсийг урих боломжтой байх хэрэгтэй.
2. Тэр шинэ итгэгчдийг дагалдуулах чуулганы ажилд туслах хэрэгтэй.
3. Түүнд сүнслэг хариуцлага хэрэгтэй.
4. Түүнд чуулганы дэмжлэг, урам зориг хэрэгтэй.

Тэрээр сүнслэг ах эгч дүүс нарынхаа итгэлийг хүлээсэн хүн байх ёстой. Тэр чуулганы удирдлага, ажлыг хүндэтгэн үздэг.

Хэрэв тэр өөрийгөө чуулгангүйгээр итгэгч байж, үйлчлэл хийж чадна гэж боддог бол тэрээр чуулганыг ч, сайнмэдээний урилгыг ч ойлгоогүй байна.

#### **(4) Үнэнийг баримталдаг байх**

Сайнмэдээг тунхаглагч нь Бурханы Үг бол бусдад хуваалцах үнэт эрдэнэс хэмээн итгэдэг. Библид аврал болон Бурхантай харилцах нөхцлүүдийг танилцуулдаг. Бид өөрсдийн мэдээг бусдаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд үнэнийг хэзээ ч өөрчилж чадахгүй (1 Коринт 4:1-2).

Учир нь Библид хэлсний дагуу, хүн бүр нэг бол мөнхийн улсад, нэг бол мөнхийн тамд очно гэдгийг бид мэддэг. Сайнмэдээг тунхаглагч нь ийм итгэл үнэмшилд тулгуурладаг.

#### **(5) Сүнсээр дүүрэн байх**

Сайнмэдээг хуваалцахад Ариун Сүнс хүчийг өгдөг. Тэр нүглийг яллаж, сүнслэг хүслийг өгөн, үл итгэгчийг итгэлээр хариу үйлдэх чадвартай болгодог.

Сайнмэдээг тунхаглагч нь Ариун Сүнсээр ашиглагдахдаа л үр нөлөөтэй байж чаддаг. Тиймээс тэрээр даруу байж, Бурханд найдах ёстой юм. Тэр Бурханаас удирдамж асуун, залбирдаг нэгэн байх ёстой.

Сайнмэдээг тунхаглагч нь Сүнсний дүүргэлтийг эрэлхийлэх ёстой. Энэ нь зүрх сэтгэлийг цэвэрлэж, үйлчлэх хүчийг өгдөг. Есүс элч нарт Сүнсний энэхүү ажлыг хүлээхийг хэлсэн байдаг (Үйлс 1:4-5). Элч нар энэхүү Сүнсний дүүргэлтийг Пентэкостын өдөр хүлээн авсан (Үйлс 1:8, Үйлс 2:4, Үйлс 15:8-9).

Сайнмэдээг тунхаглагч тодорхой сорилтыг даван туулахын тулд Бурхан Сүнсний онцгой тосолгоог өгөх ч тохиолдол бий (Үйлс 13:9-12).

#### **1-р хичээлийн даалгаврууд**

(1) Сүүлийн 12 сарын хугацаанд сайнмэдээг тараах болон дагалдуулахад хэрхэн биечлэн оролцсон талаар хэдэн догол мөрөнд бичнэ үү. Та ирээдүйд ямар зорилт тавьж байна вэ? Та энэхүү курс хичээлээс юу сурахыг хүсэж байна вэ?

(2) Танай орон нутгийн чуулганууд сайнмэдээг түгээхийн тулд ямар ажлуудыг хийж байна бэ? Ажиглалт хийгээд асуулт асуугаарай. Тэгээд 2-3 хуудас тайлбар бичнэ үү.

## 2-р хичээл

# Итгэлд ирэх талаарх Теологи

### Танилцуулга

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Энэ хичээл дээр ашиглах Бичвэрийн хэсгүүдээс гадна зүүлт тайлбарт олон Бичвэрийн эшлэлүүд бий. Ангид хичээлийн үеэр бүх эшлэлийг унших хангалттай цаг гарахгүй байж магадгүй. Та зарим эшлэлийг уншихаар сонгох боломжтой.*

Итгэлд ирэх гэдэг нэр томъёо нь хүн аврагдах үед тохиолддог өөрчлөлтийг хэлдэг. Сайнмэдээний зорилго нь үл итгэгчийг итгэлд ирэх туршлага руу хөтлөх явдал юм.

► Нэг суралцагч 1 Тесалоник 1-р бүлгийг ангид уншина. Тесалоникчуудыг итгэлд ирэх үед тохиолдсон өөрчлөлтийн нарийн ширийн зүйлс юу байв?

Хүн яагаад итгэлд ирэх ёстой, мөн хүн итгэлд ирэх үед юу тохиолддогийг ойлгохын тулд итгэлд ирэхээс өмнөх нүгэлтний нөхцөл байдлыг бид ойлгох ёстой болно.

### Итгэлд ирэхээс өмнөх хүний нөхцөл байдал

► Хүн итгэлд ирэхээс өмнөх нөхцөл байдлыг та хэрхэн дүрслэх вэ?

Адамын нүглээс болж бүх хүн Бурханаас тусгаарлагдсан мөн чанартай төрдөг болжээ (Ром 5:12). Энэ нь хүн бүр хувиа хичээж, өөр өөрийн замаар явдаг гэсэн үг юм.

### Итгэлд ирээгүй нүгэлтнүүдийн дөрвөн шинж байдал

Хүн сонголт хийж эхэлмэгцээ нүгэл үйлдэж эхэлдэг. **Хүн бүр олон нүгэлт үйлдлийнхээ улмаас гэм буруутай** (Ром 3:23).

Нүгэл бол Бурханы хуулийг зөрчих явдал юм (1 Иохан 3:4, Иаков 2:10-11). Бурхан туйлын шударга учраас нүглийг зүгээр өнгөрүүлэхгүй бөгөөд хүн бүр хийсэн бүхнийхээ төлөө шүүгдэнэ (2 Коринт 5:10, Илчлэл 20:12-13). Ямар ч хүний буруутай эсэх талаар болон түүний хүртэх ёстой шүүлтийн талаар маргах зүйл байхгүй. Нүгэлтэн бүр хэдийн яллагджээ (Иохан 3:18-19).

**Итгэлд ирээгүй нүгэлтэн Бурханы дайсан юм** (Ром 5:10). Бурханы эсрэг үйлдсэн гэмт хэргээ арилгахгүй л бол нүгэлтэн Бурхантай харилцаатай байх боломжгүй.

**Нүгэлтэн хүсэл тачаалдаа ялзарсан** (Ефес 2:3) учраас нүгэлтний итгэлд ирэхээс өмнөх нөхцөл байдал нь Бурхантай харилцах ямар ч боломжгүй юм. Мөн тэрээр нүглийн боол учраас **өөрийнхөө нөхцөл байдлыг өөрчлөх хүчгүй** (Ром 5:20, Ром 7:23) аж.

Тэгвэл итгэлд ирээгүй нүгэлтэнд хэрэгтэй аврал гэж юу вэ? Нүгэлтэн гэм буруутай учраас аврал нь уучлал гэсэн утгатай. Тэр мөн Бурханы дайсан учраас аврал нь

эвлэрүүлэл юм. Хүн гажуудаж ялзарсан учраас аврал нь цэвэрлэх гэсэн утгыг ч агуулна. Түүнчлэн хүн хүчгүй учраас аврал нь чөлөөлөлт юм. Эдгээр нь нүгэлт хүнд хэрэгтэй авралын цөөн хэдэн талбар юм.

Итгэлд ирэх мөчид нүгэлтэн уучлагдаж, Бурхантай эвлэрч, цэвэрлэгдэн, нүглийн хүчнээс чөлөөлөгддөг. Паул Коринтын итгэгчдийн итгэлд ирэхээс өмнөх нүгэлт нөхцөл байдлыг дүрслэхдээ тэдний олон аймшигтай нүглийг дурдсан байдаг. Тэгээд тэр цааш нь “гэвч... угаагдсан, ариусгагдсан, та нар зөвтгөгдсөн...” (1 Коринт 6:11) гэж бичжээ.

### **Загалмай шаардлагатай болох нь**

Хэн ч нүглийнхээ төлөөсийг өөрөө төлж чадахгүй. Нүгэл нь хязгааргүй Бурханы эсрэг үйлдсэн гэмт хэрэг бөгөөд үүнийг төлж чадах хязгааргүй үнэ цэнтэй ямар нэг зүйл хүмүүст байхгүй юм.

Хүмүүс энэ хэрэгцээгээ хангах юу ч хийж чадахгүй төдийгүй, авралыг гүйцэлдүүлж чадах ямар ч болзол шаардлагыг тэдэнд зориулан тогтоож өгөх боломжгүй байсан (Галат 3:21). Хэрэв хүмүүс авралыг өөрсдөө олж авах боломжтой байсансан бол Есүс загалмай дээр үхэх ямар ч хэрэггүй байх байв (Галат 2:21).

► Хэрэв Бурхан биднийг уучлахыг хүссэн юм бол загалмайгүйгээр зүгээр л аварч яагаад болоогүй юм бэ?

Бурхан ариун бөгөөд шударга учраас үнэн ба шударга ёсны зарчмын дагуу шүүдэг (Ром 2:5-6).

Христ төлөөсийг төлөөгүй байсан бол гэж төсөөлж үзье. Хэрэв Бурхан золилтгүйгээр нүглийг зүгээр л уучилсан бол юу болох вэ?

Хэрэв Бурхан золилтгүйгээр нүглийг уучилсан бол:

- Нүгэл нь ноцтой зүйл биш байх байсан.
- Бурхан шударга биш, мөн ариун ч биш гэсэн үг.
- Аливаа хүн зөвийг эсвэл бурууг үйлдэж байгаа эсэх нь Бурханы мэлмийд онцын ялгаагүй харагдана гэсэн үг.

Хэрэв золилтгүйгээр уучлал өгөгдсөн бол Бурханыг шударга бөгөөд ариун хэмээн мөргөн хүндлэх боломжгүй болох байлаа. Золилтгүй уучлал гэдэг нь эцсийн дүндээ Бурханыг хүндэтгэх бус харин огтоос үл хүндэтгэсэн хэрэг болох байв.

Гэсэн ч Бурхан хайрладаг бөгөөд уучлахыг хүсдэг Бурхан. Хэдийгээр энэ нь тэдний хүртэх ёстой зүйл байсан ч бүх хүн төрөлхтнийг нүгэлт нөхцөл байдалд нь орхихыг, мөнхөд хаягдаж гээгдэхийг Бурхан хүсээгүй юм.

Загалмай дээр Есүсийн өргөсөн тахил нь нүглээс болж нэхэгдэж байсан хязгааргүй үнэ цэнийг төлсөн. Учир нь Есүс **(1) ямар ч нүгэлгүй байснаараа** (төгс бөгөөд Түүнд ямар ч аврал хэрэггүй, 2 Коринт 5:21), мөн **(2) Бурхан бас хүн, аль аль нь байснаараа** шалгуурыг хангажээ.

Түүнчлэн уучлалыг хүртэх үндэс нь золилт байсан юм. Тиймээс гэмшиж, Түүний амлалтад итгэсэн хүнийг Бурхан уучлах боломжтой болжээ. Загалмай дээрх тахил золиосыг ухаарсан хэн ч нүгэл нь Бурханы хувьд ямар ноцтой зүйл гэдгийг ойлгож чадна.

Золилт бол амлалтад нь итгэсэн нүгэлт хүнийг зөвт Бурхан Өөрөө зөвт хэмээн тооцох арга зам юм. Ром 3:20-26-р эшлэлд энэхүү золилт хэрхэн явагдсан талаар логик учир шалтгааныг тайлбарласан байдаг.

Бурханаас өгөгдсөн авралыг авах цорын ганц арга зам бий гэдгийг Библи бидэнд заадаг. Хэрэв хүн Христэд итгэх нигүүлслээр ирдэг авралыг үгүйсгэвээс аврагдаж чадахгүй (Марк 16:15-16, Үйлс 4:12, Еврей 2:3).

Тийм учраас аврал зөвхөн нигүүлслээр ирэх бөгөөд үүнийг итгэлээр хүлээн авах тухай сургаалыг ойлгох нь маш чухал юм. Аврал зөвхөн нигүүлслээр л ирнэ. Яагаад гэвэл авралыг олж авах, хүртэж болох өөр юу ч байхгүй. Үүнийг зөвхөн итгэлээр хүлээж авна. Учир нь бидний хувьд Бурханы амлалтад итгэхээс өөр хийж чадах зүйл үнэндээ байхгүй билээ.

### **Анхны нигүүлсэл**

► Аль нь эхэнд тохиолддог вэ: Хүний доторх Бурханы ажил уу? Бурханд хандсан хүний хариу үйлдэл үү?

Бурханы нигүүлсэл үл итгэгчийн зүрх сэтгэлд хүрч, нүглийг нь ялладаг учраас хүн уучлагдахыг хүсдэг (Тит 2:11, Иохан 1:9, Ром 1:20). Нүгэлтэн Бурханы тусламжгүйгээр нүглээ хаяж чадахгүй. Үл итгэгч хүнд сайнмэдээнд хариу үйлдэх чадварыг өгдөг нь Бурхан юм (Иохан 6:44). Хэрэв хүн аврагдаагүй бол нигүүлсэл дутсаных бус, харин Бурханы түүнд өгсөн нигүүлсэлд тухайн хүн хариу үйлдээгүйгээс болсон байдаг.

Есүс бүх дэлхий ертөнцийн нүглүүдийн төлөө амиа өргөсөн бөгөөд Бурхан хүн бүрийг аврахыг хүсдэг (2 Петр 3:9, 1 Иохан 2:2, 1 Тимот 4:10). Бурханы нигүүлслээр сайнмэдээнд хариу үйлдэх чадвар бүх хүнд өгөгдсөн байдаг боловч Тэрбээр хэнийг ч албаддаггүй. Тиймээс Бурхан үл итгэгчийг дуудаж, гэмших ба итгэх сонголтыг өгдөг (Марк 1:15).

### **Гэмшил**

► Гэмшил гэж юу вэ?

Гэмшил гэдэг нь нүгэлтэн өөрийнхөө гэм буруутай, шийтгэл хүртвэл зохих байдлыг ухамсарлаж, нүглүүдээ орхиход бэлэн гэсэн утгатай.

Исаиа номын энэхүү эшлэлд гэмшлийн талаар:

Хорон муу нь замаа, буруу нэгэн нь бодол санаануудаа орхиг. Өөрийг нь өрөвдөх ЭЗЭН өөд эргэг, өгөөмрөөр уучлах Бурханд маань эргэг (Исаиа 55:7).

Гэмшил гэдэг бол нүгэлт хүн Бурханы уучлалыг хүртэхээс өмнө зам мөрөө засан, Бурханы өмнө өөрийгөө зөвт болгоно гэсэн үг биш. Тэгэх ч боломжгүй. Учир нь хүн нүглийн боолчлолд байгаа бөгөөд өөрийгөө чөлөөлж чадахгүй. Харин нүгэлтэн өөрийг нь нүглүүдээс нь чөлөөлж аврахыг Бурханаас хүсэх ёстой юм.

► Аврал зөвхөн нигүүлслээр өгөгдөх юм бол гэмшил ямар хэрэгтэй юм бэ?

Итгэл нь уучлагдах цорын ганц шаардлага хэдий ч Христэд итгэх жинхэнэ итгэл нь хүн нүглүүдээ гэмших гэмшилд үргэлж хөтөлдөг. Христ рүү эргэх (итгэх) болон нүглээс буцах (гэмшил) нь нэгэн зэрэг тохиолддог боловч нүглээс буцах боломжтой болгож буй нь итгэл юм. Энэхүү авралын итгэл нь Бурханы бэлэг билээ (Ефес 2:8-9). Хэрэв хүн гэмшихийг хүсэхгүй байгаа бол тэр хүн нүглээс аврагдахыг ч хүсэхгүй байна гэсэн үг.

Гэмшихгүй байгаа хүн нүглийн хорон муу чанарыг хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн үг. Хэрэв хүн нүглээс яагаад эргэх ёстойгоо ойлгохгүй байгаа бол түүний нүгэл үнэхээр хорон муу гэдгийг харж чадахгүй байна. Түүнчлэн хүн нүглийг хорон муу гэж харахгүй байгаа бол яагаад түүнд уучлал хэрэгтэйг ч сайн ойлгохгүй.

Хэрэв хүн өөрийгөө гэм буруутай, шийтгэл хүртэх зохистой гэж үзэхгүй л байгаа бол тэр хүн ерөөсөө гэмшээгүй байгаа хэрэг. Мөн тэрээр өөрийгөө нүгэлтэн гэж хүлээн зөвшөөрсөн ч, нүгэл үйлдэхийг нь зөвшөөрөх шашинтай байхыг хүсэж байгаа бол тэр хүн мөн л гэмшээгүй гэсэн үг. Учир нь түүнийг гэм буруутай болгодог зүйлийг тэр үргэлжлүүлэн хийхийг хүсэж байна.

## **Авралын итгэл**

► Авралын итгэлтэй хүн юунд итгэдэг вэ?

### **(1) Өөрийгөө зөвтгөх юуг ч хийж чадахгүй.**

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно (Ефес 2:8-9).

Аврагдахын тулд хийж чадах юм (үйлс) байхгүй, бүр өчүүхэн ч байхгүй гэдгийг тэр ухаарсан байдаг.

### **(2) Христийн тахил золиос түүнийг уучлахад хангалттай.**

Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй, хамаг ертөнцийн нүглийн учир билээ (1 Иохан 2:2).

*Тайвшруулал* гэдэг нь биднийг уучлал хүртэх боломжтой болгож буй тахил золиос гэсэн утгатай.

### **(3) Бурхан түүнийг итгэлийнх нь үндсэн дээр л уучилсан.**

Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ (1 Иохан 1:9).



Аврал авахад нэмэлт шаардлага бий гэж үзэх юм бол, хүн зөвхөн нигүүлслээр биш харин үйлсийн оролцоотой аврагдана гэж бодоход хүрнэ.

## Итгэлд ирэх

► Нэг суралцагч Үйлс 26:16-18-ыг ангид уншина. Паулын үйлчлэлийн талаар эдгээр эшлэлд юу гэж хэлсэн бэ?

Паулын үйлчлэл нь хүмүүсийг итгэлд ирэхэд нь дагуулах байв. 18-р эшлэлд итгэлд ирэх талаар өгүүлжээ. Үүнд харанхуйгаас гэрэл рүү, Сатаны эрх мэдлээс Бурхан руу эргэх, уучлалыг хүлээн авах, ариусгагдсан хүмүүсийн өвийг хүлээн авах зэрэг нь багтдаг. Энэ нь Христэд итгэх итгэлээр боломжтой болдог.

Үл итгэгчээс итгэгч болох нь агуу хувьсан өөрчлөлт юм. Библид үүнийг шинэ бүтээл (2 Коринт 5:17) гэж хэлсэн бөгөөд хуучин зүйлс нь өнгөрөн одож, бүх зүйл шинэ болжээ.

Итгэлд ирсэн хүн Бурханд бүрэн үнэнч байхтай зөрчилдөх аливаа шашны зан үйл болон шүтээнүүдийг орхидог (1 Тесалоник 1:9).

Энэхүү өөрчлөлт нь ихэвчлэн бусдыг гайхшруулдаг (1 Петр 4:3-4). Хүн яаж ингэж их өөрчлөгдөж болдгийг хүмүүс ойлгодоггүй. Магадгүй тухайн хүний хамгийн дотны найз нөхөд, хамаатан садан нь түүнийг хавчин гадуурхаж ч болох (Матай 10:34-36).

Итгэлд ирсэн хүн дэлхий ертөнцийн хүсэл таашаал, эрхэмлэх зүйлсийг орхидог. Энэхүү ялгаатай байдал нь түүний итгэлд ирсний нэг нотолгоо болдог (1 Иохан 2:15). Хүн итгэгч болохдоо бусад итгэгчдийг хайрлаж, тэдэнтэй нөхөрлөхийг хүсдэг (1 Иохан 3:14).

Итгэгч болох үед хүний хүсэл өөрчлөгддөг. Гэсэн хэдий ч түүнийг сорих уруу татлагууд байсаар байдаг. Харин тэрээр нүгэлт хүсэлдээ захирагдахаа больсон тул нүгэл үйлдэх уруу татлагыг эсэргүүцэх чадвартай болдог. Мөн тэрээр Бурханы нигүүлслийг амсаж мэдсэн учраас Бурханы Үгийг хүсэмжилдэг (1 Петр 2:2-3).

Хүн итгэлд ирээд Бурханыг хайрлаж, Түүнийг баярлуулахыг хүсдэг. Түүний хувьд Бурханы тушаалууд нь хатуу чанд, тааламжгүй санагддаггүй (1 Иохан 5:2-4).

Итгэлд ирсэн хүн Бурхантай харилцах хувийн харилцаагаа анхаарах бөгөөд энэ нь түүний залбирлаар илэрхийлэгддэг (1 Коринт 1:2).

► Хүн итгэгч болох үед ямар өөрчлөлтүүд бий болдог талаар өөрийн бодлыг хуваалцана уу?

“Үнэнч тууштай пастор хүн ‘шийдвэр’-үүдээс илүүтэй Христтэй харилцах харилцаандаа туушдаа байдаг, Бурханы Үгээр өлсдөг, христитгэлийн хайр дотор алхдаг, Христийн үхэл, амиллыг итгэлээрээ байнга хуваалцдаг, тасралтгүй залбирдаг тийм итгэгчдэд сэтгэл хангалуун явдаг.”

- Тимоти Кийп,  
“Библийн дагуух Сайнмэдээ тараалт ба Итгэлд ирэх нь”

## Шинэ төрөлтийн шинж чанарууд

Библид хүн дахин төрөх үед бүх зүйлс шинэ болдог гэж хэлдэг. Тэдгээр шинэ зүйлс нь:

- Шинэ мөн чанар—тэнгэрлэг мөн чанар (2 Петр 1:4)
- Шинэ Мастер/Эзэн—Христ, Ариун Сүнсээр дамжуулан (Матай 23:10, Ром 8:14)
- Бурханы Үгийг хүсэмжлэх шинэ дуршил (1 Петр 2:2)
- Хайрын шинэ хандлага (Ром 5:5, 1 Иохан 4:7-8)
- Бурханы хүү, охин байх шинэ харилцаа (Иохан 1:12)
- Ариун Сүнс дотор шинэ Туслагч (Иохан 14:16, Ром 8:26-27)
- Есүс Христийн дотор шинэ өмгөөлөл, хэрэв бид нүгэлд унах аваас (1 Иохан 2:1)
- Мөнх амийн шинэ, амьд найдвар (Иохан 3:15, 1 Петр 1:3)

## Хувьчилсан авралын баталгаа

► Хэн нэгнийг итгэгч гэж бодоход хүргэдэг ямар буруу шалтгаан байж болох вэ?

Хүн өөрийгөө дараах шалтгааны улмаас итгэгч гэж бодож болох юм. Учир нь:

- Баптисм хүртсэн.
- Чуулганд хамрагддаг гишүүн.
- Христитгэлийн тодорхой хэдэн онол сургаалд итгэдэг.
- Шашны тодорхой зан үйлийг дагадаг.
- Зөвийг үйлдэх хэм хэмжээг дагадаг.
- Сүнслэг туршлагууд байсан.
- Итгэлээ тунхаглаж, шийдвэр гаргасан.

Библийн дагуу эдгээрийн аль нь ч хүнийг итгэгч гэдгийг батлахад хангалтгүй юм.

Библид бид дахин төрсөн гэдгээ баттай мэдэж чадна гэж хэлдэг. Бурхан биднийг хүлээж авсан гэдэгт бид итгэлтэй байж болно. Бид айдастай амьдрах шаардлагагүй, учир нь биднийг Бурханы хүүхдүүд болгон үрчлэн авсан гэдгийг Бурханы Сүнс баталдаг (Ром 8:15-16).

Энэхүү баталгаа нь үнэхээр бүрэн дүүрэн бөгөөд бид Шүүлтийн өдрөөс айх шаардлагагүй юм (1 Иохан 4:17). Тэнгэрийн улс намайг хүлээн авна гэж найдаж байна гэж хэлдэг хүмүүсээс ч илүү найдвартай баталгаа бидэнд бий. Аврал нь хүн төрөлхтөнд ерөнхий байдлаар өгөгдсөн гэж итгэх нь хангалтгүй юм. Харин хүн өөрөө уучлагдсан гэдгээ мэддэг байх ёстой.

► Хүн өөрийгөө зөвтгөгдсөн гэдгээ яаж мэдэх вэ?

Зарим хүн өөрийнхөө мэдрэмжид найдаж болох ч мэдрэмж нь өөрчлөгддөг бөгөөд төөрөгдүүлдэг.

Өөрчлөгдсөн амьдрал нь хүнийг итгэлд ирсэн гэдгийн нотолгоо боловч энэ нь итгэлд ирэх эхний мөчид харагддаггүй. Авралын үр дүн хараахан харагдах болоогүй байдаг. Тиймээс өөрчлөгдсөн амьдрал нь авралын баталгааны үндэс биш юм.

Итгэгч хүн авралд хүргэх Бичвэрийн замыг дагаж буйгаа мэдсэнээр авралдаа итгэлтэй байж чадна. Хэрэв хүн үнэн сэтгэлээсээ гэмшиж, Библид заасны дагуу итгэсэн бол Бурхан түүнийг уучилсан гэдэгт эргэлзэх хэрэггүй юм. Хүн гэмшиж, итгэх мөчид Бурханы хүүхэд болсон гэдгийг Тэр Сүнсээрээ гэрчилдэг.

Хүн үнэн сэтгэлээсээ гэмшээгүй атлаа өөрийгөө Бурханаас төрсөн гэж мэдрэхийг оролдвол тэрээр эргэлзэж, өөрийгөө хуурч болох юм.

Хэрэв хүн (1) үнэн сэтгэлээсээ гэмшиж, (2) Бичвэр дэх Бурханы амлалтад итгэн, (3) Сүнсний гэрчлэлийг хүлээн авбал тэр хүн хууртагдахгүй. Энэхүү баталгаа нь туйлын найдвартай бөгөөд Бурханы Үгэнд үндэслэсэн юм. Бурхан амлалтаа үргэлж сахидаг.

### **Авралын шинж чанарыг агуулсан 10 үгс**

**Эвлэрэл:** Энэ үг өмнө нь дайснууд байсан бол одоо эв найрамдалтай болсон гэсэн санааг агуулдаг. Авралаар Бурхан биднийг Өөртэйгөө эвлэрүүлж, бид Түүнтэй эв найрамдалтай болсон (2 Коринт 5:19, Ром 5:1).

**Цагаатгал:** Энэ үг тэмдэглэгээг арилгасан гэсэн утгатай. Авралаар бидний нүглийн бүртгэл устаж арилсан юм (Еврей 8:12).

**Эвлэрүүлэл:** Энэ үг хэн нэгний уурыг намжаахын тулд ямар нэг юмыг өгсөн гэсэн утгатай. Аврал дахь Есүсийн өргөсөн тахил нь бидний эсрэг чиглэсэн Бурханы зөвт байдлын уур хилэнг намжаасан юм (1 Иохан 2:2).

**Аврал:** Энэ үг нь хүн өөр хэн нэгний эрхшээлээс аврагдсан гэсэн утгатай. Авралаар бид Сатаны эрхшээл, нүглийн хүчээс чөлөөлөгдсөн юм (Лук 1:74, Ром 6:6, 12-18).

**Золилт:** Энэ үг хэн нэгнийг эрх чөлөөтэй болгохын тулд үнийг төлж авах гэсэн утгыг агуулдаг. Авралаар биднийг нүглийн боолчлол ба шийтгэлээс чөлөөлөх үнэ төлөөсийг Есүс үхлээрээ төлсөн юм (Ефес 1:7, Тит 2:14).

**Зөвтгөл:** Энэ үг нь хэн нэгнийг зөвт, гэм буруугүй гэж зарласан гэсэн утгыг агуулдаг. Авралаар гэм буруутай нүгэлтний оронд Есүс зовж шаналсан учраас нүгэлтэн зөвт тооцогддог (2 Коринт 5:19, Ром 5:1).

**Ариусгал:** Энэ үг нь хэн нэгнийг ариун болгох гэсэн утгатай. Авралаар гэм буруутай нүгэлтэн Бурханы хүүхэд болж өөрчлөгддөг. Шинэ гэрээний олон захидалд итгэгчдийг "ариун хүмүүс" хэмээн нэрлэсэн байдаг (Ефес 1:1, Колоссай 1:1, Филиппой 1:1).

**Үрчлэл:** Энэ үг нь хэн нэгэн хүн өөр хүний хууль ёсны хүүхэд болно гэсэн утгатай. Авралаар бид Бурханы хүүхдүүд болсон (Иохан 1:12, Ром 8:15).

**Дээрээс төрөх / Шинээр төрөх:** Энэ үг нь хэн нэгэн амийг дахин эхлүүлэх гэсэн утгыг агуулдаг. Авралаар итгэгчийн шинэ амьдрал эхэлдэг (Ефес 2:1, Иохан 7:38-39, Галат 4:29, Иохан 3:5).

**Тамгалах:** Энэ үг нь алив зүйлийг хэн өмчилж байгааг илэрхийлэх тэмдэглэгээ гэсэн утгатай. Авралаар бидний доторх Ариун Сүнс биднийг Бурханд хамаатай болсныг тодорхойлж өгдөг (Ефес 1:13).

### **Алдаанаас зайлсхийх: Гэмшдэггүй шашин**

Аврал нь итгэлээр дамжуулан нигүүлслээр ирдэг гэдгийг сонсоод өөрийгөө аврагдсан гэж амарханаар боддог хүмүүс байдаг. Гэмших хэрэгтэй гэдгийг ойлгоогүй учраас тийм хүн жинхэнээсээ гэмшээгүй байдаг ба өөрийгөө Бурханы шийтгэл хүртэх ёстой нүгэлтэн гэдгээ огт олж хараагүй байдаг аж. Тийм хүн нигүүлслийг өөрийнхөө замаар явах гэж ойлгодог. Христитгэлийн үнэнийг хүлээн зөвшөөрсөн учраас тэр өөрийгөө Христэд итгэгч болсон гэж боддог боловч үнэндээ ямар ч өөрчлөлт байдаггүй. Тийм хүн хэзээ ч өөрийн хүслээсээ татгалздаггүй. Харин Бурханыг амьдралынхаа нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрсөн атлаа ихэвчлэн өөрийнхөө хүслийг дагаж амьдардаг. Бичвэрт заасан Бурхантай харилцах авралын харилцааны эхлэл ийм байдаггүй.

### **2-р хичээлийн даалгаврууд**

(1) Энэ хичээлээр бид авралын шинж чанарыг агуулсан 10 үгсийн талаар сурсан. Эдгээрээс аль нь таны Бурхантай харилцах харилцаанд хамгийн чухал санагдаж байгаа талаар хэд хэдэн догол мөрөнд тайлбарлан бичнэ үү. Өөр илүү бодож үзэх хэрэгтэй санагдсан зүйл байсан уу?

(2) Танай улс оронд, ялангуяа таны амьдардаг газарт хүмүүс Христэд итгэгч байх гэдгийг юу гэж ойлгодог вэ? (христитгэлийн хэлбэр, уламжлалд үндэслэн) Хэд хэдэн төрлийн бүлэг хүмүүсийн өмнөөс, тэд Христэд итгэгч хүний талаар ингэж хэлэх байсан гэж 2-3 хуудас төсөөлж бичнэ үү. Итгэгчдийн гэмшил, авралын итгэл болон бусад онол сургаалын тал дээр тэдэнд ямар алдаатай ойлголт, үзэл баримтлал байгааг тайлбарлаарай.

## 3-р хичээл

# Сайнмэдээ тараах яаралтай хэрэгцээ

### Танилцуулга

► Хүн сайнмэдээг сонсохгүйгээр зөвтгөгдөх боломжтой юу? Сайнмэдээ тараах ажил зайлшгүй хэрэгтэй юу?

Бичвэрт Израилтай ч, чуулгантай ч холбогдохгүйгээр Бурханы нигүүлслийг хүлээн авсан хүмүүсийн жишээг дурдсан байдаг. Мосегоос өмнө, мөн Бичвэрийн хуудас бичигдэхээс ч өмнө Иов хэмээх зөв шударга, бузар мууг эсэргүүцэж амьдарсан хүн байлаа. Балаам Бурхантай харилцаатай байж, транс байдалд орохгүйгээр Бурханаас мэдээ хүлээн авдаг үзмэрч гэдгээр нь хүмүүс мэддэг байв. “Энэ газарт Бурханаас айж эмээнэ гэж байхгүй тул” (Эхлэл 20:11) хэмээн бодсон Абрахамаас ч илүү Абимелехийн үйлдэл зөв байсан. Ром 1:21-32 эшлэлд гажуудаж завхарсан харь үндэстнүүдийг дүрсэлдэг. Энэ нь тэд Бурханыг хэзээ ч мэдээгүй учраас биш, харин тэд мэддэг зүйлээсээ татгалзсан учраас тийм байв.<sup>1</sup>

“ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ” (Дуулал 25:14). Гэрээ нь Бурханы хүнтэй харилцах харилцааны нөхцлүүд юм. Нэгэнт хүн бүр нүгэл үйлддэг учраас гэрээ нь нигүүлслийг хангахыг шаарддаг. Хэрэв хүн Бурханыг бүрэн эмээн хүндэлдэг бол Бурхан түүнд Өөртэйгээ харилцах замыг зааж өгөх болно.

Библид Есүсээс өөр аврах нэр байхгүй гэж хэлдэг (Үйлс 4:12). Гэсэн хэдий ч Хуучин гэрээний цаг үед аврагдсан хүмүүс Есүсийн нэрийг мэддэггүй байв. Тэд золин аврах, уучлах Бурханы амлалтад итгэсэн бөгөөд Бурхан үүнийг Есүсээр дамжуулан өгдөг. Үүний нэгэн адил, Есүсийн нэрийг хараахан сонсож амжаагүй хүмүүс Есүсээр дамжуулан өгдөг авралын төлөө Бурханд итгэж найдаж болох юм.

Тэгвэл аврал өөр ямар ч нэрээр ирэх боломжгүй гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь авралын өөр арга зам байхгүй гэсэн утгатай. Хүнийг золин авах өөр ямар нэг авралын төлөвлөгөө байхгүй. Энэ нь мөн Есүсийн тухай мэддэг хүн Түүнээс татгалзах ёсгүй болохыг хэлж байна. Учир нь Түүнийг үгүйсгэх нь авралаас татгалзаж буй, түүнчлэн авралын өөр арга замыг хайж байна гэсэн санаа юм.

“Ертөнцөд ирж хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв” (Иохан 1:9). Ариун Сүнс Есүсийн тухай сонсоогүй хүмүүст ч Түүний гэрлийг авчирдаг.

<sup>1</sup> Дуулал 19 болон Ром 10:18-ыг мөн үз.

Олон хүмүүс сайнмэдээг дамжуулах элчгүйгээр тэднийг Бурханы өмнө авчрах үзэгдэл болон онцгой илчлэлийг хүлээн авсан байдаг. Жишээлбэл, орчин цагт олон муслимчууд Бурханаас мэдээ хүлээн авсны дараа итгэлд ирж байна.

► Сайнмэдээг бүрэн ойлгохоосоо өмнө Бурхантай тусгай байдлаар холбогдож байсан хүний талаар та сонсож байсан уу?

Тэгэхээр элчээр дамжуулан сайнмэдээг сонсохгүйгээр хүн Бурханыг олж, тэр ч байтугай аврагдах боломжтой гэдгийг бид харж байна. Гэсэн хэдий ч, Библид сайнмэдээг хүн бүрийн даруй яаралтай сонсох ёстой мэдээ болохыг онцолж бичсэн байдаг.

Ром ном сайнмэдээний яаралтай байдлыг дүрсэлдэг. Элч Паул сайнмэдээ бол авралын төлөөх Бурханы хүч мөн (Ром 1:16) гэжээ. Мөн тэрээр хүн бүрд сайнмэдээг хүргэхийн тулд өөрийгөө өртэй гэж хэлсэн (Ром 1:14). Биднийг уучилна гэсэн Бурханы амлалтад итгэснээрээ бид Бурханы өмнө зөвтгөгддөг хэмээх үнэнийг тэр заасан юм (Ром 3:26, Ром 5:1).

“Хойд зүгийн уудам тал нутагт би заримдаа нэг ч илгээлтийн эзэн байхгүй мянга мянган тосгоны утааг өглөөний наранд хардаг байж билээ. Тэдгээр тосгон Христгүй, Бурхангүй, энэ дэлхийд ямар ч итгэл найдваргүй юм.”  
- Роберт Моффат

Тэгээд Паул энэхүү яаралтай байдлын талаар “Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд тунхаглагчидгүйгээр яаж сонсох вэ?” хэмээжээ (Ром 10:14). Тэр цааш нь “итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17) гэж хэлсэн. Сонсогчдын дотор авралын итгэлийг бий болгохын тулд Бурхан сайнмэдээг ашигладаг. Сайнмэдээг номлох нь алдагдсан хүмүүсийг аврах Бурханы ердийн арга хэрэгсэл юм.

Хэрэв хүмүүс элчгүйгээр аврагдаж чадах юм бол элч яагаад тийм чухал байна вэ?

### **Илгээлтийн эзэд яагаад хэрэгтэй вэ?**

Энэ асуултад илгээлтийн эзэн Стив Хайт:

Энгийн хариулт бол хүмүүс гэрлийг харахдаа түүнээс татгалзсан. Иохан 1:9-д хүн бүрд гэрлийг өгдөг жинхэнэ гэрэл бол Есүс юм гэжээ. Паул, бүтээл нь Бурханыг таниулсан (Ром 1:19-20) бөгөөд тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан гэж Түүнийг алдаршуулсангүй (Ром 1:21). Иохан үүний талаар “тэрхүү ялалт ийм билээ... гэрэл ертөнцөд ирэхэд тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм” (Иохан 3:19) хэмээн дүгнэсэн байдаг. Хүний гажуудаж завхарсан зүрх сэтгэл харанхуйг илүүд үздэг. Үүний заль мэх, цагаандаа гарсан ёс бус байдлын улмаас нүгэлт зүрх сэтгэл нь Бурханаас эргэж нүүр буруулдаг (Иеремиа 17:9).

Тиймээс илгээлтийн эзэд гэрлийг дахин гартаа өргөх ёстой! Хоёр дахь боломжийг олгодог Бурхан харанхуйгаас гэрэлд хүмүүсийг авчрахын тулд сайнмэдээний бамбартайгаар Өөрийн элчин сайд нарыг илгээдэг (Үйлс 26:18).

Есүс дагалдагч нараа сайнмэдээг тунхаглуулахаар илгээхдээ, хэрэв аль нэг хот тэдний мэдээг хүлээж авахгүй бол хотоос гарахдаа хөлийнхөө тоосыг сэгсрэх хэрэгтэй гэж хэлсэн байдаг. Тэр тоос нь шүүлтийн өдөр тэдний эсрэг гэрч болно хэмээн айлджээ. Тэрхүү хөлийн тоос нь сайнмэдээний элч тэдний хотод очсоны нотолгоо юм. Сайнмэдээнээс татгалзагч хүмүүс үүнийг хэзээ ч сонсож байгаагүй хүмүүсээс долоон дор шүүлтийг амсах болно. Тэд Содомын хүмүүсийн шүүлтээс илүү хатуу шүүгдэнэ хэмээн Есүс айлдсан. Энэ нь сайнмэдээ үүнийг сонсдог хүмүүст асар их ашиг тус авчирдаг гэдгийг бидэнд хэлж байна (Марк 6:11).

Пастор Эрик Химелик *"Илгээлтийн эзэд яагаад хэрэгтэй вэ?"* гэсэн асуултад:

Сайнмэдээ нь харилцаагаар дамжин хамгийн үр дүнтэй хүрдэг учраас бид илгээлтийн эздийг илгээдэг. Сайнмэдээний үнэн бол Бурханы талаарх эзэн биегүй баримтуудын цуглуулга юм уу, хаа нэг сонирхдог шашны итгэл үнэмшлийн хайрцаг биш. Энэ нь Есүс Христ хэмээх бодгаль дотор биеллээ олсон юм. Илгээлтийн эзэд бол Христийн төлөө, Түүний сургаал ба эвлэрлийн үйлчлэлийн төлөөх (2 Коринт 5:20) элчин сайд нар билээ.

Сайнмэдээ нь шууд, харилцаагаар дамжин хүрэхгүй л бол ихэнх хүмүүс алдагдах болно. Тийм учраас илгээлтийн эзэд хэрэгтэй. Хүмүүс бидний идэвхигүй, үйлдэлгүй байдлаас болж алдагдаж байгаа гэдэгт бид итгэхийг хүсдэггүй. Харин Ром 10:13-15-д "Тэд тунхаглагчидгүйгээр яаж сонсох вэ?" гэж бичигджээ. Харамсалтай нь тэд сонсох боломжгүй юм. Илгээлтийн эздийг илгээж, дэмжих нь зайлшгүй хийх зүйл мөн. Биднийг дуудсан ажлаа Бурхан бидний төлөө хийнэ гэж найдах нь шийдэл биш юм. Бурхан бидэнд Агуу захирамжийг өгсөн. Хэнд ихийг өгнө, түүнээс ихийг шаардах болно. Бид Бурханы нигүүлслийн хариуд болон Бурхан Өөрийн агуу зүрх сэтгэл рүү хүмүүсийг татах ажлаа хийсээр байгаа гэдэгт итгэлтэй байж, илгээлтийн эздийг илгээдэг.

### **Сайнмэдээний практик ашиг тус**

Сайнмэдээ нь алдагдсан хүмүүсийг аврахын тулд Бурханы бүтээсэн үр дүнтэй арга хэрэгсэл юм. Хүнийг ч аврах Бурханы хүч мөн (Ром 1:16). "Хэрэв хүн сайнмэдээг сонсохгүйгээр аврагдах боломжтой юм бол бид яагаад илгээлтийн эздийг илгээх ёстой гэж? гэсэн асуултыг дахин авч үзье. Үүнтэй төстэй зарим асуултуудыг ч асуух нь зөв юм. Хэрэв хүн миний залбиралгүйгээр аврагдах боломжтой бол би яагаад түүний төлөө залбирах ёстой гэж? Хэрэв хүн сайнмэдээг нэгээс олон удаа сонсохгүйгээр аврагдах боломжтой бол бид яагаад түүнд дахин хэлэх ёстой гэж? Хэрэв хүн чуулгангүйгээр аврагдах боломжтой юм бол бид яагаад чуулгантай байх ёстой гэж? Эдгээрийн хариулт

2011 оноос хойш дэлхийн хүн ам 7 тэрбум гаруй болжээ. Өдөр бүр 153'000 гаруй хүн нас бардаг ч, дэлхийн хүн ам өдөр бүр 220'000-аар нэмэгддэг. Минут тутамд 100 гаруй хүн нас барж байна. Та энэ хичээлийг уншиж эхэлснээс хойш 1000 гаруй хүн нас барсан гэсэн үг. Тэдгээр хүмүүсийн хэд нь нас барахаасаа өмнө сайнмэдээг сонссон бол?

нь мэдээж, “Тийм ээ, тухайн хүн аврагдах боломжтой, гэхдээ энэ нь маш бага тохиолдоно.” Эдгээр нь хүмүүсийг аврахын тулд Бурханы бүтээсэн арга хэрэгсэл юм.

Бурханы Үг бол үл итгэгчдийг Бурханд авчрахын тулд Ариун Сүнсний ашигладаг багаж зэмсэг юм. Хүмүүс Бурханы Үгээр дахин төрдөг хэмээн Библид хүртэл бичсэн байдаг (1 Петр 1:23, 25).

Сайнмэдээг сонсолгүйгээр аврагдсан бараг ямар ч хүнтэй илгээлтийн эзэд таардаггүй. Бурхан зөв сэтгэлтэй хүнийг сайнмэдээгүйгээр ч аврах болно гэж үзэх нь Түүний шударга зөв байдлыг харуулж болох ч, энэ нь Түүний бүтээсэн энгийн арга замыг үл тоомсорлох бидний хандлагыг зөвтгөхгүй. Ер нь бол сайнмэдээг сонсдоггүй хүмүүс алдагдах болно. “Учир нь би сайнмэдээг эс тунхаглаваас золгүй еэ!” (1 Коринт 9:16).

► Нэг суралцагч Матай 9:35-38-ыг ангид уншина.

Есүс хүмүүсийн хэрэгцээг харахдаа маш ихээр энэрч өрөвддөг байсан. Тэрээр номлож заахдаа ч, эмчилж анагаахдаа ч завгүй нэгэн байсан.

Есүс хүмүүсийн сүнслэг хэрэгцээнд хамгийн их анхаарал тавьдаг байв. Хүмүүс гэмшиж, Бурханыг мэдээсэй хэмээн Тэр хүсэж байсан. Энэхүү эшлэлээс Есүс цугласан олныг хараад, тэдний сүнслэг хэрэгцээний төлөө асар ихээр өр нь өвдөж байсныг бид уншиж байна. Тэр тэднийг хоньчингүй хонь мэт байхыг харжээ. Мөн Тэрээр ургац хураалтыг үйлчлэлтэй зүйрлэж, ажилчид цөөн байгаад харамсаж байлаа.

Улмаар Есүс дагалдагчиддаа залбирахыг сануулсан. Бурхан ажилчдыг ургац хураалтад илгээхийн төлөө залбирахыг Тэрээр хүсжээ.

► Есүс дагалдагч нартаа яагаад энэ залбирлаар залбирахыг хэлсэн бэ? Бид залбирсан ч бай, үгүй ч бай Бурхан үүнийг хийхийг лавтайяа хүсдэг, тийм биш гэж үү?

Бурханаас ажилчдыг илгээхийн төлөө залбирах нь Бурханы хүслийн дагуух залбирал юм. Үүний улмаас Бурхан бидний залбиралд хариулна гэдгийг бид мэддэг.

Итгэгч хүмүүс энэ залбирлаар залбирах өөр нэг шалтгаан бий. Есүс дагалдагч нараа Түүн шиг өр нимгэн сэтгэлтэй байж, сайнмэдээг түгээх үүрэг даалгаврыг нь хуваалцахыг хүссэн. Хэрэв тэд энэ залбирлаар байнга залбирвал ургац хураалтын талаар маш их санаа тавьж эхлэх байв. Ингэснээр тэд энэхүү ажилд оролцохыг хүсэж, бусдыг ятгаж чадна.

Бид Есүсийн санаа тавьдаг байсан зүйлд санаа тавих учиртай. Түүний дагалдагч нараасаа асуусан залбирлаар бид залбирах үед энэ нь бидэнд ч үр нөлөөг авчрах юм.

### **Илгээлтийн эзэнд тохиолдсон түүх**

Илгээлтийн эзэд баг болон шоронд номлохоор явцгаажээ. Тэнд олон мянган хоригдол хоригдож байсан бөгөөд ихэнх нь алуурчид, террористууд байв. Илгээлтийн эзэд гадаа бэлтгэсэн тавцан дээр номлож байлаа. Тэрхүү тавцангийн эргэн тойронд илгээлтийн эздийг хамгаалахын тулд буутай харуулууд зогсдог байв. Сайнмэдээний номлолын



төгсгөлд номлогч хоригдлуудаас хэн нэг нь урагшаа гарч ирэн Шинэ гэрээг авмаар байна уу гэж асууж. 30 хүн урд гарч ирэв.

Хэдэн долоо хоногийн дараа илгээлтийн эзэд тус шоронд дахин очив. Цуглааны өмнө харгалзагчдын ахлагч тэдэнд хандан, Шинэ гэрээг авсан 30 хүн бусад хоригдлуудын гарт алагдсан гэж хэлжээ. Илгээлтийн эзэд сайнмэдээг дахин номлоод төгсгөлд нь урд гарч ирсэн хүн бүрд Шинэ гэрээ өгөхийг дахин санал болгов. Энэ удаа 300 хүн урагш гарч ирэв. Тэд өмнө нь 30 эрчүүд сайнмэдээг хүлээн авсныхаа төлөө амиа алдсан гэдгийг мэдэж байсан ч сайнмэдээ тэдний хувьд үнэ цэнтэй байсан тул амь насаа эрсдэлд оруулахад бэлэн байв. Тэд сонссон номлол сургаалынхаа үнэ цэнийг сайтар ухамсарлажээ.

### **3-р хичээлийн даалгаврууд**

(1) Дараах хоёр асуултад хэдэн өгүүлбэрээр хариулж бичнэ үү. Сайнмэдээг хэзээ ч сонсоогүй хүнд аврагдах боломж бий юу? Бид яагаад илгээлтийн эзэд болон сайнмэдээг тунхаглагчдыг илгээх ёстой вэ?

(2) Иона номыг уншина уу. Сайнмэдээг дамжуулах нэгэн яаралтай хэрэгцээтэй байгааг анзаарч байна уу? Энэхүү түүхэнд Бурхан юунд санаа тавьж байна вэ? Иона юунд санаа тавьсан бэ? Өөрийн ажиглалтуудаа 1-2 хуудаст багтаан бичнэ үү.



## 4-р хичээл

# Сайнмэдээний үндсэн ойлголтууд

### Ангийн удирдагчийн тэмдэглэл

*Ойлголт тус бүрийг тодотгосон Бичвэрийн эшлэлийг аль нэг суралцагч уншина. Дараа нь тухайн санааг тайлбарласан хэсгийг мөн нэг суралцагчаар уншуулна. Тэгээд хэлэлцэх асуулт бүрээр суралцагчдыг товч байдлаар яриулаарай.*

### Сайнмэдээний үндсэн ойлголтууд

Дараах санаанууд нь сайнмэдээний үндсэн ойлголт юм. Хэн нэгэн эдгээрийг бүрэн ойлгохгүйгээр итгэлд ирсэн байж болох юм. Гэсэн хэдий ч эдгээр ойлголтуудын аль нэгийг үгүйсгэх нь сайнмэдээний үндэс суурийг үгүй болгож байгаатай адил юм. Эдгээр үндсэн ойлголтын аль нэгийг үгүйсгэх аливаа хүн, байгууллага нь өөр сайнмэдээг дэлгэрүүлж, улмаар авралын худал хуурмаг арга хэрэгсэлд итгэл найдвараа тавьдаг.

Та хэн нэгэнтэй сайнмэдээг хуваалцах үед тухайн хүний аль хэдийн итгэсэн алдаатай итгэл үнэмшлээс болоод зарим санаа ойлголтууд нь маш онцгой чухал болж болох юм. Жишээлбэл, хэрэв тухайн хүн авралыг зөвхөн тодорхой нэг байгууллагаар дамжуулан хүлээн авдаг гэж үздэг бол тухайн байгууллагын гишүүнчлэлийн шаардлага нь авралд гарцаагүй шаардлагатай гэж итгэх боломжтой. Харин тэр хүний хувьд Бурхантай хувьчилсан шууд харилцаагаар дамжуулан, уучлалыг хүлээн авдаг гэдгийг мэдэх хэрэгтэй болж байна.

#### **(1) Бурхан эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй харилцахын тулд Өөрийн дүр төрхөөр бүтээжээ (Эхлэл 1:27, Үйлс 17:24-28).**

Энэхүү үнэн бидний оршин байгаа учир шалтгаан болон авралын зорилгыг тусган харуулдаг. Мөн энэ үнэн нь бодгаль шинж чанартай Бурханд итгэдэггүй шашнуудтай зөрчилддөг. Түүнчлэн энэхүү үнэн нь Бурхантай харилцдаггүй хүмүүсийн бодит асуудлыг ч харуулдаг.

► Хэрэв хүн Бурхан өөрт нь хайртай гэдэгт итгэдэггүй бол яах вэ?

#### **(2) Анхны хүмүүс нүгэл үйлдэж, Бурханаас тусгаарлагдсан (Эхлэл 3:3-6).**

Энэ нь нүглийн гарал үүсэл, дэлхий ертөнцийн нөхцөл байдлын жинхэнэ шалтгаан болдог. Дэлхий ертөнц бол нүглийн улмаас зовж шаналан буй газар юм. Бурханы бүтээлийн загвар ёсоор баяр хөөр, зорилго байсаар байгаа ч энэ дэлхий ертөнц нь Бурханы төлөвлөсөн шиг биш байгаа юм.

► Хэрэв хүн нүглийг дэлхийн ертөнцийн жинхэнэ асуудал гэж итгэдэггүй бол яах вэ?

**(3) Хүн бүр Бурханаас тусгаарлагдсан, Түүнд дуулгаваргүй байдалд төрдөг болсон (Ром 3:10, 23).**

Хүн бүр Бурханы эсрэг санаатай нүгэл үйлдсэн гэм буруутай. Үргэлж зөв зүйл хийдэг хүн гэж байдаггүй.

► Хүн хийсэн зүйлээ зөвтгөж чадна гэж бодож байвал яах вэ?

**(4) Өршөөл уучлалыг нь хүлээн аваагүй нүгэлтэн бүр Бурханаар шүүгдэж, мөнхийн шийтгэлийг авах болно (Еврей 9:27, Ром 14:12, Илчлэл 20:12).**

Энэ нь үл итгэгч хүний авралын хэрэгцээ ямар ноцтой бөгөөд яаралтай байдалд байгааг харуулдаг.

► Хэрэв хүн түүний нүглээс болж уурсан буй зөв шударга Бурхан байдаг гэж итгэдэггүй бол яах вэ?

**(5) Хүн Бурханы эсрэг үйлдсэн нүглээ цайруулахын тулд юу ч хийж чадахгүй (Ром 3:20, Ефес 2:4-9).**

Сайн үйлс хийж, бэлэг өгснөөр нүглийн төлөөсийг төлж чадахгүй. Учир нь нүгэл бол хязгааргүй Бурханы эсрэг тэрслэл бөгөөд аль хэдийн бүх зүйл Түүнд хамаатай болсон.

► Хэрэв хүн өөрийгөө өршөөгдөх зохистой болгож чадна гэж үзвэл яах вэ?

**(6) Бурхан зөв шударга бөгөөд нүгэл нь ноцтой зүйл учраас уучлах үндэслэл байх ёстой (Ром 3:25-26).**

Бурхан уучлахыг хүсдэг. Гэхдээ хэрэв Тэр нүглийг үндэслэлгүйгээр зүгээр л уучилсан бол энэ нь Бурхан шударга бус, нүгэл тийм ч ноцтой биш гэдгийг илтгэх байсан.

► Христийн үхэл яагаад зайлшгүй шаардлагатай байсан бэ?

**(7) Бурханы хүү Есүс нүгэлгүй амьдралаар амьдарч, бидний нүглийг уучлахын тулд золиос тахил болж үхсэн (Иохан 3:16, Ром 5:8-9).**

Есүс Бурханы хүү учраас Түүний золиос тахил нь хязгааргүй үнэ цэнтэй бөгөөд энэ дэлхийн хэнийг ч уучлах үндэслэл болдог. Хэрэв Тэр зүгээр л хүн байсан бол түүний золиос тахил нь хязгаарлагдмал үнэ цэнтэй байх байв. Есүсийн цус нь бидний төлөө өгсөн Түүний амийг төлөөлдөг. Түүний цусгүйгээр аврал байх боломжгүй (Еврей 9:22). Хэрэв Тэр Бурхан биш байсан бол биднийг бүрэн аварч чадахгүй байсан. Түүнчлэн бидэнд найдвар байхгүй бөгөөд авралын өөр арга замыг бид хайх байв.

► Яагаад зарим шашинд хүн үйлсээр аврагдах ёстой гэж үздэг вэ?

**(8) Есүс үхэгсдээс амилснаараа Бурханы хүү гэдгээ баталж, мөнх амийг өгөх хүчтэй болохоо харуулсан (Иохан 20:24-28, Илчлэл 1:18).**

Есүсийн амиллыг үгүйсгэдэг тэрс үзлүүдэд ихэвчлэн Түүний Бурхан чанарыг үгүйсгэж, авралын төлөөх тахил золиос нь хангалтгүй хэмээн сургадаг. Улмаар тэд авралын өөр арга замыг санаачилдаг.

► Есүс үхэгсдээс амилсан учраас бидний мэдэх ёстой зүйлс юу байж болох вэ?

**(9) Есүсийн золиос тахил нь бүх нүглийг уучлахад хангалттай юм (1 Иохан 1:9, 1 Иохан 2:2).**

Хэрэв хүн энэ үнэнийг үгүйсгэвэл үйлсээр аврагдах сайнмэдээнд итгэх болно. Олон шашинд хүн авралынхаа тодорхой хэсгийг өөрөө олж авах талаар номлодог. Энэ нь хүмүүсийг аврагдахын тулд юу хийх ёстойг нь хэлж өгдөг аливаа шашны байгууллагын хяналт дор оруулдаг.

► Яагаад зарим хүмүүс өөрсдийн шашны байгууллагагүйгээр аврагдахгүй гэж боддог вэ?

**(10) Нүгэлтэй гэдгээ хүлээн зөвшөөрч, гэмшиж, түүнийг уучлах амлалтад нь итгэдэг хүн бүрийг Бурхан уучлан өршөөдөг (Марк 1:15, 1 Иохан 1:9).**

Хүний бий болгосон ямар ч байгууллага авралын өөр арга замыг санал болгох, авралд тавигдах шаардлагад нэмэлт зүйл оруулах эрхгүй юм.

► Уучлагдаж өршөөгдсөн хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

**(11) Гэмшил гэдэг нь хүн нүгэл үйлдсэндээ харамсаж, нүглээ орхиход бэлэн байна гэсэн утгатай (Исаиа 55:7, Езекиел 18:30, Езекиел 33:9-16, Матай 3:8).**

Гэмшил гэдэг бол хүн Бурханы уучлалыг хүртэхээс өмнө зам мөрөө засан Бурханы өмнө өөрийгөө зөвт болгоно гэсэн үг биш. Зөвхөн Бурхан түүнийг нүглийн хүчнээс чөлөөлж чадна. Гэмшил гэдэг нь хүн өөрийнхөө нүглүүдэд ихэд харамсаж, тэдгээрийг орхиход бэлэн байгааг хэлнэ. Хэрэв хүн нүглээ орхих хүсэлгүй бол түүнийг уучлах боломжгүй. Хэрэв хүн санаатайгаар нүгэл үйлдсээр байвал тэр хүн гэмшээгүй хүн юм.

► Яагаад гэмших шаардлагатай вэ?

**(12) Гэмшиж, итгэсэн нүгэлтэн Бурханд залбирч, Түүний уучлалыг гуйх үедээ өршөөлийг хүлээн авдаг (Ром 10:13, Үйлс 2:21).**

Есүсийн улмаас хүн бүр Бурханы нигүүлслийг хүртэх боломжтой болсон. Хүн Бурханы уучлалыг хүлээн авахын тулд ямар ч байгууллага эсвэл хүн, зуучлагч хэрэггүй юм. Хүн үүнийг хувьчлан хүлээн авч, Бурхантай шууд харилцаж эхэлдэг.

► Хүн хормын дотор итгэлд ирж чадна гэдгийг бид яаж мэдэх вэ?

#### **4-р хичээлийн даалгаврууд**

(1) Эдгээр ойлголтуудаас нэг юм уу хоёр нь таныг итгэлд ирэх үед онцгой чухал байсан талаар хэдэн догол мөр болгон бичиж, тайлбарлана уу.

(2) Судалгаа хийхийн тулд христитгэлээс өөр нэг шашин эсвэл тэрс үзлийг сонгоорой. Тэд сайнмэдээний зарим чухал ойлголтыг хэрхэн үгүйсгэж байгааг 2-3 хуудсанд багтаан тайлбарлана уу. Тэдний номлодог хуурамч сайнмэдээг дүрсэлж, энэ нь хэрхэн буруу онол сургаал дээр үндэслэгдэж байгааг тодорхойл. Та тэдэнд үнэнийг Бичвэрийн нотолгоотойгоор тайлбарлана уу.

## 5-р хичээл

# Эвангелизм ба Сайнмэдээний тэргүүлэх чиглэл

### Танилцуулга

► Нэг суралцагч Ефес 1:4-9-ийг ангид уншина. Энэхүү багц эшлэлд ямар чухал онол сургаалыг заасан бэ?

### Эвангелизмыг тодорхойлох нь

Эвангелийн чуулган нь зөвхөн итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдах тухай Бичвэрийн сайнмэдээг заадаг. Христийн загалмайн ажил, эвлэрүүлэл дээр нэмсэн хүн төрөлхтний ямар ч сайн үйлс биднийг авралд хүргэж чадахгүй.

Сайнмэдээнд итгэдэг хүмүүс энэ нь юу юунаас илүү чухал гэдгийг мэддэг учраас жинхэнэ сайнмэдээг тунхаглах нь эвангелийн чуулгануудын тэргүүлэх чиглэл байдаг.

Сайнмэдээ нь Бурханаас чуулганд даатгагдсан онцгой эрдэнэс бөгөөд үүнийг чуулган дэлхийтэй хуваалцахыг эрмэлздэг.

Ихэнх эвангелийн чуулганууд дараах онцлог шинжийг агуулдаг. Үүнд:

- 1. Эвангелчүүд Библийн үнэмлэхүй эрх мэдэлд итгэдэг.** Библийн эрх мэдлийг үгүйсгэх нь сайнмэдээг эргэлзээтэй болгодог.
- 2. Эвангелчүүд христитгэлийн түүхэн, үндсэн онол сургаалд итгэдэг.** Эдгээр онол сургаалыг үгүйсгэх нь сайнмэдээтэй зөрчилдөхөд хүргэдэг. Жишээлбэл, Христийг Бурхан байгаагүй гэж үздэг тэрс сургаалд Түүний загалмайн ажил, эвлэрүүллийг үгүйсгэдэг. Ингэснээр тэд үйлсээр аврагдах сайнмэдээг зааж сургадаг.
- 3. Эвангелийн чуулганууд хувьчилсан сүнслэг туршлагыг онцолдог.** Энэ шинж чанар нь хүн ухамсартайгаар итгэх болон хувьчлан итгэлд ирдэг учраас оршин байгаа юм. Энэхүү итгэл үнэмшлийн улмаас эвангелчүүд үл итгэгчдэд сайнмэдээ түгээх болон итгэгчдийн сүнслэг төлөвшлийг чухалчилдаг.

► Танай чуулганд эдгээр шинж чанарууд хэрхэн харагддаг вэ? Сайнмэдээг нэн тэргүүнд тавьдаг гэдгийг харуулах өөр ямар шинж чанарууд байж болох вэ?

### Сайнмэдээнд төвлөрөх нь

Сайнмэдээ чуулганд үүрэг даалгаврыг нь тодруулж өгдөг. Сайнмэдээг нэн тэргүүнд тавьдаггүй чуулган Бурханы өгсөн үүрэг даалгаврыг умартдаг.

Бид Матай 28:18-20-д өгөгдсөн Агуу захирамжийг судалж байсан. Тэгвэл чуулганы үндсэн үүрэг даалгавар юу вэ?

Сайнмэдээ нь хаана ч үүнийг номлосоор байх чуулганыг бүтээдэг. Түүхийн туршид жинхэнэ чуулган нь сайнмэдээг номлодог газар байсаар иржээ. Элч нарын үеэс хойш чуулганд дамжин ирсэн өв нь институтийн тасралтгүй байдал бус, харин сайнмэдээг итгэмжтэйгээр тасралтгүй номлох явдал юм.

Чуулганы бий болгосон бүх институт сайнмэдээний тэргүүлэх чиглэлд үйлчлэх ёстой. Жишээлбэл, пасторуудыг бэлтгэх сургалтын хөтөлбөр нь тэдэнд сайнмэдээ тараах болон дагалдуулах чуулганы үүргээ биелүүлэхэд чуулганыг хандуулж, удирдахад бэлтгэх хэрэгтэй гэсэн үг.

Институтууд ихэвчлэн өөрсдөө оршин тогтнох хандлагатай байдаг бөгөөд анхдагч зорилго, үүрэг даалгавраа мартаж орхидог. Сайнмэдээг дахин онцлох нь институтийг шинэчлэгдэхэд үргэлж хөтөлдөг.

“Христ захирдаг, Христ Эзэн байх тухай ойлголт нь чуулганы дэлхийд хандсан үүрэг даалгавартай шууд холбоо хамааралтай. Энэ нь Матайн Сайнмэдээн дэх Агуу захирамжаас шууд харагддаг. Чухамдаа тэнгэр, газар дээрх бүх эрх мэдлийг Бурхан Эцэг Хүү Бурханд өгсөн учраас чуулган бүх үндэстнийг дагалдагч болгох үүрэгтэй.”

- Ж. Херберт Кане,  
“Сайнмэдээний ажил”

Чуулган итгэл үнэмшил, мөргөл хүндэтгэлийн хэлбэр, христитгэлийн амьдрал, чуулганы бодлого зэрэг уламжлалуудыг хөгжүүлдэг. Харин уламжлалаа шинэчлэхийн тулд сайнмэдээг ахин дахин онцлох нь чухал юм.

## **Сайнмэдээг нэн тэргүүнд тавьдаггүй жишээнүүд**

### **Жишээ 1**

Чуулган сайнмэдээг түгээх үүрэг даалгавраа биелүүлэхээр ажиллаж байгаа тул төлөвлөгөө гаргах, баг бүрдүүлэх, хөтөлбөр боловсруулах, дэмжлэг олох шаардлагатай болдог. Эдгээр практик зорилгод үйлчлэх институтуудыг чуулган бүрдүүлдэг. Ихэвчлэн ийм байгууллагууд нь чуулган үүрэг даалгавраа биелүүлэхээр хөдөлгөгдөж, хүмүүс өөрсдийгөө зориулж эхлэх сүнслэг сэргэлтийн үед үүсч бий болдог.

Байгууллага, бүтцүүд шаардлагатай. Институт гэдэг нь энгийнээр хүмүүс ба нөөцийг урт удаан хугацаанд зохион байгуулалтад оруулахыг хэлдэг. Бүтэц байгууллагагүйгээр чуулганы барилга байгууламж, гадаад илгээлт, Библи болон бусад утга зохиол хэвлэлийн ажлууд, христитгэлийн сургуулиуд, боловсролын хөтөлбөрүүд, үйлчлэлийг дэмжих санхүүгийн дэмжлэг зэрэг нь ч байхгүй байх байсан. Орон нутгийн чуулган ч гэсэн институт бөгөөд хэсэг бүлэг хүмүүс үүнийгээ авч явж, зориулалт гаргахгүй л бол оршин тогтнох боломжгүй юм.

Хэрэв институт нь амжилттай байвал магадгүй олон хүнтэй, их төсөвтэй болж болох юм. Харин ийм институтийг удаан авч явахын тулд маш их хүчин чармайлт, зардал шаардагдана. Заримдаа тухайн байгууллагад ажиллаж буй хүмүүс институт байгуулах нь үндсэн зорилго гэж мэдэрч эхэлдэг. Тэд байгууллагынхаа анхны эрхэм зорилго үүрэг даалгаврыг биелүүлэхээс илүүтэй институтийг үргэлжлүүлэн авч явах гэж боддог.



Хэдийгээр институт шаардлагатай ч сайнмэдээний ач холбогдлын дагуу тэдгээрийг байнга үнэлж, шинэчилж байх ёстой юм.

## **Жишээ 2**

Үйлчлэл хийхэд мөнгө олох бололцоо байдаг тул зарим хүмүүс үйлчлэлийг бизнес байдлаар эхлүүлдэг. Үйлчлэлийн зардалд нэмэр болохын тулд алив зүйлийг зарах нь буруу биш бөгөөд үйлчлэлдээ санхүүгийн дэмжлэг хайх нь ч буруу зүйл биш юм. Гэхдээ тухайн хүн сайнмэдээг нэн тэргүүнд тавихаас илүүтэй мөнгөөр сэдэлжиж байвал түүний зүрх сэтгэл нь буруу бөгөөд ажил нь Бурханд таалагдахгүй (1 Петр 5:1-2, 2 Петр 2:3).

Симон байр суурьтай болж, ашиг орлого олохын тулд сүнслэг бэлгийг хүссэн боловч түүний зүрх сэтгэл буруу байсныг элч түүнд хэлсэн юм (Үйлс 8:18-23).

► Чуулганаа худалдахыг оролдох пасторын нөхцөл байдал яагаад буруу вэ? Чуулган гэж яг юу болох талаарх түүний ойлголт яагаад буруу байна вэ?

## **Жишээ 3**

Синкретизм бол христитгэлийг өөр шашны эсрэг тэсрэг итгэл үнэмшил, зан үйлтэй холих явдал юм. Шинэ гэрээний үеийн синкретизмийн жишээ бол самаричуудын шашин шүтлэг юм. Шүтээн шүтэж байсан харь үндэстнүүд Израилын нутаг дэвсгэрт нүүн ирснээр Израилын шашныг өөрсдийн шүтээнтэй хольж орхисон. Есүс тэд юуг мөргөн хүндэлдэг гэдгээ мэддэггүй гэж хэлсэн байдаг (Иохан 4:22).

Синкретизмийн өөр нэг жишээ бол Гаити улсын түүх юм. Гаити Францын колони байх үед Африк гаралтай боолуудыг христитгэлд орохыг тулган шаарддаг байв. Тэд хуучин шашнаа Ромын Католик шашинтай хольсон. Өнөөдөр олон гаитичууд сүнснүүдийг шүтдэг Вуду зан үйлээ хийсээр байгаа ч христитгэлийн бэлгэдэл тэмдэг зүүж, ариун хүмүүсийн нэрсийг хэрэглэсээр байна.

Заримдаа синкретизм нь христитгэл давамгайлж байсан үндэстнүүдтэй холбогдох нь ч бий. Хүмүүс ноёлж буй үндэстэнд таалагдахын тулд шашных нь зан заншлыг хүлээн зөвшөөрдөг ч, өөрсдийн анхны итгэл үнэмшлээ хадгалсаар байдаг.

► Христитгэл болон бусад шашин хоорондоо холилдсон ямар жишээг та мэдэх вэ?

Дэлхийлэг сэдэл нь синкретизм үүсгэх боломжтой. Хэрэв хүмүүс сайнмэдээг хүлээн авснаар санхүүгийн ашиг орлого, улс төрийн нөлөө, эсвэл нөлөө бүхий хүмүүсийн тааллыг олох зэрэг ашиг тустай гэж боддог бол итгэлд жинхэнээр ирэлгүй, харин христитгэлийн харагдах байдал өнгөн талыг л хүлээн зөвшөөрдөг байж болох юм. Улмаар тэд хуучин итгэл үнэмшил, дадал зуршлаа дагасаар байгаа ч христитгэлийн нэрээр тэднийг дууддаг. Хүмүүсийг буруу сэдлээр хариу үйлдэл үзүүлэхэд хүргэдэг алив зүйлсийг санал болгохгүй байх нь чуулганы сайнмэдээ тараалтад хамгийн үр дүнтэй.

Сайнмэдээг гадаадын илгээлтийн эзэд авчрах үед христитгэл нь харийн шашин мэт санагдаж магадгүй юм. Тийм ч учраас христитгэлийг нутаг орон, соёлдоо шингээж, өөриймсүүлэх нь маш чухал. Энэ нь цаашид харийн шашин шиг харагдах учиргүй. Нөгөөтэйгүүр илгээлтийн эзэд болон сайнмэдээг тунхаглагчид нь тухайн соёлын ямар нарийн ширийн зүйлс христитгэлтэй нийцэхгүй байгааг олж мэдэх хэрэгтэй. Энэхүү ялгааг таних нь хугацаа шаардсан, мөн орон нутгийн итгэгчдийн тусламжтайгаар хийгдэх ёстой үйл явц юм.

#### **Жишээ 4**

Зарим тохиолдолд шашин нь тухайн үндэстний уламжлалт шашин гэж тооцогддог. Жишээлбэл, зарим үндэстний хүмүүсийн ихэнх нь муслим шашинтай байдаг. Өөр зарим үндэстний хувьд ихэнх хүн ам нь өөрсдийгөө Ромын католик шашинтай гэж үздэг. Ихэнх хүмүүсийн хувьд өөрсдийн шашны ёс суртахууны хэм хэмжээг яг дагаж мөрддөггүй. Зөвхөн хаа нэг шашны зан заншил байдлаар хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч тэд өөрсдийгөө энэхүү шашныг дагагчид гэж ярьдаг.

Олон хүмүүсийн хувьд тэдний нийгмийн харилцаа хүрээлэлд байгаа бүх сайн хүмүүсийг итгэгчид гэж үздэг учраас өөрсдийгөө Христэд итгэгч гэж дуудах нь бий. Гэхдээ тэд жинхэнээсээ гэмшээгүй хүмүүс юм. Тэд өөрсдийнхөө ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдсөөр байдаг.

Сайнмэдээ бол гэмшиж, Христэд захирагдах дуудлага юм. Хэрэв хүн өөртөө төвлөрсөн аминч байдлаа үхүүлж, жинхэнэ дагалдагч болохгүй л бол Түүний дагалдагч байж чадахгүй хэмээн Есүс өгүүлсэн байдаг (Лук 9:23).

Нүгэлт нийгэмд алдар нэртэй байхын тулд христитгэлийн нэрийг зүүж болохгүй. Нийгмийн хэвийн ёс суртахуун нь христитгэлийн ёс суртахуунаас ямагт доогуур байдаг тул Христэд итгэгч нь ертөнцтэй зөрчилддөг.

► Гэмшилгүй хэдий ч алдар нэртэй христитгэл танай нийгэмд хэрхэн илэрч байна вэ?

#### **Жишээ 5**

Бүх итгэгчид бүх онол сургаал дээр санал нэгдэнэ гэж бид хүлээх хэрэггүй юм. Хэдийгээр тэд Библийг онол сургаалын эрх мэдэл гэж хүлээн зөвшөөрдөг ч итгэгчдийн хооронд ялгаа байдаг.

Заримдаа чуулганууд өөр бусад чуулгануудаас тэднийг ялгах онол сургаал дээрээ ихээхэн анхаардаг. Гэтэл тэдгээр сургаал нь христитгэлийн үндсэн онол сургаалтай адил хэмжээнд чухал биш байдаг. Хэрэв тэдгээр чуулганууд үндсэн сайнмэдээг заадаг л бол бусад чуулгануудыг жинхэнэ христитгэлтэй биш гэж хэлж болохгүй.

Чуулган бусад чуулгантайгаа тэмцэлдэж, өөрийн дүр төрхийг тогтоох ёсгүй. Энэ нь эхлээд сайнмэдээгээр, дараа нь чуулгандаа өөрийгөө зориулдаг гишүүдийн нөхөрлөлөөр батжих учиртай.

► Чуулган ямар үндэслэлээр бусад чуулганыг жинхэнэ христитгэлт гэж хүлээн зөвшөөрөх ёстой вэ?

### **Жишээ 6**

Үнэн зөв сургаалыг бусад үнэнтэй зөрчилдөхүйц хэмжээнд онцлох ч боломжтой. Чуулган нигүүлслийг онцолсноор Бурханд дуулгавартай байх хэрэгцээг багасгаж байж ч болох. Түүнчлэн чуулган итгэлд ирэх агшинг онцлохдоо дагалдагч болох үйл явцыг умартах ч боломжтой. Итгэлээсээ няцсан нэгэнд Бурханы итгэмжит байдлыг онцлохдоо чуулган итгэлээсээ урвах аюулыг сэрэмжлүүлэлгүй өнгөрөөж ч болно. Сүнслэг бэлгүүдийг өргөмжлөхдөө чуулган гүн гүнзгий сүнслэг байдал болон христитгэлийн зан чанарыг үл тоомсорлож магадгүй юм.

Онол сургаалын тэнцвэргүй байдал нь цаг хугацааны явцад илэрч, урт хугацааны үр дагаврыг бий болгодог. (1) Нүглийн талаар хайхрамжгүй хандах, (2) авралын баталгааг үгүйсгэх, (3) сайнмэдээнд хариу үйлдэхийг хүсэж буй хүний замд нэмэлт бэрхшээл учруулах, эсвэл (4) сайнмэдээг нуун дарагдуулах зэрэг аливаа сургаал нь тэнцвэргүй онол сургаал юм.

### **Түүхэн сэргэн мандалт ба шинэчлэлүүд**

Чуулганы түүхээс сайнмэдээг хамгийн их орхигдуулж байсан цаг үе нь агуу том институт байгууллагууд хөгжин цэцэглэж байсан үе мэт харагддаг. Бүтэц, байгууллагажих хөдөлгөөн, синкретизм, онол сургаалын тэнцвэргүй байдал зэрэг алдаа завхрал нь сайнмэдээнээс илүүтэй энэ үед дэлгэрсэн байдаг. Удирдагчид нь сүнслэг үлгэр жишээ үзүүлэхийн оронд буруу сэдэл, буруу зан чанар, ертөнцийн юмсыг илүү сонирхох хандлагыг харуулсан мэт санагддаг.

Бурхан чуулганд хандсан агуу сэргэлтүүдийг зарим үед авчирч байсан. Урт хугацаанд үргэлжлэх, өргөн цар хүрээтэй сэргэн мандалт нь гурван талбарыг хамарч байв.

1. Үл тоомсорлож байсан сүнслэг үнэнүүд сэргээгдэх үед буюу теологийн шинэчлэл явагддаг.
2. Сүнслэг сэргээлт бий болдог. Энэ тохиолдолд хүмүүс маш ихээр залбирч, чин сэтгэлээсээ мөргөн хүндэтгэж, үлэмж тооны хүмүүс итгэлд ирцгээдэг.
3. Чуулган сайнмэдээг тараах, дагалдагч бэлтгэх шинэ арга замуудыг олдог тул үйлчлэлийн шинэ арга барилууд бий болдог.

Протестант шинэчлэл (НТ 1500-аад оны үед Европыг хамарсан) нь зөвхөн итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдах авралын сайнмэдээг сэргээсэн. Мянга мянган хүмүүс итгэлд ирж байлаа. Бичвэрийг нийтлэг хэлүүд рүү орчуулж, олны хүртээл болгосон.

Анабаптистуудын (1500-аад оны үед болон хожуу Европ даяар) санааг Шинэчлэлийн үр дүнд бий болсон олон тооны дагагч нарын итгэл зовоож байв. Тэд зөв онол сургаалд итгэх нь л авралд хангалттай хэмээн заалгаж байлаа. Олон хүмүүс сайнмэдээний

үнэнийг хүлээн зөвшөөрч байна гэж хэлдэг ч тэд итгэлд ирэх туршлагыг амсаагүй байсан. Анабаптистууд хувьчлан итгэлд ирэхийг онцолдог байв.

Пиетистүүд (1600-аад оны сүүл үе, Германд) дагалдагч байхын чухлыг ойлгосон хүмүүс байжээ. Тэд Христэд итгэгчдийг сургаж төлөвшүүлэхийн тулд жижиг бүлгийн үйлчлэл болон тогтолцоог боловсруулсан юм.

Методист сэргэн мандалт (1700-аад оны сүүл үе, Англид) Жон Веслейн үйлчлэлээс эхэлсэн. Тухайн цаг үед Английн чуулганы ихэнх санваартнууд хүн авралын баталгаагаа хувьчилан мэдэх боломжгүй гэж үздэг байв. Харин Веслей хүн бүр Христ дотор амьд итгэлтэй байгаагаар болон Ариун Сүнснээс авралын баталгааг хүлээн авч мэдэх боломжтой гэж номлож байлаа.

► Та нийгэмдээ ямар агуу үнэнийг онцлох хэрэгтэй вэ?

### **Дүгнэлт**

Христитгэлт том, жижиг (орон нутгийн чуулгануудыг оролцуулаад) олон институтууд сайнмэдээг нэн тэргүүнд тавьж үйлчлэлээ эхлүүлдэг. Харин цаг хугацаа өнгөрөхөд тэдний олонх нь энэхүү тэргүүлэх чиглэлээс холдон одсон байдаг.

Чуулганы үр нөлөөтэй байдлыг шинэчлэхийн тулд бидэнд сонин хачин шинэ сургаал эсвэл шинэ илчлэлт хэрэггүй юм. Бидэнд хэрэгтэй тэр зүйл бол сайнмэдээг нэн тэргүүнд тавьдаг эвангелийн зарчмаа сэргээх явдал юм.

### **5-р хичээлийн даалгавар**

Та дараагийн хичээлээ 5-р хичээлийн сорилоор эхлэх болно. Сорилын асуултуудын дагуу сайтар судалж бэлдээрэй.

### **5-р хичээлийн сорил**

- (1) Эвангелийн чуулгануудыг тодорхойлох гурван шинж чанар юу вэ?
- (2) Чуулган сайнмэдээний тэргүүлэх чиглэлийг алдаж болох зургаан байдал юу вэ?
- (3) Онол сургаал тэнцвэргүй байгааг илтгэх дөрвөн шинж тэмдэг юу вэ?
- (4) Урт удаан үргэлжлэх сэргэн мандалтын гурван талбар юу вэ?
- (5) Дараах шинэчлэгчдийн талаар мэддэг зүйлээ бичнэ үү?
  - Протестант шинэчлэл
  - Анабаптистууд
  - Пиетистүүд
  - Методист сэргэн мандалт

## 6-р хичээл

### Ариун Сүнсний ажил

#### Ангийн удирдагчийн тэмдэглэл

*Суралцагч өмнөх хичээлийн сорилыг өгөх ба сорилын явцад хичээлийн материал харах эсвэл өөр хоорондоо ярилцах боломжгүй.*

#### Ариун Сүнсэнд түшиглэх нь

Бид үйлчлэлийн сургалтыг хүлээн авч, үйлчлэх арга барилд суралцахаар хичээж зүтгэхдээ хүний өөрийн ур чадвартаа түшиглэх хандлага гаргадаг нь аюултай зүйл юм. Энэ талаар элч Паул “Бид чухамхүү аливааг өөрсдөөсөө мэт зүтгэж чадахгүй ч бидний чадвар Бурханаас юм” (2 Коринт 3:5) гэж хэлжээ.

Паул Бурханы Үгийг заахдаа өөрийн мэргэн ухаан, чадварт бус, харин Ариун Сүнсний илчлэх илчлэлтэд бүрэн найдаж байсан бөгөөд сонсогчид нь хүний мэргэн ухаанд түшиглэлгүй, Бурханы мэргэн ухаанд найдаасай хэмээн тэрээр хүсэж байв (1 Коринт 2:4-5). Паул өндөр боловсролтой хүн байсан хэдий ч өөрийнхөө мэдлэг, чадвараар сүнслэг үр нөлөөг бий болгоно гэж үзээгүй юм.

Паул Тесалоник дахь чуулганд бичсэн захидалдаа, “бидний сайнмэдээ та нарт зөвхөн үгээр бус, мөн хүч ба Ариун Сүнс дор бүрэн баталгаагаар очсон” (1 Тесалоник 1:5) хэмээн өгүүлж, Бурханы хүч дотор, сайнмэдээний үгээр тэднийг ятгасан байна.

Есүс элч нарт Ариун Сүнсний талаар айлдахдаа “Тэр ирэхдээ нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг зэмлэнэ” (Иохан 16:8). Есүс “Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над руу ирж чадахгүй (Иохан 6:44) гэжээ.

#### Ариун Сүнсний ажил ба зарим шинж чанар

- Тэр үл итгэгч нүгэлтнийг зэмлэдэг (Иохан 16:8).
- Тэр нүгэл дотроо үхсэн хүмүүнд амь өгдөг (Иохан 3:5, Ефес 2:1).
- Тэр итгэгчдийг сүнсээр тамгалдаг (Ефес 1:13, Ефес 4:30).
- Тэр үүрэг даалгавар өгдөг (Үйлс 13:2, 4).
- Тэр үүрэг даалгавраа биелүүлэхэд нь итгэгч хүнд тусалдаг (Үйлс 1:8).
- Тэр заадаг (Иохан 14:26, Иохан 16:13; 1 Иохан 2:27).
- Тэр удирддаг (Галат 5:25).
- Тэр махан биеийн үйлсээ үхүүлэхэд нь итгэгч хүнд тусалдаг (Ром 8:13).

► Сайнмэдээ тараахдаа Ариун Сүнсний тусламжид хэрхэн найдах вэ? Бид Ариун Сүнсэнд найдан юуг өөрөөр хийдэг вэ?

## Сургалтын үнэ цэн

► Сайнмэдээ тараах сургалт ба арга барилын тухай бид юуг бодож үзэх хэрэгтэй вэ?

Бид Бурханы үнэнийг хүмүүст дамжуулахаар дуудагдсан. Тиймээс бид сайнмэдээг хамгийн ойлгомжтойгоор дамжуулах ёстой.

Бид Ариун Сүнсэнд найдаж байгаа учраас өөрсдийн чадвараа хөгжүүлэх шаардлагагүй гэж бодож болохгүй.

Паул “хүмүүсийг ятгахыг хичээдэг” гэж хэлсэн байна (2 Коринт 5:11). Тэр Тимотод бичсэн захидалдаа Бурханы үнэнийг бусдад зөв дамжуулах чадварт суралцаарай гэж захисан (2 Тимот 2:15). Эзэний зарцад байх ёстой чадвар бол заах чадвар юм (2 Тимот 2:24).

Апол сайнмэдээг маш үр дүнтэйгээр тарааж байсан. Түүнийг уран цэцэн үгтэй, Бичвэрийг сайн мэддэг, гал цогтой Сүнстэй гэж Библид дүрсэлсэн байна (Үйлс 18:25-26). Аполын төрөлх чадвар нь сүнслэг бэлэг авьяастай нь хоршиж, түүнийг бусдын төлөөх агуу ерөөл болгосон юм.

Элч Петр сайнмэдээний найдварыг бусдад дамжуулахын тулд үргэлж бэлэн бай гэсэн юм (1 Петр 3:15).

Хэрвээ бид Түүний зорилгын төлөө итгэмжтэй байх аваас Бурхан бидний төрөлх чадвар болон олж авсан мэдлэгийг ашиглаж ерөөх болно гэдгийг Бичвэрийн эдгээр үгээс харж болно. Бид хүч чадал, авьяас чадвараа Түүний төлөө ашиглахаар дуудагдсан.

## Ариун Сүнсний дүүргэлт

Үйлс 1:4-5-д Есүс дагалдагчдадаа “Эцэгийн амласан” Ариун Сүнсний баптисмыг хүлээх тухай хэлжээ. Үүнд дагалдагчид Ариун Сүнсийг хүлээн аваад дэлхий даяар Бурханыг гэрчлэх ажил багтана (Үйлс 1:8). Хэдийгээр дагалдагчид Христийн дотор өөрчлөгдсөн ч Есүсийг махан биеэр өөрсөдтэй нь хамт байхгүй үед сайнмэдээ тараах үйлчлэлд бэлэн байхын тулд эхлээд шийдвэрлэгдэх хэрэгтэй дотоод хэрэгцээ тэдэнд байжээ. Тэд Агуу Багшаар гурван жилийн туршид сургагдсан ч тэдний дотор асуудал байсаар байсан тул бүрэн бэлэн болоогүй байв. Бурханы төлөвлөгөөний дагуу Ариун Сүнсээр удирдуулан үйлчлэхийн өмнө Ариун Сүнсний онцгой ажлаар дамжуулан хангагдах шаардлагатай хэрэгцээ тэдний зүрх сэтгэлд байсан юм.

“Дагалдагчдад өгөгдсөн Эзэний Агуу захирамж нь хүний хүчээс давсан зүйл боловч, Ариун Сүнсний хязгааргүй хүчээр үүнийг биелүүлэх боломж тэдэнд өгөгдсөн юм. Тэр ирээд нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг зэмлэн, агуу хүч чадал гайхамшигт үр дүнтэйгээр тэдэнтэй хамтран ажилласан юм.”

- А.Б. Симпсон  
Илгээлтийн сургаал

Энэ асуудал гурван жилийн сургалтын явцад янз бүрийн үйл явдлаар илэрч байв. Зарим үед дагалдагч нар өөрсдийг нь хүлээн аваагүй хүмүүст хонзогнон, тэдний дээр гал буулгахыг хүсэж байсан удаатай (Лук 9:54-55). Тэдний зөвшөөрөлгүй сайнмэдээ

тараасан хүнийг хориглон, фарисайн бүлэглэлийн гишүүн мэт бардам авирлаж байв (Марк 9:38).

Тэд заримдаа хувиа хичээсэн бардам зан гаргаж, бусдаас илүү байр суурь хүсэж дундаа хагарал үүсгэж байв (Марк 10:35-41).

Тэд хэн нь хамгийн агуу нь болох талаар ч хоорондоо маргалддаг байв (Марк 9:33-34). Есүс тэднээс юуны талаар маргалдаж байгааг асуухад тэд дуугүй байж, тэдний маргаан зохисгүй байсныг ухамсарласан юм. Оройн зоогийн үеэр Есүс дагалдагчдынхаа хөлийг угаан бие биедээ ийнхүү үйлчлэхийг Өөрөө үлгэрлэжээ (Иохан 13:14). Тэр орой дагалдагчид Есүсийн заасанчлан бие биедээ даруу зангаар үйлчлэхээс татгалзсан нь мэдлэг дутсанаас бус харин бардам байсных юм.

Нөхдийнхөө төлөө амиа зориулах халуун хайраар бие биеэ хайрлаарай гэж Есүс тэдэнд сургасан (Иохан 15:12-13). Тэд “бидэнд бие биеэ халуунаар хайрлах хайр бий” гэж бодоцгоосон ч үнэндээ тэдэнд хайр байсангүй. Учир нь тэд үхэл хүртэл Есүстэй хамт байхаа амлаж байсан ч Есүсийг баривчлагдах үед бүгд зугтаасан юм (Марк 14:31, 50).

Эдгээр эрчүүд Есүсийг махан биеэр хамт байхгүй үед ч чуулганаа өргөжүүлж, удирдаж чадах хариуцлага бүхий эрчүүд байлаа. Тэдний дотоод хэрэгцээ хангагдах хүртэл тэд сайнмэдээг дэлхийн хязгаар хүртэл түгээх үйлчлэлд бэлэн бус байсныг Есүс мэдэж байсан учраас Эцэгийн амласныг авах хүртлээ Йерусалимд хүлээ гэж тушаасан (Үйлс 1:4-5). Энэхүү амлалт нь Ариун Сүнсний баптисм юм. Ариун Сүнсний баптисм үгүй бол тэд чуулганаа байгуулж өргөжүүлэх боломжгүй байв.

Есүс дагалдагч нартаа илүү удаан хугацааны сургалт, өсөлтийн үйл явц хэрэгтэй гэж хэлээгүй. Дагалдагчид Йерусалимд сүнслэг хямрал/оргил цаг мөчийг хүлээж байлаа.

Пентэкостын өдөр дагалдагчид Ариун Сүнснийг хүлээн авсан тухай Библид (Үйлс 2:4) дүрсэлжээ. Ариун Сүнс буун ирэх үеэр олон үйл явдал тохиолдсон ч хожим нь Петр Ариун Сүнсний гол ажлыг тэдний болон бидний зүрхийг ариусгах явдал хэмээн онцолжээ (Үйлс 15:8-9). Дагалдагч нарт зүрх сэтгэлээ ариусгах хэрэгцээ байсан. Тэдний дотоод хэрэгцээний бүх шинжүүд зүрх сэтгэлд нь буй завхрал ариусгагдах хэрэгтэй гэдгийг зааж байсан. Ариун Сүнсний дүүргэлт тэдний зүрх сэтгэлийг ариусгах үед тэд өөрсдийн гол зорилго болох амар амгалан байдал, алдар нэр хөөцөлдөх сэтгэлээ хойш тавьсан юм.

Пентэкостын өдрийн үйл явдал нь чуулганыг дэлхийн өнцөг булан бүрд сайнмэдээг хүчирхэгээр дамжуулах эрин үе рүү хөтөлсөн юм. Чуулган онол сургаалын зөрчил, иудейн хуулийг баримтлагч тэрс үзэл, дотоод гомдол зөрөлдөөн, хуурмаг байдал, чөтгөрийн явуулга, хавчлага, хүнд бэрхийг баяр хөөр ялалтын уухайтайгаар даван урагшилсаар байжээ.

Тэд Бурханы дуудлагыг дагаж,  
Бурханы хүчинд түшиглэсэн,  
Бурханы алдрын төлөө үйлчилдэг,  
эв нэгдэлтэй, тослогдсон хүчирхэг  
гэрч нарын баг байлаа.

**Өнөөгийн чуулганы итгэгчдэд Есүсийн дагалдагч нарт байсантай адилхан хэрэгцээ гарч болно. Энэ хэрэгцээ нь Ариун Сүнсний тусламжаар дамжуулан хангагдах боломжтой.**

Гэхдээ энэ нь:

1. Ариун Сүнсний онцгой дүүргэлтийг хүлээн авах хүртэл итгэгчдэд Ариун Сүнс байхгүй гэсэн үг биш.
2. Ариун Сүнс дүүрэх хүртэл ямарваа итгэгчийн амьдралд Ариун сүнсний ажлууд явагдаагүй гэсэн үг биш.
3. Зүрх сэтгэлийг цэвэрлэдэг Ариун Сүнсний дүүргэлтээс өөр тусгай дүүргэлт гэж байхгүй.
4. Ариун Сүнсээр дүүрсэн бүх хүнд элчийн үйлчлэл ирсэн гэсэн үг биш.

Бидний амьдралын туршлага Есүсийн дагалдагч нарын амьдралын туршлагатай яг ижил гэж бодож болохгүй. Гэхдээ зүрх сэтгэлийн ариусгал болон Бурханд үйлчлэх үйлчлэлд Ариун Сүнсний дэмжлэг оролцоо одоо ч бидэнд хэрэгтэй.

Дагалдагчдаас бид дараах жишээг харж болно.

1. Хэрэв энэ хэрэгцээ хэн нэгэнд байгаа бол тэр хүн үйлчлэл болон ариун амьдралд бүрэн бэлтгэгдээгүй байна.
2. Бурхан хүнийг асуудал дунд нь орхидоггүй.
3. Сургалт болон удаан хугацааны сүнслэг өсөлт нь асуудлын шийдэл биш.
4. Зөв эрэл хайгуулын дүнд хэрэгцээ хормын төдийд ч хангагдах боломжтой.

Итгэгчид Ариун Сүнсний ажлыг хэрхэн хүлээн авч болох вэ?

Петр “зөвхөн итгэлээр” хүлээн авах боломжтой гэжээ (Үйлс 15:8-9). Есүс амлалт ба найдварыг дагалдагч нарт өгсөн тул тэд Түүнд итгэж найдсан юм.

Тиймээс хэрэв хүн өөрийнхөө хэрэгцээг болон үүнд нь хандсан Бурханы хүслийг олж харвал энэхүү нигүүлслийг тэрээр итгэлээр авч чадах юм.



## **6-р хичээлийн даалгавар**

Суралцагч бүр өөрсдийгөө залбирал дотор шалган, эдгээр асуултад хариулна. Хариултаа ангийн удирдагчид хураалгахгүй байж болно.

- Би Ариун Сүнсэнд найдаж аливаа зүйлийг хийж байна уу, эсвэл өөрийн чадварт тулгуурлан хийхийг хичээж байна уу?
- Дагалдагчид Ариун Сүнсээр дүүрэх шаардлагатай байсныг харуулсан тийм адил шинж байдлууд надад байдаг уу?
- Надад Бурханаар удирдуулахыг хүсэхгүй байгаа үйлдэл, зуршил, хандлага, зорилго байгаа юу?
- Бурханы алдрын төлөө хэрэглэгдэхийн тулд Ариун Сүнсэнд өөрийгөө бүрэн даатгаж, цэвэрлэгдэх хүсэл надад байгаа юу?



# 7-р хичээл

## Залбирал ба мацаг барих нь

### Танилцуулга

Өнөөгийн чуулганд сайн бүтэц зохион байгуулалт, барилга байгууламж, шилдэг арга барил бус харин Ариун Сүнсээр удирдуулдаг хүчирхэг залбиралтай хүмүүс хамгийн чухал байна. Ариун Сүнс сайн арга барил, бүтэц зохион байгуулалтаар бус хүнээр дамжуулан ажилладаг. Тэр төхөөрөмжөөр бус хүнээр ажилладаг. Тэрбээр төлөвлөгөөг бус хүмүүсийг, тэр дундаа залбирлын хүмүүсийг тослон ерөөдөг.<sup>2</sup>

► И. М. Баундс дээрх мэдэгдлээр ямар алдааг залруулахыг хичээж байна вэ?

Залбирах үйл нь Бурханаас хамааралтай байгааг харуулдаг. Залбирах завгүй хүмүүс өөрсдийнхөө ажлыг залбиралд нь хариулдаг Бурханы ажлаас илүү чухал гэж боддог.

Харин бид Ариун Сүнснээс хамааралтай учраас бидний хувьд залбирал чухал. Тиймдээ ч Паул Эзэний Үгийг тараахын төлөө залбир гэж хэлсэн (2 Тесалоник 3:1, Колоссай 4:3, Ефес 6:19).

### Залбирал яагаад чухал вэ?

► Итгэгчдийн хувьд залбирал чухал гэдгийг бид мэднэ. Сайнмэдээг тунхаглагч хүний хувьд энэ нь онцгой чухалд тооцогдох зарим шалтгаануудыг нэрлэнэ үү?

Сайнмэдээг тунхаглагч хүний хувьд залбирал чухал. Учир нь:

**1. Сайнмэдээг тунхаглагч нь сүнслэг байдлын хувьд амьд байх ёстой.** Залбирал бол сүнсний амьсгал юм. Сайнмэдээг тунхаглагч өөрийнхөө туршлагаас Есүсийн тухай гэрчлэн хүмүүсийг Бурхантай уулзахад гүүр болдог.

2. Сайнмэдээг тунхаглагч нь Бурхантай хамт залбиралд цаг өнгөрүүлэхгүй бол үйлчлэлийн төлөөх зөв хүсэл тэмүүлэлтэй байж чадахгүй. Залбиралгүйгээр сайнмэдээ тараах нь (хувийн ашиг сонирхлыг хайх, дэмий хоосон мэтгэлцээнд цаг барах г.м) буруу сэдэлтэй болгох эрсдэлтэй.

3. Үл итгэгч хүнд нүглийн уучлалыг авах хүсэл төрүүлэхийн тулд сайнмэдээг тунхаглагч хүн Ариун Сүнснээс хамааралтай байж, ятган сэнхрүүлэх ёстой.

“Хэрэв сурах хүсэл чинь сүнснүүдийн төлөөх хүслээс давж байвал та зогсоод сүнснүүдийн төлөөх хүслээ сурах хүслээс давах хүртэл залбираарай.”  
-Вильям Смит

<sup>2</sup> Е. М. Bounds, *Power through Prayer*, [https://ccl.org/ccl/bounds/power/power.I\\_1.html](https://ccl.org/ccl/bounds/power/power.I_1.html) аягаас 2023 оны 1-р сарын 13-нд хандав..

Сайнмэдээ тараах нь дан хүний хичээл зүтгэлээс хамаардаггүй. Сайнмэдээг тунхаглагч нь Ариун Сүнсний хүчинд найдах хэрэгтэй. Хүний хүчээр нүгэлт хүн нүглээ улайх юм уу, Бурханыг хайх хүсэлтэй болно гэж байхгүй (Иохан 16:8, Иохан 6:24).

4. Сайнмэдээг тунхаглагч нь Бичвэрийн тосолгоог авахын тулд Бурханд түшиглэх ёстой (Ром 1:16, Исаиа 55:11).
5. Сайнмэдээг тунхаглагчийн үйлчлэлд Бурханы удирдамж чухал (Үйлс 11:12).

## **Байнга залбирах нь**

### **Хувийн залбирлын амьдрал**

Бүх итгэгчид өдөр бүрийн залбиралд итгэмжтэй байх хэрэгтэй. Үүний ач холбогдол нь амжилттай сайнмэдээ тараахаас ч илүү агуу үр нөлөөтэй.

Өдөр бүр Бурхан руу хандсан онцгой цагийг гаргах учиртай. Хэрэв боломжтой бол зөвхөн Бурхан та хоёр уулзах хувийн орон зайг гарга. Завгүй өдрийнхөө өмнө аливаа зүйлд сатааралгүй Бурхан руу хандан залбирахын тулд өглөө эртлэн босоорой. Хэрвээ өглөө эрт босоод залбирах боломжгүй бол шинэ өдрийн эхний цагаа Бурхан руу хандан залбирч эхлээрэй.

Бичвэрээс өдөр бүр уншиж, тунгаан бясалгаж, үнэнийг хэрэгжүүлэхийн төлөө Бурханд хандан залбираарай.

### **Залбирлын жагсаалт**

Залбирлын сэдвээ бичиж тэмдэглэх нь сайн талтай. Эс бөгөөс бид зарим нэг чухал зүйлээ мартдаг. Бид дэлхий даяар сайнмэдээ тараагдахын төлөө, Христийн дагалдагчдыг хавчдаг улс үндэстнүүдийн төлөө, эх орны минь өнцөг булан бүрт Эзэний сайнмэдээ тунхаглагдахын төлөө залбирах хэрэгтэй. Нутгийн чуулган маань байгаа газартаа Бурханы хүслийг биелүүлж, сайнмэдээг үр дүнтэй хуваалцахын төлөө залбирах ёстой. Түүнчлэн сайнмэдээ тарааж байхад Бурханд бидэнд хувьчлан туслаасай гэж залбирах ёстой.

Төвлөрөхөд хэцүү үед бичсэн жагсаалт бидэнд тусалдаг.

Залбирах бүртээ жагсаалтын дагуу залбирах албагүй. Заримдаа та ямар нэг зүйлийн төлөө залбирах хэрэгтэй гэж мэдэрвэл заавал жагсаалт харахгүйгээр тэдгээрийг санах боломжтой.

- Залбирлын жагсаалтанд өөр юу байх хэрэгтэй вэ?

“Дэлхий даяар Христийг тунхаглах анхны үүрэг хариуцлагыг үүрч байсан эрчүүд Есүсийн өмнө нэгэн агуу хүсэлттэй иржээ. Тэд “Эзэн, бидэнд номлохыг заагаач”, “Эзэн гайхамшиг үйлдэхийг зааж өгөөч” эсвэл “Эзэн, бидэнд ухаалаг байхыг заагаач” гэж хэлээгүй харин тэд “Эзэн, бидэнд залбирахыг зааж өгөөч” гэж хүссэн юм.

- Билли Грэйм

## **Залбирах хүмүүсийн нэрс**

Таны сайн мэддэг, тантай байнга холбоотой байдаг, сайнмэдээ сонсож аврагдах хэрэгтэй арван хүний нэрийг бичээрэй. Эдгээр хүмүүсийн төлөө байнга залбираарай. Хэрвээ сайнмэдээ ярих боломжийг Бурхан өгвөл яриарай. Хэрвээ тэдэнтэй сайнмэдээ хуваалцах боломжгүй бол үргэжлүүлэн залбираарай. Залбирлын дэвтэрт нэр нь бичигдсэн хүмүүс хэдэн жилийн дараа аврагдсан тухай олон хүн гэрчлэн ярьдаг.

## **Залбирлын хамтрагч**

Та тогтмол хамт залбирдаг залбирлын хамтрагч найзтай болбол сайн. Та нар долоо хоногт нэг удаа эсвэл түүнээс ч олон удаа уулзаж тулгарч буй бэрхшээл болон амжилтаа хуваалцаарай.

Эхнэр нөхөр хоёр залбирлын хамтрагчид байж болох ч нөхрийн хувьд эрэгтэй, эхнэрийн хувьд эмэгтэй залбирлын хамтрагчтай байх нь илүү сайн.

► Бүлгийн гишүүдээс залбирлын хамтрагчтай хүн байвал туршлагыг нь асуугаарай.

## **Залбирлын алхаа**

Хөршүүдийнхээ авралын төлөө хайр ба хариуцлагатай сэтгэлээр залбирлын алхаа хийж болно. Хувь хүн, бүлгээрээ тухайн газраа тойрон хэрэгцээнийх нь төлөө чимээгүй залбирч алхдаг. Ингэхдээ тэд тухайн газрын хүмүүстэй ярилцаж болох боловч залбирлын алхаа хийх гол зорилго бол залбирал юм. Залбирлын алхааг тухайн газраа сайнмэдээ тараахын өмнө болон дараа хийдэг.

## **Залбирлын цэг**

Зарим чуулганууд олон нийтийн газар түр залбирах цэг гаргасан байдаг. Тэд "Залбирлын цэг" гэсэн самбар тавиад хүмүүсээс тэдний хэрэгцээний төлөө хамтдаа залбирах хүсэлтэй байгаагаа илэрхийлдэг. Тэд ямар нэг маргаан өрнүүлэхээс зайлсхийж, ихэвчлэн сайнмэдээг хүмүүст хуваалцдаг байна.

► Таны амьдарч байгаа бүсэд залбирлын цэг болгож болох тохиромжтой газар байгаа юу?

## **Библийн дагуух залбирал**

Есүсийн залбирсан залбирлууд, элч нарын залбирлуудаар бид залбирч болно. Учир нь тэдгээр нь Бурханы хүслийн дагуух гэдгийг бид мэднэ. Энд гурван жишээ авъя.

**Эзэний заасан залбирал:** Матай 6:9-13-д Есүс дагалдагч нартаа хэрхэн залбирах жишээг үзүүлсэн. Бид Есүсийн заасны дагуу залбирахдаа Есүсийн нэн тэргүүнд юуг чухалчлан залбирч байгааг анхааран залбиралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй.

**Ефес дэх итгэгчдийн төлөө Паулын залбирал:** Ефес 3:14-19-д Паул тэдний сүнслэг төлөвшлийн төлөө залбирсан. Бид өөрсдийн болон бусдын сүнслэг төлөвшлийн төлөө залбирах хэрэгтэй.

**Ургацын залбирал:** Матай 9:36-38-д Есүс дагалдагч нартаа алдагдсан хүмүүс болон сүнслэг ургацын ажилчдын төлөө залбирахыг заасан байдаг.

### Мацаг барих нь

Мацаг барих нь махбодын болон материаллаг зүйлсээс татгалзан, сүнслэг, мөнхийн зүйл дээр анхаарлаа хандуулах гэсэн утгатай. Энэ нь сүнслэг мөнхийн зүйл нь махбодын болон материаллаг зүйлсээс илүү чухал гэдгийг илтгэдэг ба мацаг барилтаар дамжуулан хүн итгэлээ батжуулдаг.

► Мацаг барилт Бурханаар ямар нэг зүйл хийлгэхээр хүчээр өлсөж байгаа оролдлогоос юугаараа ялгаатай бэ?

### Библи дэх мацаг барьсан хүмүүсийн жишээ

Эдгээр жишээ нь Бурханыг амьдралд нь ажиллаасай хэмээн туйлаас хүсэн мацаг барьсан Библийн жишээнүүд юм. Эдгээр жишээг Бичвэрийн олон жишээнээс сонгож авсан бөгөөд Библид мацаг барихыг үр дүнтэй сайн арга гэж үзсэн төдийгүй, үүнд Бурхан яагаад хөндлөнгөөс оролцдог талаар тайлбаруудыг олонтоо дурдсан байдаг.

► Нэг суралцагч мацаг барих тухай Библийн жишээнүүдээс нэгийг уншаад дараа нь бүлгээрээ ярилцана уу.

Бичвэр	Мацаг барилт ба залбирлын үр дүн
2 Шастир 20	Улс үндэстнээрээ мацаг барин тулаанд ялалт байгуулсан.
Езра 8:21	Езра аюултай нөхцөл байдлын дунд Бурханы хамгаалалтыг дуудан мацаг барин залбирсан.
Естер 4:16	Иудейчүүдийг хомрогolon устгах дайсны төлөвлөгөөний эсрэг тэд Бурханы оролцоог хайн мацаг барин залбирсан.
Иона 3:5-9	Ниневегийн хүмүүс Бурханы нигүүлслийг хүсэмжлэн мацаг барин залбирсан.
Шүүгчид 20:26	Израил тулалдаанд Бурханы удирдамжийг авахаар мацаг барин залбирсан.
1 Самуел 7:6	Израил өршөөл, чзөлөөлөлтийн төлөө мацаг барин залбирсан.
Нехемиа 1:4	Нехемиа хотын хэрмийг дахин барих боломж хүсэж, мацаг барин залбирсан.

Даниел 9:3	Даниел Израилыг цөллөгөөс чөлөөлөгдөөсэй хэмээн мацаг барин залбирсан.
Иоел 2:12	Иоел Израилын төлөө гэмшиж, шүүлтээс аврагдахынх нь төлөө мацаг барин залбирахаар дуудагдсан.
Матай 4:2	Есүс үйлчлэлээ эхлэхээс өмнө дөч хоногийн туршид мацаг барин залбирсан.
Лук 2:37	Анна эш үзүүлэгч байсан ба мацаг барилт ба залбиралд өөрийгөө зориулсан.
Үйлс 10:30	Корнел Бурханаас мэдээг хүлээн авах үедээ мацаг барин залбирч байсан.
Үйлс 13:2-3	Чуулганыг мацаг барин залбирч байх үед Бурхан илгээлтийн эздийг илгээгтүн гэж айлдсан.
Үйлс 27:21	Паул зовлон, шаналал дундаа мацаг барин залбирсан.

### Есүсийн зааварчилгаа

“Би та нартай үргэлж хамт байхгүй (Матай 9:15, Лук 5:33-35). Тиймээс мацаг барин залбир” гэж Есүс дагалдагч нартаа заасан төдийгүй хэрхэн зөв мацаг барих талаар айлдахдаа хүмүүст харуулахын тулд мацаг барьж болохгүй гэж заажээ.

Чи мацаг барихдаа хоёр нүүртнүүд шиг бүү баргар царайл. Учир нь тэд мацаг барьж байгаагаа бусдад харуулахын тулд царайгаа барайлгадаг. Үнэнээр Би та нарт хэлье, тэд шагналаа бүрэн авсан. Харин та нар мацаг барихдаа толгойгоо тослоод, нүүрээ угаа. Ингэснээр та нар мацаг барьж байгаагаа хүмүүст бус, харин нууц оршигч Эцэгтээ харуулна. Тэгээд нууц хардаг Эцэг чинь чамд буцааж төлнө (Матай 6:16-18).

### Мацаг барьсан түүхэн жишээнүүд


Эртний чуулганы зарим итгэгчид Лхагва, Баасан гарагуудад мацаг барихын сацуу жил бүрийн мацаг барилтын өдрүүдээр мацаг барьдаг байсан байна. Мартин Лютер, Жон Калвин, Жон Нокс, Жонатан Эдвардс, Чарльс Финни, Д. Л. Мүүди нар ч гэсэн маш олон хоногоор мацаг барьдаг байжээ. Жон Веслей болон эртний методистууд мацаг их барьдаг байснаараа алдартай. Ач холбогдол бүхий урт хугацаанд үргэлжилсэн сэргэлтүүд нь залбирал болон мацаг барилтаас эхлэлтэй байдаг.

► Мацаг барьснаар сайн үр дүнд хүрсэн таны мэдэх ямар хүмүүс байна вэ?

## Өнөөгийн чуулганы сул тал

Чөтгөрт эзэмдүүлсэн хүнд туслах гэсэн дагалдагч нарын оролдлого тэдний итгэлгүй байдлаас болж бүтэлгүйтсэн гэдгийг Есүс дагалдагч нартаа “Энэ төрөл нь зөвхөн залбирлаар л гарч чадна гэв” (Марк 9:29) хэмээн сануулжээ. Мацаг барих болон залбирал нь итгэлд хүргэх арга хэрэгсэл төдийгүй мөн үл итгэлд зориулагдсан эмчилгээ ч болдог. Есүс дагалдагч нартаа зөвхөн зовлонгийн үед мацаг барин залбирах хэрэгтэй гэж хэлээгүй, харин зовлон туулах хангалттай итгэлтэй байхын тулд тогтмол мацаг барин залбирах хэрэгтэй бөгөөд мацгийг амьдралынхаа чухал хэсэг болгох хэрэгтэй гэсэн юм.

Есүсийн үг, мацаг барих тухай Библи дээрх жишээнүүдэд үндэслэн бид өөрсдөдөө байгаа ивээл ерөөлийг хэд хэдэн түвшинд хуваагдсан пирамидын зургаар илэрхийлж болно. Доод түвшний ерөөлүүдийг итгэлээр дамжуулан олж авах боломжтой бөгөөд зөвхөн залбирлаар ийм итгэлд хүрдэг. Харин дээд түвшний ерөөлүүдийг зөвхөн итгэлээр олж авдаг бөгөөд залбирал ба мацаг барилт хамтдаа ийм итгэлд хүргэдэг.



## Хэрхэн зөв мацаг барих вэ?

- Залбирал болон мацаг барилтыг хослуулснаар мацаг барих нь зөвхөн гадаад үйлдэл бус, харин сүнслэг шинэ түвшинд хүрч, итгэлээр өсөх үйлдэл болдог.
- Мацаг нь бардамнал бус Бурханыг алдаршуулах зорилготой.
- Мацаг барин залбирахдаа өөрийн хүслийг бус Бурханы хүслийг хайдаг.
- Дуулгавартай байдлыг мацаг барилтаар орлуулж болохгүй.
- Биедээ хохирол учруулан мацаг барьж болохгүй.

► Мацаг барин залбирах талаар хамтдаа ярилцаарай.

## Аюулгүй мацаг барилт

Хэрэв зөв мацаг баривал, эрүүл мэндэд хор нөлөөгүй. Тогтмол мацаг баривал эрүүл мэндэд олон талын ашиг тустай.

- Харин мацаг барихдаа ус уух хэрэгтэй. Ус уухгүй байж болохгүй.
- Нэг өдөр мацаг барихаас эхэл. Аажмаар мацаг барих хугацаагаа сунга. Хэвийн хооллосон долоо хоногийн дараа нэг хоног эсвэл дээш хугацаагаар мацаг барьж, буцаад хэвийн хооллох маягаар явна.

Мацаг барьж хэвшээгүй хүмүүст огиудас хүрэх дотор муухайрах, толгой өвдөх нь нийтлэг тохиолддог. Гэхдээ эрүүл хүмүүс тогтмол мацаг барихад эдгээр шинж тэмдгүүд эхний хэдэн хоногт ч илэрдэггүй. Муу бодисууд биеэс гадагшилж байгаа учраас аманд



эвгүй амт амтагдах, амьсгал эвгүй үнэртэх нь бий. Удаан хугацаагаар мацаг барихад хэдэн өдрийн дараа тааламжгүй шинж тэмдгүүд арилдаг.

- Урт хугацааны мацаг барилтыг жимсний шүүс, хөнгөн хоолоор тайлна.

### **7-р хичээлийн даалгаврууд**

(1) Хувийн залбиралдаа ахиц гаргахын тулд юу хийх талаар бодож үзээрэй. Өдөр бүр залбирлын цаг гаргаж тодорхой цагаа залбиралд зориулаарай. Тогтмол мацаг барих хугацааг өөрийн цагийн хуваарьт оруулаарай.

(2) Библиэс мацаг барих талаар хоёр жишээг уншаад, мацаг барилт тус бүрийн нөхцөл байдал болон үр дүнгийн тухай бичээрэй.



## 8-р хичээл

### Есүсийн арга барил

#### Танилцуулга

► Нэг суралцагч Матай 19:16-22-ыг ангид уншина. Тэр залууд өгсөн Есүсийн хариултаас чамд юу нь гайхалтай санагдаж байна вэ? Хэрэв таны найз хэрхэн мөнх амьтай болох талаар асуусан хүний асуултад Есүсийн адил хариулт өгсөн бол, та найздаа юу тайлбарлахыг хүсэх байсан бэ?

#### Буруу ойлгогдсон бэлэг

Та өөрийгөө үнэхээр эрүүл чийрэг гэж боддог нэгэн. Харин нэгэн найз чинь ирээд чиний аминд хүрэх аюултай өвчнийг эдгээх эм чамд авчирлаа гэж бодъё.<sup>3</sup> Тэрээр энэ эмийг чамд зориулан худалдан авахын тулд орон гэрээ мөн өөрийнхөө гэсэн бүхнээ худалдлаа гэж хэлэв.

► Энэ бэлгийг хүлээн авах үедээ та найздаа юу хэлэх вэ?

Түүний өгөөмөр сэтгэлийг талархан хүлээн авах боловч, бэлэг ямар учиртай болохыг ойлгохгүй байж болох юм. Яагаад тэр надад хэрэггүй зүйлийг худалдан авахын тулд өөрт байгаа бүхнээ золиослох болов?

Одоо өөр нэгэн түүхийг төсөөлөөд үз дээ. Та эмчид хандсанаар удахгүй үхэх өвчин туссан гэдгээ мэджээ. Эмчилгээний хөлс асар их үнэтэй учир төлөх ямарч боломж байсангүй. Чи гэртээ харихдаа үхлийн тухай бодон гэр бүлээсээ хагацахаа, амьдралаас найдаж байсан бүхнээ хэзээ ч авахгүй болсноо ухаарна.

Найз чинь тантай уулзаад өөрт байгаа бүхнээрээ таныг эдгээх эм авсан тухай хэлжээ. Танд амьдрал бэлэглэх хамгийн чухал зүйл өгсөнд нь та талархах буй за.

Сайнмэдээг сонсоод хүмүүс ямар хариу үйлдэл үзүүлдэг тухай бодоорой. “Gospel” гэдэг үг нь “сайн мэдээ” гэсэн утгатай. Олон хүн сайнмэдээний утга учрыг ойлгодоггүй.

Жейсон гэдэг хүний тухай төсөөлье. Түүний найз “Чиний нүглийг уучлахын тулд тахил болж Есүс загалмай дээр нас барсан” гэж түүнд хэлжээ.

Жейсон бодохдоо “Би бол муу хүн биш. Би гэр бүл болон найз нөхдөдөө сайн ханддаг. Яагаад миний нүглийн төлөө ийм их хэмжээний золиос хэрэгтэй гэж? Уучлал яагаад чухал гэж?” Магадгүй өөрийг нь уучлахын төлөө Есүс амиа өргөх хэмжээний тийм

---

<sup>3</sup> Энэхүү хичээлийн ихэнх материалыг Ray Comfort “Hell’s Best-Kept Secret” нэртэй номлол болон ижил нэртэй номд танилцуулсан байдаг. Дэлгэрэнгүй материалыг <http://www.livingwaters.com> вэб хуудсаас харах боломжтой.

олиггүй нүгэлтэн гэж найз нь Жейсоныг боддог юм байна хэмээн дургүйцэж ч болох юм.

Загалмай бол хүмүүсийн хувьд мунхаглал гэж Библи хэлдэг. Хүмүүс өөрсдийгөө зөвтгөх арга эрэлхийлдэг бөгөөд Есүсийн өргөсөн тахил тэдэнд хэрэгтэй гэж боддоггүй. Тэдэнд загалмай нь тэнэглэл мэт санагддаг (1 Коринт 1:18).

Аюулт өвчнийг эдгээх эмчилгээ, эмтэй адил яагаад загалмай тэдэнд хэрэгтэй гэдгийг ойлгодоггүй учраас тэд тааламжтай хандахгүй байгаа юм.

Сайнмэдээнд хүмүүсийг бэлтгэх Библийн дагуух арга зам нь тэдэнд яагаад сайнмэдээ хэрэгтэй гэдгийг мэдүүлдэг. Тэд Бурханаар шүүгдэх гэм буруутай гэдгээ ойлгох хэрэгтэй.

► Хүмүүс яагаад сайнмэдээг сонсоод баярлах ёстой вэ?

### **Шүүлтийн ач холбогдол**

Үл итгэгчдэд сайнмэдээг дуулгах хамгийн гол шалтгаан нь тэд цөм шүүгдэж, шийтгүүлнэ гэдэг баримт юм.

Хүн ганц удаа үхэж, дараа нь шүүгдэхээр товлогдсон... (Еврей 9:27).

Би та нарт хэлье. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно (Матай 12:36).

► Илчлэл 20:12-15-д шүүлтийг хэрхэн дүрсэлснийг уншина уу.

Үл итгэгчдийг шүүх ирээдүйн шүүлт нь үл итгэгч хүн бүрд аврал хэрэгтэй байдгийн гол шалтгаан юм.

Бурхан хүн бүрийг гэмших хэрэгтэй гэж тушаасан тул “ертөнцийг шударгаар шүүх өдрөө Тэр тогтоосон агаад...” (Үйлс 17:30-31) гэжээ.

Хэрэв хүн өөрийнхөө нүглийн ноцтой гэдгийг ухаарахгүй бол авралыг хүсэх чухал шалтгаангүй болно.

► Нүгэл ноцтой гэдгийг хүнд яаж ойлгуулах вэ?

### **Хуулийн хэрэглээ**

Өөрсдийн нүглээ ухамсарладаггүй учраас хүмүүс сайнмэдээг ойшоодоггүй. Библид хүмүүс өөрсдийгөө ямагт сайн гэж үздэг талаар дурдсан (Сургаалт үгс 20:6) байна. Хэрвээ хүмүүсээс энэ талаар асуувал тэд сайн байсан ч, үгүй байсан ч “тиймээ би сайн” гээд маргахад бэлэн байдаг. Дийлэнх хүн өөрсдийнхөө нүглийг хорон муу зүйл биш гээд өөрсдийгөө зөвтгөгдөх эрхтэй гэж үздэг. Эдгээр хүмүүст нүглийн уучлал, нигүүлсэл гэдэг утгагүй зүйл юм.

Бурханы нигүүлсэл өөрт нь хэрэгтэй гэдгээ ухаарахын өмнө би бол нүгэлтэн, би нүглийн шийтгэлээ хүртэх ёстой хүн гэдгээ ухаарах ёстой. Бурхан нүглийг илчлэхийн тулд хуулийг өгчээ.

Хууль гэсэн нэр томъёогоор сүмд мөргөл хүндэтгэл өргөх Хуучин гэрээний ёслолын онцгой шаардлагууд юм уу, эсвэл бид өнөөдөр дагаж мөрдөх шаардлагагүй Израилын засаг захиргаатай холбоотой хууль дүрмийг энд бид яриагүй. Харин Бурханы зөвт байдлын хэм хэмжээний тухай ярьж байна. Давид хаан Дуулал 119-д Бурханыг хайрладаг шигээ Бурханы хуулийг хичнээн их хайрладаг гэдгээ бичсэн байна. Учир нь ариун байдал бол Бурханы зан чанар юм.

Бурханы хууль бид хэрхэн амьдрах ёстойг болон бид хуулийг дагахгүй бол Түүний өмнө гэм буруутай гэдгийг заадаг. Хэн ч хуулийг сахиснаар зөвтөгдөхгүй (Галат 2:16, Ром 3:20). Учир нь бүх хүн нүгэл үйлдсэн. Хэрвээ хуулийг сахиснаар аврагдана гэж үзвэл та хуулийг буруугаар ойлгож байна.

Бурханы хууль бидний амьдралыг чиглүүлдэг (1 Коринт 9:21) болохоос энэ нь аврах арга зам биш. Хүн төрсөн цагаасаа хуулийн шаардлаганд төгс нийцэхгүй учраас хуулиар аврагдах боломжгүй (Ром 8:3, Галат 3:21).

Хууль нь Бурханы төлөвлөгөө, сайнмэдээний эсрэг байдаггүй. Библид хууль нь үл итгэгчдэд аврал хэрэгтэй гэдгийг ойлгуулах зорилготой гэж бичигджээ. Сайнмэдээ нь хуулийг хүчингүй болгохгүй (Матай 5:17) мөн биднээс хамааралгүй болгохгүй. Хууль нь сайнмэдээний төлөөх төгс бэлтгэл бөгөөд зөвхөн Хуучин гэрээнд төдийгүй одоо ч тийм хэвээрээ юм.

Хууль нь Христ рүү биднийг удирддаг багш юм (Галат 3:24). Зарим хүмүүс хуулийн цаг үе төгсгөл болсон, одоо бол нигүүлслийн цаг үе гэж боддог. Хүн нигүүлслийг ухаарахаас өмнө Бурханы хуультай нүүр тулж, түүгээр буруутгагдана гэдгээ ойлгох ёстой. Элч Паул "Гэхдээ хуулиар биш бол би нүглийг мэдэхгүй байхсан" (Ром 7:7) гэжээ.

Хууль нь хүнийг нүгэлтэйг гэдгийг харуулахын тулд өгөгдсөн бөгөөд шалтаг байхгүй юм гэж Паул хэлжээ. Хүмүүс хуулиар дамжуулан өөрсдийнхөө нүгэлтэй гэдгийг мэддэг (Ром 3:19-20). Хүн бүр аврагдах хүртлээ хуулийн дор байж, хуулиар буруутгагдана.

Нүгэл нь ноцтой гэдгээ ухаараагүй хүний хувьд сайнмэдээ нь сайнмэдээ биш. Харин өөрийгөө Бурханы шүүлтийн өмнө зогсох гэм буруутай гэж ухаарагч хүний хувьд сайнмэдээ нь үнэхээр сайн мэдээ юм.

► Нэг суралцагч Лук 18:10-14-ийг ангид уншина. Хэрэв хэн нэг нь фарисай хүнд Бурханы нигүүлслээр чөлөөтэй уучлагдах боломжтой гэж хэлсэн гэж бодъё. Тэр фарисай ямар хариулт өгөх байсан бол?

## Орчин үеийн эвангелчүүдийн алдаа

Өнөө үед олон эвангелийнхэн хүн бүр нүгэлтэй, хүн бүр Бурханы өмнө шүүгдэнэ гэж хэлэх дургүй болжээ.

Хүмүүсийг муу гэж хэлэхийг тэд хүсдэггүй.

Тэд сөрөг зүйлийн оронд эерэг зүйлс ярихыг хүсдэг.

Тэд энэ дэлхийн зүйлсийг анхаардаг хүмүүст хандан ярьдаг учраас мөнх авралаас даруйхан ирэх ашиг тусыг ярихаас биш, мөнхийн ашиг тусын талаар ярихаа больжээ.

Тэд Бурханы хуулийг сайн зүйл биш, харин авралын дайсан, үйлсээр аврагдахыг хүсдэг хүмүүсийн хувьд л чухал гэж хэлдэг. Гэтэл Библид хууль сайн бөгөөд ариун (Ром 7:12-14); Бурханы тааллыг хайдаг хүмүүс нь Бурханы удирдамжийг амьдралынхаа туршид даган мөрдөхийг хичээдэг (Дуулал 119:1-8) гэсэн байна.

Бурханы хэмжүүр нь бидний хувьд биелүүлэх боломжгүй, учир шалтгаангүй зүйл бөгөөд бид нүглийнхээ төлөө өөрийгөө буруутгах хэрэггүй гэж тэд хэлдэг.

Гэтэл хүн үнэхээр гэм буруугүй бол үнэнээсээ гэмшиж чадахгүй шүү дээ. Тэр буруу зүйл хийсэн гэдгээ мэдэхгүй бол хийсэн зүйлийнхээ төлөө харамсахгүй. Хэрвээ хүн өршөөл хүсэх үедээ өөрийгөө үнэхээр гэм буруутай гэж хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол зүгээр л алдаа гаргасныхаа төлөө Бурханаар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдож буй хэрэг юм.

Үл итгэгчид төрөхдөө нүгэлт мөн чанартай төрснийхөө төлөө буруутгагдахгүй, харин Бурханы эсрэг тэрслүү хандлага, санаатай нүглүүдийнхээ улмаас шүүгдэнэ (Иуда 15).

Бурхан бол хайр, өршөөлийн Бурхан гэж олон хүн итгэдэг. Гэхдээ Бурхан шударга шүүгч гэдгийг тэд мартчихдаг. Хэзээ нэг өдөр Бурхантай уулзвал, гэмшээгүй байсан ч Бурхан өөрсдийг нь өршөөнө гэж санадаг. Хагас дутуу ойлгож сонссон сайнмэдээ нь тэдэнд нүглээ илүү тухтай үргэлжлүүлэх хөшүүрэг болдог.

Орчин үед олон эвангелийнхэн хэрвээ та итгэвэл амьдрал чинь өмнөхөөсөө илүү аз жаргалтай байх болно гэж онцолдог болжээ. Нүгэлдээ сэтгэл ханадаггүй мөртлөө Бурханд хангалуун байгаа гэж тэд хэлдэг. Хүн хайр, амар тайван, баяр хөөрийг амсах болно, хүн бүрийн төлөөх гайхалтай төлөвлөгөө Бурханд бий, хэрвээ та Түүнийг дагавал тэр төлөвлөгөө амьдралд тань биеллээ олно гэх мэтээр ярьцгаадаг.

Эдгээр амлалтууд буруугаар ойлгогдож болох юм. Бурхан хайр, амар тайвныг өгдөг боловч итгэгчид болон Бурханыг эсэргүүцэгчдийн хооронд зөрчилдөөн үүсч болно (Матай 10:34-36). Бурхан баяр хөөр өгдөг гэхдээ хавчлага ч үүнтэй зэрэгцэн өгөгдөж болох юм (1 Тесалоник 1:6). Түүнд хүн бүрд зориулсан гайхалтай төлөвлөгөө байдаг ч

“Шинэ итгэгч болсон хүн хуучнаа бүхэлд нь орхидог бөгөөд үүнийг үхэлтэй адилтгаж үздэг. Бид Христтэй хамт цовдлогдсон. Загалмайгаар дамжуулан бид бурхангүй ертөнц, үүний үзэл санаа, хэм хэмжээг үхүүлсэн юм”

- Дэлхийн Сайнмэдээний төлөөх  
Лузанн зөвлөл,  
Вилловбанк тайлан

зарим хүн хүнд хэцүү зовлон бэрхшээлийг туулж ч болох юм (2 Коринт 11:24-27). Хэрвээ хэн нэгэн Түүнд итгэхдээ амьдралын минь нөхцөл байдал өмнөхөөсөө сайжирна гэж бодсон бол магадгүй тэр сэтгэлээр унаж ч болно. Христэд итгээд зарим хүмүүс хатуу ширүүн зовлон дундуур туучдаг.

Христийн дагалдагчийн хувьд бид хэцүү бэрхийг тууллаа ч Бурхантай хамт амьдрах нь гайхалтай гэдгийг ойлгох хэрэгтэй. Бурханд үйлчлэх нь гайхалтай амьдрал гэж бид хэлдэг. Хэдий тийм боловч ихэнх үл итгэгчдэд гайхалтай амьдрал гэгч яг юу болох талаар зөв ойлголт байдаггүй. Хэрвээ та тэднээс гайхамшигтай амьдралыг төсөөлөөд хэлээч гэвэл тэд эд хөрөнгө, мөнгө, эрх чөлөө, амар тайван бусад сайн сайхан зүйлсүүдийг хэлэх байх. Тэд Христийн дагалдагчдын өртсөн хавчлага, дарамт нь гайхалтай амьдрал байдаг гэж ойлгохгүй. Тиймээс та үл итгэгч хүнд Христийг дагавал гайхалтай амьдрах болно гэвэл магадгүй тэр таны юу амлаж байгааг ойлгохгүй байх.

Өөр нэг асуудал бол сайнмэдээны талаарх буруу ойлголт юм. Өөрийгөө шийтгүүлэх нүгэлтэн гэж ойлгоогүй хүн сайнмэдээг хүлээн авах боломжтой. Нүгэл нь маш ноцтой гэдгийг ухаараагүй учраас тэр хүн үнэнээсээ гэмшдэггүй. Тийм хүний хувьд нүглээс чөлөөлөгдөх авралыг бус өөр төрлийн ашгийг эрж хайдаг. Тэр өөрийгөө аврагдсан гэж бодож болох ч үнэндээ аврагдаагүй юм.

Иймэрхүү хүмүүс жинхэнээсээ итгээгүй байдаг учраас авралын ашиг тусыг амьдралдаа хүртэхгүй. Тиймээс богино хугацаанд итгэлээр амьдраад урам хугарч бууж өгдөг.

Хуурамч сайнмэдээний хамгийн муу үр дагавар нь тухайн хүн урам хугарахаас гадна ирээдүйд сайнмэдээг бараг дахиж хүлээн авдаггүй.

Илүү сайхан амьдрал амладаг сайнмэдээний асуудлыг дүгнэж хэлбэл:

1. Бурхан амлаагүй зүйлсийг амладаг.
2. Үл итгэгчдэд буруу ойлголт өгдөг.
3. Сонссон хүн нь жинхэнээсээ итгээгүй байдаг.
4. Хүсэн хүлээсэн ашиг тусаа хүртдэггүй.
5. Ирээдүйд сайнмэдээг хүлээн авах магадлал тун бага.

► Нэг суралцагч Үйлс 14:21-23-ыг ангид уншина. Элч нар шинэ итгэгчдэд юуг туулна гэж хэлсэн бэ?

Есүс Христэд итгэсэн итгэлийн чинь улмаас та нарыг хүмүүс үзэн ядах болно мөн төгсгөл хүртэл тэвчихгүй бол аврагдахгүй гэж дагалдагч нартаа анхааруулсан бөгөөд үүнийг сайнмэдээний гурван бичээч тэмдэглэн үлдээжээ (Матай 10:22, Марк 13:13, Лук 21:17). Тиймдээ ч Христийн арван нэгэн дагалдагч алагдсан түүхтэй.

Сая сая Христэд итгэгчид итгэлийнхээ улмаас амиа алдсаар байна. Энэ нь зөвхөн эрт үед л хамаатай асуудал биш. Итгэлийнхээ төлөө амиа алдсан Христэд итгэгчдийн тал хувь нь 20-р зуунд тохиожээ.

Хэрвээ хүн амар амгалангийн төлөө бус авралын амлалтаас болоод христитгэлийг хүлээж авсан бол хүнд хэцүү амьдралд бууж өгөхгүй. Тэрээр мөнхийн авралын төлөө сорилт бэрхшээлийг тэвчихэд бэлэн байна. Сорилт бэрхшээл нь авралыг илүү үнэ цэнтэй болгодог.

► Христийн дагалдагчид яагаад сорилтыг тэвчдэг вэ?

### **Хайраа харуулах нь**

► Нэг суралцагч 2 Тимот 2:24-26-г ангид уншина. Сайнмэдээг тунхаглагч хүний хандлагын талаар эдгээр эшлэлд юу гэж хэлсэн бэ?

Сайнмэдээг тунхаглагч хүн сайнмэдээг тараахдаа хүмүүстэй тэмцэлдэх ёсгүй. Сатан бол дайсан, харин үл итгэгчид сатаны хоригдлууд юм. Бид үнэнийг дөлгөөн байдал дотор тайлбарлах ёстой. Маргаан мэтгэлцээнээр тэднийг ялах бус, тэдэнд туслах нь бидний зорилго шүү дээ. Дээрх эшлэлд эелдэг зөөлөн, дөлгөөн, тэвчээртэй байдал гэх мэт үгсийг ашигласан байна.

► Нэг суралцагч Тит 3:2-5-г ангид уншина. Сайнмэдээг тунхаглагч хүний зан чанарын тухай энэ эшлэл юу хэлж байна вэ?

Бурханы нигүүлсэл байгаагүй бол бид дэлхийн хүмүүсээс ялгарах зүйлгүй гэдгээ санах ёстой. Бурхан энэ дэлхийд ирэхдээ шүүлтийг бус энэрэл, хайрыг бидэнд авчирсан.

Сайнмэдээг тунхаглагч хүн үл итгэгчдэд уурлах бус Сатан болон нүгэлд уурлах ёстой. Тэр хатуу ширүүн аашлах ёсгүй. Тэр тэдний алдаанд баярлах бус харин тэдний авралд санаа тавих хэрэгтэй.

Бид энэ хичээлээр Бурханы амлаагүй зүйлсийг үл итгэгчдэд амласнаараа тэднийг хайрлаж байгаа гэсэн үг биш гэдгийг суралцсан. Тэдний амьдралын асуудлуудыг мөнхийн хувь тавилангаас илүү чухал мэт үзсэнээрээ тэднийг өрөвдөж байгаа хэрэг огт биш.

Мессиа бол хүчирхийлэгч биш, харин дөлгөөн нэгэн бөгөөд нүглээс болж аль хэдийн шархадсан хүмүүсийг гэмтээхгүй хэмээх эртний эш үзүүлэгийг Есүс биелүүлсэн юм (Матай 12:19-20).

► Сайнмэдээ тараах үед Бурханы хайрыг илэрхийлж болох ямар аргууд байдаг вэ?

### **Библийн дагуу сайнмэдээ тараах нь**

Сайнмэдээг хүлээн авахад хүмүүсийг бэлтгэхийн тулд Бурханы хуулийг хэрэглэхийг Библийн дагуу сайнмэдээ тараах гэдэг. Үл итгэгч хүн уучлалыг хүлээн авахгүй бол шүүгдэх болно гэдгийг хууль хэлдэг.

Баптисч Иохан Эзэний ирэхэд бэлтгэж, шүүлтээс хэлтрэхийн тулд гэмших ёстой гэж номлож байсан (Матай 3:1-12).



Есүс маш олон удаа там ба шүүлтийн тухай сургаал зааж байсан. Нүглээ хүлээн зөвшөөрч гэмшсэн хүмүүсийг Тэрээр нигүүлсэх болно гэж хэлсэн байдаг.

► Нэг суралцагч Лук 7:36-50-ыг ангид уншина. Ямар хүн уучлалыг хүлээн авдаг вэ?

Нүглээ гэмшээгүй нэгэнд Есүс өршөөл үзүүлсэн тухай Түүний үйлчлэлээс бид олж харахгүй. Шүүлтийн талаар Тэрээр хүмүүст анхааруулдаг байсан. Гамшиг сүйрэл тохиож, олон хүн үрэгдсэний дараа Есүс хурсан олонд хандан, гэмшихгүй бол бүгд мөхнө гэдгийг хэлж байсан (Лук 13:1-5).

Фарисай хүн, татвар хураагч хоёрын хэрхэн залбирсан тухай түүхийг Есүс өгүүлж байсан. Татвар хураагч гэмшээд өршөөлийг хүлээн авсан бол фарисай өөрийгөө зөвтгөсөн. Фарисай хүн өршөөл түүнд хэрэгтэй гэдэгт итгээгүй учраас өршөөгдөөгүй аж.

Элч Петр номлолдоо мөнх амийн амлалтын талаар номлож, гэмшил ба уучлал руу ирэхийг хүмүүст уриалсан байдаг (Үйлс 2:38, Үйлс 3:19, Үйлс 5:31).

Стефан иудейн удирдагчдад хандан номлохдоо нигүүлслийг санал болгоогүй, харин тэд Бурханыг эсэргүүцэж, Түүний хуулийг зөрчснийх нь төлөө тэднийг буруутгасан (Үйлс 7:51-53).

Гэмшихгүй бол Бурханы уучлалыг авахгүй гэдгийг Паул ч бас тунхагласан (Үйлс 17:30-31).

Христийн дагалдагч болоход ирдэг баяр хөөр, ерөөлийг ярих нь буруу биш боловч Библи дэх сайнмэдээ нь нүглийн шийтгэл, гэмшил, шүүлтээс авралын сайнмэдээ рүү хэрхэн хүрч болох талаар тунхагладаг юм.

► Нэг суралцагч 2 Коринт 5:11-ийг ангид уншина. Элч Паул юу гэж ятгасан бэ?

► Нэг суралцагч Үйлс 24:25-ыг ангид уншина. Паул Феликст юуны талаар ярьсан бэ? Феликс хэрхэн хүлээн авсан бэ?

### **Библийн дагуу сайнмэдээ тараах жишээ**

Андрей Жейсонтой таарах үедээ хүмүүсийг чуулганд ирэхийг урьсан урилга тарааж байлаа.

Жейсон: Надад чуулганд явах шаардлага байхгүй шүү.

Андрей: Үйлдсэн нүглийнхээ төлөө бүх хүн Бурханы шүүлтийн өмнө зогсох болно гэж Библид бичигдсэн байдаг. Бурхан чамайг байгаагаар чинь хүлээн авна гэж чи бодож байна уу?

Жейсон: Тиймээ, тэгж бодож байна.

Андрей: Чи сайн хүн мөн үү?

Жейсон: Тиймээ, би бол сайн хүн.

Андрей: Чи өөрийгөө олон хүнтэй харьцуулбал магадгүй сайн хүн байж болох юм. Найз нөхөд гэр бүлийнхэндээ ч сайныг үйлддэг байж болно. Тэгвэл чи Бурханы хэрэглэдэг жишиг хэмжүүр юу болох талаар мэдэх үү? Библид Бурхан зөв бурууг хэрхэн шүүдэг тухай бичсэн байдаг. Жишээ нь, Түүний тушаалууд болох Арван хуулийг мэдэх үү?

Жейсон: Заримыг нь л мэднэ.

Андрей: “Худал бүү гэрчил” гэж арван тушаалд хэлсэн. Чи худал хэлж байсан уу?

Жейсон: Мэдээж шүү дээ, бүгд л зарим үед худлаа ярьдаг.

Андрей: Худлаа яривал Бурханы хуулийг зөрчсөнд тооцогдоно. Өөр нэг тушаал нь “Бүү хулгай хий” гэсэн байдаг. Чи ямар нэг зүйл хулгайлж байсан уу?

Жейсон: Жижиг сажиг юм авч байсан. Тэглээ гээд би хүмүүсийг тэгтлээ хохироож зовоож байгаагүй.

Андрей: Бурхан биднийг хулгай хийхийг зөвшөөрөөгүй. Түүний тушаалд “Бүү хулгайл” гэж хэлсэн. Үүнээс гадна Бурханы нэрийг хий хоосон дуудах, хүндэтгэлгүй хараалын үг болгон ашиглахыг мөн хориглосон байдаг.

[Бүх хуулийг хэрэглэж болно гэхдээ бүгдийг нь яриандаа ашиглаж болохгүй. Дараах жишээг харна уу]

- Бурхан бидэнд “Бүү завхайр” гэсэн бөгөөд эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй аль хэдийн завхайрсан хэрэг хэмээн Есүс хэлсэн юм.
- Бурхан “Хүн бүү ал” гэсэн. Харин Есүс “Нэгнээ зүрхэндээ үзэн ядах нь түүнийг алсантай адил юм” гэжээ.
- Бурхан “Эзэний өдрийг ариунаар сахь” гэсэн. Долоо хоног бүр Эзэний өдрийг ариунаар сахидаг уу?
- Бурхан бидэнд шунахайрч болохгүй, бусдад байгаа зүйл бидэнд байгаасай гэж хүсэх, Бурханаас өөр зүйлс биднийг аз жаргалтай болгож чадна гэж бүү бод гэж хэлсэн.
- Бурхан бидэнд Түүнээс өөр бурхадтай байж болохгүй, Бурханаас илүү чухал зүйлтэй байх ёсгүй, мөн Бурханд өргөх ёстой хүндлэлийг нь өгч, дуулгавартай байхаас биднийг тусгаарлах ямар ч зүйлийг бүү хүлээн зөвшөөр гэж хэлсэн.

[Тухайн хүнийг нүгэлтэй гэдгийг нь мэдүүлэхийн тулд эдгээр хуулиудаас дурдаад төгсгөл хэсэг рүү орно]

Андрей: Өнөөдөр чи Бурханы шүүлтийн өмнө зогсож байна. Харин чи шүүлтээс мултарч чадахгүй. Бурханы хэм хэмжээний дагуу чи бол нүгэлтэй хүн. Бурханаар шүүгдэхгүйн тулд хэрхэн өршөөл хүртэх талаар чи мэдмээр байна уу?

[Сайнмэдээг хуваалцсаны дараа тухайн хүнийг залбиралд урина]

► Хоёр суралцагч сайнмэдээг тараахад арван тушаалыг ашиглан, сайнмэдээ тарааж үзүүлнэ. Бүлгээрээ тэдний танилцуулгыг хэлэлцэж болно. Суралцагчид хоёр хоёроороо хуваагдан сайнмэдээ ярих дадлага хийгээрэй.

► Сайнмэдээ амжилттай тараасан гэдгийг хэрхэн яаж мэдэх вэ?

Хэрвээ хүн сайнмэдээг сонсоод үнэнээсээ гэмшиж, Христийн дагалдагч болохоор шийдсэн бол тэр хүнд сайнмэдээ амжилттай хүрчээ гэж ойлгодог. Гэвч энэ бол амжилтын цорын ганц хэмжүүр биш. Сонсогчийн зүрхэнд үнэнийг бат оруулж чадах нэгэн бол Бурхан юм. Хэрэв та сайнмэдээг хэн нэгэнд ойлгомжтой хүргэж чадсан бол хэзээ ч үр дүнг нь харахгүй байсан ч та чухал зүйлийг гүйцэлдүүлжээ. Хэрэв тэр хүн таны өөрт нь туслах гэсэн хүсэл зоригийг мэдэрсэн бол энэ ч мөн сайн зүйл юм. Хэрвээ тэр таныг шоолж, эсвэл уурлаж, ялангуяа үнэний үгийг сонсоод уурласан байлаа гэхэд энэ нь та бүтэлгүйтлээ гэсэн үг биш. Сайнмэдээгээр дамжуулан Бурхан өргөмжлөгддөг бөгөөд та сайнмэдээг хүнд хүргэсэн бол чухал зүйлийг амжилттай хийж чадсан гэсэн үг юм.

### **Ангийн удирдагчийн тэмдэглэл**

*Энэ бол сайнмэдээг үр дүнтэй танилцуулах арга юм. Суралцагчид энэ аргыг хэрэглэж сурах нь маш чухал. Дараагийн ангийн цагаараа энэ аргаар сайнмэдээ хуваалцсан талаараа ярих, бие биеэ урамшуулж зөвлөх цагийг гаргаарай. Дараагийн хичээл рүү шилжих хүртэл ийм маягаар хэсэг явах нь үр дүнтэй.*

### **8-р хичээлийн даалгавар**

Энэ хичээлд сайнмэдээг Андрейд хэрхэн тараасан тэр маягаар гурван хүнд сайнмэдээ тараа. Гурван хүн тус бүрийнхээ талаар цогцолбор бич. Дараагийн хичээл дээр энэ талаар ярихаар бэлтгээрэй.



## 9-р хичээл

# Сайнмэдээг танилцуулах “Гүүр” аргачлал

### Танилцуулга

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Энэ хичээлийн эхэнд суралцагчид өмнөх хичээлээр сурсан сайнмэдээ ярих арга туршлагаасаа бие биедээ хуваалцана. Сайнмэдээг сонсогч нь эерэг хариу өгөөгүй байсан ч суралцагч бүр сайнмэдээ хуваалцах чухал зорилгодоо хүрсэн. Тиймээс бие биеэ урамшуулаарай.*

*Энэ хичээл дээр үзүүлэнд зориулж том цаас, шохойн самбар, цагаан самбар бэлтгээрэй.*

Бид үзсэн, сонссоноо та нарт мөн тунхагласнаар та нар бас бидэнтэй нөхөрлөх юм. Үнэхээр бид Эцэг ба Түүний Хүү Есүс Христтэй нөхөрлөнө (1 Иохан 1:3).

► Сайнмэдээ хуваалцах ямар шалтгаан элч нарт өгөгдсөн бэ?

Бурхантай уулзаж, итгэлийн хүн болох, Түүнтэй харилцаж эхлэх нь ямар утга учиртай болохыг бид мэдлээ. Бид Бурхантай холбогдсон бусад хүмүүстэй онцгой харилцаатай болдог. Бид сайнмэдээг үл итгэгчдэд хуваалцахдаа тэднийг ч энэхүү Бурхантай нөхөрлөх нөхөрлөл рүү ирж, Түүнийг мэдээсэй хэмээн урьдаг.

### Сайнмэдээний танилцуулга

Сайнмэдээний танилцуулга нь суралцагчдад ойлгомжтой, санахад хялбар энгийн зураглалтай байдаг. Танилцуулга хоёр минут явагдах ба хэрвээ сонсогч илүү мэдээлэл авахыг хүсвэл нэмэлт тайлбар, хэлэлцүүлэг багтааж болно.

Та мэргэжлийн зураач байх шаардлагагүй. Зураг энгийн бөгөөд суралцагчдад хялбар, санахуйц хялбаршуулсан зураг байна.

Одоо бид зураг бүрийн үе шат, үүнтэй холбоотой тайлбаруудыг нэг бүрчлэн үзэх болно.

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Суралцагчдыг харж байх үед танилцуулгаа үзүүлнэ. **Ингэхдээ нэмэлт тайлбарууд оруулах гэж хичээх шаардлагагүй. Учир нь суралцагчдад ойлгоход хялбар, энгийн богино байх хэрэгтэй.** Суралцагчид танилцуулгыг эхний удаа үзэхдээ зургийг хуулбарлан зурах шаардлагагүй.*

*Хоёр дахь удаагаа танилцуулахдаа суралцагчид зургийн үе шат болгоныг ангид харагдахуйцаар таны зурсан шиг том хэмжээтэй зурах ёстой. Танилцуулгадаа нэмэлт тайлбарууд оруулахгүй байхыг хичээгээрэй. Үүний дараа дараагийн хэсгийн өгөгдсөн тайлбаруудыг үргэжлүүлэн судалж, танилцуулгаа эхнээс нь давтаарай.*

## Зургийн хэсэг тус бүрд ямар тайлбар өгөх вэ?

### 1-р хэсэг

“Бурхан хүнийг Өөртэй нь нөхөрлөж, ерөөгдсөн амьдралаар амьдруулахаар бүтээсэн. Бурхан хүний амьдралыг асуудал, бэрхшээлээр дүүрэн байхаар бүтээгээгүй.”


[“Бурхан” гэж бичээд дараа нь хүнийг зур]



### 2-р хэсэг

“Нүглээс болж хүн Бурханаас тусгаарлагдсан. Анхны хүн нүгэл үйлдэж түүнээс хойш бүх хүн Бурханы эсрэг нүгэл үйлдсэн.”


[Тусгаарлалт зураад “нүгэл” гэж бичээрэй]



### 3-р хэсэг

“Бурхан бол шударга Шүүгч бөгөөд үл итгэгчид Бурхантай харилцаа тогтоон, Түүний нигүүлслийг олж авч чадахгүй бол хэзээ нэгэн өдөр мөнхийн тамд үүрд яллагдах болно.”


[Сум зураад “там” гэж бичээрэй]



### 4-р хэсэг

“Сайн үйлс, чуулганд очих, шашны зан үйл, өглөг гэх мэт зүйлээр бид Бурхан руу болон Түүний нигүүлсэл рүү буцаж чадахгүй ...”


[Жагсаалтад хэлэгдсэн зүйлсийг сумтай хамт зур]



### 5-р хэсэг

“Хэрвээ Бурхан бидэнд Түүн рүү буцан очих зам гаргаж өгөөгүй бол бидний нөхцөл байдал ямар ч найдваргүй байх байсан. Бид уучлалыг авахын тулд Бурханы Хүү Есүс загалмай дээр тахил золиос болон нас барсан. Есүс гурван өдрийн дараа үхлээс амилсан.”


[Загалмай зур]



### 6-р хэсэг

“Үүнийг зөвхөн мэдэх нь ч хангалттай биш. Бүх хүн аврагдахын тулд хувьчлан сонголт хийж Бурхан руу эргэх хэрэгтэй. Хүн нүглээс эргэхийг чин сэтгэлээс эрмэлзэж, нүглийнхээ төлөө уучлалыг эрэн, Бурханы өмнө гэмших ёстой. Бурханаас хүсэмжлэн залбирвал гэмшдэг хүн өршөөлийг хүлээн авах боломжтой.”

[Сум зураад “гэмших”, “хүлээн авах” гэж бичээрэй]



### 7-р хэсэг

“Та өөрийгөө энэ зурган дээр хаана байна гэж бодож байна вэ? Нүглээ гэмшин Бурханы өршөөлийг хүлээн авч, Түүний төлөө амьдрахаар шийдсэн онцгой мөч амьдралд тань байна уу, эсвэл одоо хүртэл нүглээсээ болж Бурханаас тусгаарлагдсан хэвээр байна уу?”



[Хариултыг нь хүлээ. Олон хүн Бурханаас тусгаарлагдсан гэдгээ хүлээн зөвшөөрдөг]

“Та гэмших, уучлалыг хүлээн авах, Бурханы төлөө амьдрах гэсэн энэ алхмыг хийхэд бэлэн байна уу? Яг одоо би тантай залбирах болсондоо баяртай байна.”

[Дараах залбирлын дагуу залбираарай]

“Эзэн минь ээ, би мөнхийн шийтгэлийг хүртэх зохистой нүгэлт хүн гэдгээ мэднэ. Нүглийнхээ төлөө би Таниас уучлалыг эрэн бас нүглээсээ салах хүсэлтэй байна. Би Таниас өршөөл хүсэх зохисгүй боловч Та намайг уучлаач. Есүс, Та миний төлөө амиа өргөсөн, Таны намайг аварсан авралын төлөө би талархаж байна. Одооноос эхлэн би Таны төлөө амьдрах болно.”

## **Тайлбарууд**

### **1-р хэсэг**

Эхлээд сонсогчийн нөхцөлд тохируулан өөрчлөлт хийж болно. “Зовлон, бэрхшээлээр дүүрэн амьдрал” гэхийн оронд сайнмэдээ тараагч сонсогчийн туршлагатай илүү холбоотой тодорхой зүйлийг дурдаж болно.

### **2-р хэсэг**

Хүн нүгэлтэй төдийгүй Бурханаас тусгаарлагдсан гэдгийг сонсогч ойлгох нь чухал. Тэр зөвхөн Адамын нүглийн үр дагавраас болоод ийм нөхцөлд байгаа биш гэдгээ ойлгох хэрэгтэй.

### **3-р хэсэг**

Энэ нь үл итгэгчдийн байгаа ноцтой нөхцөл байдлын талаар харуулдаг.

### **4-р хэсэг**

Сонсогч нь аврал авахын тулд буруу зүйлд итгэх ёсгүй гэдгийг харуулах нь энэ хэсгийн зорилго юм. Мөн сонсогчийн хэрэгцээнд тохируулан өөрчлөлт хийх боломжтой. Сайнмэдээ тараагч нь сонсогчийн итгэж байж болзошгүй зүйлсийг нэрлэхийг хичээгээрэй.

### **5-р хэсэг**

Цагаатгалыг тайлбарлах хамгийн энгийн арга нь “Биднийг уучлахын тулд Есүс загалмай дээр тахил золиос болж үхсэн” гэдгийг хэлэх юм. Сонсогч Бурханы бидэнд өгсөн авралд найдах ёстой гэдгийг ойлгуулах нь энэ хэсгийн зорилго юм.

### **6-р хэсэг**

Сайнмэдээ тараагч нь сонсогчийг шийдвэр гаргах үе рүү хөтлөх мөч. Сонсогч хувьчлан шийдвэр гаргах ёстой гэдгээ ойлгох хэрэгтэй. Тэрээр гэмшлийн талаар зөв тодорхойлолттой байх ёстой ба гэмшил бол олон арван харамсал, уучлаач гэж хэлэхээс

илүү зүйл гэдгийг ойлгосон байх ёстой. Уучлал авахын тулд Бурханд хандан залбирах хэрэгтэй гэдгийг тэр хүн мэдэх хэрэгтэй.

## **7-р хэсэг**

Энэ үед сайнмэдээ тараагч нь сонсогчид аврал хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх гэж оролдох хэрэгтэй. Танилцуулга нь аврагдаагүй хүнд аврагдах хэрэгцээ бий гэдгээ ойлгоход нь чиглэгдсэн байна. Асуулт тавихдаа анхааралтай байна. Олон хүн өдөр бүр уучлал гуйгаад нүглээ үргэлжүүлэн хийсээр амьдарч болно гэж боддог. Уучлагдан, шинэ амьдралаар амьдарч эхлэх онцгой мөчийн тухай асуулт асуугаарай. Тэр хүн итгэлд ирэхээс нааш Бурханаас нүглийнхээ улмаас одоо ч тусгаарлагдсан хэвээр байгаа гэдгээ ухаарах хэрэгтэй. Сайнмэдээ тараагч нь түүний авралын төлөө залбирах хүсэлтэй байгаагаа илэрхийлээрэй.

Хэрвээ сонсогч өөрийнхөө хэрэгцээг ухаарахгүй, эсвэл гэмшилд бэлэн бус байвал сайнмэдээ тараагч түүнийг залбир гэж хүчилж болохгүй. Хэрвээ тэр үнэнээсээ гэмшиж, итгэлд ирээгүй атлаа зүгээр л залбирвал түүнд авралын хуурамч баталгаа бий болох, эсвэл итгэлд ирэх нь түүнд тохиолдохгүй гэж итгэх ч боломжтой. Аль ч тохиолдолд ирээдүйд тэрээр Бурханыг хайх хүсэлгүй болох талтай.

Зургийг хурдан танилцуулж болно. Хэрэв танд сайнмэдээг хуваалцах боломж байгаа бол та энгийнээр “Танд аврагдсан гэдгээ баттай мэдэх арга замыг Библид юу гэж хэлснийг харуулсан зургийг үзүүлэхэд хоёр минут зарцуулж болох уу?” гэж асууж болно. Энэ нь тухайн хүнд та их цаг зарцуулахгүй гэдгийг ойлгуулна. Хэрэв тэр сонирхож, энэ тухай ярихыг хүсэж байвал та илүү их цаг гаргаж болно. Ихэвчлэн хүмүүс зурж байгаа зургийг сонирхдог. Сайнмэдээ тарааж дууссаны дараа ч зураг зурж өгөхийг хүсдэг.

## **Ангийн удирдагчийн тэмдэглэл**

*Танилцуулгыг дахин хэд хэдэн удаа үзүүлээрэй. Хэрвээ танилцуулга богинохон байвал суралцагчид хялбархан тогтоож цээжлэх учраас танилцуулгадаа илүү тайлбар нэмэхээс зайлсхий. Хэд хэдэн удаа үзүүлсний дараа, янз бүрийн сурагчид ээлжлэн сайн мэдээний танилцуулгыг бүлэгт толилуулж болох ба энэ үеэр бүлгийн гишүүд тэдэнд нарийн ширийн зүйлийг санахад нь тусална. Дараа нь суралцагчид хоёр хоёроороо болж хуваагдаад, бие биедээ танилцуулгаа үзүүлж дадлага хийнэ.*

## **9-р хичээлийн даалгаврууд**

(1) Сайнмэдээг танилцуулах “Гүүр” зургаар хамгийн багадаа гурван хүнд сайнмэдээ яриарай. Ярилцлага бүр дээрээ тэмдэглэл хөтөлж, дараагийн хичээлийн цагаар ярихад бэлтгээрэй.

(2) Дараагийн хичээлд бэлтгэн, Ром 1-3, 5, 10-р бүлгүүдийг уншиж тунгаагаарай.

# 10-р хичээл

## Ромын зам

### Ангийн удирдагчийн тэмдэглэл

*Суралцагчдаас сайнмэдээ танилцуулах "Гүүр" зургийг ашиглан сайнмэдээг танилцуулсан талаар тайланг нь сонсоно.*

### Ром номын танилцуулга

Паул Ром руу аялахаар төлөвлөсөн ба тэнд сайнмэдээ тарааж (Ром 1:15), итгэгчдийг хүчирхэгжүүлээд зогсохгүй (Ром 1:11-12), Ромын чуулганаас Испани хүрэх сайнмэдээний аялалдаа дэмжлэг хүсжээ (Ром 15:24).

Ромын чуулганд бичсэн захидлын зорилго нь Паул өөрийгөө болон авралын теологийнхоо талаар Ромын итгэгчдэд танилцуулах явдал байлаа. Энэхүү захиандаа авралын теологийг тайлбарласнаар дэлхий даяар хийгдэж буй илгээлтийн ажлын үндэс суурийг харуулжээ.

Тухайн үед Испани нь дэлхийн соёл иргэншлийн төв болсон эртний Ромын колоничлолд байдаг баруун Европын улс байсан бөгөөд Паул Испани руу явах сайнмэдээний анхны аялалдаа Ромын чуулганаас дэмжлэг авахаар төлөвлөж байсан.

Паулын Ром руу явах сайнмэдээний аялал түүний төлөвлөсний дагуу болоогүй юм. Тэр Йерусалимд баривчлагдсан. Тэрээр үүнийг шударга бус гэж үзсэн учраас Цезарьт давж заалдсан. Хөлөг онгоц нь сүйрсэн аюултай аяллын дараа НТ 60 онд Ромд хоригджээ. Хэдийгээр гэрийн хорионд байсан ч түүн дээр ирсэн бүгдийг чөлөөтэйгээр хүлээн авч, хот даяар Бурханы хаанчлалыг тунхаглаж байлаа (Үйлс 28:30-31). Ромд болсон энэ үйл явдал сайнмэдээ хүчтэй дэлгэрэхэд нөлөө үзүүлсэн гэж Паул хэлсэн байдаг (Филиппой 1:12). Цезарийн гэр бүлээс ч Христэд итгэгч болж байсан. Паул хоёр жилийн дараа суллагдсан ч Испани руу явсан эсэх нь тодорхойгүй.

Түүнийг аяллаа үргэжлүүлэхэд Ромын чуулган тусалсан эсэх талаар зарим нэг асуулт гарч ирдэг. Яагаад тэр ганцаараа явах ёстой болов? гэж хэн нэгэн асууж болох юм. Паул сайнмэдээ дэлгэрүүлэхийн тулд дуудагдсан гэдгээ дурдсанаар захидал эхэлдэг (Ром 1:1). Дараа нь тэр харь үндэстнүүдийн төлөөх элчийн онцгой дуудлага болон амжилтаа тайлбарласан (Ром 15:15-20).

Яагаад хүн бүр сайнмэдээг сонсох ёстой вэ? гэсэн өөр нэг асуултыг асууж болох юм. Магадгүй энэ мэдээг газар сайгүй сонсгох шаардлага байх уу? зэрэг асуултад Паул сайнмэдээний хүн төрөлхтөн рүү хандсан хүч чадлыг (Ром 1:14-16, Ром 10:12) тайлбарлаж, мөн сайнмэдээг дэлгэрүүлэх зайлшгүй шаардлагатайг дурджээ (Ром 10:14-

15). Сайнмэдээ нь хүн бүрд хамаатай бөгөөд бүх хүн заавал сонсох шаардлагатай гэдгийг Паул хэлсэн юм.

### **Ром ном - Өнгөрсөн ба Одоо**

Энэ захидал нь сайнмэдээ дэлгэрүүлэх чухал үндэс болоод зогсохгүй анх бичигдсэн зорилгоо өнөөг хүртэл биелүүлсээр байна. Паул сайнмэдээг яагаад хүн бүр сонсох шаардлагатай, сайнмэдээ гэж юу болох, яагаад хүн бүр зөвхөн энэ сайнмэдээгээр дамжуулан аврагдахын учир утгыг тайлбарласан. Тэрээр нийтлэг тохиолддог эсэргүүцлүүдийг няцаасан. Түүний сайнмэдээний тайлбарууд, сайнмэдээг хамгаалсан номлолууд нь энэ номын талаас илүү хувийг эзлэх бөгөөд үндсэн бүтэц нь болж өгдөг.

Ром ном нь авралын теологийн тайлбар юм. Паулын авралын онол нь иудейн хуульчлах үзлийн эсрэг нотолгоо болдог төдийгүй орчин үеийн авралын онол сургаалуудын гажуудлыг ч залруулдаг.

Вильям Тиндэйл, Ром номын талаар “Паулын зорилго бол Христийн сайнмэдээг заах суурь болон Хуучин гэрээг бүхэлд нь нарийн тодорхой ойлгох суурийг ч тавьсан” гэжээ.<sup>4</sup>

Түүхийн туршид Бурхан Ром номоор дамжуулан хамгийн чухал мартагдсан үнэнийг ахин дахин сануулсаар ирсэн.

НТ 386 онд Августин Ром 13:13-14-ийг уншсаны дараа өөрийн нүгэлт амьдралаа орхих шийдвэр гаргасан.

Мартин Лютер 1515 онд Ром 1:17 эшлэлийн утгыг ухаарсан юм. Бурханы шүүлтээс хэлтрэх нэгэнд зөвхөн авралын итгэл хэрэгтэй хэмээн тэр ойлгожээ. Энэ нь түүний удаан хугацааны туршид хайж байсан авралын баталгааны үндэс байжээ. Зөвхөн итгэлээр л аврагдах болно гэсэн түүний сургаалын үндэс ийнхүү тавигджээ.

Жон Веслей 1738 онд Библийн дагуу Христийг дагах талаар судлахаар тогтмол цугладаг залуучуудын уулзалтанд оролцож байх үедээ олон жилийн туршид эрж хайж байсан хувь хүний авралын баталгаа юу болохыг олж мэдсэн байна. Залуусын нэг нь Ром номын талаар бичсэн Лютерийн өмнөх үгийг уншиж байх үед түүний зүрх халуу шатахыг мэдэрчээ. Тэрээр гэрчлэлдээ “Би Христэд итгэсэн, зөвхөн Христ л миний аврал. Тэр миний нүглүүдийг уучлан, *намайг ч бас, нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлж аварсан гэдэг баталгааг би олж авлаа.*”<sup>5</sup>

Дээр дурдсан гурван хүн бүгдээрээ Ром номоос сайнмэдээг идэвхтэйгээр дэлгэрүүлэх сэдэл ятгалгыг хүлээн авчээ. Авралын теологийг тайлбарлаж,

Үүрд мөнхийн, өөрчлөгдөшгүй Бурханы товлал эсвэл зорилгыг дэлгэн харуулах нь энэхүү захидлын ерөнхий агуулга юм. Түүнд итгэдэг нэгэн аврагдах болно. Харин Түүнд үл итгэгч нь шүүлтэд унах болно.  
-Жон Веслей

<sup>4</sup> William Tyndale, “Prologue to Romans,” *English New Testament*, 1534.

<sup>5</sup> John Wesley, *The Works of John Wesley*, (Kansas City: Nazarene Publishing House, n.d.), 103.

илгээлтийн үндэс суурь болсноороо энэ ном өнөөг хүртэл бичигдсэн зорилгоо биелүүлсээр байна.

**Ром ном бүхэлдээ Ром 1:16-18 эшлэлийг дэлгэрүүлж тайлбарласан тайлбар юм.**

Паулын хэлсэн 1-14 эшлэлд байгаа бүх санаа нь “сайнмэдээ хүргэхээр тэсэн ядаж байна” гэж хэлсэн 15-р эшлэл рүү хөтөлж байна. Харин 16-18-р эшлэлд сайнмэдээ гэж юу болох, яагаад бүх хүнд хэрэгтэй гэдгийг товчхон тайлбарласан. Нүгэлтнүүд итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь сайнмэдээ юм. Бүгд Бурханы уур хилэнгийн доор байгаа учраас бүх хүнд сайнмэдээ хэрэгтэй байгаа юм.

**Ром номын өөр нэг чухал зорилго нь “Хэн итгэнэ, тэр хүн аврагдана, хэн үл итгэнэ, тэр хүн ялагдана” гэсэн Бурханы хуулинд суурилсан сайнмэдээний тайлбар юм.**

Ром номын оргил хэсэг Ром 10:13-15-д бичигдсэн бөгөөд сайнмэдээг дамжуулах элч нар яагаад чухал болохыг тайлбарласан. Итгэлээр хүн аврагдах боловч сайнмэдээ сонсохгүйгээр итгэх боломжгүй гэж Паул хэлжээ.

**Ром номоор сайнмэдээг танилцуулах нь**

Сайнмэдээг зөвхөн Ром номын эшлэлүүдээр тайлбарлаж болох юм. Үүнийг заримдаа “Ромын зам” гэж нэрлэдэг.

Тайлбар бүрийн эхний өгүүлбэр нь гол түлхүүр утга санааг илэрхийлдэг учраас цээжлэх нь чухал.

**Ром 3:23**

“Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй”

**Хүн бүр буруу гэж мэддэг зүйлээ хийснээр нүгэл үйлдсэн.**

Энэ эшлэл нь хүмүүст тулгардаг бодит асуудлыг илэрхийлдэг. Хүмүүс Бурханыг дагаагүй, зориудаар Бурханд дуулгаваргүй хандсан юм. Дуулгаваргүй байдал нь бүх хүнд хамаатай. Хүн байнга зөв зүйл хийлээ ч Бурхан зөвт гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Дээрх эшлэлийг илүү сайн ойлгохын тулд дараах эшлэлүүдийг ашиглаж болно.

Ром 3:10 (“Зөвт хүн алга, ганц ч алга”)

Ром 5:12 (“бүгд нүгэл үйлдсэнээр үхэл нь бүх хүнд иржээ”). **Ром 6:23** “Учир нь нүглийн хөлс нь үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.”

**Нүгэлтнүүд мөнхийн үхлийг хүртэх ёстой бол харин Бурхан Есүсээр дамжуулан мөнхийн амийг бэлэг болгон өгсөн.**

Энэ эшлэлд нүгэл яагаад ноцтой вэ? гэдгийг хэлж байна. Нүглийн улмаас хүн бүрд үхлийн шийтгэл ирдэг. Бурханы шийтгэл, мөнхийн үхэл нь нүгэлтнүүдэд зориулагджээ.

Бидний хүртэх ёстой зүйл нь үхэл байсан ч харин бидний хүртэх зохисгүй зүйл буюу амийн бэлгийг Бурхан бидэнд өгч байна.

**Ром 5:8**

“Гэтэл биднийг нүгэлтнүүд байхын л Христ бидний төлөө үхсэнээр Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан”

**Бурханы бэлэг нь Христийн үхлээр дамжуулан бидэнд өгөгдсөн.**

Бидний хүртэх ёстой шийтгэлээр Бурхан биднийг шийтгэхийг хүсээгүй юм. Учир нь Тэр биднийг хайрлаж нигүүлслийг хүлээн авах боломж өгсөн. Биднийг өршөөхийн тулд Есүс нүглийн тахил золиос болж үхсэн. Аврагдахын тулд ямар нэг зүйл хийхийг Бурхан биднээс шаардаагүй бөгөөд биднийг нүгэлтнүүд байхад Бурхан бидэнд авралыг өгсөн юм. Аврал нь сайн хүний төлөө бус, харин нүгэлтнүүдийн төлөө зориулагджээ.

**Ром 10:9**

“Хэрэв та хүлээн зөвшөөрч... итгэвэл... аврагдах болно.”

**Авралын цорын ганц шаардлага нь нүгэлтэн нүглээ хүлээн зөвшөөрч, Есүсийн үхэл ба амиллаар ирэх Бурханы өршөөлд итгэх явдал юм.**

Гэмшил гэж юу вэ? Хэрэв хүн бурууг үйлдсэнээ хүлээн зөвшөөрч, өршөөлийг хүлээн авахыг хүсвэл нүгэлт замаасаа эргэхэд бэлэн гэдгээ илэрхийлж буй хэрэг юм.

**Ром 10:13**

“Эзэний нэрийг дууддаг бүхэн аврагдах болно.”

**Хүн бүр аврал авах боломжтой.**

Бүх хүнд хамаатай, өөр шалгуур гэж байхгүй.

**Ром 5:1**

“Тиймээс бид итгэлээр зөвтгөгдсөн тул... Бурхантай эвлэрсэн.”

**Бурханы амлалтад итгэснээр бид нүгэлтэн гэж тооцогдохгүй, харин Түүний анд нөхөр болдог.**

Бурхантай найрамдах гэдэг нь бид Түүний дайснууд бус харин Түүнтэй эвлэрсэн гэсэн утгатай. Биднийг Бурханаас тусгаарладаг нүглээс ангижирсан. Зөвтгөгдсөн гэдэг нь бид

гэм буруутай гэж тооцогдохгүй гэсэн утгатай. **Итгэлээр зөвтгөгдсөн** гэдэг нь бид уучлал авахад шаардлагатай Бурханы амлалтад итгэхийг хэлнэ.

### **Ром 8:1**

“Иймд эдүгээ Христ Есүс дор байгаа хүмүүст ямар ч ял үгүй.”

**Бид Бурхантай нэгдсэн учраас биднийг буруутгадаг нүглийн буруутгалаас чөлөөлөгдсөн.**

Христ нүгэлгүй амьдралаар амьдарсан ба загалмай дээрх Түүний үхэл шударга ёсны шаардлагуудыг биелүүлсэн юм. Итгэлээр бид Түүнтэй нэгдэж, Бурхан Эцэг биднийг хүлээн авсан. Биднийг хэзээ ч нүгэл үйлдээгүй мэт Бурхан бидэнд тийнхүү хандсан юм.

### **Дүгнэлт**

Үл итгэгч хүн Бурханд хандан залбирч, нүгэл үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрч, Есүсийн үхэл, амиллын золилтын үндсэн дээр өршөөлийг гуйснаар аврагдах боломжтой болсон юм.

### **Сурснаа хэрэгжүүлэх нь**

Сурснаа хэрэгжүүлэх хамгийн сайн арга бол эхлээд Ром номд байгаа хэрэглэгдэх эшлэл бүрийг Библи дээрээ дугуйлж, доогуур зурж тэмдэглэх арга юм. Дараа нь эшлэлүүдийг ашиглах дарааллыг харуулсан тоог эшлэл тус бүрийн хажууд тавина. Жишээ нь, эхлээд хэрэглэх эшлэлийнхээ хажууд 1-ийн тоог бичнэ гэх мэт.

Сайнмэдээ тараах дадлага хий. Эшлэл бүрийг уншаад холбоотой тайлбар бич. Эшлэл бүрийн дарааллаар эхний өгүүлбэрт байгаа ойлголтуудыг оруулаарай. Дараа нь шаардлагатай бүх тайлбарыг нэмж, шаардлагатай бол өөр өгүүлбэрүүдийг ашиглаарай. Энэ хичээлд заасан эшлэлүүдийг бүгдийг заавал ашиглах шаардлагагүй. Библиэс харахгүйгээр хийж чадах хүртлээ дадлага хийгээрэй.

*Ангийн удирдагчийн тэмдэглэл: Хоёр эсвэл гурван суралцагч "Ромын зам"-ыг ашиглан ангид сайнмэдээ яриарай. Суралцагчид сайнмэдээг сонсоод хэрхэн сайжруулах арга замуудыг хэлэлцэх ёстой. Дараа нь суралцагчид хоёр хоёроороо дадлага хийж, хүн тус бүр өөр өөр сонсогчдод хоёр удаа ярьж өгөөрэй.*

## 10-р хичээлийн даалгаврууд

(1) “Ромын зам” сайнмэдээний танилцуулгыг ашиглан хоёр эсвэл гурван хүнд сайнмэдээ яриарай. Ярилцлага бүрд 2-3 мөр тэмдэглэл хөтлөөд дараагийн уулзалтад ирэхдээ ярихад бэлэн байгаарай.

(2) Дараагийн хичээлийн эхэнд зөвхөн Библиэ ашиглан “Ромын зам” танилцуулгаас сурсан эшлэлүүдийг нэг өгүүлбэрээр тайлбарлан бичихэд бэлтгээрэй.

(3) Дараагийн хичээл нь сайнмэдээг номлох тухай хичээл юм. Энэ хичээлд бэлтгэхдээ заасан, сонссон эсвэл илүү дэлгэрүүлж заахыг хүсэж байгаа сайнмэдээний сургаал эшлэлүүдийг хураангуйлан тойм болгож бичээд, дараагийн хичээлд авч ирээрэй.

## 10-р хичээлийн сорил

“Ромын зам” сайнмэдээний танилцуулгад Бичвэрээс ашигласан эшлэлүүдийн эшлэлүүдийг бичнэ үү. Дор дурдсан эшлэлүүдийн тайлбарыг хамгийн багадаа нэг өгүүлбэрээр бичээрэй. Эшлэлүүдийг бичих шаардлагагүй.

(1) Ром \_\_\_\_\_

(2) Ром \_\_\_\_\_

(3) Ром \_\_\_\_\_

(4) Ром \_\_\_\_\_

(5) Ром \_\_\_\_\_

(6) Ром \_\_\_\_\_

(7) Ром \_\_\_\_\_



# 11-р хичээл

## Сайнмэдээний номлол

### Танилцуулга

► Нэг суралцагч 1 Коринт 1:17-25-ыг ангид уншина. Алдагдсан хүмүүсийг аврах Бурханы арга зам юу вэ?

Үндэстнийг нь аварч чадах хүчийг еврейчүүд хайж байлаа. Тиймээс үүнийг батлах эрх мэдлийн тэмдэг болсон хүч чадалтай номлолыг тэд хүсэж байв.

Харин амьдралыг ойлгох мэргэн ухаан болон энэ дэлхийн амжилтыг харь үндэстнүүд хүсэж байлаа. Тиймээс хүссэнээ олж авахад нь туслах аргыг тайлбарласан номлолыг л тэд хүсэж байсан.

Загалмай бол бууж өгөх, золиослох гэсэн санааг илэрхийлдэг. Эрх мэдлийг хүссэн еврейчүүдийн хувьд энэ нь сул дорой байдал байв. Харин энэ дэлхийн мэргэн ухааныг хайсан харь үндэстнүүдийн хувьд энэ нь мунхаглал байлаа. Бодит байдал дээр Бурханы мэргэн ухаан, хүч чадал нь Христийн үхлээр харагдсан юм. Тиймээс загалмай нь Бурханыг мунхаг, сул дорой харагдуулсан боловч үнэндээ хүмүүсийн хамгийн сайн хүчин зүтгэлээс ч агуу үйлс байсан билээ.

Сайнмэдээ нь хүн төрөлхтний төрөлхийн, нүгэлт мөн чанарын эсрэг мэдээ бөгөөд хүмүүсийг гэмшиж, Бурханы өмнө бууж өгөхийг уриалдаг. Гэтэл хүмүүсийн хувьд хүсэж буй зүйлээ хэрхэн олж авч болох аргыг сонсмоор байдаг учраас энэ мэдээ магадгүй тэнэг санаа шиг харагдаж болох юм.

Бурхан сайнмэдээг ашиглан хүмүүсийг аврах сонголтыг хийжээ. Тэрбээр итгэгчдэд харилцаа үүсгэх даалгаврыг өгсөн байна. *Номлох* гэдэг нь зөвхөн олны өмнө зогсоод юм ярих төдий зүйл биш, харин сайнмэдээг дамжуулж байгаа олон талт харилцаа юм. Мэдээж олон нийтэд номлох нь Бурханы сонгосон арга биш гэж энд хэлэх гэсэнгүй. Харин сайнмэдээ нь Бурханы сонгосон арга гэдгийг хэлж байна.

► Загалмайн тухай номлол нь итгэдэггүй хүмүүсийн хувьд мунхаглал гэсэн эшлэл ямар санааг илэрхийлж байна вэ?

### Сайнмэдээний номлолыг тодорхойлох нь

*Номлох* гэдэг нь Бурханы Үгийг дамжуулах янз бүрийн арга хэлбэрийг хамруулсан өргөн утга санаа юм. Гэхдээ бид энэ хичээлээр *номлох* гэсэн үгийг ердийн утгаар нь буюу Бурханы Үгийг цугларсан хүмүүст ярих гэсэн утгаар нь хэрэглэнэ.

Цугларсан бүлэг хүмүүст сайнмэдээг танилцуулан ярих нь сайнмэдээний номлол юм. Ийм номлол нь ямар нэгэн сэдэв, Библийн эшлэлийг зөвхөн танилцуулах бус, харин сайнмэдээг номлодог.

Сайнмэдээг номлогч нь ихэвчлэн сонсогчдоо ятгаж, тунхаглаж буй мэдээнд даруй хариу өгүүлэх, улмаар итгэлийн замд оруулахыг хичээдэг. Ийм номлол хүнийг шийдвэр гаргахад нөлөөлөх зорилготой.

Сайнмэдээний номлолоор ярих агуулгыг анхааралтай сонгодог. Мэдээж ийм номлол хөгжүүлж боловсруулах зорилго агуулдаггүй. Сонсож байгаа хүмүүст итгэх шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг ойлгуулсан агуулгыг номлогч дамжуулна. Энэхүү агуулга нь сайнмэдээний суурь ойлголт, хэрхэн шийдвэр гаргах болон уг шийдвэрийн боломжит үр өгөөжийн талаар тайлбарласан номлол байдаг.

Номлол магадгүй чуулганых шиг чимээгүй, цэгцтэй суудалтай орчинд эсвэл ямар нэг зорилгоор цугласан олон хүний өмнө яригдаж болно. Номлолыг нааштай хүлээж авч ч болно, үгүй ч байж болно.

► Сайнмэдээг номлож болох ямар ямар орчныг та мэдэх вэ?

### **Сайнмэдээг номлох заавар**

Сайнмэдээг чуулганд номлох болон янз бүрийн хэсэг бүлэг хүмүүсийн дунд номлох нь ялгаатай учраас бид эхлээд чуулганд сайнмэдээг номлох зааврыг өгнө. Энэхүү хичээлийн дараагийн хэсэгт бид чуулганаас гадуур сайнмэдээг номлох талаар удирдамж өгөх болно.

#### **(1) Библийн эшлэлээс тайлбарла.**

Бурханы Үг маш хүчирхэг учраас номлогч ашиглах ёстой. Эшлэл заавал урт байх эсвэл номлогч удаан ярьж, үг бүрийг нэг бүрчлэн тайлбарлах албагүй. Харин Библийн сайнмэдээний хэсгээс ярих ёстой юм. Номлогчийн ярианы гол санаа нь Библид суурилсан байх ёстой ба ингэснээр Бурханы Үгийн хүчийг ашиглах боломжтой. Харин эшлэлийг илэрхийлж байгаа утгаас нь өөр утга агуулгаар ашиглахаар сонгох ёсгүй.

#### **(2) Гэмшил ба итгэл гэх нэр томъёог тодорхойл.**

Сонсогчид эдгээр нэр томъёоны талаар буруу ойлголттой байж болно. Магадгүй гэмшиж амьдралаа зөв болговол Бурхан хүнийг хүлээн авдаг гэж бодож байж ч болох юм. Тэгвэл гэмшил гэдэг нь нүгэлдээ ихэд харамсаж, нүглээс чөлөөлөгдөхөд бэлэн байхыг хэлж байгаа гэдгийг хүмүүс мэдэх учиртай.

Сонсогчид итгэлийг шашин эсвэл шашны ёслолыг хэрэгжүүлэх гэж ойлгодог. Тиймээс авралын итгэл гэдэг нь Христийн эвлэрүүлэлд бүрэн итгэж найдах гэсэн утгатайг тэд ойлгох ёстой.

### **(3) Итгэлд ирэх мөчид хүн Христэд итгэгч болдгийг онцол.**

Христэд итгэгч байх нь хэн болох, итгэгч болно гэдэг ямар учиртай талаар хүмүүс буруу ойлголттой явдаг. Хүмүүсийн бодлоор номлогчид итгэгчдийг сүсэг бишрэл ихтэй болгох, эсвэл чуулганыхаа нэг гишүүн болгохыг хүсдэг гэж ойлгодог. Номлогчид хүмүүсийг хатуу чанд байдлаар амьдрах ёстой гэж үздэг хэмээн тэд боддог. Гэвч нүгэлтэн гэмшиж, уучлалыг хүлээн авч, Бурхантай хувьчилсан харилцааг эхлэх үедээ л итгэгч болдог гэдгийг онцлон хэлэх ёстой юм.

### **(4) Хүмүүс өөрсдийгөө Христэд итгэгч гэж хэлдэг буруу шалтгаануудыг няцаа.**

Зарим улсын ихэнх хүмүүс өөрсдийгөө Христэд итгэгч гэж үздэг. Тэд өөрсдийгөө чуулганд явдаг, сайн үйлс хийдэг, зарим үзэл ойлголтод итгэдэг эсвэл сүнслэг туршлага хураасан учраас Христэд итгэгч болсон гэж боддог ч байж болох юм. Тиймээс Христэд итгэх болон Бурхантай харилцаж амьдрах, гэмшсэний дараа дуулгавартай байх тухай онцлон ярих нь зүйтэй.

### **(5) Чуулганд хамрагддаггүй хүмүүст ч ойлгомжтой байхаар ярь.**

Зөвхөн итгэгчдийн мэддэг нэр томъёог ашиглахаас зайлсхий. Сонсож байгаа хүмүүсийн тань хувьд ойлгомжгүй байж болох шашны ёс заншлыг бүү дурд.

► Танай хөршүүдийн хувьд ойлгомжгүй, харин чуулганы тань гишүүдэд танил байж болох ямар ямар нэр томъёо байдаг вэ?

### **(6) Уучлал гүйх, Бурхантай харилцаатай байх тухай болон мөнх амийг санал болгоорой.**

Энэ бүхэн дахин төрөхийн хамгийн гол ашиг тус юм. Түүнчлэн үл итгэгчид дээр ирэх шүүлт, мөнхийн шийтгэлийг тайлбарлаж, нүгэлт хүний нөхцөл байдал ямар ноцтой байгааг хэл.

### **(7) Сайнмэдээнд дурдаагүй ямар нэг ашиг тусыг амлахаас зайлсхий.**

Хэрэв хүмүүс чуулганаас ирэх материаллаг тусламж, амжилт, өвчнөөс эдгэрэх, амьдралын нөхцөл байдлаа сайжруулах зэрэг ашиг тусыг авралын сайнмэдээтэй холбож бодвол жинхэнэ гэмшилгүйгээр сайнмэдээг хүлээн авах гэж оролдож болох юм.

Тиймээс Бурхан хүний амьдралыг удирдан чиглүүлж, ерөөж, асуудлыг шийдвэрлэхэд нь тусална гэдгийг та тайлбарлаарай. Гэхдээ Христийн дагалдагч болбол тэдний бүх асуудал шийдэгдэнэ гэх мэтээр бид амлах ёсгүй. Зарим хүмүүсийн хувьд хавчлагаас болж амьдрал нь улам хүндэрч ч болно.

### **(8) Христ дээр ирэхийг нутгийн чуулганы гишүүнчлэлтэй холбож болохгүй.**

Хүн үнэхээр Христийг хүлээн авч итгэсэн бол чуулганы гишүүн болж болно. Тиймээс итгэсний дараа чуулганы гишүүнчлэлийн талаар ярих ёстой. Нүглээ гэмших ёстойг

тайлбарлаж байхдаа чуулганы гишүүн болох нөхцөл шаардлагыг бүү ярь. Яагаад гэвэл сайнмэдээг тунхаглагч нь сонсож буй хүнээ Бурхантай уулзахад нь чиглүүлэх ёстой.

► Аврал авахтай холбоогүй, чуулганы гишүүнчлэлийн ямар ямар нөхцөл шаардлага байдаг вэ?

### **(9) Төлөвшсөн хүнээс нэхэгддэг шаардлагуудыг дөнгөж итгэж буй хүнд бүү тавь.**

Нүгэл гэж ухамсарлаж байгаа зүйлээ гэмшихийг сонсож буй хүндээ уриал. Итгэгч болоод тодорхой хугацааны дараа мэдэж болох нарийн ширийн зүйлийг хэлэх хэрэггүй. Гэмшил, итгэлийн дуудлага нь өөрөө амаргүй сэдэв юм. Тиймээс сайнмэдээг үгүйсгэхэд хүргэж болох ямарваа хүндрэлийг битгий нэм.

### **(10) Юу хийхийг уриалж буйгаа тодорхой тайлбарла.**

Сонсож буй хүн тань гэмшиж, Бурханаас уучлал гуйхаа мэдэж байгаа гэж битгий бодоорой. Урагш гарч ирээд, өвдөг сөгдөхөө мэдэж байгаа гэж ч бодох хэрэггүй. Тиймээс сонсож буй хүмүүстээ яг юу хийх хэрэгтэй байгааг та уриал. Мөн чуулганы орчинд байгаа бол ичимхий зантай хүмүүсийг яаж хамруулж болох талаар бас бодолцоорой.

### **Сайнмэдээг эрэлхийлж буй хүмүүстэй хамт залбирах**

Хүмүүс олон шалтгааны улмаас залбирахаар цуглардаг. Заримдаа пастор хүмүүсийг янз бүрийн хэрэгцээний төлөө залбирахыг уриалдаг. Энд жагсаасан удирдамж нь залбирлын бүх тохиолдлыг хамруулах албагүй. Харин сайнмэдээний номлолын дараа уриалгад хариу өгсөн хүмүүстэй хамт залбирахад зориулагдсан юм.

Авралын төлөө залбирагсдад туслах хүмүүс сайтар бэлтгэгдсэн байх ёстой гэдгийг пастор анхаарна. Пасторыг сайнмэдээнд уриалахад эдгээр туслагчид шинэ хүмүүст туслахад бэлэн байх учиртай.

Заримдаа туслах ёстой хүмүүс нь тус биш саад болох нь бий. Тиймээс асуудал гарвал пастор даруй анхаарч, туслахад бэлэн байх ёстой. Хэрэв ухаалаг бус зан авир, буруу зөвлөгөө гэх мэтээр саад болж байвал пастор үүссэн асуудлыг зохицуулж шаардлагатай арга хэмжээг авна.

Бид хүн гэмшиж, итгэж, авралын өөрчлөлтийг тэр даруйд туулж чадна гэж итгэдэг. Энэхүү итгэл үнэмшил маань сайнмэдээг эрэлхийлж буй хүмүүстэй цуг залбирахад чиглүүлдэг.

## **Сайнмэдээг эрэлхийлж буй хүмүүстэй хамт залбирах удирдамж**

### **(1) Пасторын уриалгыг хүлээн авч буй хүмүүстэй ядаж нэг төлөвшсөн итгэгч хамт залбирах хэрэгтэй.**

Шинэ хүнийг ганцааранг нь залбируулахаар орхиж болохгүй. Бид сайнмэдээнд хариу өгч буй хүмүүсийг ялаасай гэж хүсдэг шүү дээ.

### **(2) Уриалгыг хүлээн авагчаас яагаад залбирч байгааг нь асуу.**

Шинэ хүн шууд авралын төлөө залбирна гэж бодох хэрэггүй. Сайнмэдээний номлолын дараа ч хүмүүс янз бүрийн шалтгаанаар залбирахаар гарч ирж болно. Тиймээс туслахаар очсон итгэгчид залбирч байгаа хүнийг шууд тасалдуулах хэрэггүй боловч, тухайн хүнээс боломжийг ашиглан “Та Бурханаас юу хүсэж байна вэ?” гэж асуугаад үзэх хэрэгтэй. Тэгээд тэр хүний хэрэгцээний төлөө хамт залбираарай.

### **(3) Гэмшихийг хүсэж буй хүнийг урамшуулаарай.**

“Та гэмшихийг хүсэж байна уу? Бурхан нүглээс тань чөлөөлөхийг та хүсэж байна уу?” гэж асуугаарай. Тэгээд Бурханд хандан гэмшин залбирахад нь урамшуул. Тухайн хүн пастор эсвэл хэн нэгэн хүнд онцгой буруу юм хийгээгүй л бол нүглээ заавал пасторт, эсвэл хэн нэгэнд наманчлах шаардлагагүй.

### **(4) Бурхан уучилдаг гэдгийг баттай хэлж өгөөрэй.**

Бурханаас уучлал гуйж, уучилна гэсэн Бурханы амлалтад итгэх учиртайг хэлж өгөөрэй. Хэрэв тухайн хүн эргэлзээд байвал Библи дээрх амлалтуудыг үзүүлээрэй (1 Иохан 1:9, Иохан 3:16, Ром 5:8).

Хэрэв хүн өөрийнхөө үгээр залбирч чадахгүй байвал туслахаар очсон итгэгч залбирал хэлж, дагуулах маягаар ийнхүү залбирч болно.

“Эзэн минь, би мөнхийн шийтгэл хүртвэл зохих нүгэлтэй хүн гэдгээ мэдэж байна. Нүглийг минь уучлаач. Би одоо бүгдийг нь орхихийг хүсэж байна. Та намайг авраач. Би аврагдах зохистой учраас биш, харин Есүс миний төлөө үхсэн учраас намайг авраач. Таны авралд баярлалаа. Энэ цагаас эхлэн би Таны төлөө амьдрах болно.”

Дөнгөж ирсэн хүний хувьд ялалтын залбирлаар залбирах нь ихэнхдээ амаргүй байдаг. Мөн тухайн хүнд орхихыг хүсэхгүй байгаа нүгэл ч байж болно. Чин үнэнээсээ гэмшихээс нааш тийм хүн авралын итгэлтэй болж чадахгүй.

### **(5) Итгэлд ирсэн хүнээс гэрчлэл байгаа эсэхийг нь асуугаарай.**

Хэрэв Христийг хүлээн авагч нь ялалтын залбирал хийж чадсан бол түүнээс “Бурхан таны төлөө юу хийсэн бэ?” гэж асуугаад тодорхой гэрчлэн ярих урам зоригийг өгөөрэй. Магадгүй тэр хүн чуулганд гэрчлэл хийж ч болно. Ямартай ч ядаж л хамт залбирсан хүндээ гэрчлэлээ хуваалцах нь чухал юм.

## **(6) Авралын талаар тайлбарласан хэвлэмэл материалыг өг.**

Залбиралд тусалж байгаа хүн авчирсан хэвлэмэл материалаа тухайн шинэ хүнд өгөх хэрэгтэй. Иймэрхүү материалууд түүнд авралын тухай мэдэхэд нь болон бусдад тайлбарлан ярихад нь тусална.

## **(7) Дагалдагч болох эхний алхмаа хийхэд нь туслаарай.**

Пастор юм уу, төлөвшсөн итгэгчтэй уулзах нь дагалдагч болох эхний алхам байдаг. Залбирлаар шинэ итгэгч юу болж байгааг сайн ойлгосон байх ёстой. Үүний дараа жижиг бүлэгт хамрагдах, эсвэл хэн нэгэнтэй байнга уулзаж ярилцдаг болж болно.

Мөн хэн нэг нь тухайн хүний гэрт зочилж, Христийг хүлээж авсан талаар гэрийнхэн нь мэдсэн эсэхийг лавлаж, тэднийг чуулганд урьж болно. Магадгүй тэдэнд сайнмэдээ тараах боломж ч гарч болох юм.

► Танай чуулганд шинэ хүнтэй залбирах ямар арга барил байдаг вэ? Дээр жагсаасан санаанууд дээр нэмэх юу байна вэ?

## **Гадаа номлох нь**

Гадаа номлол хийх нь чуулганд ирдэггүй хүмүүст хүрэх зорилготой юм. Гэхдээ сонсож байгаа хүмүүсийн зорилго өөр байдаг учраас анхаарал тавихгүй байх магадлал их. Тиймээс гадаа номлох их хэцүү. Магадгүй чимээ шуугиан, саад ихтэй байна. Чуулганд байдаг шиг мөргөл хүндэтгэлийн аятай уур амьсгал мэдээж тэнд байхгүй.

Гадаа номлох үед номлогч нь хүмүүст сонсогдохуйц хангалттай чанга, тодорхой дуу хоолойтой байх, эсвэл ямар нэг өсгөгч ашиглах шаардлагатай болдог.

Хүмүүсийн анхаарлыг татах нь гадаа номлол хийх үйлчлэлийн эхний бэрхшээл юм. Тэр хавиар явж байсан хүмүүс сонсох эсэхээ тэр даруй шийддэг. Зарим нь хэдэн минут сонсож болох юм. Олонх нь цааш сонирхох эсэхээ шийдэхээс өмнө хэдэн өгүүлбэрийг л сонсож амждаг.

Номлогч богино өгүүлбэрээр ярьж, өгүүлбэр бүрдээ тодорхой санаа, мэдэгдлийг хийх хэрэгтэй. Номлогчийн хэлж буй өгүүлбэр болгон олон хүний хувьд сонссон эхний өгүүлбэр нь байх боломжтой гэдгийг анхаарах ёстой. Тиймээс өгүүлбэр бүрдээ тодорхой санааг хэлэх нь анхаарал татна. Хэрэв амжилттай болж хэсэг хүмүүс сонсож эхэлбэл богино дүрслэл ярьж, гол санаагаа тайлбарлаарай.

Боломжтой бол номлогч хэсэг итгэгчдийг дагуулах хэрэгтэй. Хажуугаар нь өнгөрч байгаа хүмүүс бусдыг сонсож байгааг харвал зогсоод сонсох магадлал өндөр байдаг. Хэрэв хөгжимчин байвал номлолын өмнө хөгжим тоглох нь хүмүүсийг цуглуулахад тустай.

Тэгээд номлогч сонсогчдод хандан, урагш гарч ирээд аврал авахын төлөө залбирахыг уриалах ёстой.

Мэдээж хэвлэмэл материалаа тухайн газар байгаа хүмүүст тараана.

► Танай гэрийн ойролцоо гадаа номлол хийх ямар боломж байгаа вэ?

### **Ангийн удирдагчийн тэмдэглэл**

*Суралцагч бүр бэлтгэсэн сайнмэдээнийхээ номлолыг харна. Сайнмэдээг номлох 10 удирдамжаа хэрхэн биелүүлэх талаар эргэцүүлж бодно. Тэгээд үүнийгээ хэрхэн засаж сайжруулах төлөвлөгөө гаргана.*

*Суралцагч бүрийн номлолыг анги дээр ярих цаг байхгүй байж болох ч, жишээ болгох үүднээс хэд хэдэн хүний номлолыг сонсох хэрэгтэй.*

*Дараагийн хичээл дээр энэ хичээлийг дахин үзэхгүй. Харин суралцагчид сайнмэдээний номлолоо хийж, хамтдаа үүнийгээ хэлэлцэх юм. Суралцагчид бүтэн номлол ярих шаардлагагүй, харин тус бүр 5-7 минутын танилцуулга болгон хураангуйлж ярих хэрэгтэй. Дадлага хийсний дараа дараагийн төлөвлөсөн хичээлийн цаг дээр 12-р хичээлийг үзнэ.*

### **11-р хичээлийн даалгавар**

Энэ хичээл дээр заасан удирдамжийн дагуу сайнмэдээний номлол боловсруул. Бүтэн номлол бичих албагүй ч гол санааг бичсэн байх ёстой. Үүнийгээ дараагийн хичээл дээр авчирч, хэлэлцүүлнэ.





# 12-р хичээл

## Сайнмэдээнд чиглүүлэх нь

### Танилцуулга

► Бид итгэдэггүй хүмүүсийн төлөө залбирах ёстой юу? Итгэдэггүй хүмүүсийн төлөө залбирах тухай Библийн аль хэсэгт өгүүлдэг вэ?

Итгэдэггүй хүмүүсийг итгэлд ирүүлэх залбирлын талаарх эшлэлийг Библиэс олох амаргүй. Гэхдээ сайнмэдээг үр нөлөөтэй тараах тухай маш олон эшлэл Библид байгааг харж болно (2 Тесалоник 3:1, Ефес 6:19, Колоссай 4:4, Үйлс 4:29).

Бид сайнмэдээгээ амжилттай дэлгэрүүлэхийн зэрэгцээ үл итгэгчдийг итгэгч болгохын төлөө залбирах ёстойгоо ч мэддэг. Бүх хүний төлөө залбирна гэдэг нь үл итгэгчид ч бас Христийг хүлээн аваасай гэж залбирна гэсэн үг (1 Тимот 2:1). Бид хүмүүсийг гэмшил рүү уриалах (2 Тимот 2:25), мөн тэрхүү үйлсэд Бурханы тусламжийг гуйх нь зүйтэй.

### Анхны үеийн сайнмэдээ тараалт

Чуулган хүчирхэг байх үед сайнмэдээ тараах ажил аяндаа, өөрөө явагддаг байв. Үйлс номд дүрслэгдсэн чуулганы анхны үеийнхэн сайнмэдээг баяр хөөртэй тараадаг байжээ.

► Нэг суралцагч Үйлс 2:46-47-г ангид уншина.

Чуулганы нөхөрлөл маш хүчтэй байсан учраас хүмүүсийг татдаг байсан бололтой. Хэрэв чуулганд шинэ хүн татагдахгүй байвал чуулган доторх нөхөрлөл байх ёстой шигээ тийм хүчтэй биш гэдгийг харуулж байгаа хэрэг.

► Нэг суралцагч Үйлс 5:42-г ангид уншина.

Элч нар болон бусад итгэгчид сайнмэдээ тараах боломжийг үргэлж олж хардаг байлаа. Харин одоо ч зарим чуулганууд сайнмэдээ тараадаггүй бөгөөд хэрхэн эхлэхээ сайн мэдэхгүй сууж байна. Тэд сайнмэдээ тараах боломжийг хэрхэн олж нээхээ мэдэхгүй байгаа юм.

► Нэг суралцагч Үйлс 8:1-4-г ангид уншина.

Хавчлагын улмаас анхны чуулганыхан өөр газар амьдрахаар Йерусалимыг орхин явж байв. Тэд очсон бүх газартаа сайнмэдээг хуваалцдаг байжээ. Тэгэхээр сайнмэдээг хуваалцах нь тэдний христитгэлийн амьдралын нэг хэсэг байсан гэсэн үг.

### Чуулганы талаарх маргаан

Та итгэдэггүй хүмүүсийн дэргэд бусад чуулганы талаар маргахаас зайлсхийх ёстой. Сайнмэдээг хуваалцах үедээ бусад чуулгануудыг шүүмжлэхгүй байхыг хичээгээрэй. Итгэдэггүй хүмүүст шашны чанартай маргааныг зөвөөр дүгнэх сүнслэг ойлголт байхгүй

шүү дээ. Тэгээд ч дэлхий дээр олон хүн чуулгануудын зөрчлөөс болоод христитгэлд үл итгэх хандлагатай байдаг.

Хэрэв хэн нэгэн хүн онол сургаалын ялгааны талаар асуувал Библийн дагуу хариулт өгөхөөс гадна, гол яриагаа сайнмэдээ рүү чиглүүлэх хэрэгтэй юм. Та зүгээр л “Иймэрхүү асуудлууд чухал боловч аврал авч, Бурхан Эзэнтэй харилцаа холбоотой болох нь хамгийн чухал” гэж хэлээрэй. Хэрэв тэд хэн нэгэн итгэгч, магадгүй хамаатан садан, эсвэл пасторынхаа тухай яривал тэдний дагадаг сургаалын талаар шүүмжлэлтэй зүйл хэлэхгүй байсан нь дээр.

Хэрэв танай чуулган яагаад бусад чуулганаас ялгаатай байгааг тайлбарлах шаардлага гарвал “Хүн нүглээ гэмшиж, уучлал хүртэж, Бурханд дуулгавартай амьдрах нь чухал. Манай чуулган үүнийг чухалчилдаг учраас бид бусад чуулганаас өөр байгаа юм” гэж хэлж болно.

### **Хэцүү асуултууд**

Зарим итгэгчид хэцүү асуултаас айгаад сайнмэдээ тараадаггүй. Суралцсаар байх нь сайн хэрэг боловч олонх итгэгчид хэцүү асуултад яаж хариулахаа мэддэггүй. Үнэндээ та бүх асуултын хариуг мэддэг байх албагүй юм.

Хэрэв хэн нэг нь хариулахад бэрх асуулт асуувал “Би энэ асуултын хамгийн сайн хариултыг мэдэхгүй байна. Чуулган дээр үүнд хариулж чадах хүн бий. Гэхдээ би Библид итгэдэг, энэ нь Бурханыг мэдэж, аврагдах хамгийн чухал зүйл гэдэгт итгэдэг. Таныг хэрхэн аврагдаж болохыг би мэднэ” гэж хариулах боломжтой.

Хэрэв хэн нэг нь “Би Библид итгэдэггүй” эсвэл “Би Бурханд итгэдэггүй” гэж хэлж болно. Тэгвэл ийм хариултыг залж болох хоёр өөр чиглэл бий. Нэг бол та тухайн хүнээс үзэл бодлынх нь шалтгааныг асууж, ямар нэг нотлох баримт өгөхийг хичээж болно. Эсвэл та “Та энэ талаар бодож үзсэн учраас ийм дүгнэлтэд хүрсэн байх. Гэхдээ та Библид итгэдэггүй ч ухаалаг хүний хувьд Библийн үндсэн санааг мэдэхийг хүсэж байгаа байх. Би танд үүнийг ярьж болох уу?” гэж хэлээрэй. Ингэснээр та сайнмэдээг маргаан гаргалгүйгээр тарааж чадна. Бурхан хожим нь таны ярьсан мэдээг ашиглаж болно шүү дээ.

Та сайнмэдээ тарааж байхдаа зүгээр л маргахыг хүсдэг хүнтэй тааралдаж болно. Тийм хүнтэй цаг барах хэрэггүй. Хэдийгээр та бүх зүйлийг зөв зүйтэй хэлсэн ч, тэр хүн үнэнийг хүлээж авахгүй байж болох юм. Тиймд сайнмэдээний гол санааг хуваалцаад, өөр хүн рүү явсан нь дээр.

## **Сайнмэдээг хамгаалах нь**

► Нэг суралцагч Тит 1:9-11-г ангид уншина. Сайнмэдээг хамгаалах шалтгаануудын талаар эдгээр эшлэлд юу өгүүлж байна вэ?

Христийн үнэнийг энэ дэлхийн гүн ухааны үзэл ойлголтоос хамгаалж сурах нь пасторын эзэмших чадваруудын нэг юм. Энд өөр өөр чуулганы ялгаатай онол сургаалыг бус, харин сайнмэдээг эсэргүүцдэг энэ дэлхийн эсэргүүцлийн талаар хэлж байна.

Бид өөдөөс маргаж буй хүнийг итгэгч болгоод зогсохгүй, тэр хүний нөлөөнд орсон хүмүүст туслахын тулд сайнмэдээг хамгаалж ярьдаг. Ер нь олон хүн юунд итгэхээ хараахан шийдээгүй байдаг. Тэд Христийн үнэнийг хамгаалсан үгсийг сонсох хэрэгтэй.

Ихэнх итгэгчид энэ төрлийн маргаанд бүрэн бэлтгэгдээгүй байдаг. Гэхдээ итгэгч бүр чадах чинээгээрээ суралцах ёстой юм. Мэдээж зарим нь үүнд авьяастай, ийм ажилд бэлтгэгдсэн байдаг.

Мэтгэлцэх үедээ зорилгоо харуулах нь чухал. Та тэмцээнд ялах гэж байгаа, эсвэл тэр хүнтэй хувийн дайсан мэт тулалдах гэж байгаа хэрэг бус. Харин хүмүүст санаа тавьдаг учраас үнэн таны хувьд маш чухал гэдгийг харуулах хэрэгтэй. Хэрэв тэр хүн сайнмэдээнд итгэхгүй бол сүнс нь мөхнө. Тиймээс та тэр хүний бодлыг өөрчлөхийг хүсээд байгаа юм. Та түүнд “Та Бурханыг мэдэж, аврагдаасай” эсвэл “Таныг Бурханы үнэнд хүргэхгүй ямар нэг зүйлд итгэх вий хэмээн би айж байна” гэх мэтээр хэлж болно.

## **Боломжийг ашиглах үр чадвараа хөгжүүлэх нь**

Сайнмэдээ тараах онцгой боломж олдсон элчийн тухай өгүүлсэн нэгэн хэсэг Библид бий.

► Нэг суралцагч Үйлс 8:26-39-г ангид уншина. Өөр нэг суралцагч уг үйл явдлыг дүгнэн ярина уу. Энэ үйл явдалд Ариун Сүнс ямар үүрэгтэй оролцсон бэ? Филип сайнмэдээ тараах боломжийг хэрхэн таньсан бэ?

Сайнмэдээг тунхаглах боломжийг олж харсан хүний өөр нэг жишээ бол Есүс Өөрөө юм.

► Нэг суралцагч Иохан 4:7-14-г ангид уншина. Өөр нэг суралцагч уг үйл явдлыг тоймлон ярина уу.

Есүс самари эмэгтэй хоёрын дундах энэ яриа нь угсаатны мөргөлдөөн, шашны маргаан, амьдралын энгийн үүргүүдийн талаарх сэдвийг хөндсөн яриа байлаа. Есүс эдгээр сэдэвт тийм ч их цаг зарцуулалгүйгээр яриагаа тухайн эмэгтэйн сүнслэг хэрэгцээ рүү чиглүүлсэн байна.

Та сайнмэдээний танилцуулгыг хийх аргад суралцсаны дараа үүнийгээ хүмүүстэй хуваалцах боломжийг эрэн хайх болно. Хааяа сайнмэдээг сонсох хүсэлтэй хүн гарч ирж болох хэдий ч, ихэнхдээ боломж тийм тодорхой харагдахгүй.

Хүмүүс огт сонирхохгүй учраас сайнмэдээг хуваалцах хэцүү гэж зарим итгэгчид боддог. Мөн шашны тухай яриа үүсгэх амаргүй гэж тэд үздэг.

Сайнмэдээ нь хүмүүсийн санааг зовоодог олон асуудлыг хөнддөг учраас сайнмэдээг яриандаа оруулж ирэх нь тийм ч хэцүү зүйл биш.

Энэхүү хичээлээр бид хүмүүс яагаад сайнмэдээг сонирхдог шалтгааныг ярих болно.

## **Янз бүрийн сэдэл**

Авралын мэдээнд хариу өгөхдөө хүмүүс янз бүрийн сэдэл агуулж болох юм. Заримдаа буруу сэдэл агуулсан байж болох ч ихэнх нь зөв сэдэлтэй байдаг.

► Сайнмэдээг хүлээн авах таны сэдэл юу байсан бэ? Хэд хэдэн суралцагч яагаад сайнмэдээг хүлээн авах болсон шалтгаанаа тайлбарлана.

Хүмүүсийг аврал авахыг хүсэхэд хүргэдэг янз бүрийн шалтгааныг энд дурдъя.

- Тамд биш тэнгэрийн улсад очих (эсвэл шүүлтээс айх)
- Амьдралдаа сэтгэл хангалуун, зорилготой болох
- Аюулгүй байдал, сэтгэлийн амар амгалан, айдсаас ангид байх
- Уучлагдах, ичгүүрээс чөлөөлөгдөх эрх чөлөө (мөс чанараа цэвэрлэх)
- Сүнслэг тал дээр цэвэр, бүрэн бүтэн байх
- Бурхантай харилцаатай байх (Бурханыг мэдэх)
- Христийн дагалдагчидтай нөхөрлөх
- Сүнслэг хүслээ хангах (жинхэнэ аз жаргалыг олох)
- Нүглээс чөлөөлөгдөх
- Үнэнийг мэдэх

Энэ бүхэн Бурхантай эвлэрэхийн ашиг тус бөгөөд энэ дэлхийн санаа зовнилтой зөрчилдөж байдаг мөнхийн үнэ цэн юм. Хэрэв хүн Бурханаас тусгаарлагдвал эдгээрээр дутагдах болно.

► Энэ жагсаалтыг хараад аль нь танд чухал байгааг анзаарна уу. Итгэгч болохоос тань өмнө эдгээрийн аль нь таныг татаж байсан бэ? Итгэгч болсны дараа аль нь танд чухал болсон бэ?

Ярилцаж байх үед авралын эдгээр ач тусын аль нэгийг хүртэх хэрэгтэй байгаагаа итгэдэггүй хүмүүс илэрхийлж болно. Сайнмэдээ тараагч нь тэр хэрэгцээ рүү анхаарч, сайнмэдээ тараах арга барилаа өөрчилж болох юм. "Хүмүүс Бурханаас тусгаарлагдсан учраас тэдэнд \_\_\_\_\_ байдаггүй юм. Харин Библид Бурхантай хэрхэн холбоо харилцаа тогтоох талаар өгүүлдэг" гэж хэлж болно.

Христэд итгэхийг хүсэж буй ямар ч хүнд бид энэ дэлхийн аз жаргалыг амлах ёсгүй. Дэлхийн аз жаргалыг амлах нь сонсож буй хүнийг төөрөгдүүлж, нүглээ гэмшихгүй амьдрахад хүргэж болно. Тэгвэл авралын жинхэнэ үр шимийг хүртэж чадахгүйд хүрэх магадлалтай. Дэлхийн аз жаргалыг амлаж болохгүй бас нэг шалтгаан бол Библи

итгэгчдэд сайн сайхан нөхцөл байдлыг амладаггүй, харин хавчлагын талаар урьдаас сануулсан байдаг (2 Тимот 3:12).

Хүн гэм буруугаа ухамсарлаж, айсуй шүүлтийг ойлгох нь Христийн дагалдагч болох хамгийн чухал шалтгаан юм. Харин тухайн хүн Бурханаас тусгаарлагдсан байгааг ойлгуулахын тулд дээрх жагсаалтыг ашиглаж болно.

### **Яриа үүсгэх боломжийг олж харах нь**

► Сайнмэдээ тараах боломжийг олж авахын тулд та хэрхэн яриа өдөж байсан бэ?

► Сайнмэдээ хуваалцах боломж олох нь танд хэцүү санагдаж байсан уу? Шалтгаан нь юу гэж бодож байна?

Заримдаа боломж их амархан ирнэ. Тийм тохиолдолд та сайнмэдээг зүгээр л тайлбарлаж эхэлдэг. Хэрэв Библийн эшлэлүүдийг үзүүлэхийг хүсвэл “Христэд итгэгч болохын тулд яах ёстой талаар Библи дээр юу гэж бичсэн байгааг би танд хэдхэн минутад үзүүлж болох уу?” гэж асууж болно. Магадгүй гүүрээр тайлбарласан дүрслэл бүхий зураг үзүүлэх бол “Хүн аврагдсан гэдгээ баттай мэдэж болох Библийн арга замыг харуулсан зургийг би танд үзүүлбэл та хоёрхон минут гаргаж чадах уу?” гэж асууж ч болох юм.

Янз бүрийн сэдвээр яриа өрнүүлэх үед сайнмэдээ ярих оршил тавигддаг. Сайнмэдээний оршил гэдэг нь дээр өгүүлсэн шиг “Гүүр” зурагт дүрслэл, эсвэл “Ромын зам” зэрэг Бичвэрийн сайнмэдээний танилцуулгыг хэлж байгаа юм.

► Хүнд хэцүү амьдралынхаа талаар гомдоллох хүмүүстэй хэр олон таарч байсан бэ?

Заримдаа хүмүүс хүнд хэцүү амьдралынхаа талаар ярьдаг. “Амьдрал яагаад ийм хэцүү байдаг вэ?” гэж тэднээс асуугаарай. Тэднийг хариу өгсний дараа “Амьдрал яагаад ийм хэцүү байдгийг дүрслэн харуулсан зураг үзүүлж болох уу?” гэж асуу. Бурхан хүмүүсийг Өөртэй нь харилцаж амьдраасай гэж хүсдэг болохоос ийм хэцүү амьдрал туулаг гэж хүсдэггүй. Харин нүглийн улмаас дэлхий дээрх бүх юм доголдож орвонгоороо эргэсэн” гэж хэлээд цааш зурагт дүрслэлээ үзүүлээрэй.

“Ромын зам” зэрэг Бичвэрийн сайнмэдээний танилцуулгыг ашиглах бол “Бүх хүн нүгэл үйлдсэн учраас амьдрал хүнд байдаг гэж Библид хэлж байна. Нүгэл манай дэлхийд хараалыг авчирсан” гэж хэлээд үргэлжлүүлэн “Ромын зам” танилцуулгаа үзүүлж болно.

Хэрэв шашин шүтлэгтэй хүн мэт санагдвал, та тэр хүнээс хамгийн чухал итгэл үнэмшил юу болох талаар асуугаарай. Эсвэл “Хүн тэнгэрийн улсад очно гэдгээ мэдэж болох ямар арга байдаг вэ” гэж асууж болно. Тухайн хүний хариултыг сонссоны дараа “Хүн хэрхэн тэнгэрийн улсад очиж болох талаар Библид хэлснийг танд зургаар үзүүлбэл та хоёр минут гаргаж чадах уу?” гэж асууж болох юм.

► Хүмүүс дэлхий дахины хурцадмал байдал, улс орны хүнд хэцүү асуудлын талаар яриа дэлгэж байхыг та үзсэн үү? Тийм нөхцлийг сайнмэдээ дамжуулах боломж болгон хэрхэн ашиглах вэ?

Хэрэв хүн улс үндэстний асуудал, дэлхийн өлсгөлөн ядуурал, дайн дажингийн тухай асуувал “Дэлхий яагаад ийм болсон шалтгааныг тайлбарласан Библийн эшлэлүүдийг танд үзүүлж болох уу? гэж хэлээрэй.

Хүмүүс Бурханаас тусгаарлагдсан учраас дэлхийн нөхцөл байдал ийм болсныг харуул. Гэхдээ аврал энэ бүх асуудал бэрхшээлийг даруй төгсгөнө гэх ойлголтыг өгч болохгүй. Харин хувь хүний аврал нь Бурханы шийдлийг авчирдаг гэдгийг хэлээрэй. Хэзээ нэгэн цагт шинэ тэнгэр шинэ газар бий болж, Бурхантай эвлэрсэн хүмүүсийн хувьд одоо энэ дэлхийд байгаа эдгээр асуудлууд дахиж үгүй болно гэдгийг хэлж өгөөрэй.

### **Сайнмэдээнд чиглүүлэх асуултыг ашиглах нь**

Сайнмэдээ рүү хөтлөх асуултуудыг ашиглавал сайнмэдээ ярих боломж нээгддэг.

Хамгийн амархан асуулт бол “Та Христэд итгэгч үү?” гэх асуулт юм. Энэ асуултад хүмүүс нэг их гомдоод байдаггүй. Хэрэв хүн “Үгүй” гэж хариулбал та “Библид хүн яаж Христэд итгэгч болдог талаар юу гэж хэлснийг танд ярьж болох уу?” гэж асууж болох юм.

Хэрэв “Тийм” гэж хариулбал та “Үнэхээр сайн хэрэг. Та яаж итгэгч болсон бэ?” гэж асууж болно. Хэрэв хариулт буруу эсвэл тухайн хүн будилсан мэт санагдвал, та тухайн хүний хэрхэн Христэд итгэгч болох талаар Библид юу гэж хэлдгийг тайлбарлахыг санал болгож болно.

Дээр дурдсан асуултуудыг ашиглан яриагаа өөр сэдэв рүү чиглүүлэх асуулт болгон ашиглаж болно. Энд өөр хэд хэдэн асуултуудыг орууллаа.

“Таны бодлоор амьдралын зорилго юу вэ?” гэж асуугаад ярилцагч хүндээ саналаа хэлэх боломж олго. Түүний хэлсэн үгийн сайн талуудтай санал нийлээрэй. Тэгээд “Бидний амьдралын хамгийн гол зорилго нь Бурханыг мэдэх явдал юм. Бурхан биднийг Өөртэй нь харилцаатай байхаар бүтээсэн. Бурхантай харилцаа тогтоох талаар Библид юу гэж бичигдсэнийг би танд ярьж өгч болох уу?” гэж асууж болно.

“Таны бодлоор аз жаргалын түлхүүр юу вэ?” гэж асуугаад тэд юу ч гэсэн хэлсэн бай, та “Үүнийг олж авсан хүмүүс тийм ч удаан аз жаргалтай байдаггүй бололтой. Библи бидэнд баяр хөөр Бурханаас ирдэг гэж хэлдэг (Дуулал 16:11). Би танд хүн хэрхэн Бурхантай харилцаа тогтоож болохыг харуулсан зураг үзүүлж болох уу?” гэж хэлээрэй.

“Та үхлийн дараах амьдралд итгэдэг үү? Та үүнийг ямар гэж бодож байна?” гэж асуугаад “Хүн бүр диваажинд эсвэл тамд очно гэж Библи хэлсэн байна. Би танд диваажинд яаж хүрэх талаар Библид юу гэж бичсэнийг үзүүлж болох уу?” гэж асуугаарай. Мөн “Та Библийн үндсэн санаа нь юу гэдгийг мэдэх үү?” гэж асуувал энэ нь танд 9-р хичээл дээр үзсэн зургийг тухайн хүнд харуулах боломжийг олгоно.

► Эдгээрийн аль нэгтэй нь адил аргыг хэрэглэж үзсэн үү? Хэр үр дүнтэй байсан бэ?

Энэхүү хичээлд тайлбарласан аргууд суралцагч бүрийн нөхцөл байдалд нийцэх албагүй юм. Ямар нэгэн арга бүх соёлд зохимжтой байж чадахгүй ч байж болно.

Суралцагчдад сайнмэдээ тараах өөрсдийн арга барилаа хөгжүүлэхэд туслах нь энэхүү хичээлийн гол зорилго билээ.

### **Ангийн удирдагчийн тэмдэглэл**

*Дараагийн хичээлээр сайнмэдээний товхимлуудыг тараах тухай үзнэ. Суралцагчид зарим товхимлыг хаанаас авах талаар мэдэх хэрэгтэй. Боломжтой бол дараагийн хичээлд сайнмэдээний товхимлоо бэлдэж ирээрэй.*

### **12-р хичээлийн даалгавар**

Энэ долоо хоногт ч сайнмэдээ үргэлжлүүлэн тараахдаа та дээрх чиглүүлэх асуултуудыг турших юм уу, өөрийн гэсэн асуултуудыг боловсруулаарай. Хэр үр дүнтэй байгааг ажиглаж, үүнийгээ бичиж тэмдэглэ. Дараагийн хичээл дээр туршлагаасаа хуваалцахад бэлтгээрэй.





## 13-р хичээл

# Сайнмэдээ тараах аргуудыг өөриймсүүлэх нь

### Танилцуулга


- ▶ Шинэ гэрээний үеийн сайнмэдээ тараах ажил одоогийнхоос хэр ялгаатай гэж бодож байна вэ?
- ▶ Танай улсад илгээлтийн эзэд анх ирж байсан үеийг одоогийн сайнмэдээ тарааж буй нөхцөл байдалтай харьцуулбал ямар ялгаа байна вэ?

### Сайнмэдээ түүхэнд: Жон Виклиф, Жон Веслей нарын жишээ

Жон Виклиф Английн пастор байв. Тэрээр 1324-1384 онд амьдарч байлаа. Тэр үед англи хэл дээр Библи орчуулагдаагүй байсан ба хүмүүс Ромын католик сүмийн заасан сургаалуудыг түшиглэдэг байжээ. Олон хүн сайнмэдээг мэддэггүй, бас маш олон католик санваартан Библийг сайн мэддэггүй байв. Санваартнууд орон даяар явж шашны зан үйл хийж, мөнгө гуйдаг байсан ба ихэнх сүмүүдийг сайнмэдээ номлодоггүй тахилч нар удирддаг байжээ. Виклиф болон туслахууд нь Библийг англи хэлнээ орчуулсан бөгөөд тухайн үед хэвлэх машин байхгүй байсан тул тэд орчуулгаа гараар хуулж олшруулдаг байжээ. Тэгээд хоёр хоёроороо явж Библийг хүмүүст зааж эхэлсэн аж. Тэд мөнгө гуйдаггүй байсан учраас хүмүүс тэднийг “ядуу тахилчид” гэж нэрлэдэг байлаа.

Сайнмэдээ тараах арга барилууд нь тухайн нийгмийнхээ нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Виклиф ба түүний туслахууд сайнмэдээ тараалтын үндсэн хэсгийг гүйцэтгэдэг байв. Өөрөөр хэлбэл тэд Библийн гол санааг хүмүүст шууд заадаг байжээ.

Жон Веслей бол 1703-1791<sup>6</sup> онд Англид амьдарч байсан хүн юм. Тэр үед Англикан чуулган нь баячуудын чуулган болсон байлаа. Тэд өөрийн зан үйлтэй бөгөөд сайнмэдээ тараадаггүй байжээ. Английн ядуучууд чуулганд очих эрхгүй бөгөөд сайнмэдээг мэддэггүй байв. Веслей англикан чуулганы тахилч байсан боловч хүмүүст сайнмэдээг тунхаглахыг хүсдэг байжээ. Нэгэн өглөө тэрээр маш олон уурхайчин талбайгаар өнгөрөн гарч, ажил руугаа явж байхыг харав. Веслейг тийш очиж номлох үед олон хүн зогсоод сонсчээ. Үүнээс хойш Веслей үлдсэн амьдралынхаа бараг өдөр



<sup>6</sup> Currier & Ives нарын “John Wesley preaching on his fathers grave” зураг. Конгрессын хэвлэл ба фото зургийн хэлтсийн номын сангаас авсан, <https://www.loc.gov/pictures/item/2002707689/>, “Зохиогчийн эрхийн хориглолт байхгүй” зураг.

бүр гадаа гудамжинд сайнмэдээг номлож байсан юм. Түүний үйлчлэлээр мянга мянган хүмүүс итгэлд ирж байлаа.

► Танай нутагт сайнмэдээ авчирсан анхны илгээлтийн эздээс хэн нь тодорхой санагдаж байна вэ?

### **Арга барилыг өөриймсүүлэх хэрэгцээ**

Нэгэн эр гэр бүлтэйгээ 2003 онд Лондон хотоор аялжээ. Тэд хэсэг амрахаар парк дээр зогсох үедээ нэгэн эмэгтэй тэр паркийн толгод дээр зогсож байхыг харжээ. Тэр эмэгтэй гартаа Библи бариад ярьж байхыг хараад, ойртож очвол ямар нэг шашны талаар ярьж байх нь сонсогдов. Ойролцоо зогсож байгаа найзаас нь юу болоод байгаа талаар асуулаа. Найз нь “Бид Веслей шиг гадаа номлодог уламжлалаа үргэлжлүүлж байгаа бүлгийнхэн. Хааяа олон нийтийн газар ийнхүү номлодог” гэв. Гэхдээ тэр эмэгтэй цөөн хүн явдаг газар зогсож байгаа учраас олон хүнд хүрч чадахгүй, мөн тэдний байгаа байдал ч тийм үр дүнтэй биш харагдаж байгааг тэр хүн ажиглажээ. Эмэгтэй уламжлалаа үргэлжлүүлэхийг хичээж байгаа ч, энэ аргыг үр дүнтэй болгож байсан анхдагч бүх шинжийг алдсан байв.

Аливаа арга барил нөхцөл байдалдаа тохирсон байх ёстой. Заримдаа хүмүүс сайнмэдээг тараах ганц л арга байдаг гэж боддог бөгөөд тэр аргаа үр дүнгүй болчихоод байхад ч үргэлжлүүлээд байдаг. Заримдаа нэг газар үр дүнтэй байсан арга өөр газруудад ч үр дүнгээ өгнө гэж боддог. Үнэндээ тийм биш ээ.

Олон газар хүмүүс айлаас айлд очиж, сайнмэдээ сонсож чадаагүй хүмүүст хүрэхээр айлын хаалга тогшиж явдаг. Энэ аргаар олон хүн сайнмэдээг хүлээж авсан хэдий ч энэ арга газар бүрд үр дүнтэй байдаггүй.

Зарим чуулганууд автобус худалдаж аваад хүмүүсийг чуулган руугаа зөөдөг. Ням гарагийн өглөө тэд хороолол даяар явж, хүмүүсийг цуглуулдаг. Автобусны үйлчлэлээр аврагдсан хүмүүс олон боловч энэ арга мөн л газар бүрд тохироод байхгүй.

Олон чуулган Ням гарагт чуулганы байранд ирж байгаа хүмүүст сайнмэдээг номлох маягаар сайнмэдээ тараадаг. Тэд хүмүүсийг урагш гарч ирээд гол индрийн өмнө өвдөг сөгдөн нүглээсээ гэмшин залбирахыг уриалдаг. Энэ аргаар мянга мянган хүн итгэгч болдог хэдий ч, итгэдэггүй хүмүүсийн олонх нь чуулганд ирдэггүй. Түүнчлэн хувьчлан яриа үүсгэж, сайнмэдээг ярихгүй л бол огт сонсдоггүй хүмүүс маш олон байдаг.

Элч Паул бол сайнмэдээ түгээх аргуудыг өөриймсүүлэхийн жишээ болсон хүн байлаа. Өөрөө чадварлаг “рабби” байсан учраас еврейчүүдийн синагогт хэрхэн ярихаа мэддэг байсан ба Есүс бол аврагч Мессиа гэдгийг тайлбарладаг байжээ. Түүнчлэн гүн ухааны санаа бодлуудыг дэвшүүлж мэтгэлцэхээр хүмүүс цуглардаг газруудад ч тэр ярьж сургадаг байжээ. Заримдаа тэрээр олон хөлийн газар, харин ихэвчлэн айлуудад цугладаг жижиг бүлгүүдэд хуваалцан ярьдаг байв.

## **Орчин үеийн зарим арга барил**

Сайнмэдээний яриа үүсгэхийн тулд хүмүүс янз бүрийн арга хэрэглэдэг. Зарим чуулганууд асуулт бүхий судалгаа явуулдаг. Тэд тухайн газрынхаа хүмүүсээс “Чуулган нийгмийн төлөө юу хийх ёстой гэж та боддог вэ? Христийн шашны хамгийн чухал итгэл үнэмшил юу вэ? Христэд итгэгчийг та хэрхэн тодорхойлох вэ? Хүн яаж Христэд итгэгч болох вэ?” гэх асуултуудыг багтаасан судалгаа авдаг байна. Тэгээд хүмүүсийн саналыг тэвчээртэй сонссоны дараа “Христэд итгэгч байх талаар Библид өгүүлж байгаа зүйлд итгэдэг гэдгээ би тантай хуваалцаж болох уу? гэж асуудаг.

Зарим нь олон нийтийн газар сайнмэдээний утгыг харуулсан зураг, хүснэгт байрлуулан хүмүүсийн анхаарлыг татдаг арга хэрэглэдэг. Түүнчлэн зарим нь шохойгоор зураг ч зурдаг. Зарим хүмүүс сайнмэдээний түүхүүдээс ярихдаа холбогдох зургуудыг самбар дээр байрлуулах нь ч бий.<sup>7</sup>

Зарим чуулган тухайн газрын хүмүүст хэрэгтэй байгаа сургалт семинарыг зохион байгуулдаг. Сэдвийн хувьд гэрлэлт, хүүхэд өсгөж хүмүүжүүлэх, бизнесийн зарчим, эрүүл мэнд, ямар нэг ажилд бэлтгэх гэх мэт сэдвүүд байж болдог. Чуулганууд олон нийтийн хэрэгцээний төлөө ямар нэг сайн үйлс хийдэг. Ер нь чуулган нь Библийн үнэн өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг харуулах үүрэгтэй. Библийн сургуулиуд шууд сайнмэдээг танилцуулахгүй, харин Библийн үнэнийг зааж, чуулган болон орон нутгийн хооронд сайн харилцааг тогтоодог.

Зарим чуулган олон хүн дайран өнгөрдөг газруудад залбирлын цэг байгуулдаг. Тэд “Залбирлын цэг” гэж томоор бичээд өнгөрч яваа хүмүүсийг залбиралд уриалдаг. “Танд надаар залбируулах зүйл байна уу?” гэх мэтээр асуух ба хүмүүсийн хэрэгцээнд санаа тавих тул маргаан үүсдэггүй. Энэ үеэр ихэвчлэн сайнмэдээ хуваалцах боломж гардаг.<sup>8</sup>

Сайнмэдээг сонсох хэрэгтэй хүмүүст үүнийг тодорхой ойлгомжтой байдлаар танилцуулах нь сайнмэдээг тараах арга барилын хамгийн үндсэн чухал хэсэг юм. Бурхан Үгэндээ хүч өгч, Ариун Сүнс сонсож буй хүмүүсийг ятгадаг учраас хэрэв сайнмэдээг тодорхой, шууд хүргэж байвал үүнийг түгээх аргууд илүү үр дүнтэй болно.

Хүмүүсийн анхаарлыг татаж, сайнмэдээг нийгэм даяар түгээх арга замыг олох нь чуулганы хувьд хаа сайгүй, цаг үргэлж тулгарч байгаа амаргүй даваа болж байна.

► Танай хотын чуулганууд хүмүүсийн анхаарлыг татах ямар арга барил хэрэглэдэг вэ? Эдгээр аргаар сайнмэдээг хүмүүст хүргэж чадаж байна уу?

## **Найз нөхдөдөө сайнмэдээ тараах нь**

Хүн сайн мэддэг, итгэдэг хүндээ сайнмэдээг шууд дамжуулах л сайнмэдээ тараах хамгийн үр дүнтэй арга юм.

<sup>7</sup> Эдгээр аргын талаар “Open Air Campaigners”-ийн вэбсайтаас үзнэ үү. <https://www.oacgb.org.uk/> and <https://oacusa.org>.

<sup>8</sup> Зураг ба мэдээллийг дэлгэрэнгүй авахыг хүсвэл <https://prayerstations.org> вэб хуудсаар хандана уу.

Христийн дагалдагчийн амьдралыг найз нөхөд, танилууд нь харж байдаг учраас тэдэндээ гэрчлэх нь хамгийн үр дүнтэй. Хэрэв сайн үлгэр жишээ үзүүлсэн бол тэд гэрчлэлийг нь хүндэтгэх магадлал өндөр. Ер нь итгэгч гэдгээ хүмүүст мэдэгдэхийн тулд итгэлээ үргэлж харуулах нь чухал. Библи уншиж, залбирч байгааг чинь хүмүүс харвал ичиж зовох хэрэггүй. Хүмүүс итгэгч гэдгийг тань мэдлээ ч гайхахааргүй байх учиртай.

Христийн дагалдагч нь үлгэр жишээ байдлаараа сургууль эсвэл ажил дээрээ христийн шашинд дургүй хүмүүст ч хүртэл хүндлэгддэг. Үйлдэл, хандлагадаа тууштай байвал хавчин хяхаж байдаг хүмүүс нь хүртэл итгэгч хүний үлгэр дуурайлыг хүндэлдэг. Зарим хүмүүс түүн дээр ирж залбируулж, зөвлөгөө ч авах болно.

### **Хувьчлан уулзах нь**

Зарим хүмүүс гэрчлэл хийхээсээ өмнө тухайн хүнээ хэсэг хугацаанд мэддэг болох ёстой гэж үздэг. Тэд хэн нэгэнд Бурханы тухай ярихаасаа өмнө найз болохыг хичээдэг. Хүн ер нь найзынхаа үгийг сайн сонсдог нь үнэн юм. Гэхдээ тухайн хүндээ үнэхээр санаа тавьж, сонирхож буйгаа даруй харуулах хэрэгтэй. Уулзсан хүмүүстээ сайнмэдээг хэрхэн тараах талаар бид суралцахгүй бол үр дүнтэй байж мэдэх боломжийг алдах болно. Өмнөх “Сайнмэдээнд чиглүүлэх нь” хичээлээр сайнмэдээ тараахын тулд яриа үүсгэх аргуудаас үзсэн билээ.

Нэгэн хүн “Би хэн нэгэнтэй хоёулаа үлдвэл энэ мөчийг Бурханы зохион байгуулсан уулзалт болгон ашиглахыг хичээдэг” гэж хэлсэн байдаг. Сайнмэдээнд ашиглаж болох уулзалтуудаар Бурхан хангадаг гэдэгт тэр хүн итгэдэг байжээ.

### **Сайнмэдээний товхимол**

Сайнмэдээ тараахын тулд та элч Паулын хийж чадаагүй ямар нэг зүйлийг хийж болно шүү дээ.

Бидэнд олон зууны туршид чуулганд огт байгаагүй сайнмэдээ тараах арга байна. Энэ бол хэвлэх машинаар цаасан дээр буулгасан сайнмэдээний материалууд юм.

► Хэвлэх машин гарахаас өмнөх сайнмэдээний үйлчлэл юугаараа өөр байсан гэж та бодож байна?

Хэвлэх машин бүтээгдэхээс өмнөх үеийн үйлчлэлийн талаар төсөөлөөд үз дээ. Ном бүрийг гараар бичдэг байсан учраас ганц ном гаргахын тулд бичгийн боловсролтой хүн олон хоног ажиллах шаардлагатай байв. Та өнөө цагт ном үнэтэй байна гэж боддог байж магадгүй. Тэгвэл чадварлаг мэргэжилтнийг 10 хоног хөлсөлсний дайтай үнээр ном авна гээд төсөөлөөд үз дээ.

Библийн хуулбартай хүн бараг байсангүй. Бүр пастор хүртэл бүтэн Библигүй байжээ. Гэртээ Библи унших боломж хэнд ч байгаагүй гээд төсөөлөөд үз.

Пасторуудыг сургахдаа ихэвчлэн ярих хэлбэрээр хичээл заадаг байсан учраас пасторууд сонссон зүйлээ мартажгүй байхыг хичээх ёстой байв. Өөр газар руу хэвлэмэл

сургалтын материал явуулах ямар ч боломж байсангүй. Хэвлэхгүй бол юу ч бичиж, олон тоогоор тараах боломжгүй юм.

► Хэвлэмэл материалаар сайнмэдээг тараах ямар арга байдаг вэ?

Сайнмэдээний товхимол нь жижиг нийтлэлүүдийг багтаасан багавтар материал юм. Итгэгчид тэдгээрийг тааралдсан хүмүүстээ өгч болно. Мөн олон нийтийн газар олноор нь тараах боломжтой. Түүнчлэн хүмүүст уншуулахаар зарим газар үлдээж болдог.

Хэрэв танихгүй хүмүүст сайнмэдээ тараах тал дээр ихийг хийж чаддаггүй бол хэвлэмэл материалуудыг тараах нь аятайхан эхлэл болно шүү.

Хэвлэмэл материалууд өнгөлөг, сонирхолтой гарчигтай байх ёстой. Мөн тараах материалаа гудамж эсвэл өөр газруудаар тараах үедээ инээмсэглэн мэндчилж байгаарай. “Сайн байна уу, та эдгээр материалуудаас авсан уу?” гэж асууж ч болно. Ингэж асуух нь хүмүүсийг сонирхож харахад хүргэдэг.

Хүмүүсийн олонх нь таны өгсөн материалыг сонирхохгүй байгаа мэт санагдаж болно. Магадгүй олон хүн уншилгүйгээр хаяж мэднэ. Гэсэн ч сайн үр дүн гардаг. Иймэрхүү материалуудаас сайнмэдээг хүлээж авсан хүмүүс бий. Та тарааж буй товхимолоо ямар үр дүнд хүргэхийг мэдэхгүй шүү дээ.

### **Практик хэрэгцээнд нь туслах**

Заримдаа хүмүүс амьдралын бодит хэрэгцээнд санаа зовдог. Тэд хангалттай хоол хүнс, орон байр, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байдаг. Эдгээр хэрэгцээ нь сүнслэг хэрэгцээнээсээ илүү яаралтай гэж тэд боддог. Чуулган сайнмэдээ тараадаг шигээ хүмүүсийн бодит хэрэгцээнд мөн тусалж болно. Гэхдээ чуулган аврагдаагүй хүмүүсийн адилаар сүнслэг хэрэгцээнээс илүүтэй газар дэлхийн хэрэгцээнд анхаарлаа хандуулж байвал асуудалтай.

“Илгээлтийн эзэд Энэтхэг, Уганда болон бусад газруудын хүмүүст мөнгө өгч, өлсгөлөнгөөс ангижруулж, боловсрол олгож, эмнэлгийн үйлчилгээгээр хангаж, эсвэл олон төрлийн давуу эрх олгох замаар хүмүүсийг “худалдаж” итгэгч болгосон хэмээн буруутгагдаж байна”

- Ж. Херберт Кане,  
“Сайнмэдээ Түгээх Ажил”

Чуулган материаллаг хэрэгцээг анхаарах ёстой боловч сүнслэг талыг чухалчлах тодорхой үйл ажиллагаагаа хадгалаад явах ёстой. Ингэхдээ:

1. Хүмүүсийн хэрэгцээг хангаж өгөх үедээ Бурханы хайрыг хуваалцаж байгаагаа заавал хэлэх ёстой.
2. Чуулганаас тусдаа байгууллага болохоос илүүтэй итгэлийн гэр бүлээрээ хамтран ажиллах нь зөв.
3. Итгэгчид бие биедээ санаа тавьдаг чуулганы нөхөрлөлд хүмүүсийг урих хэрэгтэй.

4. Итгэгчид сайнмэдээ тараан, мөнх амийн тухай зааж, Бурханыг мэдсэнээр ирэх ерөөлийн тухай мэдүүлэх ёстой.

Олон үйлчлэлийн байгууллага хүмүүсийн материаллаг хэрэгцээг хангах хөтөлбөрүүдийг санал болгодог бөгөөд нөөц бололцооныхоо хэрээр олон нийтийн хэрэгцээнд үйлчилдэг. Тэдний гол зорилго нь сайнмэдээ тараах боломжийг бий болгох явдал юм. Тэд хүмүүсийн бодит хэрэгцээнд тусалж, найз нөхдийн холбоо тогтоовол сайнмэдээ рүү анхаарлыг нь татаж болно гэж үздэгт байгаа юм. Эндээс Хөтөлбөр, Харилцаа холбоо, Сайнмэдээ гэсэн томъёолол харагдаж байна.

Гэхдээ тусламжийн хөтөлбөрүүд бүтэлгүйтдэг олон тохиолдол бий. Тусламжаас болоод өгөгч, авагчаас илүү харилцаа тогтохгүй байж болно. Заримдаа сайнмэдээ нь өгч байгаа эд зүйлээс тусдаа болж, хүмүүс сайнмэдээг сонирхохгүйгээр тусламж авдаг болж хувирна. Хөтөлбөр дээр ажиллаж байгаа хүмүүс тусламжаа тараагаад завгүй учраас сайнмэдээ тараахаа больдог.

Тэгвэл томъёоллыг эргүүлэх хэрэгтэй. Чуулган сайнмэдээг чухалчилж, хүн бүртэй сайнмэдээгээр анхны харилцаагаа тогтоох ёстой юм.

Чуулган сайнмэдээг дэлхийн хүмүүст тараахдаа чуулганы шинэ амьдралын тухай итгэмжтэйгээр тайлбарлаж өгөх хэрэгтэй. Аврал бол хүнийг хачин жигтэй, шинэ амьдралд ганцааранг нь үлдээдэг, хувь хүний ганцаараа аялах зам биш. Итгэдэггүй хүмүүс сайнмэдээг тарааж байгаа итгэлийн хамт олонд татагдахгүй л бол сайнмэдээг гол төлөв хүлээж авдаггүй.

Есүс ба элч нарын үйлчлэлээс сайнмэдээ бол Бурханы хаанчлалын тухай юм гэдгийг бид хардаг. Энэ бол нүгэлт хүн уучлал өршөөл хүртэн, Бурхантай харилцаатай болох боломжтой тухай мэдээ юм. Тийнхүү хүн нүглийн хүлээснээс чөлөөлөгдөж, шинэ бүтээл болдог. Ингээд хүн сүнслэг ах эгч нараасаа урам зориг авч, хэрэгцээнд нь туслах итгэлийн гэр бүлд нэгддэг.

Чуулган тэгэхээр сайнмэдээг бусдад дамжуулах гол үүрэг даалгавраа анхаарах ёстой. Магадгүй тэдгээр хүмүүс бүгд итгэгч биш байж болох ч, чуулганы явуулсан сайнмэдээний үйлчлэлд татагдсан хүмүүс юм.

Тиймээс томъёолол маань Сайнмэдээ - Харилцаа холбоо - Тусламж (хөтөлбөр биш) гэсэн дараалалд орж байна. Ер нь чуулган тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллага болох ёсгүй. Чуулган бол харилцаа холбоотой хүмүүстээ тусалдаг хэсэг бүлэг хүмүүс юм. Хэрэв тэд ямар нэг хөтөлбөр эхлүүлбэл хүмүүс харилцаа холбоогүйгээр хөтөлбөрт хамрагддаг.

### **13-р хичээлийн даалгаврууд**

(1) Орон нутгийнхаа чуулгануудын сайнмэдээ тараах арга барилыг ажигла. Эдгээр арга нь чуулганаас гадуурх хүмүүст хүрэх тал дээр амжилттай байж чадаж байна уу? Тэд сайнмэдээг тодорхой дамжуулж чадаж байна уу? Ажиглалт хийж, 2-3 хуудас бич.

(2) Хамгийн багадаа 100 ш тараах материал тараана уу. Өөрийнхөө туршлагыг тайлбарласан хэдэн өгүүлбэр бичээрэй.





## 14-р хичээл

### Хүүхдүүдэд үйлчлэх нь

#### Танилцуулга

► Нэг суралцагч Матай 18:2-6, 10-14-ийг ангид уншина. Эдгээр эшлэлээс анхаарах зүйл юу байна вэ? Бурхан хүүхдүүдийг ямар чухал гэж үзэж байгааг та хэрхэн тайлбарлах вэ?

Заримдаа хүмүүс хүүхдүүд манай дараа үе, чуулганы ирээдүй, хожмын удирдагчид учраас маш чухал гэж үздэг. Бүгд үнэн. Гэхдээ хүүхдүүд хүн учраас л хамгийн чухал байгаа юм. Заримдаа томчууд хүүхдүүдийг мөнх амийг авах ёстой хүн, танигдаагүй их нөөц боломж гэдгийг мартах хандлагатай байдаг.

Нэгэн аялагч жижиг тосгоны хажууд зогсов. Тэрээр гудамжинд сууж байгаа нэг өвгөнийг хараад "Би энэ тосгоны талаар сонсож байгаагүй. Эндээс алдар цуутай хүмүүс төрдөг үү?" гэж асуув. Өвгөн "Үгүй, энд зөвхөн нялх хүүхэд л төрдөг" гэж хариулжээ.

#### Хүүхдүүдэд үйлчлэх талаарх Бурханы тушаал

Бурхан эртний Израилтай гэрээ байгуулж, тэднийг ерөөж, халамжилна гэдгээ амласан билээ. Гэхдээ дуулгавартай байх шаардлагыг мөн тавьсан байдаг.

Бурхан бүх үеийнхэнтэй гэрээ байгуулахын хүсдэг. Тэрбээр "Өнөөдөр чамд миний тушаал буй энэ үгсийг чи зүрхэндээ байлгаж, хөвгүүдээ үүгээр хурцлан..." (Дэд хууль 6:6-7) хэмээн хэлж байна.

Бурханы ерөөлүүд болзолтой бөгөөд хүмүүсийн дуулгавартай байх эсэхээс шалтгаалдаг байсан учраас Бурханы хүслийн дагуу хүүхдүүдийг өсгөж хүмүүжүүлэх нь маш чухал байлаа. Хэрэв дараа үеийнхэн Бурханд үнэнч, дуулгавартай байхыг хүсэхгүй бол Бурхантай харилцах харилцаанаас ирдэг ашиг тусыг алдах болно. Тиймээс хүүхдүүдэд сайтар зааж сургах шаардлагатай.

► Хүүхдүүдээ Бурханыг баталгаатай дагадаг болгохын тулд израилчууд юу хийдэг байсан гэж та бодож байна?

Бурхан тэдэнд хүүхдүүдээ сургах зарим заавар чиглүүлгийг өгсөн байдаг.

Та нар түүнийг хөвгүүддээ зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, хэвтэхдээ ч, босохдоо ч түүний тухай ярьж бай. Та нар үүнийг гэрийнхээ хатавчин дээр, хаалган дээр ч бич (Дэд хууль 11:19-20).

Бурханы хэлж байгаа санаа яг юу вэ? Энэ бол хааяа биш, харин хичээнгүйлэн, байнга, тууштай заах ёстой гэсэн санаа юм.

Тэд Бурханы хуулийг сануулагчийг нүдэнд харагдахуйц газар байрлуулах ёстой байв. Тэд хаа сайгүй Бичвэрийг үзэж байх ёстой ба Бурханы зарлигуудыг огтхон ч мартаж өсгүй байлаа.

Байнга заах гэдэг нь Бурханы хуультай зөрчилдөх зугаа цэнгэл, гоёл чимэг, биеэ авч явах байдлаас хол байна гэсэн үг.

Тиймээс эцэг эхчүүд Бурханы заасан үнэ цэнийг байнга, тууштайгаар хүүхдүүддээ зааж, үүний эсрэг үзэл суртал бүхий сургаалаас хамгаалах үүрэгтэй гэдгийг эдгээр эшлэлд онцлон хэлжээ.

► Энэхүү тушаал нь эцэг эхчүүдэд өгөгдсөн. Бид чуулганы үйлчлэлд хэрхэн үүнийг хэрэгжүүлэх вэ?

Нэгдүгээрт, хүүхдийг сургах нь эцэг эхийн үүрэг гэдэг нь ойлгомжтой. Тиймээс чуулган эцэг эхчүүдэд хүүхдүүддээ хэрхэн сургах ёстойг зааж үгэлтэй. Эцэг эхчүүд сүнслэг удирдамж өгч чадахгүй учраас үүнийг хүүхдүүд чуулганаас сурах ёстой гэж хэзээ ч бодож болохгүй.

Хоёрдугаарт, чуулган аль болох гэр бүлийнх нь хүрээнд хүүхдүүдэд үйлчлэх ёстой. Эцэг эхэд нь туслах замаар хүүхдүүдэд үйлчил. Сайнмэдээг түгээхдээ гэр бүлээр нь чуулган руу хандуулахыг хичээгээрэй.

Итгэгч бус гэр бүлээс гаралтай хүүхдүүд чуулганд ирж итгэгч болдог тал бий. Тийм үед чуулган аль болох гэр бүлд нь хүрч үйлчлэхийг хичээх хэрэгтэй. Харин эцэг эх нь сайн хариу өгөхгүй байгаа тохиолдолд чуулган л уг хүүхдийн сүнслэг гэр бүл болно. Чуулганы гишүүд сүнслэг халамж үзүүлдэг, садан төрлүүд мэт хандах учиртай.

### **Чуулганы хүүхдийн үйлчлэлийг үнэлэх нь**

► Аливаа чуулганы хүүхдийн үйлчлэлийн амжилтыг та хэрхэн үнэлэх вэ?

Хүүхдийн үйлчлэлд:

- Багш нар чинь онцгой чадвартай
- Хүүхэд, багш нарын тоо өсдөг
- Хүүхдүүд Библийн мэдлэгийг авдаг
- Багш нар сайн чанартай материал хэрэглэдэг
- Хүүхдүүд цуглаандаа дуртай

гэх мэт шинжүүд байлаа гээд амжилттай үйлчилж байна гэсэн үг биш юм.

Амжилттай хүүхдийн үйлчлэлд эдгээр шинжүүд бий. Хэрэв үйлчлэл эдгээрээр юм уу, заримаар нь дутвал мэдээж асуудал гарна. Гэхдээ эдгээрийг бүгдийг нь эсвэл заримыг нь хэрэгжүүлж чадлаа ч үйлчлэл амжилтгүй болж болно.

Хүүхдийн үйлчлэлд дараах шинж чанар байвал амжилттай. Үүнд:

- Хүүхдүүд итгэж, авралын баталгаатай болсон бол
- Хүүхдүүд аажмаар сүнслэг тал дээр төлөвшиж байвал
- Хүүхдүүд том болох тусмаа христитгэлийн зарчмуудыг дагаж байвал гэх мэт.

Танай хүүхдийн үйлчлэлд ийм хүүхдүүд байвал амжилтгүй байна гэсэн үг. Үүнд:

- Христийн дагалдагч биш
- Дэлхийлэг зүйлийг үлгэр дуурайл болгодог
- Том болох тусмаа зугаа цэнгэл, элдэв харилцааг дагадаг
- Бурханы хүслийг үл тоож, хувийн ашиг сонирхлоо хөөдөг гэх мэт.

**Амьдралаа Бурханы үнэнд нийцүүлэх нь дагалдагчийн хийх ажил. Итгэгч хүн Есүсийн төлөвшсөн дагалдагч болохоор хөгжих ёстой. Христийг хүлээж авлаа гээд хүний бодол санааны хэвшил, хандлага, ойлголт, амьдралын хэв маяг нь шууд автоматаар Бурханы үнэнтэй нэгдчихнэ гэсэн үг биш. Үүнийг сурахад цаг хугацаа шаардлагатай бөгөөд энэ л жинхэнэ дагалдагчийн үүрэг юм.**

### **Хүүхдүүдэд үйлчлэх эхний шаардлага**

► Хүүхдүүдэд үйлчлэхэд хамгийн түрүүнд юу хэрэгтэй гэж та бодож байна?

Хэдэн хүүхэд, томчуудыг оролцуулан бүлэг байгуулаад хүүхдийн үйлчлэлийг хурдан хугацаанд нээж болно. Ер нь аливаа бүлэгт төрөлхийн удирдагч, албан ёсоор томилогдоогүй ч зан чанараараа бусдад нөлөөлдөг хүмүүс байдаг. Томчуудын дунд ч, хүүхдийн дунд ч энэ адилхан.

Эерэг сүнслэг уур амьсгалтай, христитгэлийн орчныг бий болгох нь үйлчлэлийн хамгийн эхний шаардлага болдог. Тийм орчинд оюун ухаан, бие бялдар, сүнслэг болон нийгмийн хувьд төлөвшөөгүй итгэгчдийг хүмүүжүүлэх боломжтой.

Үүгээрээ насанд хүрэгчид нь оюун санааны хувьд үлгэр дуурайл болохуйц хүмүүс байдаг гэж хэлэх гээгүй юм шүү. Тиймээс та жинхэнэ итгэгч биш хүнийг хүүхдийн үйлчлэлд авч болохгүй. Таны дамжуулж байгаа сайнмэдээнээс татгалзахад хүргэж чадах хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг хүүхдүүдийг мөн бүлэгтээ оруулах хэрэггүй.

Хэрэв дараах шинжүүд байгаа бол танай хүүхдийн үйлчлэл хэдийн бүтэлгүйтжээ. Үүнд:

- Үйлчлэлд тусалж байгаа насанд хүрэгчид онцгой чадвар, эсвэл өөр ямар нэг шалтгааны улмаас тэнд байгаа боловч сүнслэг тал дээр сайн үлгэр дуурайл болж чадахгүй байгаа бол,
- Сүнслэг зүйлийг сонирхдоггүй хүүхдүүд гол яриаг удирдан өрнүүлж, бүлэг дотор нийгмийн харилцаа давамгайлж байвал,
- Сүнслэг үйл ажиллагааг зөвхөн томчууд удирдаж, хүүхдүүдийн оролцоо бага байвал,

- Цөөхөн хүүхэд сүнслэг хэрэгцээг сонирхож, хамтран ажилладаг боловч тэднийг бусад нь хүлээн зөвшөөрдөггүй бол гэх мэт.

Хүүхдийн бүлгээ хараад дараах асуултыг өөрөөсөө асуугаарай. Хэрэв танай хүүхдийн бүлэгт шинэ хүү ирж эхэлбэл тэр хүү ямар хүүхдийг илүү дагаж нөхөрлөх бол? Хэрэв танай хүүхдийн бүлэгт шинэ охин ирдэг боллоо гэхэд тэр охин ямар хүүхдийг илүү дагах бол? Тэд сайн нөлөө авах уу, муу нөлөө авах уу?

Тиймээс эелдэг христитгэлийн орчныг бүрдүүлэх нь хүүхдийн үйлчлэлийн хамгийн эхний шаардлага юм. Энэхүү эхний хэрэгцээг бий болгохоос үйлчлэл эхэлнэ. Хэрэв ийм орчин байхгүй бол, ямар нэг байдлаар үүнийг дахин бий болгох ёстой. Эс бөгөөс зорилгодоо хүрч чадахгүй.

### **Амин харилцааны зарчим**

Бурханы мэдлэг харилцаагаар дамжуулан ирнэ.

Бурхан Иаковтай ярьж, Өөрийгөө мэдүүлэх үедээ “Би ертөнцийн Эзэн” эсвэл “Би энэ дэлхийг бүтээсэн Бурхан” гэж хэлээгүй. Хэдийгээр аль аль нь үнэн боловч Тэрбээр “Би бол ЭЗЭН, чиний эцэг Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан байна.” (Эхлэл 28:13) гэж хэлсэн байдаг. Бурхан Өөрийгөө хүмүүсээр дамжуулан илэрхийлдэг.

Абрахам итгэлийн хүн болж, бусад нь Абрахамаар дамжуулан Бурханд итгэсэн юм. Тиймээс Абрахамын зарц Елиезер “Миний эзэн Абрахамын Бурхан” гэж залбирсан байдаг (Эхлэл 24:12).

Таны итгэлийн улмаас Бурханыг илүү ихээр мэдэхийг хүсдэг хүмүүс гарч ирэх учиртай. Заримдаа бид хүмүүст мэдэх ёстой, хийх ёстой зүйлийг нь хэлж өгөх нь л дагалдуулалт гэж боддог. Тийм биш. Юуны өмнө та тэдэнд дагалдагч болохыг хүсмээр амьдралыг харуулах ёстой. Хэрэв тэд тан шиг амьдрахыг хүсэж байгаа бол таны хэлэх үг, зааврыг дагах болно.

Дагалдуулна гэдэг нь амьдралын туршид байх харилцаа юм. Амьдралын хэв маяг, хүсэл эрмэлзэл, үнэт зүйл бүгд дагалдуулагчаас дагалдагч руу шилждэг зүйлс.

**Багш хүн амьдралынхаа хэв маяг, сэдэл, гол үнэт зүйлсээ сурагчдаа суулгаж өгснөөр дагалдуулалт бий болдог гэж амьдралаа шилжүүлэх зарчимд заажээ.**

Нэгдүгээр зууны еврей рабби нар дагалдуулалт гэдэг бол амьдралаа шилжүүлэх үйл хэрэг гэдгийг ойлгодог байжээ. Нэгэн залуу рабби дээр очиж шавь болохыг хүсжээ. Хэрэв рабби зөвшөөрвөл амьдралаа хуваалцаж эхэлнэ гэсэн үг. Шавь нь үргэлж хамт байж, зөвхөн сургаалыг нь суралцаад зогсохгүй мөн амьдралд хандах хандлагыг нь бас суралцдаг байв.

Харин Есүс дагалдагч болох хүсэлт гаргаагүй хүмүүсийг сонгосноороо тэр үеийн багш нараас ялгаатай байлаа. Гэхдээ амьдралаа шилжүүлэх зорилгоор хамтдаа байж, суралцдаг тэр үеийн заншлыг дагасан юм.

Есүсийн үхэл амиллын дараа зарим дагалдагчид баривчлагдаж, Есүсийг яллаж байсан тэр шүүхийн өмнө очсон байдаг. Есүсийг л зайлуулчихвал бүх асуудал шийдэгдэнэ гэж иудейн зөвлөлийнхөн бодсон бололтой. Тэд Есүсийн дагалдагчдыг айлгаж, дуугүй болгоход цөөн хэдэн заналхийлэл хангалттай гэж тааварласан. Тэд дагалдагчдыг шалгах явцад дагалдагчдыг өндөр боловсролгүй, шүүхийн гишүүдээс доогуур боловсролтой хүмүүс гэдгийг харсан биз. Гэхдээ тэднийг Есүстэй хамт байсныг зөвлөлийнхөн мэдсэн тухай Библид дурдаж байна (Үйлс 4:13). Есүс Өөрийнхөө амьдралыг тэдний дээр тамгалсан байв.

Зөвлөлийнхөн дагалдагчдаас Есүсийн юуг олж харсан бэ? Хэв маяг, эсвэл хэлж ярих арга барил байв уу? Магадгүй юм. Гэхдээ үүнээс ч илүү зүйлийг олж харсан. Тэд тэнгэрлэг дуудлагыг ухаарахад ирдэг эр зоригийг олж харсан юм. Тэд ямар ч үнээр хамаагүй үнэний төлөө тууштай зогсож байхыг нь харсан. Түүнчлэн эрх мэдэлд хүндэтгэлтэй ханддаг ч буулт хийх, хоёр нүүр гаргахаас татгалзаж байгааг нь олж харсан юм. Авилгад автсан улс төрчид, хоёр нүүрт шашны удирдагчид асуудал дөнгөж эхэлж байгааг мэдээд чичирч байсан биз. Есүс тийнхүү дагалдагчдаараа дамжуулан нөлөөгөө өсгөж, мөнхжүүлжээ.

Доктор Паул Брэнд анагаах ухааны чиглэлээр суралцаж буй залуу оюутнууд нь Энэтхэгийн нэгэн эмнэлэг дээр үзлэг, оношлогооны дадлага хийж байхыг ажиглаж байв. Нэгэн оюутан өвчтөнүүдтэй тун эелдэг харилцаж байх бөгөөд нүүрэнд нь тодорч байгаа илэрхийллийг хараад Паул эмч маш их гайхжээ. Тэрхүү нүүрний илэрхийлэл нь Паул Брэнд эмчийг Англид сургаж байсан Доктор Пилчерийн нүүрний илэрхийлэлтэй тун адилхан байлаа. Пилчер эмч хэзээ ч Энэтхэгт ирж байгаагүй учраас дадлагын оюутан яагаад түүнтэй ийм адилхан үйлдэл хийж байгааг гайхан асуужээ. Эцэст нь дадлагажигч оюутнуудын нэг нь "Бид Пилчер эмчийг мэдэхгүй боловч Брэнд эмч таныг мэднэ. Таны нүүрний илэрхийлэл тийм байдаг" гэж хэлжээ."<sup>9</sup>

Үүгээр заах гэж оролдоогүй үедээ заадаг үйл хамгийн үр дүнтэй байдаг нь харагдаж байна. Та юуг ч заах гэж оролдоогүй үедээ хамгийн ихийг зааж байдаг. Нэг хүн "Та үгээрээ бага зэрэг, үйлдлээрээ маш ихийг заадаг" гэж хэлсэн байдаг.

Өөрийнхөө үлгэр дуурайлын нөлөөнөөс болгоомжил. Та үргэлж зааж байна. Та амьдралын хэв маягаараа бусдыг дагалдуулдаг. Та асуудалд яаж хандаж байгаа байдлаараа дагалдагчдаа асуудалд хэрхэн хандах замыг зааж өгдөг. Хүүхэдтэй ажиллахад эелдэг байдал, тэвчээр, маш чухал. Зарим хүн хүүхдүүдэд бусдаас илүү эелдэг, халамжтай, тэвчээртэй хандах чадвартай байдаг.

Хэрэв та бүрэн анхаарлаа хандуулж чадвал тухайн хүнд үнэ цэн өгч байна гэсэн үг. Хүнтэй ярихдаа яарах хэрэггүй. Нүүр буруулах, дараагийн хийх юм руугаа яарах, ярьж байх үед нь юм хийх, эсвэл анхаарлаа өөр хүн рүү хандуулах зэрэг биеийн хэлэмжээ анзаарч байгаарай.

---

<sup>9</sup> Paul Brand and Philip Yancey, *In His Image*. (Grand Rapids: Zondervan, 1984), 18-19

Сайн сонсох дадал зуршлыг хэвшүүлээрэй. Нүдээрээ харилцах, анхаарлаа төвлөрүүлэх, анхаарал сарниулах зүйлийг үл тоомсорлох, илтгэгчийн хошигнол болон бусад сэтгэл хөдлөлд хариу үйлдэл үзүүлэх зэрэг нь сайн сонсож байгаагийн шинж тэмдэг юм.

Хэрэв үнэхээр яарч байгаа бөгөөд сонсоод байж чадахгүй бол түүнийгээ тайлбарлаж болно. Хэрэв та хүмүүст анхаарлаа ихэвчлэн хандуулдаг бол таны үйлдэл тэднийг гомдоохгүй. Харин та цаг гаргая гэвч дэндүү завгүй, мөн бусдаар хийлгэх хэрэгтэй гэж боддог бол та хэсэг зогсосхийгээд, таны жинхэнэ ажил юу вэ гэдгийг бодож үзээрэй.

► Ямар хүүхдүүд таны амьдралд байна вэ? Тэдэнд чухал гэдгийг нь харуулах ямар арга замууд байдаг вэ? Танд өөрчлөх ёстой зарим нэг зуршил байна уу?

Бурханд цаг гаргах нь бүхий л чадвараас илүү чухал юм. Бурханд авьяас чадвараас маань илүүгээр бидний анхаарал хэрэгтэй. Түүний дуудлагыг биелүүлэх чадварыг Бурхан хүнд өгдөг.

Залуу хүмүүс олон зүйл дээр тогтвортой байж чаддаггүй. Нэг өдөр сүнслэг, нөгөө өдөр тэрслүү мэт, эсвэл өгөөмөр сэтгэлтэй эсвэл хувиа хичээсэн зантай юм шиг, мөн төлөвшсөн ч юм шиг эсвэл хүүхэд ч юм шиг болж хувирч байдаг. Энэ бол хоёр нүүр гаргаж байгаа хэрэг биш. Харин хөгжиж байгаа нь тэр бөгөөд зан чанар нь тогтвортой биш байна гэсэн үг.

“Залуу бага хүнийг өрөвдөх сэтгэлгүй хүн бол газар дэлхий дээрх хэрэггүй хүн юм.”  
- Жорж Мак Дональд

Хэдийгээр залуу хүмүүс тогтворгүй байдаг ч та тэдэнд тууштай хандах ёстой. Тэднийг бүтэлгүйтэх үед та үнэ цэнийг нь унагах юм хэлбэл тэдний өөртөө итгэх итгэлийг унагана. Тэд хэн болохоо хараахан мэдээгүй байгаа учраас таны үнэлгээ тэднийг ямар хүн болоход нөлөө үзүүлнэ.

Хүүхдүүдийн амьдралд зориулсан Бурханы онцгой төлөвлөгөөний талаар их ярь. Бурхан хүн бүрд онцгой чадвар өгсөн гэдгийг хэл. Бурханы хүслийг олбол сэтгэл ханамжтай болдог тухай ярьж өгч байгаарай.

Удирдах чадвартай залуу хүн олон санаатай байж болох ч муу хүнээс салж чаддаггүй тал бий. Сайн мууг ялгах нь төлөвшлийн нэг тал учраас мэргэн ухаанд суралцахад нь түүнд тусал. Гэхдээ гаргасан санааг нь мохоож болохгүй.

Хамгийн гол нь хүн бүрд зориулсан Бурханы төлөвлөгөө гэж бий бөгөөд Тэрбээр үүний төлөө ажилласаар байна. Хүүхдүүдийг хөгжүүлэх Бурханы төлөвлөгөөний дагуу ажиллаж чадахын төлөө залбираарай. Залуусын амьдралд Бурханы зөв чиглүүлэг, хангамж, гайхамшгууд байхын төлөө залбир.

### **Заах чадвараа сайжруулах нь**

► Сайн заах арга ямар ямар хэв шинжийг агуулдаг вэ? Та хичээл зааж байгаа хүнийг хараад сайн багш гэдгийг нь яаж мэдэх вэ?

Багш хүн заах аргыг хянаж авч явдаг. Хичээлээ төлөвлөх үедээ нарийн анхаарах ёстой хэд хэдэн тал бий.

### **(1) Заавар өгөх хэмжээ**

Хүмүүс нарийхан хүзүүтэй ваар шиг байдаг. Шингэнийг хэт хурдан асгавал зарим нь орохгүй. Хүн шинэ мэдээлэл олж авахдаа үүнийгээ өмнө нь мэддэг зүйлтэйгээ холбож ойлгодог. Түүнчлэн шинэ мэдээлэл нь амьдралд ямар хамаатай болохыг бас багш бодох ёстой. Ер нь мэдээллийг хүлээж авах хүний хурд хязгаартай.

Мартаж болох олон санааг нэг дор багтааж хэлэх гэснээс нэг санааг мартагдахааргүй арга барилаар хэлж өгсөн нь дээр. Хүүхдүүд ач холбогдолгүй олон тооны мэдээллийг сонссоноос нэг чухал ойлголтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар сурах нь илүү дээр.

### **(2) Бүлгийн хэлэлцүүлэг**

Ихэнх хүмүүс сурч байхдаа бусадтайгаа ярилцах, асуулт асуух, сурч байгаа зүйлээ өөрийнхөө үгээр давтан хэлэх шаардлагатай байдаг. Хэрэв багшийн заах арга барил нь сонсогчдод харилцах боломжийг өгөхгүй бол тэд тийм ч их зүйлийг сурч чадахгүй.

Та “Энэ яагаад чухал вэ?” эсвэл “Таны мэдэх ёстой хамгийн чухал зүйл юу вэ?” гэх мэт асуултаар сэдвээ эхэлж болно. Танилцуулах хэсэгт их цаг үрэлгүйгээр сонирхол татах аргуудыг ашиглах хэрэгтэй.

Хэсэг мэдээлэл өгсний дараа тухайн ойлголтыг өөр өөрийнхөө үгээр тайлбарлах боломжийг олгох үүднээс багш асуулт асууж болно. Жишээлбэл: “Энэ түүх дээрх хүн ямар алдаа гаргасан бэ?” эсвэл “Энэ яагаад бидэнд чухал вэ?” гэх мэтээр “Тийм, үгүй” гэх хариулт биш, харин тайлбартай хариулт өгөх асуултуудыг асуу. Асуултууд ихэвчлэн хүүхдүүдээс хангалттай хариулт авч болохуйц хялбар байх ёстой. Хэрэв хариулт нь дандаа буруу байвал хүүхдүүд оролцох сонирхолгүй болдог.

- Суралцагчийг хувийн зүйлээ хуваалцаж ярихыг шахаж болохгүй. Үүний оронд өөрөө чөлөөтэй хуваалцах уур амьсгалыг бүрдүүлээрэй.
- Зарим суралцагчийг ганцааранг нь яриулаад байж болохгүй. Тиймээс чимээгүй байгаа суралцагчаас “Чарльз, чи юу гэж бодож байна?” гэх мэтээр асуух юм уу, “Та нар юу гэж бодож байна?” гэх мэтээр бусдынх нь оролцоог хангах ёстой.
- Ангид бусдыг үл тоомсорлон өөрийнхөөрөө хэлэлцүүлгийг хийх гэж зүтгэдэг хүмүүсийг бүү яриул.
- Ярьж буй хүүхдийн яриаг таслахыг хэнд ч зөвшөөрөх ёсгүй.
- Санал сэтгэгдэл бүрийг шүүмжлэх бус, харин ямар нэг байдлаар эхлээд бататгаж өг. Хэрэв залруулах шаардлагатай бол сэдвийг өргөтгөх замаар залруулж өгөх нь зүйтэй.

### **(3) Хамаарал**

Өөрөөсөө үргэлж “Энэ материал яагаад чухал вэ?” гэж асуу. Хэрэв та яагаад гэдгийг мэдэхгүй бол тэд ч бас мэдэхгүй. Тэдэнд ямар өөрчлөлт авчрах вэ? Амьдралдаа хэрэгжүүлж болох онцгой зүйл байна уу? Хэрэв та энэ бүхний алийг нь ч олж харахгүй байгаа бол тэд ч бас олж харахгүй.

Хэрэв хүүхдүүд тухайн сэдэв өөрсдөд нь хамаатайг мэдвэл сайн сонсоно. Ангиа хяналтдаа авахын тулд сахилга батаас илүүгээр сонирхолтой талыг нь хангах ёстой.

### **(4) Ач холбогдол**

Зааж буй үнэн сургаалынхаа үр дүнг харуул. Хүмүүс үүнийг мэдэж, дагаж мөрдвөл юу болох вэ? Хүмүүс энэ үнэнийг үгүйсгэвэл яах вэ?

Тэдэнд гайхалтай сэдвүүдийг заагаарай. Жижиг асуудалд хэт их цаг зарцуулахаас зайлсхий. Таны хуваалцаж буй үнэн сургаалын дагуу амьдарч байсан бусад хүмүүсийн тухай түүхийг ярьж өг. Тэд таны хичээлийн тоймыг санахгүй ч ярьсан түүхийг чинь санах болно.

Тэдэнд баатруудыг танилцуул. Хүүхдүүд биширч дуурайх хүмүүсийг хайж байдаг. Итгэлийн баатруудын тухай болон агуу гайхамшгуудыг харсан хүмүүсийн тухай, мөн Бурханы хүчээр агуу үйлсийг хийсэн хүмүүсийн тухай ярь. Сайнмэдээ тарааж, дагалдагч бэлтгэх нь чуулганы хамгийн эрхэм зорилго бөгөөд дэлхий дээрх хамгийн том хүч сорьсон бас сэтгэл хангалуун ажил гэдгийг ойлгоход нь туслаарай.

### **(5) Үзүүлэх материал**

Боломжтой бол түүх ярихдаа өнгөлөг зураг ашигла. Ухагдахуун ойлголтын талаар ярихдаа гол үг, үндсэн санааг самбар дээр бичээрэй. Хүүхдүүд харж, сонссон юмаа сайн санадаг.

### **(6) Үйлдэл**

Хүмүүс хийж байж сурдаг. Хүүхдүүд ямар нэгэн зүйл хийх эсвэл түүхийг жүжигчлэн тоглох замаар сурдаг. Багш заасан Библийн түүхээ ашиглан жүжиг тоглуулж болно. Үүнд цаг хугацаа их шаарддаг тул бүтэн түүхийг хичээл бүр дээр тоглуулаад байж чадахгүй. Тиймээс хичээл бүр дээр үйлдлээр хийх ажлыг бодож олоорой.

► Чуулганы зарим гишүүд сүүлийн үеийн хичээл, заасан номлолоо танилцуулж, эдгээрийг хэрхэн илүү сайн хэрэгжүүлэх талаар тайлбарлаж болно. Зарим нь эдгээр зарчмыг хэрэгжүүлэхийн тулд юу хийснээ ярьж болох юм.

### **Хүүхдүүдэд сайнмэдээ тараах арга: Үггүй ном**

Хуудас бүр нь үггүй, харин өнгийн цаастай, цаас бүр нь сайнмэдээний хэсэг агуулгыг илэрхийлдэг ном бий.



Хуудас бүрийн дагалдах агуулгыг доор хураангуйлан оруулав. Та Үггүй номыг ашиглах үедээ илүү их тайлбарлан ярьж, хүүхдүүдэд асуулт асуух, харилцан ярилцах боломжийг олгоорой.<sup>10</sup>

Тэмдэглэл: Зарим хүн эхлээд алтан, тэгээд хар, дараа нь энд жагсаасны дагуу бусад өнгийн хуудсаар үргэлжлүүлдэг.

**Хар:** Хар өнгө бидний хийсэн нүгэл, муу муухайг сануулдаг. Хүн бүр нүгэл үйлдсэн гэж Библид бичигдсэн байна. Нүглээс болж бидэнд хэцүү асуудлууд тулгарсан (Энэ үед та тухайн хүүхдээс нүгэлт хүн гэдгээ хүлээн зөвшөөрч буй эсэхийг нь асуух хэрэгтэй).

**Улаан:** Бурханы Хүү Есүс бидний төлөө амиа өргөж, бидэнд уучлалыг авчирсан сайнмэдээ бий. Улаан өнгө Есүсийн цусыг төлөөлнө. Есүс үхсэн, гэхдээ үхлээс амилсан бөгөөд бидэнд тэнгэрийн улсыг бэлтгэж байна.

**Цагаан:** Бурхан биднийг уучилж, бидний зүрх сэтгэлийг цагаан болгодог. Тэрбээр бидний хийсэн нүглийг арчиж цэвэрлэсэн. Та залбирч, Бурханаас уучлал гуйж болно. Хэрэв та нүгэлдээ харамсаж байгаа бол Бурхан таныг уучлахад бэлэн байна.

**Алтан:** Алт бол бидний төлөө Бурханы бэлтгэж байгаа тэнгэрийн улсыг төлөөлнө. Бидний амьдрал дуусах үед бид Бурхантай хамт тэнгэрийн улсад амьдрах болно. Тэнд уйтгар гуниг, өвчин, муу муухай гэж үгүй.

**Ногоон:** Та уучлагдсан учраас одоо та Бурханы хүүхэд болсон. Та Бурхантай харилцах харилцаандаа өснө. Ногоон өнгө өсөлтийг төлөөлдөг. Та Бурханы тухай болон таныг Бурхан хэрхэн амьдраасай гэж хүсэж байгаа тухай илүү ихийг мэдэж болно. Библийг өдөр бүр уншиж, өдөр бүр залбирч, Бурханд ойрхон амьдрах талаар мэддэг хүмүүсийг сонсох хэрэгтэй.

---

<sup>10</sup> Үггүй номыг ашиглахдаа юу ярих талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах вэбсайтуудаар зочлоорой.

<http://berean.org/bibleteacher/wb.html>

<http://www.abcjesuslovesme.com/ideas1/bible/bible-themes/1150-wordless-book>.

Үггүй ном эсвэл үүнтэй төстэй зүйлсийг хэрхэн хийх талаар мэдээлэл авахыг хүсвэл энэ холбоосыг үзнэ үү:

<http://www.teenmissions.org/resources/wordless-book-bracelet/>.

## 14-р хичээлийн даалгаврууд

(1) Та энэ хичээлийн “Амин харилцааны зарчим” гарчгийн доорх хэсгийг дахиж хараарай. Зөвхөн хичээл зааж байгаагаа биш, харин хүүхдүүдтэй харилцах харилцаагаа, тэдэнтэй тааралдах бүрдээ ямар байдгаа анзаараарай. Та юуг өөрчлөх хэрэгтэй байна? Таныг сайн мэддэг хүнтэй ярилцаарай. Түүнд материалуудаа үзүүлж, өөрийнхөө үнэлгээг тайлбарлаарай. Тэдний шударга саналыг асуу. Тэгээд энэ даалгаврыг хийхдээ үүнийгээ тайлагнаарай. Гэхдээ өөрийнхөө үнэлгээний талаар дэлгэрэнгүй оруулах эсэхээ өөрөө шийдээрэй.

(2) Хүүхдэд зориулсан хичээл юм уу, номлол бэлтгэ. Үүндээ зургаан төрлийн хэв шинжийг ашиглан нямбай бэлтгээрэй. Хэрхэн төлөвлөсөн талаараа тайлбараа мөн бэлдээрэй.

(3) Үггүй ном худалдаж авах, эсвэл хийх арга ол. Танилцуулан ярих аргыг сурч, хамгийн багадаа гурван хүнд тайлбарлаж өгөөрэй. Тэгээд туршлагынхаа талаар цогцолбор бичээрэй.

# 15-р хичээл

## Чуулганы төсөл/загвар

### Танилцуулга

Жоел чуулганыхаа эхний хэдэн жилийн талаар ярих дуртай. "Бид цэцэрлэгт хүрээлэнд уулзаж, харсан бүхнээ л урьж байлаа. Хүйтэн болмогц, бид хуучин автобусанд цугладаг байв. Бидэнд угаалгын өрөө гэж байсангүй. Хожим нь бид спорт зааланд хэсэг хугацаанд уулзаж байгаад дараа нь чуулганы хуучин байрыг түрээсэлсэн."

Жоелын чуулган тэр жилүүдэд өсөж байлаа. Тэр чуулганд үнэнч байсан хүмүүс чуулганы барилгад бус, харин тэрхүү хэсэг бүлэг хүмүүст татагдаж байв.

Энэ хичээл дээр бид чуулганыг хэрхэн төлөвлөх талаар ярина. Мэдээж барилга байшингийн тухай ярихгүй. Тэгээд ч олон том чуулганууд хүнд хэцүү нөхцөлд эхэлсэн түүхтэй байдаг.

Зарим чуулганыхан барилга байгууламж нь хангалтгүй учраас хүмүүсийг татаж чадахгүй байна гэдэг. Гэвч тэдэнд барилгаас илүү чухал зүйл дутагдаж байгаа нь үнэн билээ.

### Чуулганд урихын утга учир

Итгэгчид үргэлж л хүмүүсийг чуулгандаа урьж байдаг. Зочдод нь тэдний чуулган таалагдаж, тэднийг үргэлжлүүлэн ирнэ хэмээн тэд найдна. Түүнчлэн зочид нь сайнмэдээнд хариу өгнө гэдэгт найдаж суудаг.

► Та хэн нэгнийг чуулганд урина гэдэг нь ямар утгатай вэ? Та тэр хүнд юуг санал болгож байгаа хэрэг вэ?

Бид хүмүүсийг шашинлаг дасгал сургуулилтад оролцуулах, эсвэл үүргээ биелүүлэх гэсэндээ чуулгандаа урьдаг юм биш. Итгэл байхгүй бол шашны ёс заншлууд үр нөлөөтэй байна гэж үгүй.

Түүнчлэн хүмүүс Христийг хүлээж аваагүй бол Бурханы хүндэтгэх гэдгийг ойлгоно гэж бид бодохгүй байна.

Харин бид хүмүүсийг чуулганы найрсаг байдалд татагдаж, дахин хамт байхыг хүснэ хэмээн найддаг.

Хүмүүсийг сайнмэдээнд хариулна хэмээн бид найдсаар байдаг.

Зарим чуулган сүнслэг зүйлийг сонирхдоггүй хүмүүсийг татах зорилгоор хөтөлбөр хийдэг. Мэдээж хүмүүст уг хөтөлбөр таалагдвал үргэлжлүүлэн оролцоно гэж найдна. Гэхдээ хөтөлбөр үзүүлбэр амжилттай болбол чуулганд сүнслэг бус сонирхол агуулсан

хэсэг бүлэг хүмүүс хөтөлбөрт татагдан ирэх асуудал бий. Ингээд чуулган нь мөргөл хүндэтгэл өргөх сонирхолгүй, харин үзүүлбэр үзэж зугаацах гэсэн хүмүүсийг багтаасан холимог бүлэг болж хувирна. Магтаалын удирдагчид нь хөгжимчид, жүжигчид болно. Яваандаа мөргөл хүндэтгэл өргөх сонирхолгүй мөргөл хүндэтгэлийн удирдагчид бий болно. Улмаар мөргөл хүндэтгэл гажиж эхэлдэг.

► Энэ асуултыг дахин бодож үзээрэй. Та хэн нэгнийг чуулганд урихдаа юу санал болгодог вэ? Та юу санал болгох ёстой вэ?

Хүн Христийг хүлээж авахад ямар өөрчлөлт гардаг тухай бодно уу. Хуучин шашнаа орхиж, магадгүй найз нөхөд, гэр бүлээсээ ч салж болно. Нүглээ гэмшиж, баяр цэнгэл олж чадна гэсэн ихэнх зүйлээ орхидог. Тэгээд амьдралынхаа хяналтыг Бурханы гарт даатгадаг.

Хүн итгэх үед маш том өөрчлөлт болдог учраас нэгдэж байгаа итгэгч хамт олон, орхиж байгаа хуучин зүйлсээ бодолгүйгээр хүн итгэлийн замд орно гэж байхгүй. Хэрэв хүн гэрчлэл эсвэл хэн нэгэн итгэгчид татагдсан бол тухайн итгэгчийн итгэлийн гэр бүлийг харахыг хүсдэг. Итгэл нь үнэхээр хэрхэн амьдруулж байгааг харахыг хүснэ. Түүнчлэн сонсож байгаа сайнмэдээ нь түүний нэгдэх гэж байгаа итгэлийн хамт олныг үүсгэсэн гэдгийг тааварлаж байдаг. Тэрээр "Энэ мэдээнд итгэж, үүгээр амьдардаг хэсэг бүлэг хүмүүс хаана байна? Би тэр хүмүүсийн дунд орвол ямар байх бол?" гэж асууж байгаатай адил юм.

Есүс ихэвчлэн тэнгэрийн хаанчлалын сайнмэдээг номлож байсан. Тэрбээр хүмүүст Бурханы хаанчлал тэдэн дээр ирчихээд байна (Лук 10:9) гэж хэлж байсан. Бурханы хаанчлалд орсон хүмүүс Бурханы захиргааг хүлээн зөвшөөрч, хуулийг нь дагаж, амьдралаа хуваалцдаг. Бурханд үнэнч байдал нь тэднийг итгэлийн хамт олон болгодог.

"Есүс дагалдагчдаараа дамжуулан үхлийн хүч ба тамыг сорьж, ялах чуулганы бүтцийг байгуулсан. Энэ нь гичийн үр шиг өчүүхнээс эхэлсэн ч хэмжээгээрээ ч хүчээрээ ч өссөн юм."

- Роберт Коулмэн,  
"Мастерын төлөвлөгөө"

Хүмүүс сайнмэдээгээр бий болсон итгэлийн хамт олныг харахыг хүсдэг учраас сайнмэдээ нь зөвхөн хувь хүн хувь хүнийг ятгах замаар явагдах боломжгүй. Өөрөөр хэлбэл нутгийн чуулган хэрэгтэй гэсэн үг. Нутгийн чуулган нь итгэлийн хамт олныхоо хувьд бусдыг татдаг байх ёстой.

► Итгэлийн хамт олонтой нэгдэхээсээ өмнө хүн юу харахыг хүсдэг вэ?

Чуулганд Бурханы загварчилсан мөн чанар, Бурханы өгсөн үүрэг даалгавар байдаг. Нутгийн чуулган бүр Бурханы тогтоосон жишгийн дагуу хамгийн сайнаараа байх ёстой. Бид хүмүүсийг татахын тулд чуулганыг өөр ямар нэг газар болгож болохгүй. Бид чуулганыг байх ёстойгоос нь өөр ямар нэг газар мэт харагдуулах гэж оролдох ёсгүй.

Чуулган Бурханы өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэг л бол зөв хүмүүсийг татаж, зориулалт бүхий хамт олныг бий болгоно.

## Хүмүүсийг татдаг нутгийн чуулганы шинж чанар

**(1) Гишүүд нь Бурхантай харилцах харилцаандаа үнэн голоосоо, сэтгэл хангалуун байгаа эсэхээ харуулж байдаг.** Итгэдэггүй хүмүүс Бурхантай харилцаа холбоогүй. Гэхдээ Бурхантай амьдрал ямар байдгийг хараад хүн энэ хэрэгцээгээ мэдэрч эхэлдэг. Чуулганы гишүүд Бурханыг мэдэхийн баяр хөөрийг гэрчилж, тууштай амьдралаараа үүнийг харуулж байдаг. Хэрэв хүн чуулганд явдаг атлаа нүгэл үйлдсээр байгаа бол Бурханд сэтгэл хангалуун бус байгаагаа харуулж буй хэрэг.

**(2) Чуулган нь онол сургаалаа үнэн болон Бурхантай харилцах харилцааг үндэслэн зааж сургадаг.** Бид онол сургаалыг үнэн учраас номлодог. Зөвхөн үнэн байгаад зогсохгүй, Бурхантай хамт амьдрахыг хүсдэг хүслийнхээ улмаас бид Христийн сургаалаас суралцдаг. Гэрлэлт шиг амлалт дээр холбогдсон Бурхантай харилцах харилцаа маань зориулалт гаргах амлалтыг бас агуулна. Онол сургаал нь хэрхэн амьдрахыг тайлбарладаг юм.

**(3) Бурханд мөргөл хүндэтгэл өргөхийн баяр хөөрийг чуулган харуулдаг.** Мөргөл хүндэтгэл өргөх баяр хөөр нь зугаа цэнгэлээс таашаал авахаас өөр. Үнэндээ жинхэнэ Бурханыг хүндэлдэггүй хүмүүс Бурханыг мөргөн хүндэтгэхээс ирдэг баяр хөөрийг мэдэрдэггүй. Харин бид мөргөл хүндэтгэл өргөхөөр бүтээгдсэн учраас бидний баяр хөөртэй мөргөл хүндэтгэлийг харсан итгэдэггүй хүн тэрхүү хэрэгцээг мэдрэх болно.

**(4) Чуулганы гишүүд өнө мөнхийн хэтийн төлөв бүхий амьдралын зорилгыг харуулдаг.** Христийн дагалдагчид өөрсдийнх нь амьдрал хэр чухал байгаа эсэхэд ач холбогдол өгдөггүй. Хүнд хэцүү цагт итгэгчдийн дээр тайтгарал, зоригжуулалт байдаг. Харин итгэдэггүй хүмүүс сэтгэлийг нь хангах амьдралын зорилгыг олохын төлөө тэмцэлддэг бөгөөд үхэл ба үүрд мөнхийг хэрхэн угтахгаа мэддэггүй.

**(5) Чуулган нь аминч зорилго бус харилцаа чухал гэдгийг харуулдаг.** Чуулган нь байгууллагаа босгон байгуулахын тулд зорилго тавин, сайнмэдээ тараадаг газар биш. Дэлхийн хүмүүс харилцааг үл тоомсорлож, эсвэл харилцааг хувиа хичээсэн зорилгодоо ашиглах хүсэлтэй байдаг.

**(6) Чуулганы сургаал нь хүний сүнслэг гүн хэрэгцээг хангадаг.** Аврагдаагүй хүмүүс сүнслэг өлсгөлөнд автсан байдаг бөгөөд энэ дэлхийн юугаар ч тэр өлсгөлөн дарагдахгүй. Харин чуулганы номлол, сургаал, зөвлөгөө нь хүний жинхэнэ хэрэгцээ рүү чиглэсэн байдаг.

**(7) Чуулган бол нэг нэгнээ халамжилдаг итгэлийн гэр бүл юм.** Аливаа бүлэг хүмүүс нь гишүүдийнхээ хэрэгцээнд тусалдаг боловч, Христийн дагалдагчид л жинхэнэ христитгэлийн нөхөрлөлийг бий болгож чаддаг.

► Эдгээр шинж чанарыг харуулах ямар ямар онцгой шинж чуулганд байж болох вэ? Чуулган нэн тэргүүнд тавих зүйлсээ сайтар харуулах юу хийж эхлэх ёстой вэ?

## **Чуулганыг сайнмэдээ тараахад бэлтгэх нь**

Чуулган нь хөтөлбөр, зохион байгуулалтаа сайнмэдээг тараах, дагалдагч бэлтгэх гэсэн үүрэг даалгавраа биелүүлэхэд зориулан төлөвлөх хэрэгтэй. Чуулганы хийж буй бүх үйл ажиллагаа энэхүү тэргүүлэх чиглэлтэй нийцэх ёстой юм.

### **Зочдыг угтах нь**

Чуулган нь зочдыг хүлээн авч, ая тухтай байлгахад бэлтгэх ёстой. Зарим хүнд чуулганы ёс заншил танил бус байдаг. Чуулганд зочлон очих үед юу болох талаар ямар ч мэдлэггүй учраас анх чуулганд ирээд эхний хэдэн минутад ирсэндээ баярлах, эсвэл ирдэггүй байж гэж боддог байна. Тиймээс чуулган шинэ хүмүүсийг хүлээн авах угтагчдыг бэлтгэх ёстой.

Түүнчлэн чуулган ядуусыг хэзээ ч гадуурхаж болохгүй. Чуулганы хүмүүс хувцас хунараараа ядуу хүнийг гадуурхах ёсгүй.

Түүнчлэн чуулганд эцэг эхгүйгээр ирсэн хүүхдүүдэд үйлчлэхэд бэлэн байх хэрэгтэй. Чуулганд ирсэн хүүхдүүдэд санаа тавьж, хариуцах хүмүүсийг чуулган заавал томилдог. Зочдыг асуулт тавьж, ярилцаж болохуйц жижиг бүлэг эсвэл цугларалтад хамруулахаар урьдаг.

### **Чуулганы гадна байгаа хүмүүст хүрэх нь**

Үнэнч гишүүддээ анхаарал халамж тавих нь чуулганы хамгийн эхний үүрэг. Гэсэн хэдий ч чуулган эргэн тойрныхоо хүмүүс рүү үргэлж очдог байх ёстой. Чуулганы гадна байгаа хүмүүс чуулганы үйл ажиллагааг харж, сайнмэдээг сонсож байгаа эсэхийг баталгаажуулах үйл ажиллагааг чуулган заавал зохион байгуулна. Эдгээр үйл ажиллагааны зарим нь аяндаа бий болно. Харин удирдагчид бусад үйл ажиллагааг мөн зохион байгуулах хэрэгтэй юм. Чуулган чадварлаг гишүүдээ урьж, иймэрхүү үйл ажиллагаанд сургах хэрэгтэй.

Түүнчлэн чуулган эргэн тойрныхоо хэрэгцээг хангах арга замыг хайх ёстой юм. Бурханы хайрыг харуулах, Библийн зарчмуудыг танилцуулах нь ямагт хамгийн эрхэм чухал үүрэг байх ёстой.

### **Жижиг бүлгийн үйлчлэл**

Аврагдсан хүн зөвхөн мөргөл хүндэтгэлд л оролцоод явж болохгүй. Харин шинэ хүнийг даруйхан дагалдагч болгох хөтөлбөрүүдэд хамруулах нь зүйтэй. Мэдээж пастортой биечлэн уулзахаас эхэлж болно. Түүнчлэн долоо хоног бүр цугладаг жижиг бүлэгт хамруулахаар урьж болох юм.

Эрүүл чуулганд сүнслэг амьдралыг тогтвортой хангаж байдаг жижиг бүлгүүд бий. Эдгээр бүлэгт гэр чуулган, хүүхдийн цуглаан болон бусад жижиг бүлгүүд багтана. Сүнслэг хариуцлага, амьдралын янз бүрийн өөрчлөлтийг ихэвчлэн жижиг бүлгээрээ хуваалцдаг. Тиймээс чуулганы удирдагч эдгээр жижиг бүлгүүдийг амьд оршиж байгаа

эсэх болон эдгээр зорилгын дагуу цуглаж байгаа эсэхийг шалгаж байх ёстой. Хэрэв чуулганы одоогийн бүтэц сүнслэг амьдралыг бий болгож чадахгүй байгаа бол өөрчлөлт хийх шаардлагатай.

### **Тодорхой гишүүнчлэл**

Чуулганы үйлчлэлд оролцож байгаа хүмүүс зориулалт гаргах гэж ямар утгатайг сайтар ойлгосон байвал зохино. Зарим чуулганууд гишүүнчлэлийн зохион байгуулалтгүй гэж хэлдэг ч, аливаа чуулган гишүүдээ мэдэх өөрийн арга замтай байдаг. Чуулганыг бүрдүүлж буй хүмүүс хэн бэ гэдгийг хүмүүс мэдэх ёстой шүү дээ.

Гишүүн хүн ямар зориулалт гаргах хэрэгтэй талаар бүгд мэдэх ёстой. Гишүүн болоход тавигдах шаардлага, үйл явцын талаар тодорхой бичиж хэвлэсэн байвал зохино.

Чуулганд зориулалт гаргахад бэлэн итгэгч чуулганд шуурхай туслах чадвартай байх учиртай. Энэ бол албан тушаал, удирдах үүрэг хариуцлага хүлээлгэнэ гэсэн үг биш. Харин уг итгэгч чуулганы нэг хэсэг гэдгээ мэдрэх нь чухал гэсэн үг.

### **Шинэ итгэгчтэй даруй холбогдох нь**

Дагалдагч болох нь Христийг хүлээн авахаас эхэлнэ. Шинэхэн итгэлд ирсэн хүнд хэд хэдэн яаралтай хэрэгцээ бий. Бурхантай харилцах харилцаа нь дөнгөж эхэлж буй тул, энэхүү харилцаагаа үргэлжлүүлэхийн тулд залбирах, Библи унших талаар суралцах ёстой юм. Мэдээж хуучин найз нөхдөө алдах учраас шинэ найз нөхдийн хүрээлэл хэрэгтэй. Үүнээс гадна шинэ итгэгчид амьдралын хэв маягтай холбоотой олон асуудлаар чиглүүлэг хэрэгтэй байдаг.

Хүн Христийг хүлээн авмагц чуулган тэр хүнийг даруйхан дагалдагч болгох ёстой юм. *Даруйхан* гэдэг нь дараагийн Ням гараг гэсэн үг биш. Тухайн хүн аврал авахаар гараа өргөсөн учраас тэр хүнтэй ядаж эхний долоо хоногийн өдөр бүр холбоо барих хэн нэгэн итгэгчтэй уулзуулах ёстой. Чуулганы хэд хэдэн хүн шинэ хүнтэй уулзах ёстой. Өөрөөр хэлбэл түүнд тохиолдож байгаа өөрчлөлтүүдийн талаар ярилцаж, асуултад нь хариулж өгөх учиртай.

Түүнчлэн шинэ итгэгчийг асуулт асууж, урам зориг авч болох жижиг бүлэгт урьж болно. Боломжтой бол жижиг бүлгийн цуглаанаас өмнө тус бүлгийн хэд хэдэн хүнтэй танилцуулбал зүгээр. Хэд хэдэн гишүүн урьдчилан холбоо барьж, танилцан, бүлэгтээ угтан аваарай. Ингэснээр шинэ хүн жижиг бүлгийн нэг хэсэг болох мэдрэмж үүсэж эхэлдэг.

Шинэ итгэгч дараагийн уулзалтаас шинэ итгэгчийн бүлэгт хамрагдах ёстой. Энэ бүлгийн хичээлүүдийг давталттайгаар ээлжлэн явуулбал шинэ хүмүүс нэмэгдэж, хамрагдах боломжтой болдог. Ийм маягаар шинэ итгэгчид дэмжих бүлэгт хамрагддаг бөгөөд гишүүд бүх хичээлээ дуусгасны дараа шинэ итгэгчийн ангийг дүүргэдэг.

## **Хэрэгцээг анхаарах нь**

Чуулган цуглааныхаа хүмүүсийн санхүүгийн хэрэгцээг анхаарах ёстой. Ихэнх хэрэгцээг чуулганы удирдагчийн оролцоогүйгээр хүмүүс бие биедээ туслах замаар хангах нь зөв. Хэрэв гишүүдийн олонх нь бусдад туслах үүргээ ухамсарладаггүй бол тухайн чуулган хараахан төлөвшөөгүй байна гэсэн үг.

Үүнээс гадна чуулганы хэрэгцээнүүдэд анхаарал тавьдаг туслагчид (диакон) байх хэрэгтэй. Энэ зорилгоор томилогдсон чуулганы анхны туслагчдын тухай Үйлс номд өгүүлдэг.

Хэрэгцээг анхаарах нь сайнмэдээг тараахад зайлшгүй шаардлагатай юм. Чуулган бол бие биедээ санаа тавьдаг, итгэлийн гэр бүл гэдгээ хүмүүст харуулах учиртай.

## **15-р хичээлийн даалгавар**

Энэ хичээлд дурдагдсан бүх шинж чанарыг агуулсан чуулган байна гээд төсөөлж үзээрэй. Чуулганд очиж, Христийг хүлээн авч, чуулганы гишүүн болох шийдвэр гаргаж буй хүнийг төсөөлье. Энэ бүхэн хэрхэн биеллээ олж байгааг дүрслээрэй.



# 16-р хичээл

## Жинхэнэ дагалдагч

### Есүсийг дагах нь

► Есүсийн дагалдагч байна гэдэг ямар утгатай вэ?

Зарим хүн Христэд итгэгч хүнийг сайн хүн гэж боддог. Зарим нь итгэгч байхыг тодорхой зүйлд итгэдэг гэсэн утгаар хардаг. Гэхдээ иймэрхүү хүмүүсийн олонхийн амьдралд итгэл үнэмшил тийм ч их өөрчлөлт авчирдаггүй.

Өөр заримынх нь хувьд үнэнд арай илүү ойр байна. Тэд хүн Христэд итгэгч болох үед заавал нэгэн өөрчлөлтийн цаг үе байх ёстой гэдгийг мэддэг. Христийг чин үнэнээсээ хүлээн авсан бол юу ч болсон бай, тэнгэрийн улсад очих баталгаатай хэмээн олон хүн итгэдэг аж.

Христийг чин үнэнээсээ хүлээн авах ёстой гэдэг нь үнэн. Итгэлийн хариуд Бурханы өршөөлөөр уучлал ирдэг гэдэг нь ч үнэн. Итгэгч хүн Бурханд дуулгавартай амьдардаг нь ч үнэн юм. Гэвч Есүсийн дагалдагч байна гэдэг нь энэ бүхнээр хязгаарлагдахгүй.

Итгэх нь л Христэд итгэгч байх цорын ганц шалгуур болбол юу болох вэ? Тэгвэл энэ нь итгэгчид Бурханы тушаалуудыг заавал биелүүлэх албагүй гэсэн үзэл буюу антиномианизмд хүргэдэг. Ингээд үнэгүй нигүүлсэл маань нүглийг зөвтгөсөн, дүр эсгэсэн, төсөөллийн нигүүлсэл болж ойлгогддог байна.

Иймэрхүү төсөөллийн нигүүлслийг сурталчилдаг чуулганы гишүүд нь чуулганд хамрагддаг атлаа нүгэл дундаа амьдардаг аж. Тэдний пасторууд болон бусад удирдагчид нь чуулганы хүмүүсээс илүү дээр амьдралтай байж болох ч, нүгэлт зуршилтай байх нь бий. Тэдний хувьд нигүүлслээр аврагдсан учраас Бурханд бүрэн дуулгавартай амьдрах шаардлагагүй ажээ. Тэд хүмүүсийг Христийн дуулгавартай байдалд авчир гэж Есүсийн чуулганд өгсөн үүрэг даалгаврыг умартдаг. Чуулган бол итгэдэггүй хүмүүсийг итгэгч болгож, Бурханы ариун мөргөн хүндлэгч болгох онцгой үүрэгтэй бөгөөд өөр оршин тогтнох шалтгаан чуулганд үгүй юм.

Түүнчлэн Бурханыг дуулгавартай дагах ёстой гэж үздэг чуулгануудад ч өөр алдаа дутагдал байдаг. Тэд өөрсдийнхөө зөв гэж үзсэн шаардлагын дагуу амьдралаа тохируулсан байдаг бөгөөд Христтэй адил сүнс сэтгэл тэдэнд байдаггүй. Тийм хүмүүс хатуу ширүүн, өршөөлгүй байдаг тул даруухан бөгөөд нигүүлсэнгүй сэтгэлээр уучлал гуйж чаддаггүй. Тэд бас бусдыг шүүхдээ гаргууд. Цөөхөн хүнд л итгэдэг. Өөрсдийнхөө зөв гэдэгт хэзээ ч эргэлздэггүй мэт. Түүнчлэн асуулт болгонд хариулдаг бөгөөд өөрсөдтэй нь санал нийлээгүй хүмүүсийг үл хүндэтгэдэг. Тэдэнд алдагдсаныг аврах халуун сэтгэл байхгүй, харин үзэл бодлоо хамгаалах асар их хичээл зүтгэл бий. Тэд өөрсдөдөө сэтгэл ханасан хүмүүс тул өөрчлөлт хийх төлөвлөгөөгүй ажээ.

Ийм хүмүүс Есүсийг үнэхээр мэддэг болов уу? Есүс шиг байхыг хүсдэг болов уу?

Үнэндээ итгэгч байна гэдэг Есүсийн дагалдагч байна гэсэн үг юм.

Дагалдагч байна гэж юу гэсэн үг вэ? Христэд дуулгавартай байна гэсэн үг үү? Хамгийн багаар бодоход тийм гэдэг нь эргэлзээгүй. Есүс Агуу захирамжийг өгөхдөө “газар сайгүй явж, дагалдагч бэлтгэ, шинэ дагалдагчдад Есүсийн тушаасан бүхнийг сахин биелүүлэхийг заа” хэмээн тушаасан юм (Матай 28:19-20). Есүсийн тушаалыг дагах нь дагалдагчийн хийх бүх зүйл биш.

Еврей раббичуудын шавь нар багштайгаа хамт амьдарч, сургаал номлол төдийгүй, амьдралын хэв маягийг нь бас суралцдаг байжээ. Тийнхүү шавь нар хандлага, эрхэм зүйлсээ суралцах явцдаа олдог байв.

Есүс дагалдагчдыг дуудахдаа “ирж, Намайг дага гэлээ”<sup>11</sup> гэж хэлсэн нь ийм утгыг агуулж байсан. Тэрбээр одоо ч дагалдагчдыг сайнмэдээгээр дамжуулан ийнхүү дуудсаар байна.

Тэгвэл яаж дагалдагч болох вэ?

Эхлээд та Есүст итгэх ёстой. Итгэхгүйгээр Есүсийг дагах шалтгаан байхгүй юм.

Та явж буй чиглэлээ өөрчлөх хэрэгтэй. Төрөлхийн Есүсийн дагалдагч гэж байхгүй, харин бид бүгд эхлээд өөр өөрийнхөө замаар явж байсан. Тиймээс та өөрийнхөө замыг бус Есүсийг дагах эсэхээ шийдэх ёстой. Өөрөөр хэлбэл таны замд ямар нэг юм буруу байгааг та өөрөө харсан гэсэн үг. Үүний дараа гэмших ёстой. Та нүгэлдээ харамсахгүйгээр Есүсийг дагах боломжгүй. Хэрэв та нүглээ хаяхын төлөө хангалттай харамсаагүй бол та өөрийнхөө замаар явсаар байгаа гэсэн үг.

“Есүс Христ бидний дотор өмнө нь хаанчилж байсан алив шүтээнийг зайлуулж, Өөрөө хаанчлахыг шаарддаг. Энэ бол Христийг хүлээн авснаар ирдэг үнэнч байдал, бүр багаар бодоход эхлэл нь юм. Христ зөв газраа эзэлсний дараа бүх юм өөрчлөгдөж эхэлдэг”

- Дэлхийн сайнмэдээний төлөөх Лузанны зөвлөл,  
*Вилловбанк тайлан*

Хүн Есүсийн уучлалыг мэдрэхэд Түүнтэй харилцаа үүсгэж эхэлдэг. Ингээд Түүнийг илүү ихээр мэдэж эхлэх ба Түүн шиг байхыг хүсэх болно.

► Нэг суралцагч Матай 16:21-25-г ангид уншина.

Есүс дагалдагчидтайгаа ярилцаж байхдаа айсуй үхлийнхээ тухай дурдаж байна. Петр энэ үгэнд цочирджээ. Петрийн бодлоор Есүст зовлон, үхэл огт тохирохгүй байв. Тиймээс Есүсийн үгийг сөрж, үхлийн тухай бодлыг нь хориглохыг хичээсэн.

Есүс Петрийг зэмлээд, Бурханы юмсыг ойлгохгүй байна гэж хэлсэн юм. Есүсийн дагалдагч байхын тулд хүн өөрийгөө үгүйсгэн загалмайг үүрч, Есүсийг дагах ёстой

<sup>11</sup> Матай 4:19, Матай 9:9, Матай 16:24, Матай 19:21, Иохан 1:43

гэжээ. Энэ бол үхлийг өөртөө хүлээн зөвшөөрөх гэсэн үг. Энэ нь жинхэнэ дагалдагч байхын эсрэг зүйлс болох өөрийгөө хангах, өөрийгөө өргөмжлөх, өөрийгөө хамгаалах хүний төрөлх мөн чанар, төрөлх хандлагын эсрэг зэмлэл байлаа.

► Хүний төрөлх мөн чанар яагаад дагалдагч байхын эсрэг байдаг вэ?

Дагалдагчид зовлон шаналал, үхлийг өөрсдөдөө тохиолдохгүй гэж үзэж байв. Тэд Есүсийг дагах нь ямар утгатай болохыг хараахан ойлгоогүй байсан хэрэг. Уучлал хүртэхийн тулд танаас ямар ч зардал гарахгүй боловч, Христийг дагахын төлөө та бүхнээ зориулах ёстой юм. Есүсийг дагаснаар тасралтгүй Түүнийг эрэлхийлж, зүрх сэтгэлээ даруусгаж, өөрчлөгддөг.

► “Христийг дагахад танаас өртөг золиос шаардагдана” гэдэг үгийг тайлбарлана уу.

Загалмайг үүрнэ гэдэг бол Бурхантай мөнхөд хамт байх харилцааны төлөө ямар нэг зүйлийг үхүүлнэ гэсэн утгатай. Энэ бол дотор хүнээ үхүүлэх, бүрэн эрхт байдлаа үхүүлэх явдал бөгөөд зөвхөн гадна байдлаараа хүлцэнгүй байх биш, харин зүрх сэтгэлээрээ бүхлээрээ даруусна гэсэн үг. Ийм дарууслыг Есүсийн хаанчлалд орох шаардлага гэж тодорхойлжээ.

Анхны дагалдагчдын адилаар өнөөдөр ч олон хүн дагалдагч байх гэж ямар утгатайг ойлгоогүй явж байна. Чуулганууд гэмшээгүй хүмүүст нигүүлслийг санал болгож байна. Ингэснээр Христийг хүлээж авч байгаа хүмүүсийг зөв замаар эхлүүлэхгүй, ирж буй зүйлсэд бэлтгэхгүй байна. Энэ бол жинхэнэ итгэгчдийн амьдралаас маш их ялгаатай, өөр зам юм.

Германы пастор Диетрих Бонхоферыг Адольф Гитлерийн тушаалаар цаазаар авчээ. Тэрээр *Дагалдагч байхын үнэ өртөг* (The Cost of Discipleship) хэмээх номдоо ингэж бичжээ.

Үнэтэй нигүүлсэл бол талбайд нуугдсан эрдэнэ мэт. Үүний төлөө хүн дуртайяа явж, байгаа бүхнээ зарна. Худалдаачин бүх бараагаа зараад худалдан авах тийм агуу үнэтэй сувд мэт. Энэ бол Христийн засаглал хаанчлал бөгөөд хүн үүний төлөө өөрийг нь бүдрүүлдэг нүдээ ухаж хаях зүтгэл, дагалдагч нар загасчилж байсан тороо орхиод Түүнийг дагадаг тийм л дуудлага юм. Биднийг ийнхүү дагахыг уриалдаг учраас энэ нигүүлсэл ийм агуу үнэтэй байгаа юм.

Есүсийг дагана гэдэг нь Есүстэй адил болох юм. Түүнд бүрэн бууж өгсөн учраас өөрийгөө үхүүлнэ гэсэн үг. Зүгээр л зарим зүйлсийг буруу хийхээ болих биш, харин Есүсийн хүссэнээр тэднийг бүрэн орхино гэсэн үг. Есүс цэвэр ариун байдлаараа, өрөвч нинжин сэтгэлээрээ, өршөөлөөрөө юу хийх байсныг бид ч хийхийг эрмэлздэг.

Зүрх сэтгэл маань эсэргүүцээд байхад бид зүгээр л зөвийг хийгээд байж чадахгүй. Тиймээс зүрх сэтгэл маань ч адилхан байгаасай гэж хүсдэг. Есүс хэнийг ч үзэн ядаагүй. Түүнтэй дайсагнах сонголтыг хийсэн хүмүүс байсан хэдий ч Тэр Өөрөө харин хэнтэй ч дайсагнаагүй юм. Загалмай дээр байхдаа ч Тэр өршөөж уучилсан билээ.

Христийн жинхэнэ дагалдагчид хонзогнодоггүй. Тэд муу хандаж байхад хариуд нь сайн ханддаг, хараах үед нь ерөөдөг байсан. Тэд өөрсдийгөө уучлалаар хязгаарлаж байгаагүй. Үүний оронд хувийн эрхээ огоорч, оронд нь үйлчилж байсан юм.

Дагалдагч хүн өөрийгөө огоорч амьдрахаас өөр газаргүй. Амиа аврахыг хичээдэг хүн алдана, амиа өгөх хүн үүнийгээ аварна (Марк 8:35).

► Хүмүүсийг дагалдагч болгон бэлтгэх замаар хэрхэн аврал руу дуудах вэ?

## Сүнслэг өсөлт

Итгэгчийг сүнслэг төлөвшилд хүргэх сүнслэг өсөлтийн үйл явц<sup>12</sup> гэж бий.

Итгэгч хүн насан туршдаа үргэлжлүүлэн төлөвшсөөр байх ёстой бөгөөд сүнслэг талаасаа насанд хүрсэн гэж болохуйц төлөвшлийн түвшин байдаг. Элч Паул итгэгчдийг цаашид хүүхэд байхаа больж, өөр түвшинд хүрч чадна гэж хэлсэн байна (Ефес 4:14).

Сүнслэг өсөлт нь суралцах явцад зарим талаараа бүрэлддэг. Тиймээс элч Паул төлөвшөөгүй хүмүүсийг ахисан түвшний сургаалыг хүлээн авахад бэлэн бус байдаг гэж хэлжээ (1 Коринт 3:1-2. Мөн Еврей 5:12-14, үз). Түүнчлэн итгэгчдийн төлөвшлийн шинж чанарууд нь онол сургаал дээр үндэслэгддэг хэмээн тэрээр өгүүлсэн. Суралцах нь сүнслэг өсөлтийн нэг хэсэг учраас заах нь дагалдагч бэлтгэх ажлын нэг хэсэг мөн.

Гэхдээ сүнслэг өсөлт нь зөвхөн суралцах замаар бүрэлдэхгүй.

Сүнслэг төлөвшил бол итгэгчид эв нэгдэлтэй байж, Бурханы Хүүгийн тухай мэдлэгтэй болж, Христийн адил болохыг эрмэлзэх явдал (Ефес 4:13) гэж Паул хэлсэн байна. Төлөвшил бол мэдлэгээс илүү бөгөөд дан ганц мэдлэгээс бий болохгүй.

► Нэг суралцагч 2 Петр 1:2-11-г ангид уншина.

Энэ хэсэг сүнслэг хөгжлийн тухай өгүүлж байна. Гол санаануудыг нь анзаараарай.

**Эшлэл 3:** Биднийг бурханлаг байхад шаардагдах бүх зүйлийг Бурхан хангаж, Христийн давуу чанар руу дууджээ.

**Эшлэл 4:** Биднийг нүглээс гэтэлгэж, Бурханы мөн чанарыг өгөх өөрчлөлтийн нигүүлслээ Бурхан бидэнд амлажээ.

**Эшлэл 5-7:** Бид авралын итгэлээ зогсоож болохгүй, харин христитгэлийн зан чанараа хөгжүүлэх ёстой.

**Эшлэл 8:** Эдгээр чанарууд нь биднийг сүнслэг үр жимстэй болгоно.

**Эшлэл 9:** Эдгээр чанаруудаа хөгжүүлээгүй хүн бол нүглүүдээсээ салаагүй, хаашаа яваагаа мэдэхгүй хүн юм.

---

<sup>12</sup> “Сүнслэг өсөлт бол бусдын төлөө Есүс Христтэй адил болж нийцэх нигүүлслийн үйл явц юм. Энэхүү тодорхойлолтыг М. Robert Mulholland Jr., *Invitation to a Journey* (Downers Grove: InterVarsity Press), 12-оос авав.

**Эшлэл 10-11:** Итгэгч хүн христитгэлийн зан чанаруудаа хөгжүүлэхийн төлөө зүтгэлгүйгээр авралын баталгаандаа сэтгэл амарч болохгүй юм. Христитгэлийн зан чанар хүнийг авралд бататгаж, агуу ялалтаар Бурханы мөнхийн хаанчлалд авчрах болно.

2 Петр номын 2-р бүлэгт сүнслэг өсөлтийг үгүйсгэдэг хүмүүсийн тухай дурддаг. Тэд зөвхөн итгэгч гэсэн нэрийг л хүсэж байв. Сүнслэг байдлын хувьд ахихаас татгалздаг учраас нүглийг зөвтгөдөг ажээ. Тэдний хуурамч сургаал шинэ хүмүүсийг нүглийн хүчинд унагаж, авралын нигүүлслийг огт амсаагүй байснаас ч дор байдалд ороход хүргэдэг байна (2 Петр 2:18-22).

Энэ захидал сануулгаар төгсөж байна. Бид хуурамч сургаалд автан нүгэлд төөрөлдөхөөс болгоомжилж, нигүүлсэл дотор өсөхөд анхаарлаа хандуулах ёстой (2 Петр 3:17-18).

Хүмүүсийг Христэд дуулгавартай байхад дагуулах нь дагалдагчийн хийх ажил гэдгийг Есүс Агуу захирамждаа хэлсэн билээ. Мэдээж суралцаж байгаа хүн сурч байгаа зүйлдээ дуулгавартай байх ёстой, эс бөгөөс урагш ахихгүй. Бурханыг баярлуулж, зан чанараа хөгжүүлэхэд чиглүүлэх нь мэдлэгийн зорилго юм. Хэрэв хүн суралцсаар байх атлаа дуулгавартай дагахгүй байвал дагалдагч биш гэсэн үг. Шашны мэдлэг ихтэй боловч төлөвшсөн итгэгчийн амьдралыг харуулж чаддаггүй хүмүүс чуулгануудад маш их байдаг.

► Нэг суралцагч Филиппой 1:9-11-г ангид уншина.

Филиппой хотын чуулганыхан гайхалтай итгэгчид байсан бөгөөд тэдэнд хандсан Паулын захидал баяр хөөрөөр дүүрэн уур амьсгалтай бичигджээ.

Эдгээр эшлэлд Паул филиппойчуудын сүнслэг өсөлтийг дурджээ. Энэ дүрслэл бол мэдлэг, ялгах чадвар, хайр, биеэ авч явах байдалтай холбогддог учраас их ач холбогдолтой.

Паул тэдний хайрыг улам нэмэгдээсэй, хайр нь алив сайныг ялган таниулаасай гэж залбирсан бөгөөд ингэснээр филиппойчууд хамгийн сайн хандлага, зан чанарыг сонгож чадна гэжээ. Ийм амьдрал Есүсийг буцаж ирэхэд Бурханы өмнө гэм зэмгүй байх амьдрал юм. Тийм хүмүүсийн амьдрал Бурханыг алдаршуулах сүнслэг үр жимсээр дүүрэн байдаг.

► Бидний судалсан ойлголт дээр үндэслэн Есүсийн дагалдагч гэж хэн болохыг хэлнэ үү?

Сурсан үнэндээ дуулгавартай амьдарч, Бурханы хүслийг илүү сайн ойлгохыг чин сэтгэлээсээ хүсдэг, итгэгч хүний зан чанар, зан төлөвөө хөгжүүлэхийн төлөө Бурханы хүч чадалд түшин амьдардаг хүнийг Есүсийн дагалдагч гэнэ.

► Одоо бид сүнслэг өсөлтийн талаар мэддэг боллоо. Та бусдыг дагалдуулдаг хүнийг хэрхэн тодорхойлох вэ?

Дагалдуулдаг хүн бол Библийн үнэнийг заадаг, Есүст дуулгавартай байхын үлгэр дуурайл болсон хүн бөгөөд бусад итгэгчдийн сурах, дагах явцыг урамшуулж, Бурханы ажил явагдсаар байхыг зөвшөөрдөг хүн юм.

### Нигүүлслийн хүч чадал

Өмнөх хэсэгт бид 2 Петр 1:2-11-ийг судалсан. Энэ хэсгээс Бурхан биднийг нүгэлт хүслийн хүчнээс ангижруулж, ариун мөн чанарыг өгдөг нигүүлслийг амласан гэдгийг мэдэж авдаг бөгөөд ийм мэдлэг бидний сүнслэг өсөлтийг удирддаг юм.

Зарим хүн Бурханы тушаалыг огт зөрчихгүйгээр амьдрах боломжгүй гэж үздэг. Тэд хүнд цэвэр ариун зүрх сэтгэл байхгүй гэж боддог бөгөөд эдгээр санаа бодлууд нь тэдний дагалдагч байх амьдралд нөлөөлдөг.

Дагалдагч гэдэг бол Христийн тушаалуудыг сурч, дуулгавартай дагана гэсэн үг. Хэрэв бид бүрэн дуулгавартай байх боломжтой гэдэгт итгэж чадахгүй бол сүнслэг байдлыг арай өөрөөр үнэлэх аргыг хайхад хүрнэ.

Жон Веслей нигүүлслийг хүртэхгүй л бол хүн Бурханы тушаалуудыг бүрэн биелүүлж чадахгүй гэж үздэг байсан. Гэхдээ нигүүлслийг олох боломж хүн бүрд өгөгдсөн байна. Веслейн үзлээр нүгэлт хүн бүр нигүүлслийн ачаар авралын сайнмэдээнд хариу өгөх чадвартай болдог. Түүнчлэн Христийн дагалдагч бүр Бурханд бүрэн дуулгавартай амьдрах нигүүлслээр хангагддаг гэж тэрээр үзсэн юм.

Веслейн теологиос “Амлалтын зарчим” гэж нэрлэгддэг Бичвэрийг хөрвүүлэх зарчим үүсжээ. Веслейн үзлийг баримтлагчид “Бурхан юу ч тушаасан бай, биелүүлэх боломжийг хүмүүстээ олгодог” гэж итгэдэг байна. Ингэхээр Библийн тушаал бүрийг “нигүүлслийн амлалт” гэж харах боломжтой.

### Амлалтын зарчим

Дараах хэсэгт энэхүү зарчмыг<sup>13</sup> тайлбарласан Веслейн тайлбарыг оруулав.

Хамгийн түгээмэл үгүйсгэлийн нэг нь “Христэд итгэгч хүнийг төгс болгоно гэсэн амлалт Бурханы Үгэнд байхгүй” гэх үгүйсгэл юм. Гэхдээ бид Бурхан Эзэнээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлах болно гэсэн маш тодорхой амлалт байна. Үүнийг “ЭЗЭН Бурхан чинь чамайг өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ хайрладаг болгохын тулд чиний зүрхийг болоод чиний үр удмын зүрхийг хозолно” (Дэд хууль 30:6) гэж хэлжээ. **Бидний Эзэний үг хэдийгээр тушаал хэлбэрээр байгаа ч амлалт мэт харагдаж байгааг** “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла” (Матай 22:37) гэснээс харж болно. Үүнээс илүү хүчтэй үг, үүнээс илүү тодорхой амлалт гэж байхгүй. Мөн түүнчлэн “Чи

<sup>13</sup> Энэ хэсгийг дараах номоос эш татав. John Wesley, “Christian Perfection,” from *A Timeless Faith: John Wesley for the 21st Century*. Edited by Stephen Gibson. (Nappanee: Evangel, 2006).

хөршөө өөрийн адил хайрла” (Матай 22:39) гэсэн нь тушаал хэлбэртэй амлалт байна.

Энэхүү хязгааргүй амлалт нь сайнмэдээний бүхий л үед захирч, “Би хуулиудаа санаанд нь оруулж, зүрхэнд нь бичнэ” (Еврей 8:10) гэсэн бөгөөд “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай” (Филиппой 2:5) гэх амлалтыг оролцуулаад **бүхий л тушаалыг амлалт болгосон юм. Энэ тушаал нь амлалттай дүйцэх бөгөөд Тэрбээр биднээс шаардаж байгаа зүйлийнхээ төлөө бидний дотор ажиллана гэдэгт найдах үндэслэл болж байна.**

**Гэгээн Петрээр дамжуулан өгөгдсөн Бурханы тушаалд “Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун” (1 Петр 1:15) гэсэн нь хэрэв бид хүсэж л байгаа бол биднийг ариун байлгана гэсэн амлалтыг агуулж байна.** Бурханы талаас дутагдах зүйл гэж байхгүй. Тэрбээр биднийг ариунаар дуудсан, үүнийгээ эргэлзээгүй хүсэж байгаа тул энэхүү ариун чанараа бидний дотор ажиллуулна. **Учир нь Тэрбээр дорой бүтээлүүдээ басамжилдаггүй, мөн бидэнд өгөхийг зориогүй зүйлийг нь хүлээн авахаар Тэр дуудахгүй.** Тэрбээр биднийг ариун байдалд дууддаг нь маргаангүй бөгөөд хэрэв бид тэнгэрлэг дуудлагад дуулгавартай байх юм бол Тэр үүнийгээ өгөх л болно.

“Гэхдээ биднийг махбод дотроо байхад нүглээс аварна гэж Тэр амласан уу?” Гарцаагүй амласан. Учир нь “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла” (Матай 22:37) гэх **амлалт нь Бурханы бүх тушаалыг агуулж байгаа юм.**

Бид Бурханы зан чанарын талаарх бодол дээрээ тулгуурлан Бурханы нигүүлслийг хүлээх ёстой. Бурханы тушаалуудыг биелүүлэх боломжтой бөгөөд Тэрбээр чин сэтгэлээсээ хүсэж байгаа учраас үүнийгээ ямар нэг аргаар бидэн дээр биелүүлж чадна.

Бид Библийг бүхэлд нь нухацтай авч үзэх ёстой. Библийн эшлэлүүдийн энгийн утгыг бид хэзээ ч гуйвуулах ёсгүй. Бурхан итгэгчдийг ариун байгаасай гэж хүсдэг төдийгүй ариун болоход нь туслах хүч чадалтай учраас энэхүү Амлалтын зарчим нь Бурханыг өргөмжилж байна. Библи дээрх сануулга, амлалт, залбирлыг үл ойшоож болохгүй. Сайн теологи нь Библийг хэрхэн ашиглаж байгаагаар батлагддаг.

### **Ариун амьдрах боломжтой юу?**

Төгс Хүчит Бурхан хүний сүнсийг биедээ байх үед нь ариусгаж яагаад болохгүй билээ? Тэрбээр таныг байшинд ч бай, гадаа ч бай, ариусгаж чадах уу? Тоосго эсвэл чулуун хана Түүнд саад болох уу? Тэгвэл мах, цусаар бүрдсэн эдгээр хана нь таныг бүхэлд нь ариусгах үйл явцад нэг хором ч саад болохгүй. Тэрбээр таныг биедээ ч бай, биеэсээ гадуур ч бай, амархан аварч чадна. “Тэрбээр биднийг махан биедээ байх үед нүглээс аварна гэж Тэр амласан уу? Гарцаагүй тэгж амласан. Учир нь “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа

хайрла” (Матай 22:37) гэх энэ тушаалыг оролцуулаад Бурханы бүх тушаалд амлалт агуулагддаг. Энэ ч бай, бусад тушаалууд ч бай, бүгдээрээ үхэгсдэд биш, харин амьд хүмүүст өгөгдсөн тушаалууд юм. Дээр өгүүлсэн эшлэлд байгаа энэ үгээр бид “үүрд Түүний өмнө... ариун” алхах ёстой юм (Лук 1:73-75).<sup>14</sup>

Олон хүн итгэгч байхад мэргэшдэг боловч нүглийн уруу татлагыг огт ялдаггүй. Тэд мэдлэг, үйлчлэх ур чадвар дотор өсдөг боловч хамгийн чухал зүйл дээрээ өсдөггүй аж.

“Хэрэв Түүний өгөөмөр чанар шударга ёстой нь тэнцдэг бол, Түүний нигүүлслийн амлалтыг шударга ёсны шаардлагуудтай нь адил хэмжээнд үзэх ёстой болно. Хэрэв тэр өгөхдөө авах мэт баярладаг бол Түүний амлалтууд Түүний зарчим шаардлагууд адил утга учиртай юм.”

- Чарльз Финней,  
*Системт теологи*

Нүглийг ялж, ариун зүрхтэй болох нь итгэгч хүнд тавигддаг Бурханы жишиг юм гэдгийг Библид тодорхой зааж байна (Тит 2:11-12, Үйлс 15:9, 1 Иохан 3:2-10, 1 Иохан 5:1-4). Хэрэв итгэгч хүн өөрийгөө Бурханы хүссэн хүн шиг биш байна гэдгийг ойлговол даруйхан, тун нухацтайгаар Бурханы Сүнсний өөрчлөгч, бас хүчирхэгжүүлэгч ажлыг эрэлхийлээрэй.

Дагалдагчдыг бэлтгэх үйлчлэлд байгаа хүн хамгийн эрхэм чиглэлээ тодорхой байлгах ёстой. Нүглийг ялах нь нэн тэргүүний зорилт мөн. Хэрэв хүн нүгэлд унасан бол дагалдуулагч нь ямар нэг юм болохоос өмнө түүнийг гэмшил, ялалт руу дуудах ёстой.

## 16-р хичээлийн даалгавар

Дараах асуулт бүр дээр цогцолбор бич.

- Хэрэв хүн Есүсийн дагалдагч болохыг хүсвэл юунд найдах ёстой вэ?
- Сүнслэг өсөлтийн талаар Петрийн хэлсэн гол үнэнийг та хэрхэн тайлбарлах вэ?
- “Амлалтын зарчим” гэж юу вэ?

Та нийтдээ хоёр хуудас бичих ёстой.

<sup>14</sup> Дараах номоос эш татав. John Wesley, “Christian Perfection,” from *A Timeless Faith: John Wesley for the 21st Century*. Edited by Stephen Gibson. (Nappanee: Evangel, 2006).



# 17-р хичээл

## Сүнслэг төлөвшлийн зүг

### Чуулганы зааж сургах үйлчлэл

Христийг хүлээж авахад өөрчлөлт тохиолдоно. Итгэгч хүн шинэ хүсэл, шинэ эрхэмлэх зүйлстэй болох тул энэ өөрчлөлт үнэхээр агуу юм. Тиймээс Библид үүнийг шинэ бүтээл хэмээн дүрсэлсэн байна (2 Коринт 5:17).

Гэхдээ зарим зүйлд цаг хугацаа хэрэгтэй. Итгэгч болсон ч христитгэлийн зарчмуудыг амьдралынхаа бүх хэсэгт хэрхэн хэрэгжүүлэхээ хүн даруйхан олоод харчихна гэж байхгүй. Эхлээд зарчмуудыг сурч, дараа нь хэрэгжүүлдэг.

Үүнээс гадна хувь хүний сүнслэг төлөвшлийн үйл явц гэж бий. Шинэ итгэгч нь Христ доторх нялх хүүхэд юм.

► Нэг суралцагч 1 Коринт 3:1-2-г ангид уншина. Эдгээр эшлэлийн дагуу шинэ итгэгчийн онцлог шинж чанар юу вэ?

► Нэг суралцагч Еврей 5:13-14-г ангид уншина. Эдгээр эшлэлд сүү гэж юуг хэлж байна вэ? Бор хоол гэж юуг хэлэв? Сүнслэг төлөвшил ямар шинж чанартай вэ?

Энэ сургалтын эхэнд бид Есүсийн өгсөн Агуу захирамжийн тухай үзсэн. Одоо дахин харцгаая.

► Нэг суралцагч Матай 28:18-20-г ангид уншина. Есүс сайнмэдээ тараахаас гадна өөр ямар үүрэг хариуцлага өгсөн талаар энэ эшлэлд өгүүлж байна вэ? Агуу захирамжийг өгөхөөсөө өмнө Есүс тэнгэр, газар дээр бүрэн эрх мэдэлтэй гэдгээ хэлсэн. Дараа нь чуулганд хандаж хүмүүсийг Өөр рүү нь авчир гэж тушаасан билээ.

Есүс дагалдагч нартаа сайнмэдээг номлоод зогсохгүй Өөрийнх нь тушаасан бүхнийг дагалдагчдад заах ёстой хэмээн тушаасан. Сайнмэдээ тараах нь энэ ажлын зөвхөн эхний хэсэг юм. Шинэ итгэгчдэд Есүсийн бүх тушаалыг дагахыг заах нь дагалдуулах үйлчлэл бөгөөд дагалдуулах үйлчлэл бүтэлгүйтэх нь сайнмэдээг тараах ажил бүтэлгүйтсэнтэй адил ноцтой.

Чуулганы зааж сургах үйлчлэл нь шинэ итгэгчийг сүнслэг төлөвшилд хүргэх зорилготой.

Ефес номд шинэ итгэгчдийг өсгөж, сүнслэг тал дээр хүүхэд хэвээр үлдээхгүйн тулд зарим итгэгчдэд үйлчлэлийн онцгой үүрэг хариуцлага оноосон тухай өгүүлдэг (Ефес 4:11-14). Үүний үр дүнд онол сургаалын хувьд тогтвортой, сүнслэг насанд хүрсэн итгэгч болох учиртай.

Пастор хүн дагалдуулах ажилд онцгой үүрэг хүлээнэ. Паул Тимотод “Бичвэрийн уншлага, ятгалга ба сургаалдаа анхаар” (1 Тимот 4:13) гэсэн байдаг. Тэрээр Тимотыг өөрийн сурах үйл явцыг анхаар гэхээсээ илүүгээр үйлчлэлдээ анхаар гэсэн утгаар хэлсэн. Тимот Бичвэрийг уншиж тайлбарлах, сүнслэг удирдамж өгөх, Христийн сургаалыг заах зэрэг үйлчлэлийг хийж байв. Пастор хүний нэг чухал шалгуур бол зааж сургах чадвар юм (1 Тимот 3:2).

Сурах нь сүнслэг өсөлтийн чухал хэсэг учраас заах нь дагалдагч бэлтгэх ажлын нэг хэсэг болдог. Чуулганд багш нар чухал үүрэгтэй тул чуулган багш нараа хөгжүүлэхийн төлөө үргэлж ажиллах ёстой.

“Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга” (2 Тимот 2:2). Паул энэхүү зааварчилгааг туршлагатай сайнмэдээ тараагч, пастор хүнийхээ хувьд залуу үйлчлэгч Тимотод өгчээ. Зөвхөн номлолоор итгэл цааш дамжихгүй гэдгийг Паул хэлж байна. Тиймд хүмүүсийг онцгой чармайлт гарган сургаж, цаашид бусдыг сургахад бэлтгэх ёстой юм. Ийм сургалтыг цуглаан дээр явуулах боломжгүй бол итгэмжтэй хүмүүсийг тусад нь авч ганцаарчлан, эсвэл бүлгээр сургах хэрэгтэй.

Зааж сургах зүйлс маш их байдаг. Хүн бүр нэг ижил зааврыг хүлээн авахад бэлэн биш байдаг тул бүгдийг хийж амжуулдаг пастор гэж хаа байх вэ? Гэхдээ Ефес 4:11–д “Тэрээр пасторыг өгсөн” (ганц хүн, ганц үүрэг) гэж хэлээгүй. Харин янз бүрийн үүрэг, тэдгээрийг гүйцэтгэх хэд хэдэн хүний тухай дурдсан байна. Бурхан багш нарыг дуудаж, зааж чадвар өгч, тэднээр дамжуулан чуулганыг үйлчлэлд бэлтгэж, хүчирхэгжүүлдэг.

“Есүсийг Бурхан Эцэг рүү  
буцсаны дараа  
амьдралаараа Есүсийг  
гэрчлэгч болж, ажлыг нь  
гүйцэлдүүлэх хүмүүсийг  
элсүүлэх нь Түүний  
төлөвлөгөөний эхний  
зорилго байлаа.”  
- Роберт Коулмэн,  
“Мастерын төлөвлөгөө”

### **Христитгэлийн хамт олон ба сүнслэг хариуцлага**

Жинхэнэ дагалдуулалт гэдэг мэдээллийг дамжуулахаас илүү зүйл. Үүнд үнэ цэн, эрхэмлэх зүйлс, хандлага, амьдралын хэв маягаа төлөвшүүлэх ч бас багтана. Энэ үйл явц зөвхөн сүнслэг хариуцлага бүхий христитгэлийн хамт олонд (бүлэг) тохиолддог.

Бурхан хүмүүсийг хамт олны дунд амьдруулахыг зорьсон болохыг бид “Адам ганцаараа байх ёсгүй” (Эхлэл 2:18) гэсэн эшлэлээс эхлээд Библийн бүх хэсгээс харж болно.

Хамт олноороо, бүлгээрээ байхын зарим давуу талыг Номлогчийн үгс 4:9-10-д дурджээ.

Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр билээ. Тэгвэл тэдний зүтгэл сайнаар хариулагдах болно. Хэрэв тэд хамтдаа ойчих аваас нэг нь нөгөөгөө босгоно. Харин ганцаар байгч унахад түүнийг босгох хүн үгүй тул, хөөрхий!

Бурхан Мосед хандаж израилчуудыг тахилчдын хаант улс, ариун үндэстэн (Гэтлэл 19:6) болгоно гэжээ. Энэ өв гэр бүлүүдээр дамжин цааш уламжлагдаж, “Агуу захирамж”-д тусгалаа олжээ (Дэд хууль 6:4-9).

Шинэ гэрээнд чуулганыг эдгээр нэр томъёогоор илэрхийлдэг. Ариун Сүнс Шинэ гэрээний бичигчдийг ийнхүү хөглөжээ (1 Петр 2:9).

Бурхан Өөртэй нь харилцаж байгаа хүмүүсийг өөр хоорондоо харилцаатай байхыг үргэлж хүсдэг. Бурхантай харилцах харилцаа нь биднийг итгэлийн хамт олон болгоно. Түүнчлэн Бурхантай харилцах бидний харилцаа зориулалт шаарддаг шиг Бурханы хүмүүстэй харилцах бидний харилцаа ч бас зориулалт шаарддаг. Хүн өөрийгөө Бурхантай зөв харилцаатай байж чадна гэж боддог атлаа Бурханы ард түмэнтэй харилцахгүй байхаар шийдвэл энэ нь буруу юм.

Паул чуулганы гишүүдийн харилцааг биеийн эрхтнүүдээр дүрсэлжээ (1 Коринт 12). Ямар ч эрхтэн биеэсээ тусгаар ганцаараа байвал ажиллаж чадахгүй. Тиймээс гишүүд бие биедээ санаа тавих ёстой. Эс бөгөөс бие гэж үгүй. Нэг гишүүн гэмтэхэд бүгд зовно. Нэг гишүүний үйлдэл бүх биед нөлөөлнө. Паул энэ үгийг ёс зүйгүй хэрэг хийсэн хүний нөхцөл байдал дээр хэлсэн боловч, үүндээ талхны тухай зүйрлэлийг дурдсан байдаг. Ингэхдээ, "Зуурсан гурилыг жаахан хөрөнгө бүхэлд нь исгэдгийг та нар мэдэхгүй гэж үү?" (1 Коринт 5:6) гэжээ. Бид өөрсдийгөө христитгэлийн хамт олны салшгүй нэг хэсэг гэж харах учиртай.

Христитгэлийн хамт олонгүйгээр аливаа хүн Шинэ гэрээний тушаалуудыг дагаж мөрдөх боломжгүй. Бурханы тушаалуудыг биелүүлэхийн тулд итгэгчид нэг нэгэндээ зориулалт гаргах ёстой. Өөрөөр хэлбэл христитгэлийн хамт олон сүнслэг хариуцлага хүлээнэ гэсэн үг.

Христитгэлийн хамт олон ба сүнслэг хариуцлагын холбоо хамаарлын талаар Библид олонтоо дурджээ.

Удирдагчдаа дагаж, тэдэнд захирагдагтун. Учир нь тэд тооцоо хийгчид адил сэтгэлийг чинь сэрэмжилдэг. Тэд үүнийг санаа алдалгүйгээр, баяртайгаар хийг. Эс бөгөөс та нарт ямар ч ашиг болохгүй (Еврей 13:17).

Энэ эшлэлд сүнслэг эрх мэдэлтэй хүмүүст захирагдах тухай зааж байна. Сүнслэг удирдагчдын хувьд ч энэ тушаал асар их үүрэг хариуцлага хүлээлгэж байгаа юм. Удирдагчийн хариуцлага бол эрх мэдлээр удирдан чиглүүлэх төдий биш, харин тэдний халамжид байгаа сүнснүүдийг харгалзах явдал. Үүнийг хийхийн тулд удирдагчид хүмүүстэйгээ сайн харилцаатай байж, сүнслэг удирдамж өгөх ба үүнийг хийх боломжтой хүмүүстэй харилцаатай байх хэрэгтэй.

Эдгээр эшлэлд христитгэлийн хамт олон ба сүнслэг хариуцлагын талаар дүрсэлжээ.

► Нэг суралцагч Еврей 10:24-26-г ангид уншина. Эдгээр эшлэлд юу тушаасан бэ?

Бусад итгэгчдийн хэрэгцээг мэдэж, зөв зүйлийг хийхийг урамшуулах ёстойг энд тушаажээ.

► Энэ үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд итгэгчдийн дунд ямар харилцаа холбоо байх ёстойг тайлбарлаарай.

Бид хүмүүстэй зөв харилцаа тогтоохгүй бол бидний өгч буй урамшуулал үр дүнгүй болно. Бид тэднийг сайн мэдэж, хайр халамжаа харуулах ёстой. Эс бөгөөс хувьчилсан зөвлөгөөнд гомдож мэднэ.

Ах дүү нар аа, та нараас хэн нэг нь ёрын, итгэлгүй зүрхтэй байж, амьд Бурханаас салах вий хэмээн болгоомжлогтун. Харин “өнөөдөр” гэгдэж л байгаа бол бие биенээ өдөр бүр зоригжуулагтун. Эс бөгөөс та нараас хэн нэгэн чинь нүглийн мэхлэлээр хатуурах вий (Еврей 3:12-13).

Бид бие биеийнхээ өмнө хариуцлагатай байхыг уриалж байна. Тиймээс сургах явц чуулганы цагийн хуваариас давсан байх ёстой. Тэгээд ч өдөр бүр ятган сэнхрүүлж байхыг тушаасан шүү дээ. Үүнийг хувьчилсан болон жижиг бүлгийн нөхөрлөлөөр дамжуулан хийнэ. Ингэх нь зөвхөн хамт хооллох, зочлох төдий бус, харин сүнслэг зорилгын төлөө юм. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бид харилцан яриа, жижиг бүлгийн уулзалт бүхнээ зорилготойгоор төлөвлөн, гол зүйлдээ анхаарах ёстой.

Бие биедээ тус дэм болох талаар Сургаалт үгс 27:17-д ийнхүү хэлжээ.

Төмөр төмрийг ирлэдэг. Хүн хүнээ хурцалдаг.

Хүн бусдад сүнслэг удирдамж, урам зориг өгөхөд заавал бусдаас давуу байх шаардлагагүй. Үнэндээ даруугаар өгсөн сүнслэг удирдамжийг хүлээн авах магадлал өндөр.

... бие биенийхээ өмнө нүглээ улайж, бие биенийхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой. Зөвтийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна (Иаков 5:16).

Том цуглаан дээр хувийн нүглээ улайх явдал бараг гарахгүй. Тиймээс чуулганы энэ үйлчлэл амархан хэрэгждэггүй. Хам сэдвээс нь энэ тушаалын шалтгааныг харж болно. Гол нь алдаа гаргасан хүмүүсийг сэргээх зорилготой юм.

Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн (Галат 6:2).

Итгэгчдийн хувьд ихэвчлэн өөрсдийнх нь юу туулж байгааг хэн ч тоодоггүй мэт санагддаг. Христэд итгэгчид бусдын зовлон зүдгүүрийг үнэхээр ойлгож чадвал санаа тавьж чадна. Гэхдээ ихэнхдээ хангалттай сайн ойлгож чадахгүй. Хэрэв бид бусдын ачааг үнэхээр мэдэхгүй бол яаж үүрэлцэх юм бэ?

Чуулган үүссэн анхны үед итгэгчдийн дунд ойр дотно харилцаа хэвийн зүйл байв.

Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж, талархал хийгээд өгөөмөр зүрхээр хооллоцгоон (Үйлс 2:46).

Жон Веслей “бие даасан итгэгч гэж байхгүй” гэж хэлсэн байдаг.

► Веслей энэ үгээрээ юу хэлэхийг хүссэн бэ?

Сүнслэг хариуцлага нь христитгэлийн хамт олны дунд л байна гэсэн утгатай.

Сүнслэг хариуцлагатай байх гэдэг нь өөрсдийн сүнслэг байдал, сүнслэг тал дээрх амжилт ба уналт, цаашид өсөж хөгжихийн төлөө зориулалт гаргах хүн эсвэл бүлэг, хамт олонтой харилцаатай байна гэсэн үг.

Сүнслэг хариуцлага байхгүй бол бид Бичвэрийн бүх тушаалыг биелүүлэхгүй байгаа хэрэг төдийгүй, бидэнд нигүүлслээ өгөхийн тулд Бурханы төлөвлөсөн арга хэрэгслийг үл тоомсорлож байна гэсэн үг.

### **Сүнслэг төлөвшлийн шинж**

Сүнслэг төлөвшилтэй байна гэж юу гэсэн үг вэ? Төлөвшсөн итгэгчийг та хэрхэн тодорхойлох вэ?

Төлөвшил нь цаг хугацаа шаарддаг учраас нас ахих тусам төлөвших талтай (Тит 2:1-5). Мэдээж, зарим хүн сүнслэг талаараа төлөвшихгүйгээр хөгширч байхад, гайхалтай сайхан төлөвшсөн залуу хүмүүс ч байдаг.

Төлөвшлийн ихэнх шинжүүд нь нэг мөсөн тогтохгүй, харин аажмаар нэмэгдээд явдаг. Заримдаа сүнслэг туршлага, амьдралын туршлагаас болж огцом нэмэгдэж болно. Хэдийгээр хүн амьдралынхаа туршид үргэлжлүүлэн хөгжих ёстой боловч сүнслэг төлөвшил гэж хэлж болох тийм түвшинд хүрэх боломжтой.

Сүнслэг төлөвшлийн шинж чанарыг Бичвэрийн хэд хэдэн хэсэгт тодорхойлсон байна.

► Хэд хэдэн суралцагч Ефес 4:11-14, Еврей 5:12-6:1, 1 Коринт 3:1-2, болон 1 Иохан 2:12-14 эшлэлийг ангид тус тус уншина.

Сүнслэг төлөвшлийн тэмдэг болох шинж чанаруудын жагсаалтыг доор харуулж байна. Энэ жагсаалт бүрэн биш бөгөөд жагсаалтын зарим санааг бусдаас нь бүрэн ялгах боломжгүй юм.

Төлөвшсөн итгэгч хүн эдгээр бүх шинж чанаруудыг бүрэн харуулж чадахгүй байлаа ч өссөөр л байдаг. Зарим алдаагаа ухаарахгүй байж болох ч, зүрх сэтгэл дэх Ариун Сүнсний тасралтгүй ажилд хариу үйлдсээр байдаг юм.

### **Сүнслэг төлөвшлийн 10 шинж**

#### **(1) Хүсэл сэдэл, хандлага, үйлдлээрээ Христийн адил**

Христийг танин мэдэхийг чин сэтгэлээсээ хүсэж, Христийн үхэл, амиллыг өөрсдийнхөө амьдралд сүнслэг байдлаар мэдрэхийг хүсэх эрмэлзлээс Христтэй адил байх нь хамаардаг (Филиппой 3:10). Үүнд хавчлага дунд Түүний зовлон шаналлыг хуваалцах нь ч багтана. Христийг ийнхүү хайрладаг хүн Христтэй адил болж өөрчлөгддөг.

Христтэй адил байх нь аминч үзэл, бардам зангаар бус, харин хайраар тэтгэгддэг. Тиймээс Христийн дагалдагч хүн Христтэй адил байхыг хүсдэг бөгөөд хэлсэн үг, хийсэн үйлдлээрээ Христтэй адилгүй байгаагаа ухаарах бүрдээ гуниглаж харуусдаг.

## **(2) Бурхантай дотно харилцаатай**

Хүн Бурхантай харилцах харилцаагаа улам ойртуулах ёстой. Бурханы оршихуйгаас таашаал авах, Бурханы Үгийг хайрлах, залбиралд цаг зарцуулах нь Бурхантай сайн харилцаатай байгаагийн илрэл юм.

## **(3) Ариун Сүнсний үр жимс харагддаг**

Ариун Сүнс итгэгчийн амьдралд хайр, баяр баясгалан, тэвчээр, өөрийгөө хянах чадвар зэрэг үр жимсийг бий болгодог. Амьдралд нь Ариун Сүнс ажиллаж байгаа итгэгч хүний зан чанар илүү тууштай, эелдэг зөөлөн байдаг.

## **(4) Дотоод болон гадаад нүглийг ялдаг**

Итгэгч хүн уруу татлагыг даван туулахын тулд Бурханд хэрхэн найдахад суралцдаг. Зүрх сэтгэлээ ариусгахын тулд Бурханы цэвэрлэгээнд сэтгэлээ нээдэг бөгөөд тууштай ялж амьдрахад тусалдаг дадал зуршил, сахилга батыг өөртөө хөгжүүлдэг.

Хэрэв сорилтод унавал Бурханы өмнө улайж, уучлал ба хүч чадлыг олохын төлөө залбирдаг. Түүнчлэн өөрийнх нь төлөө залбирдаг итгэгч дотны найзуудтайгаа алдаа дутагдлаа хуваалцах ёстой юм (Иаков 5:16).

## **(5) Сүнслэг сахилга баттай**

Бурхантай харилцах харилцаагаа нэн тэргүүнд тавих нь сүнслэг сахилга бат юм. Тогтмол залбирдаггүй, Библи уншдаггүй, чуулганд хамрагддаггүй хүн төлөвшсөн итгэгч биш.

## **(6) Христитгэлийн зан чанарыг хөгжүүлсэн**

Христийн дагалдагч хүн шударга, итгэмжтэй, үнэнч байх зарчмуудыг амьдралынхаа хэв загвар болгохын төлөө суралцдаг.

## **(7) Тууштай итгэлийн амьдралтай**

Итгэгч хүн христитгэлийн зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж сурдаг. Төлөвшсөн итгэгч хүн хандлага болон биеэ авч явах байдлаараа үргэлж Христийн дагалдагч адил байхыг хүсдэг. Тэрээр хэлсэн үг, хийсэн зүйл нь зүрхэн дэх хайртай нь нийцэхгүй байгааг ойлгох тусам, өөрчилж өгдөг Бурханы хүч чадлыг түшдэг.

## **(8) Эрүүл харилцаа холбоотой**

Төлөвшсөн итгэгч бусад итгэгчидтэй дотно нөхөрлөлийг үүсгэдэг. Тэрээр үнэнч шударга, тэвчээртэй, өршөөнгүй байдлаа харуулж харилцаагаа хадгалдаг бөгөөд даруухан, алдаагаа хүлээн зөвшөөрсөн хандлагатай байдаг. Нөхцөл байдлаас болоод

буруу ойлгогдох үед тэвчээр алдаж мэдэх боловч, алдаагаа даруй зөвшөөрч, нөгөө хүнийхээ зөв санаа бодлыг хүлээн авдаг.

### **(9) Өөрийн үйлчлэлтэй**

Итгэгч хүн өөрийн сүнслэг бэлгүүдийг тодорхойлох ёстой. Тэрээр бусдад ерөөл болохын тулд чуулганыхаа байх ёстой талбарт зогсдог. Итгэгч хүн бусдад сайнмэдээг тарааж, христитгэлийн амьдралд дагалдуулах замаар бусдад тусалж, чуулганд үйлчилж чадна.

### **(10) Хүнд нөхцөлд тэсвэртэй**

Итгэгч хүн муу зүйл тохиолдоход Бурханд найдаж сурах ёстой юм. Хүнд хэцүү үед Бурханд л найдах ёстой. Төлөвшсөн итгэгч хүн өөрт нь муу зүйл яагаад тохиолдож байгааг ойлгохгүй байсан ч, итгэлээ алддаггүй.

### **Дүгнэлт**

Сүнслэг төлөвшлийн шинжүүд нь төрөлх авьяас чадвараас хамаарахгүй.

Түүнчлэн үйлчлэлийн ур чадвартай ч адилгүй.

Сүнслэг төлөвшил нь удирдах чадвартай холбоогүй. Удирдагч хүн сүнслэг төлөвшилд хүрсэн бол сайн хэрэг. Гэхдээ зарим хүн сүнсээр төлөвшөөгүй боловч, өөрийн авьяас чадварынхаа ачаар удирдагч болох нь бий. Зарим нь сүнслэг төлөвшилд хүрсэн боловч удирдах чадваргүй байх нь ч бий.

Зарим хүн төрөлхөөсөө тэвчээртэй, эелдэг зан чанартай байдаг. Гэхдээ хувь хүний бодгаль чанар нь сүнслэг төлөвшлийн шинж чанартай адилгүй. Бурхан бидний бодгаль чанар дээр ажилладаг бөгөөд аливаа зүйлд хандах хандлагыг маань тэнцвэртэй болгоход тусалдаг билээ. Бид хувь хүнийхээ талаас шинжилж үзлээ ч, тухайн хүний төрөлхийн зан чанар болон сүнслэг өсөлтийн шинж чанарыг нь нарийн сайн ялгаж чадахгүй.

Эрүүл мэндийн асуудал нь хүний ялгаж салгах чадвар, хариу үйлдэлд нөлөө үзүүлдэг. Тиймээс бид бусдыг шүүх гэж яарах ёсгүй юм.

### **17-р хичээлийн даалгаврууд**

(1) Сүнслэг төлөвшлийн 10 шинж байдлаар өөрийгөө шалгаарай. Аль нь танд хамгийн их дутагдаж байгааг залбирч тунгаан бод. Залбирах, судлах, бусдаас зөвлөгөө авах, Бурханы тусламжид найдах зэргээр өөрийгөө хэрхэн зориудаар хөгжүүлэхээ төлөвлө.

(2) Чуулган зааж сургах болон сүнслэг хариуцлага хүлээх үүргээ хэрхэн зорилготойгоор биелүүлж чадах вэ? Чуулганы үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлон хоёр хуудас бичнэ үү.





# 18-р хичээл

## Жижиг бүлгийн гарын авлага

### Ангийн удирдагчийн тэмдэглэл

*Энэ хичээл нь бусад хичээл шиг ангид суралцахаар зохиогдоогүй болно. Та хичээлийг эхнээс нь заагаад явах ба хэлэлцэх олон сэдэв бий. Энэ хичээлийн хувьд нэгээс олон удаа уулзах шаардлага гарч болно.*

*Ангийнхан цаашид хийх зүйлийнхээ талаар ярилцах цаг гаргах хэрэгтэй. Сайнмэдээ тараах, дагалдуулах тал дээр нутгийн чуулгануудад хэрхэн тусалж болох талаар хамтдаа төлөвлөгөө гаргах ёстой.*

### Жижиг бүлгээр дагалдуулахын үнэ цэн

Дэлхий даяар жижиг бүлгийн олон төрлийн үйлчлэл байдаг ба зорилгоосоо хамаарсан янз бүрийн жижиг бүлгүүд бий. Жижиг бүлгүүд нь суралцах, сүнслэг хариуцлага хүлээх, үйлчлэх, залбирах, ямар нэг онцгой төсөл хэрэгжүүлэхээр цугладаг.

Зарим чуулганууд гэрт цуглардаг жижиг бүлгүүдэд хуваагддаг ба бүлгүүд нь жижиг чуулган шиг үйл ажиллагаатай байдаг. Шинэ гэрээний чуулганууд ийм байдлаар ажилладаг байжээ.

Энэ хичээлээр бид жижиг бүлгээр дагалдуулахын үр нөлөөг ярилцах болно.

### Веслейн загвар

Жон Веслей (18-р зуун, Их Британи) анхны жижиг бүлгүүдийг зохион байгуулсан хүн биш боловч энэхүү системийг маш үр дүнтэй болгож хөгжүүлсэн юм.

Веслей “нийгэмлэг, анги, бүлэг” гэх мэтээр нэрлэгддэг их бага янз бүрийн хэмжээтэй дагалдагч бэлтгэх системийг хөгжүүлсэн<sup>15</sup> юм. Веслейн арга нь эхэндээ бүрэн систем байгаагүй боловч, аажмаар хэрэгцээг хангаж эхэлжээ. Веслейн үйлчлэлээр христитгэлийг хүлээн авсан хүмүүс урам зориг, зөвлөгөө, залбирал хүсэж байлаа. Тэд дэндүү олон байсан учраас Пүрэв гараг бүр уулзалдахаар тохирсон гэдэг.

Ингээд Веслей ба түүний номлогчдоос сайнмэдээ хүлээн авсан хүмүүс тухайн газартаа итгэгчдийн бүлэг байгуулж, тогтмол цугладаг болов. Гэхдээ цуглаан хэт том учраас олон хүн сүнслэг хэрэгцээнийхээ талаар ярих боломжгүйн зэрэгцээ тэдэнд хангалттай анхаарал хандуулж чаддаггүй байлаа. Иймээс “анги” гэж нэрлэдэг жижиг бүлгүүдийг байгуулж, удирдагчид нь гишүүдээ урамшуулан чиглүүлдэг, пасторын үүргийг

---

<sup>15</sup> “A Plain Account of the People Called Methodists,” in *The Works of John Wesley, Volume VIII* (Grand Rapids: Zondervan), 249-258-г үзнэ үү!

гүйцэтгэдэг болжээ. Илэрхий нүгэлтэй, өөрчлөгдөөгүй гишүүнийг гишүүнчлэлээс хасаж, цуглаанд оруулдаггүй байв.

Ангиас жижиг бүлгүүд байгуулагдан, гишүүд нь сүнслэг сорилт бэрхшээлээ хуваалцаж, бие биеийнхээ өмнө сүнслэг хариуцлага хүлээх боломжтой болжээ. Энэхүү жижиг бүтцийг бүлэг (хамтлаг) гэж нэрлэдэг байв. Ийм уулзалт дээр удирдагч өөрийн сүнслэг байдлын талаар ярьж, дараа нь бусдынхаа нөхцөл байдал, нүгэл, уруу татлагын талаар асуудаг. Энэ бүлэгт эрэгтэй, эмэгтэйгээрээ тусдаа уулздаг байжээ.

Веслейн амжилт алдарт Жорж Вайтфийлдийг ийнхүү хэлэхэд хүргэсэн юм. “Веслей ах маань ухаалгаар үйлчилж байсан учраас хүмүүс үйлчлэлийнх нь үеэр сүнсээр сэрж, ангиудад нэгдэн хөдөлмөрийнх нь үр жимс болж байлаа. Харин би үүнийг үл тоомсорлож, миний хүмүүс элсийг олсоор хүлэх мэт байдалтай болжээ.” Веслейн арга барилыг Америкийн Методист чуулган анхандаа хэрэгжүүлж байсан боловч дагалдуулах зарчмууд болон онол сургаалуудыг нь орчин үеийн методистууд ойшоодоггүй.

### **Чуулганы үндсийг ойлгох нь**

Хамгийн эртний чуулганы барилга ойролцоогоор НТ 250 онд баригдсан байдаг. Эхний хоёр зуунд чуулган өөрийгөө барилга байгууламж, эсвэл байгууллага биш харин хүмүүс гэж үздэг байв. Чуулган нь хамтдаа мөргөн хүндэтгэж, сайнмэдээ түгээж, Библийг дагадаг итгэгчдийн бүлэг байлаа.

Жижиг бүлгүүд нь үр дүнтэй чуулганыг барьж байгуулах үндсэн орц найрлага юм. Жижиг бүлгээр дагалдуулах ажил нь шинэхэн гарч ирээд хэзээ нэгэн цагт хуучирч оддог хөтөлбөр биш. Түүнчлэн зарим газар ажилладаг, зарим газар ажилладаггүй арга барил ч биш. Харин чуулганыг барьж байгуулах барилгын материал юм. Нутгийн чуулганд тулгардаг бэрхшээлүүдийг шийдэхийн тулд жижиг бүлгүүд янз бүрийн аргаар үйл ажиллагаагаа явуулж болно.

Хүмүүсийг нийт чуулганаар нь эсвэл Ням гарагийн сургалтаас илүүтэйгээр хувьчилсан байдлаар тогтмол сургаж, боловсруулахгүй л бол чуулган зорилгодоо хүрэхгүй.

### **Болгоомжлол**

Жижиг бүлгүүдийн сүнслэг байдал нь хамрагдаж байгаа хүмүүсээсээ хамаарна. Хэрэв тэд Бурханд таалагдах, итгэмжит амьдрал, дагалдагчийн амьдрал зэргийг чухалчлахгүй, мөн чуулганы үүргийг гүйцэлдүүлэхгүй бол бүлэг буруу замаар явдаг.

### **Сүнслэг хариуцлага хүлээх хэрэгцээ**

Сүнслэг хариуцлага хүлээх гэдэг нь өөрийнхөө сүнслэг байдал, сүнслэг сахилга батыг хэрэгжүүлэхэд гарсан амжилт, бүтэлгүйтэл, өсөлт хөгжилтийн төлөө хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүнтэй холбоотой байж, тайлагнаж явахыг хэлнэ. Хэрэв та буруу юм хийвэл тэд танд сануулна. Та ямар зориулалт гаргахаа хэлж, тэд таныг хэлсэндээ хүрч байгаа эсэхийг асууна.

Эрүүл харилцаатай христитгэлийн бүлэг дотор сүнслэг үүрэг хариуцлага хүлээх тухай Библийн үндэслэлийг өмнөх хэсэгт нарийн тайлбарласан. Сүнслэг хариуцлага үүрэхгүйгээр бид Библийн тушаалуудыг биелүүлж чадахгүй юм. Улмаар Бурханаас биднийг нигүүлсэхээр өгсөн арга хэрэгслүүдийг үл тоомсорлодог болно.

... бие биенийхээ өмнө нүглээ улайж, бие биенийхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой. Зөвтийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна (Иаков 5:16).

Дотно харилцаа үүсээгүй бол хүн хувийн нүглээ тийм амархан улайхгүй. Хэрэв хүн алдаа дутагдлынхаа талаар залбирч, гэмшихгүй бол энэхүү хэрэгцээг хангахаар бүтээсэн Бурханы арга замыг үл тоож байгаа хэрэг юм.

Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн (Галат 6:2).

Бид хэн нэгнийг сайн мэдэхгүй л бол түүний хамгийн хүнд ачаа юу болохыг ойлгохгүй. Тиймээс харилцаа үүсгэж, бие биеэ мэдэлцэхгүйгээр бид Бичвэрийн тушаалыг биелүүлж чадахгүй.

Хайр болон сайн үйлсийг бадраахын төлөө нэг нэгнээ анхаарч... (Еврей 10:24).

Бид хэнд ямар урам зориг, зэмлэл хэрэгтэйг мэдэхийн тулд бие биеэ хайрын сэтгэлээр шалгаж ажиж байх ёстой. Гэхдээ онцгой харилцаа үүсээгүй л бол урамшуулал нь өнгөц болдог бөгөөд хүн зэмлэлийг хүлээж авахгүй байх талтай.

Дараах асуултууд таны амьдралд сүнслэг хариуцлага байгаа эсэхийг тодорхойлоход тусална.

Миний хүлээн зөвшөөрдөг харилцаа холбоо юу вэ?

- Хүнд ачаагаа үүрэхэд минь туслах хүн байна уу?
- Алдаа нүглээ улайх хэн нэгэн байна уу?
- Хэн нэгний хүнд ачааг би үүрэлцдэг үү?
- Миний одоогийн сүнслэг байдалд дүгнэлт хийх хүн байна уу?

Ийм цаг үеүүд байна уу?

- Түшиж тулах хэн ч байхгүй байна уу?
- Миний нөхцөл байдлыг хэн ч мэдэхгүй байгаад би баяртай байдаг уу?
- Залбирал, Библи судлалын цагаар залбирлын сэдвээ хэлэхээс ичдэг үү?

Сүнслэг үүрэг хариуцлага хүлээх тогтолцоог бий болгохгүй л бол олонх чуулган энэ ажлыг хийж чадахгүй. Харин жижиг бүлгийн систем нь олон хүний хувьд энэ бүхнийг хийж болох газар болдог.

## Жижиг бүлгийн удирдагчийн шалгуур

Дагалдагч хүнд юу эрхэм чухал болохыг Есүс зааж өгчээ. Үйлчлэлийнхээ эхэн үеэс чуулганыг удирдан чиглүүлэх үүрэг хариуцлагыг хүлээн авах цөөн хэдэн хүнийг Тэрээр сонгосон юм. Есүс Өөрийг нь дагаж байсан олон мянган хүнд номлохын тулд бүх цагаа зарцуулаагүй, харин үүний оронд 12 элчийг сургахын төлөө цаг гаргадаг байсан. Улмаар сургасан элч нараараа дамжуулан үйлчлэлээ өргөжүүлсэн билээ.

Дагалдуулж байгаа хүмүүс дараах зан чанарыг өөртөө шингээсэн байх учиртай. Бүх талаар гаргууд байх албагүй боловч бүх талаа сайжруулахаар хичээдэг байх ёстой юм. Хэрэв эдгээрийн аль нэг нь доголдвол, гарах сайн үр дүн ч багасах болно.

### (1) Сүнслэг төлөвшилтэй

Өмнөх хэсэгт дурдагдсан сүнслэг төлөвшлийн зан чанарууд жижиг бүлгийн удирдагчдад байх ёстой. Хэрэв сүнсний хувьд төлөвшөөгүй бол сайн үлгэр дуурайл үзүүлэхгүй, тийм хүнээс мэдлэг туршлага ч гарахгүй.

### (2) Боломжтой

Цагийн хуваарь нь дүүрчихсэн, сайн зохицуулах аргагүй байдаг хүн жижиг бүлэгт үйлчлэх боломжгүй. Тиймээс удирдагч хүн нэн тэргүүнд тавих зүйлээ тодорхой болгох ёстой.

“Хэдийгээр Есүс олон түмэнд туслахын тулд чадах бүхнээ хийсэн ч, илүү олныг аврахын тулд олон хүнд бус, харин цөөн хэдэн хүнд Өөрийгөө зориулах ёстой байв. Энэ бол Түүний ухаалаг стратеги байлаа.”  
- Роберт Коулмэн, *Мастерын төлөвлөгөө номоос.*

### (3) Хариуцлагатай

Жижиг бүлгийн удирдагч амлалтаа биелүүлдэг хүн байх ёстой. Өөрөө цугларалтдаа ирдэг, бусад хүмүүсийн амлалт зориулалтыг санаж байдаг хүн байх учиртай.

### (4) Өөртөө итгэлтэй

Тэрээр бүлгээ удирдаж сурна гэдэгтээ итгэлтэй байх ёстой. Хэрэв чадвартай атлаа үүндээ итгэж чадахгүй байвал юуны өмнө өөртөө итгэлтэй байдлаа хөгжүүлэх талаар зарим нэг заавар удирдамжийг авах ёстой.

### (5) Зөрчилдөөнийг шийдвэрлэх чадвартай

Хүмүүс санал зөрөлдөж, асуудал гарах үед жижиг бүлгийн удирдагчид зөв хандлагатай байх ёстой. Улмаар бусдын дундах зөрчилдөөнийг шийдвэрлэхэд туслах чадвартай байвал зохино.

### (6) Заах чадвартай

Хүмүүс түүний тайлбарлан ярьж байгааг ойлгож байна уу? Удирдагч хүн бусдыг төөрөлдүүлэлгүй ярих ёстой.

### **(7) Бурханы Үгээр өлсөж цангадаг**

Бурханы Үгэнд баярлан баясдаг байх ёстой. Тэгвэл бусдыг мөн үүнд уриалж чадна. Түүнчлэн Бурхантай харилцахдаа Библийг чухалчилдаг байх учиртай.

### **(8) Бурханаас хамааралтай**

Зөвхөн Ариун Сүнсний ажлаар л сүнслэг үр дүн гарна гэдгийг удирдагч хүн ойлгох ёстой. Тиймээс Ариун Сүнстэй хамтран ажиллахад бэлэн байна. Түүнчлэн тэрээр Бурханы тосолгоонд найдах ёстой. Өөрийнх нь чадварын ачаар цуглаан нь амжилттай болно гэж итгэх ёсгүй.

### **(9) Үйлчлэхэд бэлэн**

Бусдад үйлчлэх нь үнэ цэнтэй гэдгийг мэдэрдэг байх ёстой. Харин үйлчлүүлэхийг хүсдэг хүн байж болохгүй. Мөн үйлчлэлийг өөрийнхөө авьяасыг харуулах талбар болгохыг хүсэх ёсгүй. Хэрэгцээ шаардлага гарахад сайн дураар үйлчлэхэд бэлэн байх учиртай.

### **(10) Сүнслэг эрх мэдлийн дор байдаг**

Хэн нэгний өмнө сүнслэг хариуцлага хүлээж, сүнслэг удирдагчийнхаа чиглүүлгийг дагах ёстой юм.

### **(11) Чуулганд итгэмжтэй**

Бүлгийн удирдагч нь нутгийн чуулганы тууштай гишүүн байх ёстой. Дагалдуулах үйлчлэл нь хүмүүст чуулганыг үнэлэх, илүү зориулалт гаргахад нөлөө үзүүлдэг.

### **(12) Амжилтад тэмүүлдэг**

Амжилтад хүрэх хүсэлтэй хүн яаран бууж өгөхгүй. Харин нөхцөл байдалд хурдан дасан зохицно. Илүү үр дүнд хүргэх мэдлэг мэдээллийг эрэлхийлж, асуудал эсвэл боломж гарах үед санаачлага гаргана. Бүлгийн удирдагч эрч хүч, урам зоригтой байх ёстой.

### **(13) Онол сургаалын алдаагүй**

Библи ба сайнмэдээний онол сургаалын сайн суурьтай байх ёстой.

### **(14) Үйлчлэлд сургагдсан**

Үйлчлэлийн сургалтыг заавал академик байгууллага хийх албагүй. Сургалтыг ажиглалтаар эхлүүлж болно. Итгэгч хүн эндээс үйлчлэл хэрхэн явагддагийг хардаг. Хүмүүс оролцоотой байж, удирдамжийн дагуу үүрэг даалгавар авах тусам сургалт сайжирдаг. Уншиж судлах сайн материал үнэхээр чухал.

### **Дагалдуулах хөтөлбөр боловсруулах нь**

Дагалдагчийн үүрэг хариуцлага, ач холбогдлыг ойлгодог, эв нэгдэлтэй нутгийн чуулган өөрөө дагалдагч бэлтгэх хамгийн сайн арга зам болдог.

Тиймээс эдгээр удирдамж нь бүлгийн удирдагчид болон зориулалт гаргадаг гишүүдэд зориулагдсан болно.

Хэрэв чуулган дагалдагч бэлтгэх тал дээр ахиц дэвшил гаргах ёстойгоо ухаарвал эхлээд Библийг болон энэхүү дагалдагчийн тухай хичээлийн гол санааг сайн судлах ёстой. Удирдагчид материалуудыг зааж, чуулганы оролцох боломжтой, зориулалт гаргасан гишүүд суралцвал зохино. Ингэснээр тэд алсын хараагаа хуваалцаж чадна.

Чуулган юу хийж байгааг ажиглах нь өсөлтийн хоёр дахь хэсэг юм. Ихэнх чуулганууд жижиг бүлгийн хөтөлбөрийг зориудаар эхлүүлээгүй байсан ч аль хэдийн үйл ажиллагаагаа явуулж буй жижиг бүлгүүдтэй болсон байдаг. Жишээлбэл, чуулган дээр байнга уулзалддаг хөгжимчид гэж бий. Хамтдаа дасгал хийдэг найрал дууныхан ч байдаг. Ахлагчдын зөвлөл, хүүхдийн цуглааны хичээл эсвэл хүүхдийн цуглааны багш нарын бүлэг гэж бий. Чуулганы залуучууд хааяа уулзаж болно. Янз бүрийн үүрэг хариуцлага хүлээсэн зөвлөлүүд байж болно. Төсөл дээр хамтран ажилладаг хүмүүсийн албан бусаар байгуулсан бүлэг, эсвэл хааяа хааяа нөхөрлөх зорилгоор цугладаг чуулганы гэр бүлүүдийн бүлэг ч байдаг. Түүнчлэн гэрээр Библийн хичээл хийдэг бүлэг, залбирлын цуглаанууд ч бий.

Эдгээр бүлгүүд нь дагалдуулах, эсвэл сүнслэг үүрэг хариуцлага хүлээх зорилгоор байгуулагдаагүй байж болох ч, ийм зорилготой үйлчлэлд тусалж болдог. Сүнслэг амьдралтай аливаа чуулганд сүнслэг амьдралыг дэмжих зарим бүлгүүд байнга үйл ажиллагаагаа явуулж байдаг. Хэрэв танай чуулган дагалдагч бэлтгэх хөтөлбөрөө сайжруулахаар шийдсэн бол одоо байгаа бүлгүүдээ судалж, юу болж байгааг олж тодруулаад, дараа нь зорилгодоо яаж илүү сайн хүрч болох талаар бодолцоорой.

Шинэ бүлгүүд байгуулах хэрэгтэй байж ч мэднэ. Олон төрлийн бүлгүүд эхлүүлэх шаардлага ч тулгарч болно. Үйлчлэлийн талаар практик сургалт ордог бүлэг, Библи судлалыг голчилдог, эсвэл залбирдаг бүлэг ч байж болно. Сүнслэг хариуцлагыг чухалд авч үздэг жижиг бүлэг байх ч боломжтой.

Бүлгийн зорилго нь хэнийг хамруулах, бүлэг хэрхэн ажиллах ёстойг тодорхойлдог. Жишээ нь, сүнслэг хариуцлагыг чухалчлах багт арваас цөөн хүн байх ёстой. Хэрэв бүлэг том бол нууцлал багасч, хуваалцах нь гүехэн болж, илүү их хяналт шаардагдах ба хүмүүсийн оролцоо багасч, ирц дордох хандлагатай. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс холилдож орсон тохиолдолд хувийн хуваалцах зүйл ч хязгаарлагдмал болдог.

Шинэ гишүүдэд нээлттэй байх эсэхийг бүлгийн зорилго нь тодорхойлно. Хэрэв сүнслэг хариуцлага үүрэлцэх зорилготой бүлэг бол хэдэн удаа цугласаны дараа шинэ гишүүд нэмэхээ болино. Мөн хүмүүс аюулгүй байдлыг мэдрээгүй бол бусад хүмүүст сүнслэг байдлынхаа талаар хуваалцахгүй. Хэрэв цуврал хичээлүүдийг судлах зорилготой бүлэг бол цуврал уулзалтын явцад хүмүүс нэмж оруулж болно.

Шинэ итгэгчдэд зориулсан бүлэг байж болно.<sup>16</sup> Гол нь шинэ хүн энэ бүлэгт элсэхийн тулд хэдэн долоо хоног хүлээхгүй байх нь чухал. Тиймээс энэ бүлэгт шинэ хүмүүс хэзээ ч элсэх боломжтой болгож, хичээл нь дахин давтан заагддаг цуврал байх хэрэгтэй. Зарим шинэ итгэгчид сургалтыг орхино гэдгийг удирдагчид ойлгоорой. Зарим хүмүүс бүлгээсээ гарч байгаа нь бүлгийн үйл ажиллагаа муу байна гэсэн үг биш. Хэдийгээр зарим нь орхиж байсан ч шинэ итгэгчийн бүлэг үргэлж шинэ хүмүүст нээлттэй байх ёстой.

Хэрэв үйлчлэлийн сургалт эсвэл гүн гүнзгий сүнслэг хөгжилд зориулагдсан бүлэг байгуулбал, сүнслэг байдлын хувьд өсөх хүсэлтэй, бүлгийн зорилгодоо тууштай хандахад бэлэн хүмүүсийг бүлгийн гишүүн болгох ёстой. Гишүүдийн зарим нь тууштай ажиллахгүй бол бүлэг зорилгодоо хүрч чадахгүй.

Ихэнх гишүүдийг хувьчилсан байдлаар урьж элсүүлнэ. Хүмүүсийг өөрсдөө нэгдэж ирэхийг хүлээх хэрэггүй.

Чуулганы бүх хүн жижиг бүлгийн хөтөлбөрт хамрагдах албагүй. Хэрэв та чуулганы удирдагч бол хүмүүсийг жижиг бүлэгт ороогүй гэж шүүмжлэх, хөөх ёсгүй. Харин бүлгийн үйлчлэлийн ач тусыг тайлбарлаж сурталчлах ёстой.

Бүлгийн эхний уулзалт дээр хүн бүр тус бүлгийн ач холбогдлыг ойлгож байгаа эсэхийг шалга. Дагалдагч байхын ач холбогдлыг дурдсан Библийн эшлэл, сургаалыг хуваалц.

Ирцээ бүрэн байлгахын тулд зарим жижиг бүлгийг тодорхой хэдэн долоо хоногийн хугацаатай байхаар төлөвлөж болно. Бүлэг тодорхой цуврал хичээлүүдийг үзэх ёстой талаар тайлбарлаж, сургалт хэзээ дуусахыг хэлж байгаарай. Ингэснээр гишүүн бүр ямар зориулалт гаргах ёстойгоо яг таг мэдэх юм. Ийм сургалтад бүрэн ирц чухал гэдгийг онцлоорой. Мэдээж хугацаа дуусахад цааш үргэлжлүүлэх хүсэлтэй хүмүүс дахиад бүлэг эхлүүлж болно.

### **Бодолцох ёстой жишээ**

Андрей итгэгч болоод хэдэн жил болжээ. Тэрээр чуулганы гишүүн бөгөөд чуулгандаа тусалдаг. Чуулганд нь дагалдагч бэлтгэх төлөвлөгөө байхгүй байгаад тэр санаа зовдог. Андрей жижиг бүлэг байгуулья гэж боддог ч, удирдагчид нь жижиг бүлгүүд байгуулах сонирхолгүй байна.

► Андрей юу хийх ёстой вэ?

Андрей чуулганы удирдагчидтай уулзаж, жижиг бүлгийг удирдах зөвшөөрөл авах хэрэгтэй. Харин чуулганы үйлчлэлийг шүүмжлэлгүйгээр, жижиг бүлэг байгуулбал ирэх

---

<sup>16</sup> Shepherds Global Classroom байгууллага нь шинэ итгэгчдийг дагалдуулах 26 хичээл бүхий номыг санал болгож байна. Энэхүү үнэгүй эх сурвалж болох *Cultivate Discipleship Lessons* номыг [shepherdsglobal.org](http://shepherdsglobal.org) вэб хуудсаас татаж авах боломжтой.

ашиг тусыг тайлбарлах нь зөв. Хэрэв бүлэг сайн ажиллавал чуулган ийм төрлийн үйлчлэлийн ач тусыг ойлгож эхэлнэ.

### **Үр дүнтэй бүлгийг удирдах нь**

Бүлэг эхлэхэд сэтгэлийн хөөрөл, хүлээлт их. Олон хүн юу хүлээж байгаагаа мэдэхгүй боловч бүлгээс ирэх ач тусад найдаж байдаг. Тиймээс бүлгийг үр дүнтэй ажиллуулах зорилгодоо хүрэхэд танд дараах чиглэлүүд тусална. Жижиг бүлгүүдийн үйл ажиллагаанд чухал зарчмууд гэж бий. Удирдагч бүлгийнхэндээ эдгээр зарчмуудыг дагахад тусалбал бухимдал, урам хугарах явдал бага гарна.

Анхны цуглаанаар бүлэг хэрхэн явагдах талаар ярих учраас бусад цугларалтаас ялгаатай байж болно. Гэхдээ эхний уулзалт нь дараагийн уулзалтуудын хэв маягийг тодорхойлдог. Хэрэв хүн эхний уулзалтад юм ярихгүй байвал ирээдүйд ч чимээгүй байна гэж бодож болно. Харин эхний уулзалт дээр голчилж яриад байгаа хүн цаашид ч голчилж ярих хандлагатай гэсэн үг. Уулзалт эмх замбараагүй болбол цаашдаа ч бас тийм байх магадлалтай. Хэрэв бүлгийн уулзалт оролцоо багатай, анги шиг байвал цаашид ч бас тийм хэв маягтай байна.

Бүлэг нь хүлээлтээс өөр байгаагаас болж зарим гишүүд хэд хэдэн уулзалтын дараа бүлгээс гарч магадгүй. Тиймээс зөв хүлээлттэй, гишүүдийн урмыг хугалахгүйн тулд уулзалтаа зөв явуулах нь чухал.

### **Үр дүнтэй байхад туслах заавар**

**(1) Боломжтой бол жижиг бүлгээрээ долоо хоног бүр цуглах төлөвлөгөө гарга. Зарим хүнд хүүхэд харах хүн олох шаардлага гарч болно шүү дээ.**

**(2) Уулзалт нь (а) Библи судлалын цаг, тэгээд (б) хувийн залбирлын хэрэгцээгээ хуваалцах, дараа нь (в) залбирал гэсэн хэсэгтэй байна.**

Хэрэв бүлэг судлалд зориулагдсан бол, суралцах хугацаа урт, бусад хэсэг нь богино байж болно. Гэхдээ дээрх гурван хэсгийг заавал оруулах ёстой. Хэрэв сүнслэг үүрэг хариуцлага нь бүлгийн зорилго бол судлалын цаг богино байж болно. Гэхдээ заавал ном материалтай байх ёстой.

Бүлэг цуглаад хувийн асуудлаа хуваалцаж, залбирч байгаа боловч ямар нэг судлах хичээлийн материал байхгүй бол эмх замбараагүй болно. Дээр нь зарим гишүүдийн давамгайл оролцоо ихсэх талтай. Тиймээс хичээлийн материалтай байх нь бүлгийнхний оюун санаанд байгаа зүйлээс илүү бодит хариу олоход тусална.

**(3) Уулзалтын эхлэх ба дуусах цаг.**

Хэрэв уулзалтаа оройтож эхэлж, оройтож дуусгавал цаг заваа эрхэмлэдэг хүмүүс оройтож ирнэ, эсвэл зарим уулзалтыг алгасна.



#### **(4) Жижиг бүлгийн хугацааг товло.**

Гишүүд хэр хугацаанд зориулалт гаргахаа мэдэх хэрэгтэй юм. Бүлэг шинэ итгэгчдэд зориулсан, хичээл нь дахин давтагддаг бүлэг биш л бол, хэдэн уулзалтын дараагаас эхлээд шинэ хүн элсүүлэхгүй байх нь зөв. Хэрэв бүлэг цуврал хичээл судалж байгаа бол, хичээлийн тоогоор уулзалтын тоог тогтооно. Хэрэв сүнслэг хариуцлага хүлээх бүлэг бол ядаж 6 сарын хугацаа товлох хэрэгтэй. Цуврал хичээлээ дуусгаад дахин зохион байгуулж ч болно. Хугацаа дуусахад зарим гишүүд гарч, бүлэгт өөр гишүүдийг нэмэх талаар ярилцаж болно.

#### **(5) Суралцахдаа өөрийнхөө төлөө мэдлэг олж авахаас илүүгээр амьдралыг өөрчлөх зорилго тавь.**

Суралцаж байхдаа гишүүд хувийн, онцгой хэрэгжүүлэлт гаргаж чадвал, тухайн бүлгийн цугларалт үнэ цэнтэй санагдах болно.

#### **(6) Зориулалтыг нь шалга.**

Хэрэв хэн нэг нь асуудал бэрхшээлээ хуваалцаж, тодорхой алхам хийнэ хэмээн зөвшөөрсөн бол дараагийн уулзалт дээр өнөө хүнээс амлалт өгсөн зүйлээ хийсэн эсэхийг нь асуугаарай.

#### **(7) Гишүүн бүртэй хувьчлан уулзаж, сүнслэг удирдамж өгч бай.**

Бусад гишүүд ч бас бие биедээ урам зориг өгөхийн тулд цуглаанаас өөр үед уулзалдаж болно.

#### **(8) Уулзалт хийх сайн газар сонго.**

Уулзалт хийх газар гэрийнх шиг уур амьсгалтай, албан бус газар байвал зохино. Суудал аль болох дугуй хэлбэртэй байвал гишүүн бүр бусдынхаа царайг харах боломжтой. Ингэж байрлуулах нь бүх хүнд оролцох боломж олгоно. Тасалдуулахгүй, анхаарал сарниулахгүй газар уулзаарай.

#### **(9) Сайн сонсогч байх дадалтай бол.**

Сайн сонсогч нь нүдээрээ харилцах, нүүрний хувирал үзүүлэх, анхаарал сарниулах зүйлийг үл тоомсорлох, ярьж буй хүний хошигнол болон бусад сэтгэл хөдлөлд хариу үзүүлэх байдлаар харилцдаг.

#### **(10) Бүх гишүүдийг яриулахыг хичээ.**

Юм ярихгүй байгаа хүн байвал шууд асуулт асуугаарай. Жишээ нь: Калев, та энэ талаар юу гэж бодож байна? гэх мэт.

#### **(11) Хувийн асуудлаа хуваалцахыг бүү шах.**

Үүнийхээ оронд чөлөөтэй ярих уур амьсгалыг бүрдүүлээрэй. Нүдээрээ харилцаж, ярьж байгаа зүйлийг нь дэмжих маягаар гишүүддээ итгэлтэй ярих боломж бүрдүүлээрэй.

**(12) Өөртөө итгэлтэй болгох асуулт асуу.**

Хэрэв хэн нэг нь буруу хариулт хэлбэл шүүмжлэхээсээ өмнө хариултад байгаа ямар нэг сайн талыг дурдаж дэмжээрэй.

**(13) Хариулт бүрийг шүүмжлэлгүй, харин ямар нэг байдлаар хүлээн авахыг хичээ.**

**(14) Хэн нэг нь хэт ярих хандлагатай бол тэр хүнийг хязгаарлах зорилгоор бусдаас нь бүх асуултыг асуу.**

Шууд тодорхой хүнд хандаж асуулт асуух нь их ярьдаг хүнийг хязгаарлах арга юм. Эсвэл та "За бусад нь юу гэж бодож байна?" гэж асуусан ч болно. Хэлэлцүүлгийн үеэр "Одоо энэ талаар саналаа хэлээгүй хүний ярихыг сонсоцгооё" гэж хэлж ч болно.

Хэрэв хэн нэг нь хэт их яриад байвал удирдагч тухайн хүнтэй уулзалтын дараа ярилцаж болно. Жишээлбэл ийм маягаар яривал зүгээр. "Калев аа, та хурдан сэтгэдэг, хэлэлцүүлэгт хурдан хариу өгдөг хүн юм. Гэхдээ бид түрүүлээд хариуг нь хэлчихээд байхаар бусад хүмүүст оролцох боломж гарахгүй байна. Би үүнд санаа зовж байгаа болохоор та бүх хүнийг оролцуулахад надад тусалж болох уу?" гэх мэт.

**(15) Бүлгийн хоёр юм уу, гурван гишүүн хороондоо яриад бусдыгаа үл тоох байдал гаргахаас сэргийл.**

Хэн нэг нь ямар нэг зүйлийн талаар удаан маргалдах хүсэлтэй байвал тухайн хүнд хандаж уулзалтаас гадуур хэлэлцүүлгээ дуусгах ёстой гэдгийг хэлээрэй.

**(16) Бусдын яриаг тасалдуулахыг бүү зөвшөөр.**

Яриа тасалдуулагчийг гараа өргөж зогсоогоод, ярьж байгаа хүнийг үргэлжлүүлэн ярих боломж гарга. Эс бөгөөс хэлэлцүүлэг дээр дураараа зантай хүмүүс давамгайлсаар дуусаж мэднэ. Өөртөө итгэл муутай хүмүүс үгээ дуусгаж чадаагүй бол дургүйцэж бухимддаг.

**(17) Гомдол гаргагчийг сонс.**

Аливаа гомдол нь засах боломжтой асуудлыг хөндсөн байж болно. Хүмүүс сэтгэл дундуур байгаа бол үүнийг тоохгүй орхиж болохгүй. Бүлгийн зорилгыг сайн ойлгоогүй хүн бүлгийн уулзалтад сэтгэл ханамжгүй байж болно. Эсвэл үнэхээр үндэслэлтэй гомдол байж ч болно.

**(18) Бүлгийн зорилгыг ойлгоогүй хүн байнга дайсагнасан, үймүүлсэн, маргасан, уйдсан үйлдэл гаргах тал бий.**

Магадгүй бүлэг тухайн хүний хүсэж хүлээж байснаас өөр байж болно. Тиймээс тэр хүнд бүлгийнхээ зорилгыг ойлгуулж, ганцаарчлан ярилцаарай.

**(19) Удирдагч хүн асуудал болгонд хариу өгөх албагүй.**

Удирдагч хүн бүх зүйлд хариу өгөх гэж биш, харин бүлгийнхээ залбирлыг чиглүүлэх зорилгоор үйлчилдэг.

**(20) Уулзалт тасалдах үед уян хатан, тэвчээрэй ханд.**

Амьдралд тохиолдож байгаа асуудлууд маань биднийг хөгжүүлж буй Бурханы ажлын нэг хэсэг гэдгийг санаарай. Асуудал бол боломж юм.

**(21) Уулзалт бүрийг өөрийнхөө хэрэгцээг хуваалцах цаг болгох гэдэг гишүүн байвал тухайн хүнд тусдаа зөвлөгөө өгөх цаг гаргахыг санал болго.**

Эс бөгөөс бусад гишүүдэд цагийг нь хумслаад байгаа мэт санагдана. Бүлгийн зорилгыг өөрчлөх тал дээр гишүүд бүгд санал нэгдээгүй л бол бүлгийнхээ зорилгыг алдагдуулж болохгүй.

**(22) Хэлэлцүүлгийг хорлох оролдлогыг бүү зөвшөөр.**

Жижиг бүлэг нь нутгийн чуулган ба чуулганы удирдагчдыг шүүмжилдэг хэлэлцүүлэг болж болохгүй.

**(23) Бүлгийн үр нөлөөтэй байдал үүний дунд ажиллаж байгаа Бурханы хүч чадлаас хамаарна гэдгийг санаарай.**

Бичвэрийн дагуух Бурханы ашиглаж буй цорын ганц бүтэц нь жижиг бүлэг юм.



# 19-р хичээл

## Дагалдагчдын төлөө залбирах нь

### Паулын залбирлаар итгэгчдийн төлөө залбирах нь

Шинэ итгэгчдэд ямар хэрэгцээ тохиолдох талаар шинэ итгэгчдийн төлөө залбирсан Паулын залбирал харуулж байна. Бид залуу итгэгчдийн төлөө Паул шиг залбирах ёстой бөгөөд эдгээр залбирал бидэнд тэдний төлөө хэрхэн залбирахыг зааж өгч байна. Бид залуусын төлөө Бурханы ажиллаж байгаа үйлчлэлтэй хамтрах ёстой учраас эдгээр залбирал бидний үйлчлэлийг ч удирдан чиглүүлж байгаа юм.

Гурван өөр бүлгийн төлөө залбирсан Паулын залбирлыг үзэцгээе.

#### Тесалоникчууд

► Нэг суралцагч 1 Тесалоник 5:23-24-г ангид уншина.

Тесалоникчуудад бичсэн эхний захидалд ариун байдлыг уриалж байна. Итгэгч бүр ялалт, ариун байдлын төлөө дуудагдсан бөгөөд үүнийг итгэлээр хийх боломжтой гэдгийг Бурхан амлажээ. Бид итгэгч бүрийг ялалт, ариун байдалд хүргэх зорилгоор залбирч, бас заан сургах ёстой.

#### Филиппойчууд

► Нэг суралцагч Филиппой 1:9-11-г ангид уншина.

Итгэгчдийн амьдралд өрнөж буй үйл явцыг эдгээр эшлэлд өгүүлжээ. Итгэгч хүний хайр байнга нэмэгдэж байх учиртай. Тэгвэл түүний сайныг ялгах чадвар нэмэгдэнэ. Ялгах тусмаа амьдралын хамгийн чухал зүйл дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Ингэснээр гомдолгүй, цэвэр ариун (чин сэтгэлтэй) болох юм.

Паулын эдгээр эшлэлд бичсэн хүмүүс нь хэдийн итгэгч болсон хүмүүс байв. Гэсэн ч Паул тэднийг Бурханыг хайрлах хайраа улам бүр нэмэгдүүлж, энэ хайраараа Бурханы тэдэнд зориулсан хүслийг илүү ихээр ойлгож мэдээсэй хэмээн залбирчээ.

Залуу итгэгчийн анхаарах ёстой зарим зүйлсийг энд дурдъя.

- Бурхан надад хандлага, зуршил, үйлдэл минь тийм ч сайнгүй байна гэдгийг харуулах үед миний зүгээс амьдралдаа хийж болох өөрчлөлтийн жишээ юу вэ?
- Миний амьдралд эргэлздэг зүйл байна уу?
- Амьдралдаа ямар өөрчлөлт хийх ёстойг Бурхан надад залбирлаар харуулахыг би зөвшөөрч байна уу?

## **Колоссайчууд**

► Нэг суралцагч Колоссай 1:9-12-г ангид уншина.

Паул тэднийг мэргэн ухаан ба сүнслэг ойлголт дунд Бурханы хүслийн талаарх мэдлэгийг олж аваасай хэмээн залбирсан юм. Залуу итгэгчид амьдралынхаа хэв маягийг Бурханы хүслийн дагуу ямар байлгах ёстой талаар бүрэн ойлгоогүй байдаг. Гэхдээ аажмаар тодорхой дадал зуршил, үг хэллэг, хандлагууд нь өөрчлөгдөх ёстойг тухайн хүн олж хардаг. Бурханыг хайрладаг болсон тул амьдралаа Бурханы хүсэлд улам бүр нийцүүлж эхэлнэ. Дагалдуулагч нь залбирч, Бурханы хүслийг хэрхэн таних талаар залуу итгэгчдэд болгоомжтой заах учиртай.

Залуу итгэгчид Бурханы хүслийг илүү сайн ойлгосны үр дүнд Эзэнд зохистой байдлаар амьдарна гэдгийг элч Паул дурджээ. Ингэснээр тэд Бурханыг төлөөлөгч, илүү зохистой хүмүүс болох ба амьдрал нь нигүүлслээр өөрчлөгдсөн итгэлийн амьдралтай нь илүү нийцэх болно. Харин энэ үйл явц хэсэг зуур үргэлжилж дуусах хүртэл залуу итгэгчийн амьдралд зарим нэг алдаа мадаг гарч болно гэдгийг дагалдуулж байгаа хүн ойлгох ёстой.

Үр дүнтэй амьдралын нэг хэсэг нь “аливаа сайн үйлсэд үр жимс гаргах” явдал юм. Шинэ итгэгч маань сайн үйл болгондоо үр жимстэй байж чадахгүй байвал бид гайхах хэрэггүй. Тэр хүн ямар хариуцлага, үүрэгтэйгээ хараахан ухаараагүй байна.

Эдгээр эшлэлд хэрэв бид Бурханы агуу сүр жавхлангаар хүчирхэгжиж чадвал баяр хөөртэйгөөр тэсвэрлэж чаддаг гэжээ. Үйлчилж, тэвчиж байх үедээ Христийн баяр баясгаланг хадгалж чаддаг хүн сүнслэг төлөвшилтэй болсон байна.

### **Паулын залбирлын дүгнэлт**

Залуу итгэгчдийн төлөө залбирсан Паулын залбирал бидэнд дагалдуулах ажлын талаар ихийг хэлж өгч байна. Бид итгэгчдийг хөгжүүлэхийн төлөө зөв зорилготой байх ёстой. Ахиц дэвшлийг ч хүлээн зөвшөөрөх чадвартай байх учиртай. Бид тууштай бус, буруу ойлголттой, хариуцлагагүй байдлыг харвал гайхаад байх хэрэггүй. Угаасаа христитгэлийн зан чанарууд гэнэт бүгд бий болно гэж байхгүй.

Паул тэднийг үйлчлэлд сургах болон үйлчлэлийн чадварыг нь хөгжүүлэх талаар төдийлөн санаа зовохгүй байсныг анзаараарай. Харин тэрээр итгэл ба христитгэлийн зан чанараа хөгжүүлэх тал дээр нь илүү санаа тавьж байсан юм. Тиймээс үйлчлэлийн ажлаа сайн хийдэг ч, зан чанарын хувьд хангалтгүй байгаа хүмүүст бид санаа зовних ёстой юм.

Багш байх нь үлгэр дуурайл, мэдээлэл өгөх чадвараараа үнэ цэнтэй юм. Дээрх залбирлуудын хоёр залбиралд нь суралцах талаар онцлон өгүүлсэн байна. Мэдлэг бол сүнслэг өсөлтөд онцгой нөлөөтэй. Харин багш үнэнийг хуваалцаж, үр дүнтэй хэрэгжүүлснээрээ бусдад ихээхэн нөлөө үзүүлдэг.

Бидний нөлөөг авч буй залуу итгэгчдийнхээ төлөө бүгдээрээ Паулын залбирлаар залбирах ёстой. Өсөлтийн үйл явцыг итгэгчдийн амьдралд бий болгохын тулд бид Ариун Сүнстэй хамтран ажиллах учиртай.

Залуу итгэгчдийн төлөөх дараах залбирал нь Паулын залбиралд суурилсан юм.

### **Залуу итгэгчдийн төлөөх залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Та \_\_\_\_\_ -г бүрэн ариусгаасай хэмээн би залбирч байна. Түүний үйлдэл, хандлага, сэдэл бүр нь ариун байгаасай гэж залбирч байна.

Таныг хайрлах хайр нь улам нэмэгдэхэд туслаач. Тэгвэл өөрт нь хандсан Таны төгс хүсэл юу болохыг тэрээр ойлгох болно. Тэрээр зөв сайныг ялгаж таниад, сонгож чаддаг болоход нь туслаач. Ингэснээр түүний амьдрал Таны алдрын төлөө үр жимс ургуулах болно.

Өдөр бүр христитгэлийн амьдралаар амьдарч, бүх зүйл дээр Таны таалалд нийцүүлэн, Таны замыг улам ихээр таньж мэдэхэд нь түүнд туслаач. Тэрээр ялалтад хүрч, сорилтуудыг баяр хөөртэй туулахын тулд Танаас хүч чадлыг авдаг байх болтугай. Таны өгдөг нигүүлсэлд тэр үргэлж талархаж явах болтугай.

Есүсийн нэрээр залбирч байна. Амен





# Санал болгох эх сурвалжууд

## Номууд

Coleman, Robert. *The Master Plan of Evangelism*. Ada: Revell, 2010.

Coleman, Robert. *The Master Plan of Discipleship*. Ada: Revell, 1997.

Eims, Leroy. *The Lost Art of Disciple Making*. Grand Rapids: Zondervan, 1978.

Friedeman, Matthew. *The Master Plan of Teaching*. Wheaton: Victor Books, 1991.

Gorman, Julie. *Community That is Christian: A Handbook on Small Groups*. (2nd edition).  
Ada: Baker Books, 2002.

Neighbor, Ralph. *Where Do We Go from Here?* Touch Publications, 1991. (Available on Kindle, 2011.)

Snyder, Howard. *The Radical Wesley: Patterns for Church Renewal*. Downers Grove: Intervarsity Press, 1980.

Snyder, Howard. *The Problem of Wineskins*. Franklin: Seedbed Publishers, 2017.

Wilkinson, Bruce. *The Seven Laws of the Learner*. New York: Multnomah, 1992.

## Цахим эх сурвалжууд

Сайнмэдээний сургалт, материал болон бусад мэдээллийг Рэй Комфорт, Кирк Камерон нараас <https://www.livingwaters.com/> вэб хуудсаар аваарай.

Гадаа сайнмэдээ тараах, зурагт хүснэгт зэргийг Open Air Campaigners -ийн дараах вэб хуудсаас авна уу. <https://www.oacgb.org.uk/> and <https://oacusa.org>.

*Cultivate Discipleship Lessons*, from Shepherds Global Classroom цувралын 26-р хичээл нь шинэ итгэгчдийг дагалдуулахад зориулагдсан. Эдгээр хичээлийг <https://www.shepherdsglobal.org/> вэб хуудсаас аваарай.

Өөр шашнаас христитгэл рүү ирсэн хүмүүсийг дагалдагч болгох талаар Натан Брауны маш сайн материалыг <https://comeafterme.com/> вэб хуудсаас авах боломжтой.



# Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр: \_\_\_\_\_

Хичээл	Даалгавар 1	Даалгавар 2	Даалгавар 3
1			
2			
3			
4			
5	(сорил)		
6			
7			
8			
9			
10		(сорил)	
11			
12			
13			
14			
15			
16			
17			

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах өргөдлийг манай [www.shepherdsglobal.org](http://www.shepherdsglobal.org) вэб хуудсаар орж бөглөх боломжтой. Суралцагчдынхаа өмнөөс өргөдөл илгээсэн багш, сургагч багш нарт SGC байгууллагын ерөнхийлөгч төгсөлтийн гэрчилгээг цахим хэлбэрээр илгээх болно.